

ТӨГС ГЭГЭЭРСЭН ИХ БАГШ ЧИН ХАЙ



ТӨГС ГЭГЭЭРСЭН ИХ БАГШ ЧИН ХАЙ АГШИН ЗУУР ГЭГЭЭРЭХИЙН ТҮЛХҮҮР 9



АГШИН ЗУУР ГЭГЭЭРЭХИЙН
ТҮЛХҮҮР 9

ТӨГС ГЭГЭЭРСЭН ИХ БАГШ ЧИН ХАЙ

АГШИН ЗУУР
ГЭГЭЭРЭХИЙН ТҮЛХҮҮР

Есдүгээр боть

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Олон Улсын Нийгэмлэг

АГУУЛГА

Намтрын өмнөх үг	3
Товч илгээлт.....	5
Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн товч намтар	6
Өмнөх үг	11
Бурханаас суралцах нь бурханы хутагт хүрэхийн төлөө.....	12
Сахил санваарын жинхэнэ утга учир.....	25
Үнэн ёс цорын ганц байдаг.....	45
Бурхан ерөөл барилдлагатай хүмүүсийг л гэтэлгэдэг.....	59
Зургаан билиг барамид.....	87
Бясалгал хийх болон сахил сахихуй.....	117
Гурван эрдэнэд аврал одуулах болон авшиг авах ёсон.....	136
Бурхан ба хүн.....	161
Хүний амьдралын зорилго.....	183
Хорсол заналыг хайраар арилгахуй.....	211
Сахил сахихын чухал чанар.....	233
Хаа сайгүй орших уг дүр.....	254
Веган хоолны ач тус	261
Эрүүл мэнд ба хоол хүнс	262
Экологи ба хүрээлэн буй орчин	266
Дэлхийн өлсгөлөн	267
Гэгээнтнүүд ба үйлс нэгтнүүд	268
Авшиг хүртэхүй- Арьяабалын бясалгалын арга.....	270
Таван сахил	272
Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн ном хэвлэлийн жагсаалт ..	273
Бидэнтэй хэрхэн холбогдох вэ?	277

НАМТРЫН ӨМНӨХ ҮГ

Машид гэгээрсэн Их Багшийн дэсийг эгэл хүний чадвар, энэ ертөнцийн үгээр илэрхийлэх боломжгүй. Түүний бүхий л амьдрал, үзэл санааг хичнээн тодорхой хичээнгүйлэн дүрсэлсэн ч бүрэн дүүрэн өгүүлж чадахгүй.

Эрт цагт Энэтхэгийн нэг бясалгагчид өөрийн Багшийн намтар түүхийг бичих үүрэг оногджээ. Хэдэн сарын дараа бичиж дууссан эсэхийг асуухад дуусаагүй гэжээ. Дахиад хэсэг хугацааны дараа асуухад: “Их Багштай ижил дэсэд хүрч, түүний үзэгдэх, үзэгдэхгүй түвшний ажлыг жинхэнэ үнэн зөвөөр ойлгохоос нааш би энэ ажлыг хэзээ ч дуусгаж чадахгүй. Учир нь миний багш эгэл ертөнцөөс хэтийдсэн төрөлтөн билээ” гэж хариулсан гэдэг.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай өөрийн өмнөх амьдралын талаар дурдсан нь тун бага. Гэсэн ч Багшийн намтрыг ихэд сонирхсон газар газрын шавь нарынхаа тавьсан олон янзын асуултад хариулахаас өөр аргагүй болдог. Энэ товч намтарт Их Багшийн амьдралын замналыг эмхэтгэж, найруулан бичжээ. Иймээс бүрэн төгс болоогүй тал мэдээж бий.

ТОВЧ ИЛГЭЭЛТ

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай уран бүтээлч, оюун санааны агуу хөтчийн хувьд сүнслэг гоо сайхныг илэрхийлэх аливаа хэлбэрт дуртай. Тэрээр Вьетнамыг “Ау Лак”, Тайванийг “Формоса” гэж нэрлэдэг. “Ау Лак” нь Вьетнамын эртний нэр, амар амгалан амьдрах гэсэн утгатай. Харин “Формоса” (үзэсгэлэнтэй сайхан) гэдэг нэр энэ эрдэнийн арал, ард түмнийх нь гоо сайхныг бүрэн дүүрэн илэрхийлнэ. Эдгээр нэрийг хэрэглэх нь тухайн улс орон, зон олонд сүнслэг дэвшил, буян хишгийг авчирна гэж Их Багш үздэг юм.

ТӨГС ГЭГЭЭРСЭН ИХ БАГШ ЧИН ХАЙН ТОВЧ НАМТАР

ХАЙР ЭНЭРЛИЙН ЗАМ

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай бол дэлхий дахинаа алдар суу нь түгсэн оюун санааны их удирдагч, уран бүтээлч, хүмүүнлэгийн үйлстэн юм. Их Багшийн хайр энэрэл хүн төрөлхтний соёл, ёс заншлын хил хязгаарыг давж, дэлхий даяар түгж байдаг билээ.

Төгс Гэгээрсэн Их Багш Ау Лакын (Вьетнам) төв нутагт мэндэлж, Европт очиж суралцсан бөгөөд тэндээ Улаан загалмайн нийгэмлэгт ажилласан байна. Тэрээр энэ хугацаанд дэлхий дахин зовлон зүдүүрээр дүүрэн байгааг даруй олж мэдээд үүнээс ангижрах арга замыг эрэн хайхаар шийдсэн нь Түүний амьдралын эрхэм дээд зорилго болсон байна.

Тэрбээр тухайн үед герман эмчтэй гэр бүл болж, аз жаргалтай амьдарч байсан ч тус тусын зам мөрийг хөөх хэн хэндээ амаргүй шийдвэрийг гаргаж, нөхрийнхөө чин сэтгэлийн ерөөлийг өвөрлөн, өөрийн зорилгоо биелүүлэх аяндаа морджээ. Ийнхүү Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай үнэнийг эрэн хайж, сүнслэг гэгээрлийн зам мөрөөр замнаж эхэлсэн байна. Эцэст нь Энэтхэгийн Хималайн ууланд нэгэн Төгс Гэгээрсэн Их Багш түүнд дотоодын Гэрэл ба Аялгууг

ажих “Арьяабалын Бясалгалын Арга”-ыг уламжилжээ. Ийнхүү тэрбээр хэсэг хугацаанд хичээнгүйлэн бясалгасны эцэст Төгс Гэгээрэлд хүрчээ.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн гэгээрлийн сургаал номлолыг удирдлага болгосон Олон улсын нийгэмлэг 1980 онд байгуулагджээ. Хүмүүсийн чин сэтгэлийн хүсэлтээр Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай Арьяабалын бясалгалын аргыг уламжилж, тэднийг өөрийн дотоод дахь бурханлаг чанараа нээн илрүүлэхэд нь дэмжин зоригжуулж эхэлсэн юм. Удалгүй Америк, Европ, Ази, Австрали, Африк зэрэг таван тив болон Нэгдсэн Үндэсний Байгууллагаас Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайг ном тайлуулахаар урин залах болжээ.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай энэрэн нигүүлсэх сэтгэлээрээ зовж зүдэрсэн олонд бүх талаар хайр энэрэл, тус дэмжлэг үзүүлдэг бөгөөд Түүний хүмүүнлэгийн ажил нь бүхий л хориг саадыг даван туулж, дэлхийн өнцөг булан бүрийн орон гэргүй ядуучууд, дорой буурай амьдралтай өндөр настнууд, шоронгийн хоригдлууд, хөгжлийн бэрхшээлтэй болон оюуны хомсдолтой иргэд, дүрвэгсэд, Америкийн ахмад дайчид зэрэг хүмүүст түгэн хүрчээ.

Дулаарлаас үүдэлтэй элдэв хямрал дэлхий дахинд нүүрлээд байгаа өнөө үед Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай өгөөмөр сэтгэлээр олон сая долларын хүмүүнлэгийн тусламжийг үзүүлдэг бөгөөд байгалийн элдэв гамшигт нэрвэгдэгсэд туслуулахаар нийгэмлэгийнхээ гишүүдийг дэлхийн бүхий л оронд илгээж байна. Үүнээс гадна Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай энэ дэлхийд бидэнтэй зэрэгцэн оршигч эрхэм ариун амьтад болон хүрээлэн буй орчны асуудалд ихэд санаа тавьдаг билээ.

Их Багшийн энэрэл хайр, асрал нигүүлсэл олон сая хүмүүсийн сэтгэлийг хөдөлгөж, бусдын төлөөх харамгүй сайхан сэтгэл нь тэдний даган дуурайх үлгэр жишээ болж байна. Их Багш өөрийн уран зураг, дэнлүү чимэглэл,

хувцасны загвар, үнэт эрдэнийн гоёл зэрэг урлагийн бүтээлүүдийнхээ орлогоороо тусламж хэрэгтэй Эзэн Бурханы үр хүүхдүүдийг дэмжин тэтгэдэг билээ.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн сүүлийн жилүүдэд бичсэн “Шувууд миний амьдралд”, “Миний амьдрал дахь ноход”, “Эрхэм ариун амьтад” хэмээх гурван ном нь дэлхийн хамгийн их борлуулалттай номоор шалгарч, олон хэлээр орчуулагдаад байна. Их Багш телепат холбоо болон сүнслэг ажиглалтаараа эрхэм ариун амьтдын сэтгэл хөдлөл, бодол санааг гүн гүнзгий ойлгож, тэдний эрхэм дээд санаа зориг, хэзээ ч хариу үл нэхэх өгөөмөр хайрыг эдгээр бүтээлүүддээ тод томруун тусган харуулжээ.

Төгс Гэгээрсэн Их Багш хүмүүст үлгэр дуурайл болох зөв ёс зүйтэй сайн үйлсийг урамшуулан сайшааж 2006 оны 3 сард “Дэлхийн Гэрэлт манлайллын шагнал”-ыг, мөн удалгүй “Дэлхийн Гэрэлт Баатарын шагнал”, “Дэлхийн Гэрэлт Нигүүлсэнгүй үйлсийн шагнал”, “Дэлхийн Гэрэлт шударга үйлсийн шагнал”, “Дэлхийн Гэрэлт Зохион Бүтээгчийн шагнал” зэрэг олон цол шагналуудыг бий болгожээ. Эдгээр нэр төртэй шагналыг хувь хүн, албан байгууллага, улс орнуудад олгодог бөгөөд тэдний үлгэр дуурайлтай ажил үйлс нь манай гарагийг улам гоо үзэсгэлэнтэй, эв зохиролтой болгож, дэлхийн тогтвортой хөгжилд жинтэй хувь нэмэр оруулж байна. Тухайлбал: Словени Улсын хоёр дахь Ерөнхийлөгч доктор Жанез Дрновшек, АНУ-ын 45 дахь Дэд ерөнхийлөгч, 2007 оны Нобелийн Энх тайвны шагналт, НҮБ-ын Уур Амьсгалын Өөрчлөлтийн Засгийн Газар Хоорондын Мэргэжилтний Хороо (IPCC)-ны гишүүн Аль Гор, НҮБ-ийн Уур Амьсгалын Өөрчлөлтийн Засгийн Газар Хоорондын Мэргэжилтний Хороо /IPCC/-ны тэргүүн бөгөөд Энэтхэг улсын Эрчим Хүч, Эрдэс Баялгийн Хүрээлэн (TERI)-гийн тэргүүн, НҮБ-ын Хүний суурьшлын хөтөлбөрийн 2010 оны шагналт, доктор Ражендра К.Пачаури, АНУ-ын Сансар Судлалын Үндэсний Төвийн

(НАСА) тэргүүн, 2009 оны Карл Густаф Россби судалгааны шагналт, доктор Жэймс Е.Хансен, Английн нэрт доктор, бичний овгийн хөхтөн амьтан судлаач Жэйн Гуудал нарын олон хүн эдгээр шагналыг хүртсэн байна.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай амиа үл хайрлан аюул эрсдэлийг сөрж, бусдын амь насыг аварсан бидний эрхэм анд нөхөр амьтдын баатарлаг үйлсийг нь сайшаан “Дэлхийн Гэрэлт Баатарын шагнал”, “Дэлхийн Гэрэлт оюун ухааны шагнал”-ыг олгодог бөгөөд үүгээр амьтдын баатарлаг зориг, сэргэлэн ухаан, хайрын сэтгэлийг илчлэн харуулдаг билээ.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн дэлхийн хөгжил дэвшилд оруулсан сүнслэг болон материаллаг асар их хувь нэмрийг олон улс орны төр засгийн газар, хувийн байгууллагууд өндрөөр үнэлэн шагнаж хүндэтгэлээ илэрхийлсэн байна. Тухайлбал: Гуси Энх Тайвны шагнал (2006 он), Телли-гийн 27 дахь жилийн шалгаруулалтын Мөнгөн Эрдэнийн тэргүүн шагнал (2006 он), Лос Анжелесын Хөгжмийн Долоо хоногийн Сайшаалын гэрчилгээ (2002 он), Дэлхийн Оюун Санааны Удирдагчийн шагнал (1994 он), Дэлхийн Хүний Эрхийг Дэмжигчийн Шагнал (1994) зэргийг дурдаж болно. Түүнчлэн АНУ-ын төр засгаас жил бүрийн 2 дугаар сарын 22 болон 10 дугаар сарын 25-ны өдрүүдийг “Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Өдөр” болгон тэмдэглэж байхаар зарласан юм. Их Багшийн дэлхийд өргөсөн тусламж, түүний бие сэтгэл харамгүй их үйлсийг олон орны төрийн тэргүүн, ард иргэд өндөр үнэлэн талархлаа илэрхийлсээр байдаг билээ.

Их Багш Чин Хай бол өөрийн билиг ухаан, баатар зоригоороо цаг уурын өөрчлөлтийн сэдвийг зоригтой хөндөж тавьсан өнөө үеийн хүрээлэн буй орчныг хамгаалагчдын манлайлагч юм. Үнэн хэрэгтээ хориод жилийн өмнөөс хүрээлэн буй орчныг хамгаалахыг уриалж байсан бөгөөд “Тайм амьдралыг сонгож болно”, “SOS-дэлхийн дулаарлыг

зогсоох нь” зэрэг үйл ажиллагааг санаачлан эхлүүлжээ.

Түүнчлэн дэлхийн цаг уурын өөрчлөлтийн хуралд зочин илтгэгчээр оролцож, дэлхий ертөнц дээр өнөө үед тасралтгүй гарсаар байгаа байгалийн гамшгийн үндсэн шалтгаан болон түүнийг шийдвэрлэх гол арга болох нигүүлсэнгүй веган амьдралын хэв маягийг сонгоход олны анхаарлыг хандуулж байна.

Олон нийтэд хэдийнээ танил болсон “Веган болж, энх тайвныг цогцлооё” хэмээх уриаг Их Багш Чин Хай дэвшүүлсэн билээ. Хоол хүнсний сонголт нь цаг уурын өөрчлөлтөд асар их нөлөөтэйг үндэслэн энэрэнгүй, тогтвортой амьдралын хэв маягийг сонгоход нь хүмүүст туслахын тулд “Loving Hut” веган хоолны сүлжээ ресторанууд Их Багш Чин Хайн урамшуулал дэмжлэгээр амжилттай өргөжин тэлсээр байна. Олны таашаалыг хүлээсэн энэ хоолны газрууд дэлхий даяар тархаж, олон төрлийн эрүүл тэжээллэг, хямд үнэтэй, амтлаг веган хоолоор үйлчилдэг. Гараг ертөнц, түүний оршин суугчид, зэрэгцэн оршигч төрөлтнүүд болоод бидний үр хойчийг дэлхийн дулаарлаас үүдсэн сүйтгэгч нөлөөнөөс аврахын тулд үүний эсрэг хамгийн үр дүнтэй арга болох эрүүл энэрэнгүй хоол хүнсийг дэлгэрүүлж байна.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай хүн төрөлхтөнд хосгүй гайхамшигт энэ гараг дэлхийдээ гэрэлт ирээдүйгээ цогцлоох үйлсэд нь амь биеэ огоорон, эцэс цуцалтгүйгээр тусалсаар байгаа билээ.

ӨМНӨХ ҮГ

Их Багш Чин Хай гүн утгатай, ойлгоход хэцүү үг хэллэг хэрэглэхээс ямагт зайлсхийж, хамгийн ойлгомжтой ярианы хэлбэрээр ном тайлдаг. Түүний ном хэвлэлүүд нь уран яруу илэрхийллийг бус, уншихад хялбар ойлгомжтой байхыг урьтал болгодог. Их Багшийн адислалын хүчийг бууруулахаас эмээж, түүний шавь нар эгэл хүний ухаанаар номын агуулгыг өөрчилдөггүй.



БУРХАНААС СУРАЛЦАХ НЬ БУРХАНЫ ХУТАГТ ХҮРЭХИЙН ТӨЛӨӨ

*Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Америкийн Калифорни мужийн Санта Ана хот
1987оны 10 дугаар сарын 21.
(Эх нь вьетнам хэлээр)*

*※ Бидний чин сэтгэл Бурханыг уяраадаг болохоор
биднийг адисалдаг, тэр үед бидний дотоодын хүч,
бидний Бурхан Чанар сэргэж, үйлдэж хөдөлж эхэлдэг.*

Элэг нэгт ах дүүс маань эрх чөлөөт оронд аюул осолгүй хүрэлцэж ирэн эрүүл саруул, баяр жаргалтай байгааг хараад Багш нь тун их баярлаж, сэтгэл догдолж байна. Бурхан Бодьсадва нарын адислал хамгаалалтаар хүн бүр амар амгалан байж чадна, мөн материаллаг болон оюун санааны амьдралын аль алинд нь элбэг баян байж чадна. Тиймээс Багш нь та нарын өмнөөс Бурхан Бодьсадва нарт баярлан талархаж байгаагаа илэрхийлж байна!

Өвөг дээдсийн үйлийн үр ба тогтсон үйлийн үр

Та нэгэнт Бурханы Хутагт хүрчихсэн байтлаа яагаад өөрийн эх нутаг Вьетнамаа авран тусалдаггүй юм бэ? гэж Багшаас нь олон хүн асуудаг. Ингэх боломжтой юу? Үнэндээ бид эхлээд өөрийн биеэ аврах хэрэгтэй. Шагжамуни Будда амьд сэрүүн байхад Түүний улс оронд бас дайн дажин их байсан бөгөөд шавь нар нь Түүнээс дайтаж байгаа хоёр этгээдийг эвлэрүүлэхийн тулд ид шид болон адислах хүчээ ашиглаж, улс орноо авраач гэж гуйж байжээ. Тэгэхэд Бурхан Багш: “Ингэж болохгүй, тэд төрөл төрөлдөө үйлийн үр болон үйл түйтгэр маш их үйлдсэн болохоор түүнийгээ заавал төлж дуусгах хэрэгтэй, тэгсний дараа тэд эв найрамдалтай болно, тэр үед дайн дажин аяндаа замхарна, одоо бид хөндлөнгөөс оролцож болохгүй” гэжээ. Бурхан Багшийн их шавь Модгальяна Багш нь туслахгүй байгааг хараад Бурхан Багшид нигүүлсэнгүй сэтгэл байхгүй гэж буруугаар ойлгож: “Багш Та туслахгүй юм чинь би тусална” гээд дайтаж байгаа хоёр улсыг өөрийн бадар аягандаа хурааж, нэг удаагийн цуст дайныг зайлуулчихлаа гэж боджээ, хэдэн хоногийн дараа бадар аягаа нээтэл, харин дүүрэн цустай байсан нь өнөө хоёр улс бадар аяганы жижигхэн зайд мөн л харилцан хядалцсан байжээ.

Тогтсон үйлийн үрийг өөрчилж чаддаггүй гэж “Очир огтлогч судар”-т (The Diamond sutra) дурдсан байдаг. Тогтсон үйлийн үр гэж үйлийн үрийн өр төлөөсийн нэг төрөл юм, Католик шашинтнууд үүнийг удам дамжин үеийн үед уламжлагддаг өвөг дээдсийн нүгэл гэдэг. Өвөг дээдэс гэж хэн бэ? гэвэл үнэндээ бид өөрсдөө л юм. Бидний урд төрөлдөө үйлдсэн алдаа гэмийн “үйл” нь төрөл арилжсаны дараа өөрсдийн биед “үр” болж боловсордог. Адам, Ева хоёр үр хойчдоо анхны гэм нүглийг үлдээгээгүй, хэрвээ үлдээсэн гэвэл дэндүү шударга бус болно. Эзэн Бурхан ингэх ёсгүй. Энэ тухай Библи сударт маш товчхон ярьсан байдаг бөгөөд энгийн хүмүүст үүнийг ойлгохуйц хангалттай билиг ухаан

байдаггүй болохоор үнэнийг ойлгохын аргагүй байдаг. Үнэн хэрэгтээ өвөг дээдэс гэгч нь бид өөрсдөө л юм. Яг л та зуун жилийн өмнө Жиа овогтын гэрт мэндэлсэн бөгөөд амьдралаа элээж насан эцэслэсэн, тэгээд зуун жилийн хойно дахин Жиа овогтынд хүн болж төрөөд үр хойч нь болж хувирчээ, тэгэхлээр Жиа овогтын өвөг дээдэс нь үнэндээ бас л та өөрөө мөн болохтой адил юм, үүнийг мэддэг хүн байдаггүй нь тун харамсалтай! Өвөг дээдсийн гэм нүгэл гэдэг нь өөрсдийнх нь урд нь үйлдсэн үйлийн өр төлөөс мөн, тиймээс л үйлийн өр төлөөс нь өөрсдөөс маань үүсдэг гэж хэлдэг.

Та яагаад Вьетнамыг авран тусалдаггүй юм бэ? гэж зарим хүн асуудаг. Бурхан минь ээ! Ингэж болохгүй шүү! Шагжамуни Будда: зовлонгийн далайгаас гэтлэе гэвэл Бурханы номыг журамлан дагах хэрэгтэй гэж ярьсан байдаг. Тэрээр: “Сарыг заасан миний хурууг дагуулж харвал гэгээн сарыг харж чадна” гэж хэлсэн. Тиймээс бид Бурханд найдаж болохгүй, Бурхан зөвхөн бидэнд зөв замыг зааж өгдөг л төдий.

Бурхан Багш ч гэсэн бурхны номыг журамлан дагаснаар л Бурханы хутагт хүрчээ. Бид хэрвээ Бурханы хутагт хүрч, зовлонгийн далайгаас гэтлэе гэвэл Бурханы сахил дүрмийг сахих хэрэгтэй. Тэнгэрийн төрөлтний хутагт хүрье гэвэл тэнгэрийн төрөлтний сахилыг сахих хэрэгтэй, Бурханы хутагт хүрье гэвэл заавал Бурханы сахилыг сахих хэрэгтэй. Зөвхөн сайн санаат хүн болоход ч гэсэн энгийн хууль дүрмийг дагах хэрэгтэй байдаг, хуулийг зөрчвөл зөвхөн өөртөө саад тотгор учруулж, өөрийгөө зовоох болно. Бурхан биднийг аварч, тусалсангүй гэж гомдоллох хэрэггүй, Бурхан биднийг аварч тусалдаггүй биш, харин бид өөрсдөө түүний зааврыг сонсдоггүй. Яг л бид өвчилснийхөө хойно эмчид очиж: би өвчилчихжээ, надад эм уулгаж өвчнөөс аварна уу? гэж гуйхаар эмч чамд эм өгдөг, гэтэл та эмчийн

өгсөн эмийг уухгүй бол улмаар өвчин чинь мэдээж хүндэрч, тэр ч байтугай амиа алдаж ч мэдэхтэй адил, ойлгож байна уу?

Ид шид бол хамгийн төгс төгөлдөр нь биш

Ид шид ерөөсөө бусдыг аварч чадахгүй, аврагдсан ч зөвхөн түр зуурын төдий хэрэг. Тиймээс Бурхан Багш биднийг мухар сохроор сүсэглэж болохгүй гэжээ. Бурхан Багшийн ярьсан бүхэн бүгд л үнэн зөв бөгөөд учир зүйд нийцдэг. Тэр (Бурхан) элдэв янзын үйл хөдлөл хийж, ид шид үзүүлэн бидний сэтгэлийг татаж: “Хараач! Би ид шидтэй шүү!” гэж хуруугаараа заангуут аливаа бүхэн төгс төгөлдөр болчихдог гэж Бурхан Багш яриагүй. Харин: үйл байвал үр байна, зол жаргал, баяр бахдалын сайн үрийг хураая гэвэл заавал эхлээд сайн үйл үйлдэх хэрэгтэй гэж сургасан байна.

Бурхан Багшийг амьд сэрүүн байх үед нэгэн настай эмэгтэйн хүү нь хүнд өвчилсөн учраас өнөөх настан Бурхан Багшаас аврал гуйжээ. Тэгэхэд Бурхан Багш хүүг нь аварч тусалсан уу? Туслаагүй. Энэ нь Бурхан Багш нигүүлсэнгүй сэтгэлгүйдээ биш, харин цаг нь болохоор заавал явах ёстой байдаг үйл үрийн хуулийг тодорхой ойлгодог болохоор түүний үйл үрд хөндлөнгөөс оролцох дургүй байснаас тэр юм. Нэг хүний үйлийн үр тоолшгүй олон хүнтэй холбоотой, нэг хүний хувь заяаг өөрчилбөл тоолшгүй олон хүний хувь заяанд нөлөөлөх болно.

Яг л багшийнх нь гарт байгаа маанийн эрих шиг, үүнийг Тайваний нэгэн шавь маань надад өгсөн юм, энэ маанийн эрихний түүхийг яривал: багшийнх нь нэг шавь өвчлөх үед хувилгаан багш ирж, түүнийг аварч байхыг харжээ, тиймээс тэр энэ маанийн эрихийг хийж, багшид нь дурсгал болгон бэлэглэсэн юм. Нэг маанийн эрихийг маш олон сувсыг хэлхэж бүтээдэг, хэрвээ нэг хүн: “Багш

аа! Танай гарт байгаа маанийн эрих нээрэн гоё юм аа, нэг сувсыг нь надад өгнө үү?” гэвэл багш нь мэдээж түүнд нэг сувс өгч болно, гэвч нэг сувсыг нь авчихвал бусад сувс нь ч дагалдан газар унаж бөмбөрч одно, ингэснээр дахин нэг нэг мөхлөгөөр хэлхэх хэрэг гарна. Тиймээс багш нь: “Яршиг яршиг! Өгөхөө больё!” гэх болно .

Бусдыг аврах нь тийм ч хялбар биш. Өөрийгөө аврах гэж чин сэтгэлээсээ хүсдэг бөгөөд алдаа дутагдалдаа гэмшиж ухаарсан байвал л сая аварч болдог. Бидний чин сэтгэлд Бурханы сэтгэл хөдөлж, биднийг адисалдаг, энэ үед бидний өөрсдийн дотоодын хүч, бидний Бурхан чанар сэрж үйлдэж хөдөлж эхэлдэг, тэгээд зөв замд гарангуут аян замын саад бартаа алга болдог.

Гэр чинь хойд зүгт байтал хүмүүс харин машинаа жолоодон өмнө зүг явжээ гэе. Гэхдээ зарим хүн буруу чиглэлээр явснаа мэдээд гэдрэг буцдаг, зарим нь харин буруу чиглэлээрээ, цэх урагшаа яваад л байвал мэдээж гэрээсээ улам л холдоно. “Аль зүг рүү ч явсан бай, танд арга ухаан их байдаг болохоор та намайг гэрт хүргэвэл болчихно, олон юм ярих хэрэг юу байна?” гэж зарим хүн бодож ч байж магад, гэтэл гол нь та өөрөө буруу тийшээ явахаа болиод гэдрэг буцахгүй, заавал өргүүр машин ирж, таныг машинтай чинь хамт нааш чирч, буцаахыг хүлээдэг. Тэгсээр байтал зам түгжирч, олон хүний цаг завьг саатуулах болно. Тиймээс хамгийн сайн бөгөөд хамгийн хялбархан арга нь та өөрөө гэдрэг буцах юм.

Үүнтэй адил, бурхнаас суралцахад заавал сахилаа чанд мөрдөх хэрэгтэй. Ямар ч шашныг шүтсэн бай, бүгд л тэр шашныхаа сахилыг сахиж байж л зөв замаар замнаж чадна. Шагжамуни Бурхан болон Есүс Христ бүгд л өөрийнхөө ашиг тус, эсвэл нэр алдрын төлөө бусдыг хүчээр сахил мөрдүүлж, шавь элсүүлж байгаагүй. Шагжамуни Бурхан болон Есүс Христ бүгд л бодь мөрийг олсон бөгөөд

энэ бясалгалын замаар замнасан хүмүүс билээ. Гэхдээ энэ зам бол зөв бөгөөд аюулгүй байдгийг мэдсэн болохоороо л хамаг төрөлтнийг удирдан дагуулж, хамт явсан байна. Хэрвээ бид тэдний зам мөрийг мөрдвөл маш сайн үр дүнд хүрнэ.

Хэрвээ та Тэднийг дагах дургүй бол яах ч аргагүй шүү дээ! Яг л гэр чинь хойд зүгт байтал заавал өмнө зүг рүү явах, эсвэл гэр чинь өмнө зүгт байтал хойд зүг рүү явахтай адил. Ингэвэл төгс гэгээрсэн их багш байлаа ч гэсэн ямар ч арга байхгүй, ойлгож байна уу? Төгс Гэгээрсэн Их Багш бидэнд тусалдаггүй биш, тэдний хувьд бидэнд туслах нь маш хялбархан хэрэг. Харин та нар машиныхаа явах чиглэлийг өөрчлөхгүй, цэх урагшаа яваад л, өргүүр машин ирж нааш нь чирээд буцахыг хүлээх нь дэндүү ядаргаатай бөгөөд өргүүр машин замд гарвал замын түгжрээ үүснэ. Тиймээс хамгийн сайн арга нь өөрсдөө зөв чиглэл рүү буцах юм.

Толгойгоо эргүүлээд эргийг олж хар

Сахил сахих нь өөрийгөө хамгаалахын төлөө юм, Бурхан багш бас “Буцаж эргээд эрэг рүү хар” гэж хэлсэн байдаг.

Нэгэн өглөө Багшийг нь ном тайлах гэж бэлтгэж байх үеэр нэгэн бяцхан шавж хаанаас нисэж ирснийг бүү мэд өрөөнд орж ирээд ийш тийш ниссээр аалзны торонд наалдаад тийчилж байв. Багш нь үүнийг хараад сэтгэл зовохдоо өнөөх шавжийг аалзны торноос салган аяганд хөнгөхөн хийгээд цаасаар тагласны дараа гадаа гаргасан. Тэгтэл ч тэр шавж дахин чөлөөтэй нисэн одсон. Аяганд байхдаа тэр амиа алдахаас эмээж, байдаг хүчээрээ тийчилж, гарахыг хүссэн. Тэгэхээр нь гаргахгүй гэж аягаа тагласан тул бараг л амьсгалж чадахгүйд хүрсэн. Бага зэрэг л тэвччихвэл

дорхноо суллагдах гээд байтал Багшийн чинь сайн санааг тэр ойлгож чадахгүй байсан хэрэг.

Бурхны сургаал нь яг л тэр аягатай адил биднийг түр зуур нэгэн хүрээ царгаанд хорьдгийн зорилго нь бүр ч эрх чөлөөт оронд дагуулан аваачихын төлөө билээ. Яг л тэр нисдэг шавж шиг, аяганд байхдаа эрх чөлөөгүй шиг санагдан хүмүүс түүнийг хорлох байх гэж эмээж байжээ, гэтэл удаж төдөлгүй жинхэнэ эрх чөлөөтэй болжээ. Энэ ертөнцийн эрх чөлөө бол жинхэнэ эрх чөлөө биш. Заримдаа бид: яах гэж бясалгал хийх хэрэгтэй юм? Амьдрал маань тун ч зүдгүүртэй, өдрийн гурван хоолоо цадтал идэж чадахгүй, дандаа өлсгөлөн байхад бас бясалгал хийж, сахил сахина гэдгийг чухам хэн тэвчиж хүлцэж чадах билээ гэж бодож магад. Гэтэл хэрвээ ингэж чадвал мөнхийн баяр жаргал, амар амгалан болон эрх чөлөөг олж, эгэл ертөнцийн мөнх бус эрх чөлөөг даван гарах болно.

Вьетнамчууд болон Зүүн Азийн хүмүүс Дорно Дахины гүн ухааны нөлөөнд гүн автаж, Бурханы шашин, Бумбын шашин, Күнзийн сургаал, Католик шашныг мэдэхгүй хүн бараг байхгүй болсон бөгөөд хүн болгон бага зэрэг ч гэсэн ямар нэгэн шашны нөлөөнд автсан байдаг. Гэхдээ нөлөөнд автах нь нэг хэрэг, сургаал ёсыг нь мөрдөх нь ондоо нэг хэрэг. Бид хэрвээ бурхны шашинтан юм бол Бурхан Багшийн зааврыг сахиж, амьдралаа сайжруулбал зохино, хэрвээ католик шашинтан юм бол католик шашны сургаалыг мөрдөнө, ингэснээр бидний амьдрал ондоо болсныг харж чадах болно.

Хэрвээ Бурхан буюу Эзний сахил дүрмийг сахихгүй, харин ид шидэд шунаад байх юм бол амьдрал нь сайжран дэгжинэ гэдэг тун бэрх. Яг л аяган доторх шавж шиг, тийчлэх тусам багш чинь түүнийг гадагш нь гаргахад хэцүү болно. Тэр заавал тийчлэхээ больж, тайвширсны дараа л багш чинь сая түүнийг аюулгүй газар луу гаргаж чадна шүү дээ.

Харийн оронд байх нь бясалгахад сайн

Та нар гадаадад амьдарч, өдөр бүр амьдралын төлөө яаруу ажиллаж байна. Энд бясалгал дадуулах нь Вьетнамд бясалгал дадуулахаас хүнд байна гэж бодох байж магад. Ингэж боддог хүн байна уу? Өөрийн нутагтаа бясалгал хийх илүү хялбар дөхөм гэж зарим хүн боддог (Тийм гэж нэг хүн хариулав). Яагаад хэцүү бэрх байна гэж? Үнэндээ бясалгал хийхэд эсрэгээрээ харийн оронд харин тун хялбар дөхөм байдаг. Яагаад гэвэл эндхийн амьдралын нөхцөл нилээд сайн.

Америкт гэхэд л наад зах нь өглөө гурав, дөрвөн цагийн үеэр босож, хоол унд бэлтгэн зоогийн газрын ажлаа эхлүүлэх албагүй. Гэхдээ энд тун хүйтэн болохоор гудамжаар ийш тийш хэсэх хүн тун цөөн бөгөөд бид сэтгэл татагдан гадаа гарах ч боломжгүй, тийм биз? Хэрвээ бид олон хүн ийш тийш хэсэхийг харвал өөрийн эрхгүй сэтгэл татагдан гадаа гарах бодол төрдөг. Хэрвээ хэсүүчлэх хүн байхгүй бол хараанд өртмөөр зүйл ч байхгүй бөгөөд гадаа хооллох бодол ч төрөхгүй болно. Сэтгэл татах зүйл бага болохын хэрээр өөрийгөө тэгж ихээр хязгаарлах шаардлагагүй болно.

Эндхийн зоогийн газар Вьетнамынх шиг тэгж хүмүүсийн сэтгэлийг татдаггүй, Вьетнамд хүмүүс бүтэн өдөржин зоогийн газарт цэнгэлдэн суудаг, гэтэл эндхийн зоогийн газрын зочид тун цөөн. Гэхдээ зоогийн газар очсон ч бүгд л танил бус хүмүүс, ганцаар суугаад архи уухад ч бас цагаар нь хэмжээлж мөнгө авдаг бөгөөд чих дөжрөм хөгжмийн дуунд нь зүрх салганах нь хэцүү шүү! Иймэрхүү байдал нь Вьетнамынхаас их ондоо. Тиймээс энд бясалгал хийхэд нилээд дөхөм, та нар санал нийлж байна уу?

Өөр бас тун олон шалтгаан байдаг. Жишээлбэл, энд

хамаатан садан нилээд цөөн болохоор айлчлах тохиолдол ч цөөн бөгөөд нутаг усаа санан дурсах үеэр ганцаараа гэртээ суухаас өөр аргагүй. Ийм болохоор л бясалгал хийх цаг завтай болно. Гэтэл Вьетнамд хамаатан садан дэндүү олон болохоор өдөржингөө төрөл садандаа зочилж, цаг заваа үрнэ, харийн оронд ийм тохиолдол байхгүй болохоор бясалгал хийхэд тустай байдаг. Гадуур хэсэх бодол төрдөг ч чухам хаана очихоо ч мэдэхгүй, найзындаа айлчлах гэхээр өрөө нь дэндүү давчуу, суух зай ч олдохгүй хэцүү. Гэтэл Вьетнамд газар нутаг уужим, агаар цэнгэг, хүмүүс нь нөхөрсөг, гадаа сууж цайлсан ч маш тааламжтай. Энд архи их уувал машин жолоодож болохгүй. Гэтэл Вьетнамд согтчихсон ч тоох хүн байхгүй, цагдаа нь хүртэл архи уудаг юм чинь! Эндхийн хууль дүрэм маш чанга, амьдрал дүрэм журамтай бөгөөд нам жим, хэн ч байсан бясалгал хийхэд тун хялбар, энэ бүхэн нь бүгд л харийн оронд бясалгал хийхийн сайн тал болох билээ.

Бурханаас суралцахад үйлийн үрийн хуульд итгэх хэрэгтэй. Бусдыг занаж хорсох нь буруу, зөвхөн өөрсдөө хичээнгүйлэн бясалгаж, бясалгалын ач буянаараа бусдад нөлөөлнө, өөрсдөө гэгээрсний хойно л бусдыг гэгээрүүлж, удирдан дагуулж, туулан гэтэлгэж чадна. Улсаа хайрлах сэтгэлтэй, улс орондоо ач тусаа өргөх хүсэлтэй Вьетнамчуудад өгөх багшийнх нь сануулга гэвэл: бясалгал хийх нь дөрвөн их энэрэл (улс орны энэрэл, эцэг эхийн энэрэл, хамаг төрөлтний энэрэл, гурван эрдэнийн энэрэл)-ийг хариулах хамгийн сайн арга мөн. Бид хэрвээ хүчирхийлэл хэрэглэвэл эцсийн эцэстээ мөн л садан төрөл найз нөхдөдөө хор учруулсан л хэрэг болно. Даяар түмнийг бусниулсан дайн дажин нь хичнээн олон шилдэг залуусыг үрэгдүүлж, зөвхөн буурал настнууд л амьд мэнд үлджээ. Дайнд үрэгдэгсэд нь бидний ах дүүс, үр хойчис шүү дээ, харин өөр хүн биш.

Багшийнх нь бодлоор хамгийн сайн арга нь бясалгал хийх явдал юм. Бясалгал хийсний хойно бясалгалын ач буянаараа ах дүүсийн хоорондох тэмцлийг арилгаж чадна. Хэрвээ вьетнамчууд бүгдээрээ бясалгал хийвэл нэг хүн тун олон хүнийг гэтэлгэж, хэзээ нэгэн өдөр бүх улсаараа аяндаа туулан гэтлэх болно, ойлгож байна уу?

Бид дэлхий дахиныг өөрчлөхийн аргагүй бол өөрийгөө өөрчилж болно. Бясалгалын ач буянаараа бусдад тусална, ингэх нь хамгийн сайн. Хорсол заналаа марталгүй, харилцан уучлан өршөөхгүй тэмцэн тулалдвал хэзээ нэгэн өдөр дайтаж мэднэ, дайн дажин нь яг л ингэж үүсэж, тасралгүй үргэлжилдэг байжээ. Харилцан дайрч, харилцан дайтах нь асуудлыг шийдвэрлэж чадахгүй гэдгийг бид ойлгож болно. Аугаа их хайр энэрэл болон бясалгал л сая бүхнийг эрхшээн төгс сайхан үр дүнд хүргэж чадна.

Дэлхийн хүн ам яагаад улам олшрон нэмэгдээд байна вэ?

Дэлхийн хүн ам яагаад улам олшрон нэмэгдээд байна вэ? гэж олон хүн Багшаас чинь асуудаг. Шашныхан бүгд л манай шашин сүсэгтнүүдээ авран тусалж, туулан гэтэлгэж, баяр жаргалтай, амар амгалан диваажин, тэнгэрийн оронд дагуулан аваачна гэж ярьдаг. Багш чинь тэнгэрийн орныг жинхэнээр харсан болохоор тэнгэрийн орон болон диваажин гэдэг нь адилхан орон болохыг мэднэ. Яг л зарим хүн зочид буудал гэж ярьдаг байхад зарим нь Hotel гэдэг. Нэрийдэл нь адилгүй ч үнэндээ утга нь адил. Эл шашныхан бүгд л манай шашин сүсэгтнүүдээ дагуулан тэнгэрийн оронд аваачиж чадна гэж ярьдаг байтал яагаад дэлхийн хүн ам улам нэмэгдээд байна вэ гэдгийг та нар мэдэх үү? Учир нь туулан гэтэлж чадсан хүн тийм ч олон байгаагүй болохоор хүн ам улам нэмэгдсээр байгаа хэрэг. Хэрвээ туулан гэтэлчихсэн

бол энд аль хэдийнээ эзгүйрчихсэн байх байсан.

Жишээлбэл, дэлхийн бүх хүн амын гурваны нэг нь католик шашинтан, гуравны нэг нь Буддын шашинтан, үлдсэн нэг нь өөр шашинтан гэж төсөөлье. Хэрэв Буддын шашин л зөв зам мөр гэж ярьвал - би энд зөвхөн жишээлэн ярьж байгаа төдий шүү! - Католик шашныхан намайг битгий зодоорой (Багш инээв). Багш чинь тун эмээж байна. Ямар нэг шашны талаар яримагц өөр шашныхан тэр дорхноо муухай харж, нэгийгээ үзэж, нэхий дээлээ уралцахад бэлэн болчихдог.

Жишээлбэл, Буддын шашинтнуудыг зөв номтон гэвэл хүн амын гуравны нэг нь хорогдох ёстой биш үү? Хэрвээ Буддын шашин сайн биш, зөвхөн католик шашин л хамгийн сайн байж, хүмүүсийг туулан гэтэлгэж чаддаг гэвэл ядаж католик шашинтнууд туулан гэтэлж чадах нь зөв байж таарна. Гэтэл дэлхийн хүн ам яагаад урьдынх шигээ өдрөөс өдөрт нэмэгдэж, туулан гэтэлж байгаа хүмүүс байхгүй байна вэ? Шалтгааныг нь мэддэг хүмүүс гараа өргөөрэй, зөв хариулбал чихрээр шагнаана шүү! (Ном сонсож байх хүмүүсийн нэг нь хариу хэлэв). Хэрвээ ийм юм бол амьтнаас хүний төрөл авагсдын тоо болон хүнээс амьтны төрөл авагсдын тоо адилхан байвал зохино. Яагаад хүн ам улам нэмэгдээд байна вэ? Энэ талаас үзвэл улам олон амьтан хүний төрөл авч байгаа бөгөөд туулан гэтэлж байгаа хүмүүс эсрэгээрээ багасаж байгаа хэрэг.

Дэлхий дээр шашин тун олон, сахил санваар нь ч маш олон, гэтэл хүмүүс жинхэнэ ёсоор сахиж чаддаггүй. Бурхан Багш биднийг амь хороож болохгүй гэсэн. Бид Бурхан Багшийг шүтэн биширдэг хэдий ч бидний бүх үйл ажил түүний сургаал ёсыг зөрчин сөрж байдаг. “Би амь хороогоогүй, өөр хүн хороосон болохоор л бид идэж байна. Хэрэв идэхгүй бол хайран биш үү?” гэж ихэнх хүн мэтгэн маргадаг. Үнэхээр хөөрхийлөлтэй! Энэ бол бидний хэлдэг

нигүүлсэнгүй сэтгэл мөн гэж үү? Хэрвээ бүгдээрээ мах идэхээ больчихвол мах зарж худалддаг хүнгүй болчихно, хүмүүс Бурхан Багшийн сургаал ёсыг бүгдийг мартчихжээ.

Амь хорооход шууд бусаар хороох болон шууд хороох гэсэн хоёр төрөл байдаг. “Баатараа явагч их хөлгөн судар”-т: Бид мах идэхгүй бол амь хороох хүн байхгүй гэж дурдсан байдаг. Учир нь мах иддэг хүн байдаг болохоор амь хороох хүн байгаа хэрэг. Тиймээс мах иддэг хүн болон амь хороодог хүний ял гэм нь адилхан. Та нар “Баатараа явагч их хөлгөн судар”-ыг уншсан уу? Эсвэл үлгэрийн зохиол унших дуртай юу? Бурхны судрыг унших нь дэндүү уйтгартай, тийм үү, үгүй юү? Дандаа ургамал хоол идэж, сайн үйл үйлд гэж бидэнд сануулахыг сонссоор бүр халширч залхчихжээ. Та нар эрх дураараа амьдрах дуртай, ургамал хоол идэж юу хийх вэ? Дэндүү ядаргаатай, тийм үү?

※Аугаа их хайр энэрэл болон бясалгал л аливааг даван туулж, төгс сайхан үр дүн авчирч чадна.

Амь хороохын үйлийн үр

Одоо энэ жаахан зовлон зүдгүүрийг хүлцэн тэсвэрлэхгүй бол ирэх төрөлдөө бүр ч илүү зовлонд унах болно. Энэ бол үйл үрийн сансрын хүрд мөн. Бид өнөөдөр тэднийг хөнөөвөл маргааш тэд биднийг хөнөөнө, үр дүнд нь дайн үүснэ – үй олноороо амь үрэгдэнэ, яг л өдөр бүр амиа алдаж, тэр даруйдаа зах зээлд худалдагддаг тэр тоо томшгүй амьтантай адил.

Нэгэн хүн ингэж ярьсан байдаг: тэрээр америкт байхдаа нэг өдөр нэгэн тариалангийн талбайн хажуугаар өнгөрчээ. Өглөө харахад хар, улаан зүсмийн олон үхэр байсан байтал орой буцах үеэрээ харсан чинь харин бүгд алга болчихож, бүгдийг алаад шарчихсан байжээ. Тиймээс

яагаад дайн дажин байдаг вэ? гэж асуух хэрэггүй. Бурхан Бодьсадва ийм хэрцгий байдлыг бидэнд бүтээсэн байх ёсгүй, хүмүүс өөрсдөө л зохиосон хэрэг шүү дээ.

Яг л саяхан Сан Францискод үүссэн хүчтэй газар хөдлөлт шиг, гүүр тасарч, байшин нурж, зүрх шимшрэм байдал үүсжээ. Энэ тухай бид ярилцаж болох юм. Тэр гүүр уг нь хоёр давхар байж. Яагаад доод давхар нь яагаа ч үгүй байтал харин дээд давхар нь нурчихав аа гэвэл дээд давхрын тэр хүмүүсийн насны тоо нэгэнт гүйцчихсэн байж. Хаана ч байсан үхлээс мултарч чадахгүй нь маш тод харагдана. Эс бөгөөс үүнийг юу гэж хэлэх юм? Адилхан хүчтэй газар хөдлөлтөд дайруулсан байтал яагаад доод давхар нь яагаа ч үгүй, харин дээд давхар нь нурж, байшинд байсан хүмүүс нь нас барсан бэ? Үүнийг гэнэтийн осол гэж хэлж болохгүй, тоолж тавьсан нас, төөлж тавьсан бие гэдэг энэ байжээ.

Тиймээс шашин суртахууны төрөл зүйл тун олон хэдий ч ихэнх хүн мөн л туулан гэтэлж чадаагүй л байна. Учир нь хүмүүс шашны эздийн заасан удирдлага жолоодлогод жинхэнээрээ итгэдэггүй. Бид аль шашин нь сайн, аль шашин нь муу гэх мэтээр мэтгэж маргалдах шаардлагагүй. Сахил санваарын жинхэнэ утга учрыг ойлгодог, чанд сахидаг хүмүүс л жинхэнэ сайн сүсэгтнүүд байж таарна.

Эзэн Бурхан олон янзын шашныг хүмүүсийн өөр өөр шаардлагад нийцүүлэн бүтээсэн бөгөөд аливааг бүгдийг нь сайхан зохицуулчихсан байдаг. “Хотол зохилдогч зүйл”-д: Арьяабал Бурхан заримдаа энэтхэг хүн, заримдаа чавганц, хатагтай, их түшмэл, зандан эр, онгон охин гэх мэтийн олон янз шинж төрхөөр илэрч, хамаг төрөлтнийг гэтэлгэдэг гэж тэмдэглэсэн байдаг. Арьяабал Бурхан тухайн үеийн нөхцөл байдал болон тухайн төрөлтний хувь барилдлагыг харж байж хувирдаг, ойлгож байна уу? Тиймээс Есүс Христ бол Арьяабал Бурханы ондоо нэг хэлбэрийн хувилгаан төрх байж ч болзошгүй. Бид ямар нэгэн шашин л хамгийн сайн,

өөр бусад нь муу гэж нотолж тогтоохгүй байвал зохино. Өөрсдийнхөө хүний мөс, ёс суртахуунаа харгалзах нь л хамгийн чухал.

Библи сударт ч гэсэн хүмүүсийг амь хороож болохгүй гэж сургажээ. Арван сахилын нэгдүгээрт, амь хороож болохгүй гэж тогтоосон байдаг. Гэтэл ихэнх хүн билиг нь нээгдээгүй болохоор үүнийг ойлгодоггүй. Харин амь хороож болохгүй гэдэг нь хүний амийг хороож болохгүй гэдгийг л хэлж байгаа хэрэг гэж үздэг. Эзэн Бурханы өгүүлсэн амь хороож болохгүй гэдэг нь үнэн хэрэгтээ зөвхөн хүний амь хороож болохгүй гэсэн төдий зүйл биш. “Амь” гэдэг нь бүх амийг хэлж байгаа хэрэг. Ямарваа амь насыг хөнөөх нь бүгд л амь хороож байгаа хэрэг билээ. Бурхан Багш бас амь хороож болохгүй гэж ярьсан бөгөөд зөвхөн хүн алахгүй л бол болчихно гэж хэлээгүй, харин ямарваа амь насыг хороож болохгүй гэжээ.

“Бид амь хороож болохгүй гэдэг сахилыг сахиж байглаа яагаад ургамлыг үндэстэй нь зулгааж иддэг вэ? Ингэх нь амь хороож байгаа хэрэг биш үү?” гэж зарим хүн надаас асуудаг. Ингэж ярихад бас зөв юм бий, гэтэл нэг ширхэг өвсийг зулгаах болон нэг тахианы хүзүүг огтлох хоёр нь адилгүй. Өвсөнд амьтан шиг тэгж их өвдөж шаналах мэдрэмж байдаггүй. Гэхдээ өвсийг зулгаасны дараа дахин ургуулж болох бөгөөд урьдахаасаа бүр ч сайн ургаж төлжиж ч магад. Гэтэл тахианы хүзүүг огтолсны дараа дахин ургах боломжгүй. Ургамал болон амьтны ялгаа үүнд л байгаа билээ. Ургамлын биед зуун хувийн ер хувь нь ус болохоор амьтан шиг тэгж их зовж шаналах мэдрэмжгүй. Гэтэл амьтны үзэл ухамсрын хэмжээ нь хүнийхээс тийм ч доогуур биш. Хүн төрөлхтөн билиг ухаан, сүнслэг ухамсар болон бурхан чанараар өндөр дээд болохоор хүний амийг хороохын ял гэм маш хүнд байдаг.



САХИЛ САНВААРЫН ЖИНХЭНЭ УТГА УЧИР

*Төгс гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Америкийн Калифорни мужийн Санта Ана хот
1989 оны 12 дугаар сарын 3
(Эх нь вьетнам хэлээр)*

*※ Сайн болон мууг ялган танихдаа уг зорилгыг нь
харах хэрэгтэй, харин гаднах үйлдлийг нь харах биш.*

Та бүхний номын сэтгэл бялхам байгаа болон намайг баярлан угтаж байгаад маш их баярлаж байна. Өчигдөр Панамд сайн амарч чадаагүй, хоол унд нь аятайхан биш байсан болохоор өнөөдөр бие жаахан ядарч байна. Хэрвээ ямар нэг юм орхигдуулбал та нарыг уучлан өршөөгөөсэй гэж хүсье.

Бурханы хутагт хүрсэн хүн бол дотооддоо нэгэнт бурхан болж, билиг ухаан нь хөгжин тэлсэн хэдий ч махан бие нь мөн л эгэл хүн хэвээр байдаг тул заримдаа бас ядарч цуцдаг. “Мөр ёсыг бясалгагчид яагаад бүгд ширүүн зантай байдаг вэ?” гэж зарим хүн багшаас нь асуудаг. Ширүүн зантай биш, харин нөхцөл байдлаас болж тийм болдог юм. Жишээлбэл, шавь нар нь дэндүү олон асуулт,

бясалгалтай холбогдолгүй зүйлийг асуудаг болохоор тэд уурладаг. Гэхдээ энэ бясалгагчид байхгүй бол бурхны ном ч тасарчихаж мэднэ, тиймээс бид мөн л тэднийг хүндэтгэх хэрэгтэй. Намайг хүндэтгэх хэрэгтэй гэж байгаа юм биш шүү! Тэр бясалгагчдыг хүндэтгэх хэрэгтэй. Та нар намайг нэгэнт ихэд хүндэлчихсэн, үүнээс илүү зүйлийг би хүсэхгүй. Гэрээс гарагчийн үүрэг хариуцлагаа сайн гүйцэтгэж чадахгүй байх вий гэдгээс л санаа зовж байна.

Ном тайлахаас өмнө эхлээд ном сонссоны дараа бүгдээрээ гэгээрэх болтугай гэж хамаг бурханд хүсэн даатгая! Тэгвэл энд хүрэлцэн ирж ном сонссон та бүхний чин сэтгэлийг хөсөрдүүлэхгүй болно.

Буддын шашинд тун олон сахил санваар байдаг бөгөөд сахихад тун амар хялбар биш гэж ихэнх хүн үздэг. Багш нь үсээ хусуулж, гэрээс гарахаасаа өмнө гэртээ аль хэдийн мөр ёсыг бясалгаж, ургамал хоол иддэг байсан. Удаан хугацаагаар ургамал хоол идэх нь миний хувьд тун хялбар хэрэг. Гэтэл та нарын хувьд харин нилээд хялбар бус байж ч магад. Та нар заримдаа ургамал хоол идэх дургүй байдгийг багш нь мэднэ, гэвч та нарын нинжин сэтгэл хүлцэж чаддаггүй болохоор ургамал хоол идэх нь илүү дээр, дэлхий дээр хялбар үйл хэрэг гэж байдаггүй, намайг дөнгөж эхлэн бясалгаж байх үед бас тун олон саад бэрхшээл тохиолдож байсан. Багш бол тэнгэрээс бууж ирэн хүн болж мэндэлсэн болохоор ямар ч саад бартаа тохиолдох боломжгүй гэж та нар битгий бодоорой!

Сахил баримтлахад хамгаас түрүүнд өөрийн биеэсээ эхлэн муу муухай дадал зуршил болон алдаа дутагдлаа өөрчлөх хэрэгтэй. Бид анх эхээс төрөх үед зөвхөн эхийн сүүгээ л хөхдөг байснаа хожим нь алгуураар хоолонд орж, мах идэх дадалтай болдог. Тэгсээр байгаад улам улам олон дадалд автаж, найзуудтай болж, ихэд идэж уун цэнгэлдэж найрладаг болчихдог. Гэхдээ энэ дадал зуршил нь бүгд л

хожуу суусан зүйл боловч дадал болчихсоны хойно халж өөрчлөхөд маш хүнд хэцүү байдаг. Муу муухай дадал зуршил нь бүгд л бусдын муу нөлөө болон гадаад орчноос нөхцөлдсөн. Харин төрөлхийнх биш. Бидний уг чанар үнэндээ маш сайн гэдгийг тов тодорхой танин ойлгохын зэрэгцээ өөрийн биедээ бат итгэвэл муу дадлаа алгуураар өөрчилж, бие, хэл, сэтгэлээ ариусгаж чадна.

Багшийн сахил хүртсэн түүх

Багш нь гэрээс гарахаасаа өмнө аль хэдийн гэртээ өөрөө мөр ёсыг бясалгаж, олон жилээр ургамал хоол иддэг байсан, үргэлж сүм хийдэд очиж Бурханд мөргөдөг байлаа. Нэг удаа би хамгийн анхны багштайгаа уулзсан юм, тэр бол нэгэн гэлэнмаа бөгөөд надад сахил хүртээсэн.

Тухайн үед би түүнээс: “Яагаад таван сахилыг мөрдөх хэрэгтэй вэ? Одоогийн энэ хэвшил байдал маань нилээд сайн болчихсон юм биш үү?” гэж асуухад тэр: “таван сахилыг мөрдсөний хойно л жинхэнээр сайн болно, та таван сахилыг мөрдсөнийхөө дараа л ойлгож мэднэ. Буддын шашны шавь болоход зөвхөн бурханд мөргөж ургамал хоол идвэл л болчих биш, бас таван сахилыг мөрдөж байж л жинхэнэ Буддын шашны шавь болсонд тооцогдоно” гэсэн билээ. Тэгэхэд нь би: Сахил сахисан ч яах вэ дээ! Ямар болохгүй хэрэг биш гэж бодсон. Гэтэл багш ширээ алгдан чанга дуугаар: “Сахил мөрдөхөөр сэтгэл шулуудсан уу, үгүй юү?” гэж асуухлаар нь би хожим сахилаа сахиж чадахгүй болов уу гэхээс айчихсан.

Таван сахилыг мөрдөн баримтлах хүмүүсийн ихэнх нь махтай хоол идэж болдог, зарим хүн өөрөө хүн, амьтны амийг хороохгүй л бол бусад хүн амь тасалж бидэнд идүүлэхэд ер хамаа ч үгүй гэж үздэг болохоор маш олон хүн үргэлжлэн мах иддэг. Тэр үед би нэгэнт олон жилээр ургамал

хоол идчихсэн болохоор нэгдүгээр сахил “амь хороохгүй”-г сахихад нилээд хялбар, хоёрдугаар сахил “хулгай дээрэм хийхгүй”-г сахихад асуудалгүй, гуравдугаар сахил “садар самуун явахгүй” ч мөн ч хялбар хэрэг, гэтэл дөрөвдүгээр сахил “худал ярихгүй” болон тавдугаар сахил “архи уухгүй” нь миний хувьд жаахан төвөгтэй болчихов. Яагаад гэдгийг та нар мэдэх үү? Би багадаа Вьетнамд байх үедээ урт, шулуухан үстэй байсан. Хожим нь тайруулсан юм. Бас нэг нь би угаас цав цагаан царайтай мөртлөө ихэд гоёж гооддог байлаа. Энэ бүхнийгээ би худал ярьж байна гэж үзсэн хэрэг. Тиймээс сахил хүртээх багш надаас гурвантаа асуух үеэр хэлээ хазсан.

Сахил хүртээх үед их багш ширээ алгадан чанга дуугаар: “Сахил сахихаар бэлтгэчихсэн үү?” гэж асуух үед хэн хүн хэрвээ: “бэлтгэчихсэн” гэж гурвантаа хариулбал сахил баримтлахаар сэтгэл шулуудсаныг нь илэрхийлж байгаа хэрэг билээ. Эхний удаа асуух үед нь би жаахан бодолхийлжээ. Хоёр дахь удаагаа асуух үед нь би мөн л бодсоор байсан бөгөөд гурав дахь удаагаа асуух үед нь мөн л хариу өгч чадаагүй. Тэгэхэд их багш намайг сахил сахих эрх байхгүй гэж бодсон тул хүртээж зүрхлээгүй. Азаар их багштай уулзахаасаа өмнө би эхлээд өөр нэг гэлэнмаагаас: “Зарим сахилыг сахиж чадахгүй бол явал зохистой вэ?” гэж асуухад тэр: “Сахиж чадахыгаа чадна гэж хэлээд чадахгүйдээ хариулж хэрэггүй” гэсэн юм. Хариулахгүй ч гэсэн болох юм чинь эхлээд сахил хүртчихээд дараа нь шийдье гэж би бодсон болохоор хоёр удаа хариулаагүй.

Багш минь яагаад надад сахил хүртээх гэсэн юм бол гэдгийг би мэдэхгүй байв. Би нэгэнт олон жил ургамал хоол идсэн, бас ном дэлгэрүүлэхэд байнга тусалж, сүсэгтнүүдийн асуултад хариулдаг байсан юм. Хэрвээ надад сахил хүртээхгүй бол энэ нь нүүрээ барсан хэрэг болно гэж тэр бодсон байж ч магад. Ихэнх хүн нэр алдрыг тун чухалд

үзэн: “Та сахил хүртчихсэн үү? Номд орсон уу? Аль багшид шавилсан бэ?” гэж байнга асуудаг. Бид хэрвээ номд ороогүй гэвэл хүмүүс чамайг Буддын шашны жинхэнэ шавь биш, “хожуу сахил авсан энгийн хүн” гэж үздэг болохоор тэр гэлэнмаа намайг сахил хүрт гэж сануулсан байх.

Би өөрийгөө сахилыг чанд сахиж чадахгүйгээ мэдэж байсан, учир нь тухайн үед аль хэдийн ургамал хоол иддэг хэдий ч бас архи уудаг байсан, тэр үед би жаахан архи уух нь амь хороох үйл ч биш (багш инээв) ямар хамаа байх вэ? гэж боддог байж. Гэхдээ би гэр бүлтэй, эр нөхөр маань эмчийн ажилтай, найз нөхөдтэй, тэд маань үргэлж манайхаар айлчилдаг, тэд надад архи барихаар нь жаахан ч гэсэн уухгүй бол ёс алдсан хэрэг болно, гадаадын хүн болон гэрээс гараагүй хүмүүсийн хувьд жаахан архи уух нь тун энгийн хэрэг, согтохгүй л бол болчихно. Тэгсэн хэр нь би архи уухгүй гэдгээ нөхөртөө мэдэгдэх дургүй байсан, намайг бусадтай найзалж нөхөрлөх талаар тааруухан гэж бодохоос санаа зовж байсан хэрэг. Тийм болохоор сүүлийн хоёр сахилыг асуух үеэр хариу хэлээгүй юм. Тэр үед би сахил санваарын жинхэнэ утга чанарыг тийм сайн ойлгохгүй, гоёж гоодвол бясалгагч гэж тооцогдохгүй гэж боддог байв. Мэдээжээр одоо Багшийнх нь үзэл тэр үеийнхээс өөр болжээ.

Сахил санваар нь хүмүүсийг хамгаалахын төлөө байдаг

Нэгдүгээр сахил бол “амь хороохгүй” юм, англиар Non Violence гэдэг. Хүчирхийлэлгүй гэсэн утгатай. Хүчирхийлэлгүй гэдэг нь хүн таныг зодсон ч эсэргүүцэхгүй, цус нөж болтол зодсон ч хөдлөхгүй байх явдал гэж ойлговол буруу шүү. Хууль дүрэм нь хүмүүсийг хамгаалахын төлөө зохиогдсон, харин хүмүүс хууль дүрмийг аялдан дагахын төлөө биш. Жишээлбэл, хүн бидний хүүхдийг зодох, эд

хөрөнгийг чинь булаан дээрэмдэх, эхнэр хүүхдийг чинь гутаан доромжлох үед бид бас тоох ч үгүй байж болох уу? Ингэж болохгүй шүү! Харин тэднийгээ хамгаалах хэрэгтэй.

Бас нэг жишээ хэлье: усанд живж байгаа хүнийг аврахад эхлээд түүнийг цохиж ухаан алдуулах хэрэгтэй байдаг. Эс бөгөөс хоёулаа живж үхэх аюултай, усанд живж байгаа хүн аврахаар ирсэн хүнийг харангуутаа түүнээс хамаг чадлаараа тас зуурчихдаг болохоор хоёулаа живж үхэх ч хэрэг гарч мэднэ, тиймээс заавал эхлээд түүнийг цохиж, ухаан мэдээ алдуулах хэрэгтэй. Ингэх нь хүчирхийлж байгаа хэрэг биш. Эсвэл дайнд оролцсон цэрэг эрс бол улс орноо хамгаалахын төлөө дайтаж байгаа тул бас хүчирхийлэл үйлдэж байгаад тооцогдохгүй. Учир нь тэд өөрсдөө дайтах дуртайдаа биш, хүн алах дуртайдаа биш, харин улс орон, элэг нэгтэн болон ядуу дорой ард иргэдээ хамгаалахын төлөө аргагүйн эрхээр дайтаж байгаа бөгөөд уур хилэнгээсээ болж хүчирхийлэл үйлдэж байгаа ч биш, ойлгож байна уу?

Нэгдүгээр сахил бол хүчирхийлэхгүй байх, гэхдээ эсэргүүцэхгүй гэсэн утгатай биш. Одоо Багш нь үүнийг бүр ч сайн ойлгодог болсон. Урд нь би хүчирхийлэлгүй байх гэдгийг бусдад зодуулсан ч эсэргүүцэхгүй байх явдал гэж ойлгодог байсан. Зарим гэгээнтэн үнэхээр өчүүхэн ч эсэргүүцдэггүй, тухайлбал Шагжамуни Бурхан, Арьяабал Бурхан, тэд энэ дэлхийд ирэхдээ ямар ч нөхцөл байдал тохиолдсон ерөөс эсэргүүцдэггүй. Есүс Христ ч бас тийм. Үнэндээ эсэргүүцсэн ч бай, эсэргүүцээгүй ч бай бас л үйл түйтгэрт орооцолддог. Энэ ертөнцөд мэндэлмэгц л бурхан сахиусыг хичнээн хүндэтгэн шүтсэн ч үйл үрээс мултарч чаддаггүй.

Үйл үрийн сансрын хүрдэнд дахин эргэлдэж зовлонд өртөхгүй байя гэвэл жаахан дээд дэсийн аргаар бясалгаж, Бурхантай нэг цогц болж, Бурхантай нэвтрэлцэхийг

бодоорой! Яавал Бурхантай холбогдож харилцаж чадах вэ? Буддын шашны ном сударт: “Мөргөж байгаа, мөргүүлж байгаа хоёр нь мөн чанартаа хоосон, чимээ аниргүй. Үнэн Ном болон түүнийг сэхээрэн хүртэх нь хоорондоо төсөөлөхөд ч бэрх байдлаар сүлжилдсэн байдаг. Миний энэ Бодьманда (сэхээрлийн газар, биет сүм) бол Индра Бурханы сувд эрдэнэ мэт, түүн дотор ертөнцийн арван зүгийн хамаг Будда заларч байдаг. Хамаг Буддын өмнө энэ бие цогцсоороо зогсож, өлмий дор нь мөргөн залбирахдаа би амьдралдаа эргэж буцаж ирдэг”. (“Самандбадраа хааны Арван аугаа ам тангараг”, “Арьяабал Бодьсадва хорт самади дхарани-г устгасан нь”, “Сайн болон муу үйлийн үрийн хойноос хөөцөлдсөний шийтгэл хэмээх судар”-аас) Чухам “Хамаг Буддын өмнө энэ бие цогцсоороо зогсож”, Будда болон Диваажинтай хамт байх тэр төлөв байдалд хүрсэн үедээ л бид “Тэдний өлмийд сөгдөж, мөргөн залбирахдаа амьдралдаа эргэж буцаж ирдэг” гэж хэлж болно. Энэ нь бид Буддаг тов тодхон харж байгааг маань илтгэн харуулах бөгөөд тэр цагт л бид Тэдэнд хүндэтгэлээ илэрхийлж чадна. Гэвч бид Буддаг тод харж чадахгүй байх нь олонтоо, тийм учраас бид хүндэтгэлээ модон Бурхан, хүрэл Бурханд илэрхийлдэг.

Заримдаа Багш нь шавьдаа Бурханы хөрөгт мөргөх хэрэггүй гэж хэлдэг нь зөвхөн зарим нэг хүнд л хандаж хэлсэн зүйл болохоос биш бүх хүнд хандаж хэлсэн юм биш. Бурханд мөргөхийг Багш нь эсэргүүцэхгүй, бурханд мөргөх нь тун сайн. Гэтэл зарим хүний сэтгэл дэндүү их баригдаж хүлээслэгддэг болохоор Багш нь Бурханы хөрөгт мөргөх хэрэггүй гэж хэлдэг. Тийм хүмүүст ингэж хэлэхгүй бол хүлээснээсээ мултарч чадахгүй, модон бурхан бол бурхан мөн гэж үзэж итгэдэг. Ийм үзэл бол үнэхээр огт буруу бөгөөд жаахан сэргэлэн ухаалаг хүн бол ингэж бодохгүй. Гэтэл зарим хүн үнэндээ модон бурхныг бурхан гэж сүсэглэн

хамаг бүхнээ өмнө нь өрж, өргөл болгон тахиж, түүнд мөргөн залбирч байдаг.

Бид бурханд мөргөдөг нь бурхныг санан дурсахын төлөө, өөрийн биедээ бясалгал хийхийг сануулж байгаа хэрэг. Харин мөргөж сөгдсөнөөр л Буддын шашинтан гэж тооцогддог биш юм. Бурхны хөрөг нь үнэхээр жинхэнэ бурхан сахиустай юм бол дэлхий дахин тун олон бурхантай болчих биш үү? Сүм хийдэд бурхан сахиусны хөрөг маш олон, нэгийг худалдан аваад ирэхэд л болчих байтал яах гэж бас бясалгал хийх хэрэгтэй байх вэ?

Амьд сэрүүн байгаа Бодьсадваг хайх нь

Хэннэгэнбясалгалхийгээдбурхныдэс,Бодьсадвагийн дэс, аршийн дэст хүрсэн гэж ярьж байхыг сонсоход зөвхөн тэд л тийм дэст хүрч чаддаг, зөвхөн Шагжамуни Бурхан л бурханы хутагт хүрч чаддаг гэж үздэг аж. Үнэндээ тийм биш. “Олонх бурхант судар”-г: аль цаг үед ч Бурхан Бодьсадва илэрч, жинхэнэ номыг хамгаалдаг, Бодьсадва газрын гүнээс илрэн гарч, үнэн ёсыг хамгаалан үнэн номыг уламжлан дэлгэрүүлж, үнэн ёсыг алдагдуулдаггүй гэж тэмдэглэсэн байдаг. Газрын гүнээс илэрсэн тэдгээр Бодьсадва хэн юм бэ? Бид өөрсдөө мөн.

Бид энэ хорвоо дээр амьдарч буй шалтгаан бол газраас өндийсөн Бодьсадва гэдгээ батлах гэж, ядаж л газраас мандсан тэр Бодьсадваг олж, тэднийг дагахын төлөө билээ. Буддын шашны сударт ийм тодорхой заасан байтал яагаад бид амьд сэрүүн Бодьсадваг хурдан эрэлхийлэхийн оронд энд модон Буддадаа мөргөсөөр байна вэ?

Бодьсадва тун олон, хаа сайгүй байдаг. Багш нь Энэтхэгийн Ганга мөрний эрэгт хүрсэн, Ганга мөрөн асар том бөгөөд элс ихтэй, Бодьсадва нар яг л Ганга мөрний элс шиг олон, тоолохын аргагүй гэдгийг Бурхан нэгэнт

бидэнд маш тодорхой хэлчихжээ. Хэрвээ эрж хайхгүй бол өөрсдөө л хохирно. “Аль ч цаг үед ч гэсэн Бурханы хутагт хүрсэн хүн байсан” гэж Бурхан Багш хэлсэн байна. Хамаг төрөлтөн бүгд л бурхан чанартай, бурхан чанар хэзээд мөхөж устдаггүй. Зөвхөн зөв бясалгалын арга болон Төгс Гэгээрсэн Их Багшийн хүчээр л бид бурхан чанараа агшин зуур нээж, уг дүрээ харж чадна.

Багш чинь ч гэсэн хамаг төрөлтөн бүгд Бурхан чанартай, эрх тэгш, ямар ч ялгаагүй гэж ярьдаг. Гэтэл та нарт харин: “Тэр яагаад өөрийгөө Бурханы хутагт хүрсэн гэж ярьдаг юм?” гэж сэжиг төрдөг. Бурханы хутагт хүрчихсэн юм чинь хүрсэн л гэж ярина шүү дээ. Тийм ч их гайхмаар хэрэг биш. “Бурхан сэтгэлд байдаг”, Бурхан бидний дотоодод байгаа юм чинь яагаад Бурханы хутагт хүрч болохгүй гэж? Бид эгэл хүн болоод аль хэдийн дадчихсан болохоор “Дотоодын бурхан”-аа эрж хайя гэсэн бодол төрдөггүй, эсвэл өөр хүн бүхэн надаас сэргэлэн ухаантай, би Бурханы хутагт хүрэх боломжгүй гэж өөрийгөө голдгоос болсон ч байж мэднэ.

Саяхан Багш нь тухайн үед хоёр зүйлийн сахилыг сахиж чадахгүй байсан гэж ярьсан. Учир нь заримдаа би хүмүүстэй уулзаж ярилцах шаардлагатай болохоор жаахан гоёж гооддог байжээ. Гэхдээ өөрөө дуртайдаа биш. Тухайн үед би гоёж гоодохыг худал ярихтай адил гэж үздэг байсан болохоор өөрийгөө уучилж чадаагүй юм. Харин Бодьсатва уучилж өршөөхгүйд биш. Үнэн хэрэгтээ гадна төрх дотоод сэтгэлд нөлөөлөхгүй. Бид гадна төрхөө гоёж гоодоход хүлэгдээд байвал чухам хэзээ бясалгаж чадах юм бэ? Тэгээд үүний учрыг бид сайн ойлгохгүй, гоёж гоодох нь сайн биш гэж үздэг болохоор өөрийгөө дорд үздэг. Яагаад өөрийгөө дорд үзнэ вэ? Бид цөмөөрөө тархиа угаалгачихсанаас болж байгаа юм. Гоёж гоодохыг алдаа буруу гэж үзэж, өөрийгөө буруу муу хэрэг хийж байна гэж боддог.

Сайн болон мууг ялган танихад зорилгыг нь харах хэрэгтэй. Харин үйлдлийг нь харах биш. Жишээлбэл, бусдын сэтгэлийг татахын төлөө гоёж, гэр бүлийнх нь эв зохицлыг эвдэж нураах нь муу хэрэг. Хэрвээ энгийн хүмүүс шиг бага зэрэг гоёж, хүмүүс харахад нь тааламжтай санагдаж, ажлын урам зориг сэргэж байгаа бол бас ч гоё шүү дээ! Энэ дэлхийд гоё сайхан зүйлс угаасаа хомс байхад гоёж чимэхийг хасчихвал үнэндээ сайн сайхан гэж ярмаар зүйл ч алга болно, тийм үү, үгүй юү? Тиймээс бага зэрэг гоёж гоодох нь тийм ч их айхтар хэрэг биш.

Гэтэл Багш нь урьд нь үүнийг сайн ойлгоогүй, тэр үед би ажилтай, эр нөхөртэй байлаа, хэрвээ гоёж гоодоогүйгээс минь болж эр нөхөр маань зугтчихвал миний л буруу болно, тийм үү, үгүй юү? Тиймээс та нар бүгд гоёж гоодож болно (Багш инээв). Бид гэрлэлтийнхээ зол жаргалыг хамгаалах хэрэгтэй. Хүмүүс бүгд л гоёж гоодож байхад та харин өөрөө зориуд муухай дүртэй явбал, эр нөхөр чинь голоод зугтчихаж мэднэ, тэгвэл яах билээ?

Сахил санваар нь нийгэм олныг хамгаалахын төлөө зохиогдсон зүйл. Жишээлбэл, “хулгай дээрэм хийхгүй” гэх сахил нь бас тийм. Үнэндээ бид хулгай дээрэм хийсэн ч бурхан ер уурлахгүй, бурхан зөвхөн хүмүүсийг хайрлахаас биш уурладаггүй. Гэтэл бид нээрэн хулгай дээрэм хийснээс болж баригдаад шоронд орвол зовлон амсах нь хэн байх бэ? Бурхан Бодьсадва бидний юу хийхийг огт хамаардаггүй, харин үйл үрийн хууль дүрэм л биднийг өөрийгөө залхаан шийтгэхэд хүргэдэг.

Бурхан энэ ертөнцөд ирдгийн зорилго

Бурханд мөргөх нь ач тустай байдгийн шалтгаан нь бид бурхны мөр ёсыг хүндэтгэн биширч, бурхны сургаал ёсонд суралцан сахил санваарыг сахихад оршино. Гэтэл

бурхан бол “хамаг төрөлтнийг гэтэлгэх”-ийн төлөө, өөрөөр хэлбэл, хамаг төрөлтөнд “Бурханы сургаалыг ойлгуулах” гэж л энд ирсэн гэдгийг бид бас мэдэж байх хэрэгтэй. Би энэ ертөнцөд ирсний зорилго нь хүн бүхэнд бурхны билиг ухааныг олгож, бүгдээрээ бясалгал хийж, Бурханы хутагт хүрэхийн төлөө юм гэж Бурхан Багш хэлжээ. Бурхан Багш энэ ертөнцөд ирсэн нь биднийг түүнд ёслол мөргүүлэхийн төлөө биш бөгөөд ертөнцийн жаргалыг эдлэхийн төлөө ч биш, харин биднийг өөрийн бурхан чанараа таньж, хүн болгон бүгд л бясалгал хийж Бурханы хутагт хүрч чаддаг гэдгийг ойлгуулж мэдүүлэхийн төлөө билээ.

Шагжамуни Бурхан нирваандаа буцаагүй байхдаа гэгээнтэн Махакасьяапаг урьж хажуудаа суулган шавь нартаа хандаж: “Би бясалгал хийж Бурханы хутагт хүрч чадсан, Махгашив ч адилхан тэгж чадна” гэж хэлжээ. Үүнээс бид хүн бүхэн бүгд л бясалгал хийж Бурханы хутагт хүрч чадна, харин зөвхөн Шагжамуни Бурхан л хүрч чаддаг тийм зүйл биш гэдгийг ойлгож болно. Гэтэл Буддын шашинтай ихэнх хүн үүнийг бүгдээрээ мартчихаж, хэн нэгэн хүн Бурханы хутагт хүрсэн гэж сонсонгуутаа ихэд цочин гайхаж: “Бурханы хуггийг олчихсон гэнэ үү? Яасан их үг ярьдаг онгиороо хүн бэ?” гэдэг.

Есүс Христ ч гэсэн: Би бол Эзний ганц хүү, Эзэн Бурханы хүү мөн гэжээ. Энэ нь тэр бол Эзэн Бурхантай нэгдэж, нэг цогц болчихсон гэсэн утгатай. Эцэг тэнгэр бол хамгийн дээд бурхан, Оройн дээд төгс гэгээрэл, үнэн ёсыг бүрмөсөн ойлгож, бүрмөсөн гэгээрсэн хүн мөн, бас хамгийн дээд Эзэн Бурхан гэж нэрлэдэг, үнэндээ нэрийдэл нь л ондоо төдий.

Шагжамуни Бурхан Буддагийн дэст хүрэх үед тухайн үеийн хүмүүс бас түүнд итгэдэггүй байжээ. Шагжамуни Бурхан: “Би нэгэнт Бурханы дэст хүрсэн” гэж хэлэхэд хүмүүс: “Та чинь бидэнтэй адил эгэл хүн шүү дээ, яаж

Бурханы дэст хүрч чадах вэ?” гэж эргүүлэн асууж байжээ. Есүс Христ ч гэсэн: “Би бол Эзэн Бурханы хүү мөн, би бол үнэн ёс, зам мөр мөн” гэж ярихад хүмүүс итгэхгүй байжээ. Итгэх хүмүүс байсан ч тун цөөн. Тиймээс тэр загалмай модонд цовдлуулсан. Энэ бүхэн нь бурхан сэтгэлд байгаа гэдгээ мартчихсанаас болжээ. Библи сударт: “Диваажин бидний дотоодод бий” гэжээ. Энэ тухай зөвхөн Шагжамуни Бурхан л ярьсан юм биш, Библи сударт бас ингэж өгүүлжээ, гэхдээ: бие цогцос бол нэгэн сүм дуган шиг, Эзэн Бурхан түүний дотор бий гэж тодорхой хэлжээ.

Бурхан багш бас хүний бие бол нэгэн зүйлийн сүм хийд мөн гэж хэлсэн байна. Гэтэл бид харин өөрсдийн дотоодын сүм хийдээ мартаад өөрсдөө мөн Бодьсадва, архад, маш эрхэм дээд төрөлтөн болохоо мартчихжээ. Будда болсон бүх хүн та нар бас бурхан мөн гэдгээ бат цээжилж бай гэж ярьдаг. Тэгвэл өөрийгөө бурхан гэдгээ яаж санаж олох вэ? гэвэл “гэгээрвэл” л болчихно, тун хялбархан. Яг л бид хэр удтал хар дарж, хэр их муу зүүд зүүдэлсэн ч зүүднээсээ сэрмэгц юу ч үгүй хоосон болчихдогтой адил.

Багшийгаа дагаж бясалгадаг хүмүүс яагаад бүгд л дэвшилттэй байдаг вэ? Саяхан илтгэл хийсэн тэр авшигтан дөнгөж сар илүү бясалгаж байгаа ч тун дэвшилттэй, санаа бодол нь өөрчлөгдсөн бөгөөд тачаал шунал нь ч багасаж, идэх унтах нь багасаж, мөнгөнд шунахаа ч больжээ. Яагаад ийм болов гэвэл түүний билиг нээгдэж, уг чанар нь эд мөнгөнөөс бүр ч илүү ховор нандин, эд баялгийн жаргалаас бүр ч илүү эрхэм дээд гэдгийг ойлгожээ. Билиг нээгдсэний хойно бид алгуур аажмаар өөрийгөө хайж олон өөрийгөө хэн болохоо мэдэж, муу дадал аяндаа багасдаг. Яг л наран мандвал харанхуй арилан одохтой адил. Энэ бол аяндаа болдог хэрэг. Багш нь ямар нэгэн увдис болон ид шид хэрэглэж, хүмүүсийг Бурханы хутагт хүргэдэг биш, харин тэр өөрөө өөрчлөгдсөн байна, ойлгож байна уу?

Билиг ухаан бол өөрийнх чинь, бурхан чанар бол өөрийнх чинь гэдгийг бясалгагч хүн мэдэх хэрэгтэй. Тиймээс багш нь өргөл барьц авдаггүй, яагаад гэвэл би авахаасаа ичнэ. Та нар шинэхэн цэцэг, амтат жимс өргөж, багшийгаа чин сэтгэлээсээ баярлан угтаж, Калифорни мужид суугаа Вьетнамчуудын хайр хүндэтгэлийг илэрхийлж байгаа хэрэг. Гэтэл энэ бүхнийг багш нь хүсээгүй, би нэгэнт Бурханы хутгийг олчихсон болохоор та нар шинэхэн цэцэг, амтат жимс өргөх хэрэгтэй гэж Багш нь ерөөсөө боддоггүй. Багш нь тун ичимхий болохоор багшийгаа тэгж ихээр сайшаан магтах хэрэггүй. Надад гавьяа зүтгэл гэмээр зүйл байхгүй. Бурханы хутагт хүрэх нь аяндаа болдог хэрэг. Бурханы хутагт хүрэх, Бодьсадвагийн хутгийг олох, ямар нэгэн дэсийг олох зэрэг нь бүгд сайн. Бид юу сурна, түүгээрээ мэргэшдэг болохоор бардамнах хэрэг алга. Яг л хэдэн арван жилээр эмчийн мэргэжил суралцаад хэзээ нэгэн өдөр эмч болдогтой адил, хуульчийн мэргэжил сурвал хуульч болно. Бурханаас суралцвал Бурханы дэсийг олно. Энэ нь өчүүхэн ч гайхмаар хэрэг биш (Бүгдээр инээлдэхийн зэрэгцээ алга ташив).

Бид бясалгах тусам толгой тархи сэргэг болдог. Толгой тархи сэргэг болох тусмаа хүч чадалтай болж, амьдрал ахуйгаа улам сайнаар зохицуулдаг болно. Билиг ухаан улам нэмэгдэж, ямар ч асуудал тулгарсан тэр дор нь шийдвэрлэж чадна. Гэгээрсний хойно билиг ухаантай болно. Билиг ухааныг Бурхан Бодьсадва бидэнд соёрхон өгдөг юм биш. Гэвч бид Бурхан Бодьсадвад баярлан талархах нь буруу биш, харин билиг ухааныг тэр бидэнд соёрхон өгсөн биш гэдгийг мэдэж байх хэрэгтэй.

Яг л бид эмчээс эмнэлгийн мэргэжил суралцаад дараа нь эмч болдогтой адил. Эмч бие сэтгэлээ зүдрээн байж бидэнд эмчийн мэргэжил заасан болохоор түүнд баярлаж талархах нь зөв. Гэвч бид бас өөрөө чармайн судалж, чин

сэтгэлээсээ хичээнгүйлэн суралцаж байж л эмч болдог. Харин зөвхөн онол сонсож, өнгөн талын зүйлсийг сураад л амжилтад хүрчихдэг биш билээ. Эмч болоход зөвхөн алдартай эмчид шавилаад л болчих биш. Заавал өөрийн биедээ түшиж, чармайн суралцах хэрэгтэй.

Үүнтэй адил, бид нэгэн их багшаас суралцах нь түүн шиг багш болохын төлөө л юм. Харин насан туршид түүний боол болох гэж биш, бид бурхнаас суралцах нь бурхантай адил болохын төлөө болохоос харин насан туршид түүний боол болох гэсэн хэрэг биш. Бид бурхан болж чадахгүй бол бурхан ихэд шаналан зовно, бид хичнээн ёслон мөргөсөн ч ямар ч хэрэггүй.

Яг л та хэн нэг эмчээс олон жилээр анагаах ухааны мэргэжил сурсан ч эмч болж чадаагүйтэй адил, ингэвэл тэр эмч баярлана гэж үү? Та өдөр бүр түүнд бэлэг сэлт хүргэж: “Таны ангаах ухааны мэргэжил үнэхээр сайн аж, дэлхийд хосгүй хувилгаан эмч байна” гэж магтан чин сэтгэлээр асран хамгаалсан ч тэр баярлахгүй. Тэр таныг анагаах ухаан сурч, амжилтад хүрч, ажил үйлсийг нь залгамжилж, өвчтөнийг эмнэж, гэрийнхээ хүмүүсийг эдгэрүүлж, өөрийгөө эмчлээсэй гэж хүсэж байгаа, ингэвэл л сая баярлана, тийм үү, үгүй юу? Шавь нь гарамгай сайн эмч болж, өвчтөнийг түүн шиг авран туслаасай гэж л бодно.

Бясалгал хийх нь бурхны дэст хүрэхийн төлөө юм гэдгийг бүгдээр хэзээ ямагт санаж яваарай! гэж би хаа ч очсон бүгдэд нь ингэж хэлдэг. Бурханы хутагт хүрэхэд маш сайн нэг арга байдаг. Энэ нь юу вэ гэвэл: бусдаасаа суралцах. Яг л эмчийн мэргэжил сурч байж л эмч болдогтой адил. Бурханы хутагт хүрэхэд бурхнаас суралцах хэрэгтэй, эсвэл тэр бурхнаас суралцаад амжилтад хүрсэн хүмүүсээс: “Танд Бурханы хутагт хүрч чадах бясалгалын арга байгаа юу?” гэж асууж болно. Хэрвээ байхгүй гэвэл өөр хүнийг хайна биз дээ.

Анагаах ухааны мэргэжилд суралцахад ч гэсэн анагаах ухааны дээд зэргийн сургуульд суралцах хэрэгтэй байдаг. “Өөр хүн эмч болж байхад би яагаад болж чаддаггүй билээ?” гэж та ердөө л өөрөөсөө асуугаад л өнгөрч байсан бол үнэндээ та өөрөө эмчийн мэргэжилд сурах дургүйгээс болсон хэрэг. Сурах дуртай бол эмч болж чадна. Бид нэгэнт Бурханы хутагт хүрсэн хүнийг хайж олоод түүнээс суралцдаг л юм бол Бурханы хутагт хүрч чадна. Бурханы дэсийг олсны хойно энэ дэсийг өөрөө олсон, Бурханы хутгийг соёрхож өгч чадах хүн байхгүй гэдгийг мэдэх болно.

Бурханы дэст хүрэх арга

Ихэнх шашин суртахуун бүгд тун сайн, харамсалтай нь бүгд л амаар ярьсан сургаал номлол юм уу, ном дэвтэрт тэмдэглэсэн тайлбар төдий л байдаг. Хүмүүс уншсан ч жинхэнэ утгыг нь ойлгодоггүй. “Олонх бурхант судар”-т: “Аль ч цаг үед Бодьсадва үнэн ёсыг хамгаалахаар дэлхийд ирдэг” гэж тэмдэглэжээ. Бид яагаад тэднийг хайхаар очихгүй байна вэ? Ном судар уншаад яагаад эргэлзээ төрдөггүй вэ? Бурхан багш ингэж ярьсан юм бол тэр Бодьсадва нар хаашаа явчихсан юм бэ? Ихэнх хүн бүгд л бурхныг харахыг хүсдэг болохоор сүм хийдэд очиж бурханд мөргөдөг, тийм биз?

Зүүдэндээ ч болов бурхны гэгээн дүртэй ганц удаа ч болтугай уулзахыг чин сэтгэлээсээ хүсдэг хүмүүс их байдгийг багш нь мэднэ. Бид Бурхан Багштай уулзсан тэр хүмүүсийн ярьсан үлгэрийг уншсан. Тэр үлгэр бүгд л тун гайхалтай, сэтгэл хөдлөм бөгөөд бид ч бас Бурхан Багшийн үнэн дүрийг хармаар санагддаг. Та нарт бас ийм бодол төрдөг үү? Багш нь тэр судар номыг унших болгонд сэтгэл тун их догдолдог.

Бурхан Багштай хамт байж чадсан тэр хүмүүс тун их буянтай, тэд яагаад тийм азтай байж, өдөр бүр Бурхан

Багштай шадарлаж, ном тайлахыг нь сонсож, гэгээн дүрийг нь харж чаддаг вэ? Бид яагаад төрсөн цагаасаа хойш одоо болтол Бурхантай ерөөс уулзаагүй вэ? Бид ингэж бодож байвал хүсэл мөрөөдөлтэй гэдгээ илэрхийлж байгаа хэрэг. Хүсэж мөрөөдөж байвал ном судар уншина, ном сударт: Цаг үе болгонд Ганга мөрний элс шиг олон Бурхан Бодьсадва байдаг гэж тэмдэглэсэн, ийм байтал бид яагаад тэднийг эрж хайхгүй байна вэ? Үнэндээ тийм холоос хайх хэрэггүй. Учир нь бид өөрсдөө Бурхан Бодьсадва мөн, ядаж л архад мөн. Өөрийгөө хэн болохоо мэдье гэвэл билиг нээгдэж гэгээрвэл мэдчихнэ. Энэ нь тийм ч гайхмаар нууцлаг хэрэг биш. Бурханы хутаг, Бодьсадвагийн хутагт хүрэх нь гарцаагүй хэрэг.

Бид бүгд л дээд дэсийн ертөнцөөс хүний ертөнцөд мэндэлсэн хүмүүс. Энэ дэлхийд гэрэл гэгээ, сайн сайхныг авчирч, хүний ертөнцийн түмэн бодисын билиг ухааныг дээшлүүлэхийн төлөө ирсэн юм. Багш нь хэдийгээр жинхэнээр ном уламжлаагүй ч номын хурлын талбайд байгаа ихэнх хүний биеэс гэрэл цацарчихсан байна. Бид бясалгах тусмаа гэрэл гэгээтэй болж, бүх орчлонг гийгүүлж хангалттай чадна; энэ гэрэл рүү ирсэн хэн бүхний гэрэл нь асаж, сэтгэл нь баясаж, ариусан цэвэршинэ, тэд төөрөгдлөөс мултарч, билиг ухаан нь нэмэгдэж, хэзээ нэгэн өдөр бас Бурханы хутагт хүрч чадна.

Одоо дээрээ тэд бурхан биш шиг байгаа ч хэзээ нэгэн өдөр дээд дэсийн хүнтэй тааралдаж, түүнээс өөрийн бурхан чанараа хайж олох аргыг сурвал дорхноо Бурханы дэст хүрч чадна. Ихдээ л нэг хэсэг хугацаагаар бясалгасны хойно Бурханы дэсийг олж чадна.

Шагжамуни Бурхан зургаан жил бясалгаад Бурханы дэст хүрсэн. Бид алгуурхан бясалгаж гэж бодъё, тэгээд ихдээ жаран жилийн цаг хугацаагаар бясалгавал бас амжилтад хүрч чадна. Гэхдээ заавал Бурханы хутагт хүрэх оньсыг

хайх хэрэгтэй. Бясалгалд нууц жор байдаггүй гэж багш нь урьд нь боддог байсан. Одоо харин саяхнаас нууц жор гэж байдгийг мэдсэн. “Бурхан сэтгэлд байдаг” гэдэг нь гаднаас эрэх шаардлагагүй гэсэн утгатай билээ. Гэтэл ихэнх хүн үүний жинхэнэ утгыг ойлгожгүйгээр бясалгалын арга болон нууц жорыг хайх хэрэггүй гэж буруугаар ойлгодог байна. Бурхан сэтгэлийн аль хэсэгт байгааг та нар мэдэх хүсэлтэй байна уу? Билиг нээгдсэний хойно ойлгох болно оо.

Билиг ухаанаа бүрэн нээж ашиглахуй

“Бурхан сэтгэлд байгаа” гэж багш нь бусдыг сургах үед тэд бүгд л: “Ийм боломж байж болох уу? Багш бусдыг мэхэлж байна!” гэж асуудаг. Яах гэж мэхлэх юм бэ? Бурхан багш ч гэсэн “Бурхан сэтгэлд байдаг. Нууц жор байдаг л бол, олодох учиртай” гэж ярьжээ. Гэтэл хүмүүс үүний утгыг ойлгохгүй, хүн Бурханы дэст хүрч чадахгүй гэж боддог. Ойлгосныхоо хойно Бурханы хутагт хүрч чадна. Бурхан гэгч юу вэ? Бурхан бол билиг ухааныг хэлнэ.

Хүн төрөлхтөн оюун ухааныхаа зөвхөн зууны тавхан хувийг л ашиглаж, ерэн таван хувийг нь ашиглаж чадаагүй л байна гэж одоогийн шинжлэх ухаантнууд нотолжээ. Хэрвээ оюун ухааныхаа ерэн таван хувийг нь бүрэн ашиглаж чадвал бид Бурханы хутагт хүрч чадна. Зуун хувийн тавхныг л ашиглаж байгаа атлаа харин ийм их зүйлийг хийж чаджээ. Олон хэлээр ярьдаг, зургаа дахь мэдрэхүйтэй болж, зөн билиг нь ихэд бүрэлджээ. Нисэх онгоц зохиож, телефон утсыг бүтээжээ. Харилцуур утас бол “тэнгэрийн чих” мөн. Урьд нь хүмүүс утастай харилцуур хэрэглэдэг байснаа одоо харин утасгүй харилцуур хэрэглэх болсон бөгөөд хүн болгон ашиглаж чадах болжээ. Энэ нь урьдах тэнгэрийн чихээс бүр ч илүү дэвшилттэй болсон хэрэг.

Зөвхөн зууны тавхан хувийн билиг ухаанаа ашиглаж

байгаа атлаа нэгэнт ийм дэвшиж хөгжсөн соёлтой болчихож. Хүн төрөлтөн одоо онгоцонд суугаад дэлхий дахины өнцөг булан бүрт хүрч чаддаг болжээ. Тэр ч байтугай өөр бусад гараг руу ч хүрдэг болов. Хэрвээ ашиглаж чадаагүй ерэн таван хувийн билиг ухаанаа хэрэглэвэл бид бүр ч их зүйлийг хийж бүтээж чадна. Цаашилбал диваажинг өөрчлөн байгуулж, тамын орныг нээн ашиглаж болно, өөрт чинь итгэдэг бүх хүнийг авран диваажинд аваачиж болно.

“Авид Бурхны судар”-т тэмдэглэсэнчлэн: Авид Бурхан хараахан Бурханы дэст хүрээгүй үедээ: “Намайг Бурханы хутагт хүрсний дараа миний ертөнц маш үзэсгэлэнтэй болно, надад итгэдэг бүхэн намайг дурсангуут түүнийг авран диваажиндаа аваачна” гэж андгайлсан байна. Авид Бурхан Бурханы хутагт хүрсний дараа түүний ертөнц үнэхээр тийм болсон байна. Учир нь тэрээр билиг ухаанаа бүрэн нээн ашиглаж, Төгс баясгалант орныг байгуулжээ. Төгс баясгалант орон гэж урьд нь байгаагүй. Хэрвээ урьд нь тэнд хүн амьдарч байсан бол Авид Бурхан тэндхийн шашны эзэн болох боломжгүй. Тэр тэндхийн шашны эзэн болж чадсан шалтгаан нь өөрөө Төгс баясгалант орныг байгуулсан явдал бөгөөд шавь нараа дагуулан тэнд амьдарснаас нь болжээ. Та нар ойлгож байна уу?

Бясалгал хийсний хойно бид юугаар ч дутахгүй болж, санасан санаа бүхэн сэтгэлчлэн бүтнэ. Төгс баясгалант орны хүмүүсийн хүссэн бүхэн нь биелж, ажил хийх шаардлагагүй. Юу л идье гэсэн хүсэл байвал түүнийгээ идэж, хаа хүрье гэвэл дорхноо нисэж хүрдэг. Өмсгөл зүүсгэл нь маш үзэсгэлэнтэй, гуниг зовлон гэдгийг огт мэддэггүй.

Бурханы хутагт хүрсний дараа гарамгай бүтээлч чадвартай болдог. Хүн төрөлхтөн зөвхөн зууны таван хувийн билиг ухаанаа ашиглаж байгаа хэдий ч нэгэнт зургийн аппаратыг бүтээж, хүний зургийг авч үүрд хадгалж чадах болжээ. Урд нь зургийн аппарат гэж байгаагүй.

Хүмүүс зөвхөн зураг зурж хадгалдаг байжээ. Одоо бас утсаар дэлхийн аль ч орны хүмүүстэй холбоо барьж, сансрын хөлгөөр саранд хүрч, тэндээс дэлхийн бөмбөрцгийн хүмүүстэй холбоо барьж, ярилцаж чадах болжээ. Оюуны хүч нэгэнт ийм их болж хөгжсөн байна. Хэрвээ бид Бурханы дэст хүрвэл оюуны хүч бүр ч ихээр өргөжин тэлэх болно.

Даатгамагц тэр даруй илэрнэ

Авид Бурханд нигүүлсэнгүй сэтгэл төрмөгц хамаг төрөлтнийг дагуулан дээш гарч чаддаг, ингэх нь бас тун энгийн хэрэг, нууцлаг зүйл биш. Хүн төрөлхтөн угаас бүгд зургаа дахь мэдрэхүйтэй байдаг бөгөөд хамаг төрөлтөнтэй ойлголцож чаддаг. Тэр ч байтугай Арьяабал Бурхан болж, аливаа төрөлтөн хаа ч байлаа гэсэн даатгах юм бол бүгдийг нь сонсож чадна. Соронзон талбай өргөжих тусам билиг ухаан хаа сайгүй тархана. Бясалгах тусам өргөжин тэлсний хойно бидний соронзон талбайд байгаа бүх хүн юу ч ярьсан бүхнийг сонсож чаддаг. Гэхдээ эгэл хүний сонороор сонсдог биш, харин бурхны хүчийг ашиглан сэрж мэдэрдэг. Энэ нь зургаа дахь мэдрэхүйгээс бүр ч дээд дэсийнх байдаг. Зургаа дахь мэдрэхүй бол зөвхөн зарим зүйлтэй л шүтэн барилдлагатай байдаг. Бурханы сэрж мэдрэх хүч бол харин хаа сайгүй оршдог. Тиймээс л сая Арьяабал Бурхан даатгамагц даруй илэрч чаддаг хэрэг.

Арьяабалын номын цогцсыг бясалгах нь зөвхөн Арьяабалыг дурсаж, түүнээс аврал гуйх төдий биш. Ингэх нь зөвхөн анхан шат юм. Арьяабал Бурханыг бүр ч илүү дурсвал нь түүнтэй уусан нэгдэж, (бүх оршихуйтай нэгэн цогц болох юм. Тэр үед бид ямарваа хүний гуйлтыг сонсож чадна. Гэхдээ бас нөхцөл байдлыг харна. Харин хүн болгон Арьяабал Бурханд даатгадаг хэр нь бүгд л хариу авч болдог юм биш. Яг л хүүхэд байнга чихэр нэхдэг хэдий ч бид нэхэх

бүрт нь өгдөг биш, харин байдлыг харж байж өгдөг. Хүүхэд заавал хоол идэж байж л сая өсөж том болдог болохоор заримдаа бид чихрийг заавал өөр зүйлээр орлуулах хэрэгтэй.

Хүмүүсийн ихэнх нь Бурхан Бодьсадвад даатган мөргөх нь нэмэргүй гэж үздэг. Учир нь хүмүүс ердөө өөрт нь тохирохгүй, тусгүй зүйлийг л гуйдаг, тэгээд Бурхан Бодьсадва өөр нэгэн орлох эд зүйл өгвөл бид харин Бурхан Бодьсадва ид шидгүй гэж боддог. Үнэндээ тун их шидтэй, хэрвээ бидний хүслийг аялдан дагаад л байвал биднийг хорлож байгаа хэрэг болно. Яг л хүүхэд үргэлж чихэр их идээд байвал хоолоо идэх дургүй болоод өсөж бойжихгүй. Тиймээс ахмад хүмүүс эрхбиш тэднийг шахаж байж хоол зууш, ногоо жимс идүүлэх хэрэгтэй. Бас жишээлбэл, хүүхэд тоглоомд шунаж, суралцах дургүй бол яаж эрдэм мэдлэг сурч чадах вэ? Тиймээс бид тэднийг сайн харж харгалзан чармайн суралцуулах хэрэгтэй.

Бурхан хамаг төрөлтнийг бас л ингэж харж ханддаг. Өгч болохгүй зүйлийг өгдөггүй, өгч байгаа зүйлийг нь бид таашаахгүй байдаг ч байж магад. Гэвч бүгд л бидэнд ач тустай. Бурхан Бодьсадвагийн билиг ухаан биднийхээ гүн, сайн, мууг ялгаж чаддаг, тэд цаг ямагт бидэнд тусалж байдаг. Бид хэрвээ Бурхан Бодьсадва хамаг төрөлтнийг яаж авран тусалж байгаа, даатгамагц л яаж тэр даруй илэрч чадаж байгаа, орчлонгийн хамаг бодисыг яаж нэвт ойлгож чадаж байгааг мэдэх цорын гагц арга бол өөрөө Бурханы дэст хүрэх явдал юм.

Үнэндээ бас ямар нэгэн бурхан болох биш, бурхан аль хэдийнээ бидний сэтгэлд байж байдаг. Түүнийг нээн ашиглавал л болчихно. Хүний ертөнцөд мэндлэхээсээ өмнө бид угаасаа бурхан мөн. Тэгээд ямар нэгэн үүрэг хариуцлагын төлөө энэ ертөнцөд ирснийхээ хойно үүрэг хариуцлагаа мөн л мартчихдаг. Үүнийгээ дахин саная гэвэл үнэндээ тийм хүнд хүчир биш. Нам тайвуу суугаад сайтар

сэтгэн бодоорой! Угийн билиг ухаанаа хайж олох цорын гагц арга гэвэл бясалгал хийж Бурханы хутагт хүрэх явдал юм. Энэ номын цогцсыг Багш нь нэгэнт бясалгаад амжилтад хүрсэн. Гэхдээ энэ нь тийм хүнд хэцүү юм биш, та нар хэрвээ сурах хүсэлтэй бол Багш нь боломжийнхоо хэрээр та нарыг заан жолоодно. Багш нь дэлхийн олон орноор тойрон аялж, өнөөдөр энд ирсний зорилго бол та бүхэнтэй энэ бясалгалын аргыг хуваалцах гэсэн хэрэг! Та бүхэнд баярлалаа!

ҮНЭН ЁС ЦОРЫН ГАНЦ БАЙДАГ

*Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Америкийн Калифорни мужийн Саннивейл хот
1989 оны 12 дугаар сарын 10
(Эх нь вьетнам хэлээр)*

*※ Энэ ертөнцөөс бидний сурдаг хайр гэдэг нь зөвхөн л нэг
үлгэр загвар төдий байдаг бөгөөд үүнд түшиглэж өдий
болсны хойно дахин Бурханы түгмэл хайранд суралцдаг.*

Оройн дээд гүн нууцлаг гайхалтай ном

Багш нь Жэффри Мосесийн гэдэг нэг америк хүний бичсэн “Бүх шашинд адил байдаг аугаа зарчмууд” номыг уншлаа. Тэр зохиолч алдартай шашнуудын судар номыг судлан уншаад аливаа шашин бүгд л адилхан аугаа их хүслэнтэй байдгийг нотолжээ. Үнэндээ судар ном дахь тайлбар болон шүүмж үнэлэлтийн ихэнхийг нь шашныг үндэслэгч Эзэд биш, харин шавь нар нь сүүлд бичиж тэмдэглэсэн байдаг. Тэр шавь нарынх нь дэс нь шашны Эздээс доогуур бөгөөд бичиж тэмдэглэсэн судар ном нь мөрөн гол мэт олон, тэнгис далай мэт уудам байдаг. Азаар, судар номын гол өгүүлбэрүүд нь бүгд л зөв бөгөөд тухайн

үеийн Бурхан Багш болон энэ шашны Эздийн айлдвар ажээ.

Католик шашин, Күнзийн сургаал, Бурханы шашин, Японы Шинто шашин, Энэтхэгийн Брахман шашин болон Сикх шашны судар номоос эш татсан зарим жишээг доор харуулав.

Католик шашин: Диваажинг ертөнцийн орон бүхнээс, тэнгэр газрын зай бүхнээс хайж олдог биш, диваажин бидний дотоодод байдаг.

Күнзийн сургаал: Билиг ухаанаар хомсхон хүн бол тэнгэрийн орон (мөр)-ыг гаднаас хайдаг, билиг ухаанаар гүн хүн бол тэнгэрийн орон (мөр)-ыг дотоодоосоо хайхыг мэддэг.

Бурханы шашин: Та хэрвээ мөр ёсыг гадна байдаг гэж үзвэл зөвхөн төгс төгөлдөр бус мөрийг хайж олно. Дотоодоосоо хай! Гадна талаас хайх нь хангалтгүй.

Японы Шинто шашин: Битгий алс холын тэнгэрийн оронд хүрч Эзэн Бурханыг эрж хай! Харин зүрх сэтгэлээсээ хай! (Багшийн тайлбар: “Зүрх сэтгэл” гэдэг нь билиг ухааныг хэлж байна, харин махан биеийн зүрхийг хэлж байгаа биш.)

Энэтхэгийн Брахман шашин: Эзэн Бурхан хамаг төрөлтний сэтгэлд байдаг.

Сикхийн шашин: Юунд ой хөвч, уул толгод дээрээс бурхан чанарыг хайна вэ? Бурхан чанарыг тэндээс хайгаад олохгүй. Цэцгийн анхилам үнэр нь цэцгээс л ирдэг гэдгийг та ойлгох хэрэгтэй. Эзэн Бурхан бидний дотоодод байгаа юм чинь эрхбиш чин сэтгэлээр дотоодоосоо хайх хэрэгтэй.

Энэ Америкийн зохиолч бас судар ном дахь ариун дагшин үзэл санааны тухай доорх мэт адилтгал хийжээ.

Католик шашин: Судар ном дахь үг, өгүүлбэр амархан эндүүрэл үүсгэдэг, үсэг бичиг нь уламжлан дамжуулах үзэл санаа болон сүнслэг мөн чанарыг үргэлж бууруулдаг. Зөвхөн судар номын дотоод агуулгыг хайж олж байж л сая бид дахин шинээр мэндэлж чаддаг.

Иудаизм: хамгийн сайн нь аливаа үсэг бичгийг бүгдийг таягдан хаяж, үнэн ёсыг хай! (Багшийн тайлбар: хэрвээ судар номыг уншаад ойлгохгүй бол судар номд сохор балайгаар найдсанаас уншихаа болих нь илүү дээр.)

Исламын шашин: коран судар нь долоон улсын хэлний адилгүй хувилбартай, хувилбар бүр нь долоон өгүүлбэртэй, өгүүлбэр бүр нь бүгд л ил, далд хоёр давхар утга санаатай.

Брахманшашин (Энэтхэгшашин): судар номыг судлах нь сайн хэрэг, гэхдээ үсэг бичгээр уламжлан дамжуулсан жинхэнэ агуулгыг нь ойлговол зохино. Ойлгосны хойно, үг үсэгт нь баригдахаа больдог. Яг л тутаргын сүрлээс цагаан будааг нь салгаж, ялган авсны дараа хальсыг нь идэлгүй хаядагтай адил.

Исламын шашны суфи урсгал: бясалгаж суухын зорилго нь шавь бологсод санаа сэтгэлээ дэндүү ихээр зүдрээж, судар номын үг хэллэгийг нягтлан судлахгүй байхын төлөө билээ. Билиг ухаантай хүмүүс судар номыг аяндаа ойлгодог бөгөөд дэндүү ихээр задлан шинжилдэггүй.

Бурханы шашин: “Үг үсэг хэрэглэхгүйгээр сургаалаас ангид, ном уламжилдаг”. Судар номын үг үсэг нь хүмүүсийг төөрөгдүүлж мэднэ, үүний жинхэнэ амин сүнс нь л амьд сургаал мөн.

Өөр бас маш олон судар номыг дурдсангүй. Энэ зохиолч олон судар ном уншдаг гэгээрсэн хүн байна. Ялгаварлан гадуурхах үзэл, атаа жөтөө байхгүй, үзэл бодол нь хэт туйлсрахгүй, нэг шашныг нөгөө шашнаас илүү гэж бодоогүй байна. Гэгээрсэн хүн зөвхөн үнэнийг батлахын тулд л судар уншдаг.

Энэ нийтлэлийг уншсаны дараа бид юу мэдэж авсан бэ? гэвэл аливаа шашин бүгд л адилхан хүслэнг ярьж, нэг л үнэн ёсыг заасан байдаг, гэхдээ хамгийн чухал зүйл бол аливаа шашин бүгд л хүмүүсийг үсэг бичигт битгий хүлэгд,

мөнх бусын үг хэлээр өөрийгөө битгий хүл, харин “Оройн дээд гүн нууцлаг гайхалтай ном”, өөрөөр хэлбэл “Олонх бурхант судар”-т дурдсанчлан, “тоолшгүй олон галавт тааралдахад бэрх” номын цогцсыг хайх хэрэгтэй гэдгийг сануулжээ. Дэлхий ертөнцөд судар ном тийм их байхад яагаад бас тааралдахад бэрх гэж хэлдэг вэ? Үнэндээ судар ном дахь гүн нууцлаг, жинхэнэ утга чанартай тааралдахад бэрх, харин өнгөн талын өгүүлэл зохиолтой тааралдахад бэрх биш.

Шагжамуни Бурханыг мэндлэхээс өмнө аль хэдийн маш олон судар ном байсан. Жишээлбэл, Энэтхэг шашны “Ведийн судар” байна. Зарим хүний яриагаар бол Энэтхэг шашны сургаал ёсыг Буддын шашнаас хулгайлсан бөгөөд өөрсдийнх нь судар биш гэдэг. Үнэндээ тийм биш, эсрэгээрээ “Ведийн судар” нь Буддын шашны судраас ч эрт зохиогдсон. Шагжамуни Бурхан ч гэсэн эхлээд “Ведийн судар”-ыг уншиж байсан бөгөөд хожим нь тэрээр Энэтхэг шашны хэдэн гэрээс гарагчтай хамт бясалгаж, хамгийн сүүлд нь сая Бурханы хутагт хүрчээ. Гэхдээ тэр Төгс Гэгээрсэн Их Багшийг хайж олсон ч байж мэднэ.

Бурхан чанар бол бидний хамгийн төгс төгөлдөр билиг ухаан мөн

Хоёр төрлийн Төгс Гэгээрсэн Их Багш байдаг: гадна талын Багш болон Дотоодын Багш. Ямрыг нь гадна талын Багш гэдэг вэ? гэвэл нэгэн шүтэн биширмээр Багштай учирч, Түүний ярихыг сонсоход билиг ухаанаар маш гүн, торолгүй мэтгэлцэх чадвартай санагддаг тийм хүнийг хэлнэ. Учир нь энэ Багш жаахан билиг нээгдсэн болохоор юм бүхнийг тийм тодорхой ойлгож чаддаг бөгөөд номыг төгс сайхан тайлж, биднийг бишрүүлдэг. Тиймээс бид Түүгээр заалгаж удирдуулахыг ихэд хүсэж, өөрсдөө Түүнтэй адилавар

дэст хүрэхийг боддог. Тэгээд гадна талын Багшийн зааж жолоодсоноор бидний билиг ухаан бага зэрэг нээгдсэний хойно дотоодын Төгс Гэгээрсэн Багшаа хайж олдог. Энэ дотоодын Төгс Гэгээрсэн Багш бол жинхэнэ Төгс Гэгээрсэн Багш юм. Тэр бол хүн бүрийн дотоодод байдаг бурхан чанар, диваажин буюу Эзэн Бурхан юм.

Эзэн Бурхан тийм танил бус, эсвэл алс хол байдаг юм биш. Тэр бол бидний төгс төгөлдөр билиг ухаан мөн. Төрөл төрөлд хэзээ ч төрдөггүй, мөхдөггүй, бохиртдоггүй, ариусдаггүй. Тиймээс л Эзэн Бурхан бидний сэтгэлд байдаг, Бурхан бидний сэтгэлд байдаг гэж хэлдэг. Хэрвээ Эзэн Бурхан хэлбэр дүрстэй, орших газартай гэвэл, бидний сэтгэлд байж чадна гэж үү? Бурхан чанар гэдэг бол бидний өөрсдийн хамгийн төгс төгөлдөр билиг ухаан мөн. Энэ төгс төгөлдөр билиг ухааныг олдог л юм бол тэр биднийг төрлөөс төрөлд ивээн гийгүүлнэ. Тэр үед бид: “Би нэгэнт Бурханы Хутагт хүрсэн” гэж хэлж болно.

Бурхан Багш заримдаа: Бурхан чанар бол билиг ухаан мөн гэж хэлдэг. Заримдаа бас: Бурхан чанар бол мөр ёс мөн гэж хэлдэг. Бурхан Багш байтлаа адилхан зүйлийг адилгүй нэрийдлээр илэрхийлсэн байгаа юм чинь өөр бусад шашныхан адил бус улс орон, адил бус цаг үед оршиж байсан болохоор бүр ч илүү адил бусаар нэрлэх нь мэдээжийн хэрэг билээ.

Бид өөрсдийн гүн далд билиг ухаанаа яаж хайх вэ? гэвэл дотоодоосоо хайна. Зургаадугаар үеийн өвөг багш Хүй Нэн: “Гадна талдаа хэлбэр дүрсээс салахыг бясалгал гэнэ, дотооддоо сэтгэл самуурахгүй болохыг төвлөрөл гэнэ” гэжээ. Яагаад эгэл ертөнцийн аливаа зүйлээс салж байж л сая “төвлөрөл”-д орж чаддаг вэ? гэвэл бидний сэтгэл төвлөрөх үед л өөрсдийн билиг ухаанаа таних завшаан олдоно. Билиг ухааныг хэзээ ч алддаггүй, зөвхөн түүний оршин байгааг бид мартчихсан төдий л байдаг билээ! Бид өдөр бүр аль

авхай үнэхээр гоё байна, аль залуу ёстой ганган байна, аль бүсгүйн алмаас эрдэнийн бөгж нь хамгийн том, гэрэлтэй байна гэхчлэн нүдээ эрээлжилтэл гадагшаа харж, бүр ч илүү эрхэм дээд газраа харахаа мартчихдаг.

Хэрвээ гадна ертөнцийн аливаа эгэл зүйлийг бүгдийг бодохоо боливол бид уг чанараа аяндаа харж чадна. Нэг хялбар жишээ дурдвал: бидний толгой, эсвэл хэвлий өвдөж байх үед хамаатан садан чинь, найз чинь, эсвэл амраг хонгор чинь чамайг эргэхээр ирж, тэдэнтэй яриа хөөрөө болж хөгжилдөн ярилцвал хэвлий өвдөж байснаа түр зуур мартчихдаг. Гэдсээ өвдөж байгааг дахин санах хүртлээ хэсэг хугацаанд түр зуур мартдаг. Эсвэл заримдаа зурагт үзэж байгаа хэр нь цаг үргэлж өөр учрыг бодоод л байвал зурагтаа сонирхоогүйтэй адил юм. Учир нь анхаарлаа зурагтад хандуулж байгаа биш болохоор харсан ч хараагүйтэй, сонссон ч сонсоогүйтэй адил билээ.

Үүнтэй адил, бид өдөр бүр анхаарлаа ертөнцийн хэрэг юманд хандуулж, аливааг үнэлэн шүүдэг. Харин энэ бүх үйл хэргийг хэн магадлан шүүгээд байна вэ? гэдгийг боддоггүй. Тэгээд хэзээ нэг өдөр санаа сэтгэл нам тогтуун болохын хэрээр л сая тэр магадлах чадвар бол бидний дотоодын эзэн болохыг мэддэг. Урд нь үүнийг ерөөс анзаараагүй явсан байдаг. Биднийг нас барах үед тэр эзэн бие махбодоос салж оддог.

Энгийн үед бид ер нь “миний гар”, “миний хамар” гэж яриад дадал болчихсон байдаг. “Миний” гэж ярихыг сонсохоор ондоо нэг хүнийг хэлж байгаа шиг санагддаг, яг л “миний эхнэр” гэж яривал “миний эхнэр” ба “би” гэж өөр өөр хүнийг хэлдэгтэй адил. “Эхнэр” ба “би” гэх хоёр хүнийг зааж байна. Тиймээс жинхэнэ “би” бол эгэл хүн биш. Бид өдөр бүр маш олон буруу мэдээллийг хураан авч, янз бүрийн ерөөсгөл ойлголтыг бий болгодог. Үнэндээ тэдгээр нь бүгд л ахмад үеийн сургаал болон нийгмийн зан үйл, дадал зуршил

төдий билээ. Жинхэнэ “Би” бол зан үйл, хүсэл тачаалтай огт холбоогүй, тэр бол сая жинхэнэ “Би” мөн.

Хар багаасаа ой хөвчид төрж өссөн хүүхдэд гоё хүүхнийг эрж олох хүсэл ер төрөхгүй. Эгэл хүмүүсийн хүсэл тачаалаас үүссэн гэмт мэдрэмж нь бүгд жинхэнэ “би”-гээс үүсэлтэй биш. Бид муу дадал зуршлынхаа ихэнхийг нь дэргэдэх хүмүүсээсээ сурсан байдаг. Тамхи татахыг жишээ болгоё: дөнгөж төрсөн хүүхэд яаж тамхи татаж чадах вэ? Төрмөгцөө тамхи татдаг хүүхдийг та нар харж байсан уу? Тиймээс ял гэмтэй хүн үнэндээ байдаггүй, яг л “Гурван үсэгт ном” (хятадын эртний сургаал хүмүүжлийн ном)-д өгүүлсэн шиг: “Хүн анх төрөхдөө чанар нь угаас цэвэр”. Бурхан Багш бас: “Хамаг төрөлтөн бүгд Бурхан чанартай”, “Үйл түйтгэр угаас хоосон” гэжээ. Бид хэзээ нэгэн өдөр “үйл түйтгэр угаас хоосон” гэдгийг ойлгож байж л ариун тунгалаг уг чанартаа буцаж чадахаа мэдэх болно.

Яагаад бясалгах хэрэгтэй вэ?

Бясалгахын утга чанар нь яг ийм юм. Чанга дуугаар маани, тарни унших, бурханд мөргөх зэрэг нь ерөөсөө л өнгөн талын ажиллагаа юм. Бид өдөр бүр ажиллахдаа үйлдвэрийн машин тоног төхөөрөмжид анхаарлаа хандуулдаг. Орой гэртээ буцаж ирээд модон бурханд анхаарлаа хандуулж, чанга дуугаар бурхныг дурсаж, бурхны судар номыг уншдаг. Бид дэндүү их зав зайгүй, өдөр бүр үг ярьж, сүм хийдэд очиж чанга дуугаар маани, тарни унших буюу сүм дуганд очиж дуу дуулаад завгүй байдаг. Залбиран наманчлах болон бурханд мөргөх үедээ ч гэсэн мөн л ингэж зав зайгүй, яарч сандран үймэлдэж шуугилддаг юм чинь ямар заваараа хичээнгүйлэн бясалгаж сууж чадах вэ дээ?

Бурхан Багш: “Явах, зогсох, суух, хэвтэх бүгд л даяан мөн” гэж ярьсан байдаг. Бид зөвхөн явах, зогсох,

хэвтэхийг л мэдэхээс биш “суух”-ыг харин орхигдуулжээ. Яагаад бясалгаж суух хэрэгтэй вэ? гэж олон хүн асуудаг. Учир нь бясалгаж суувал санаа сэтгэлээ нам тайвуу болгож чадна. Ингэж байж л сая өөрийгөө хэн болохоо таньж чадна. Хамгийн гүн нууцлаг билиг ухааныг хамгийн нам тайвуу үедээ л таньж чадна.

Жишээлбэл, бид нэгэн маш чухал үйл хэргийг хийе гэвэл заавал эхлээд нам тайвуу болж, бодох хэрэгтэй, тийм үү, үгүй юү? Үймээн шуугиантай орчин нь хүмүүсийн сэтгэлийг үймүүлж, анхаарлыг нь сарниулж, юу ч бодох аргагүй болдог. Энэ үед эрхбиш нэг нам сэлүүхэн газар очиж, бодох хэрэгтэй. Тиймээс л тийм олон хүн тамхи татаж, архи уудаг. Ийм болохоор бид тэднээс юунд тамхи татаж, архи уудаг юм бэ? гэж асуух шаардлагагүй. Учир нь тамхи татах үед тамхины никотин санаа сэтгэлийг нам тайван болгож, бодож сэтгэх зай олгодог. Ийм шалтгаанаас болж ихэнх зохиолч тамхи татаж, архи увал сая өгүүлэл зохиолоо бичиж чаддаг. Тэд ийм зүйлд найдан байж онгодоо хайж, түр зуур гадаад орчны хөл үймээнээс салж, санаа сэтгэлийн нам тайван, тав тухыг эрэлхийлдэг байна.

Марихуан болон хар тамхи татдаг нь бүгд адилхан. Бид тэднийг өрөвдвөл зохино, харин зэмлэн буруушааж болохгүй. Тэд бас бидэнтэй адил гуниг зовлонтой байдаг тул сүнснийхээ нам тайван, баяр баяслыг хайхыг зорьдог. Зөвхөн буруу замаар замнаж, буруу эм уусан байна. Хэрвээ тэд бясалгаж суух дуртай бол ямар аргаар бясалгаж суусан ч бай, бүгд л санаа сэтгэлийн нам тайвныг олгож, дахин тэдгээр зүйлд найдах шаардлагагүй болдог.

Яг л хүүхэд шиг, түүнд эхийн сүү, эсвэл үнээний сүү уулгах үед, хүүхэд соосгоо тоохгүй дорхноо хаячихдаг. Эс бөгөөс хүүхэд өлсөх үедээ юуг ч хамаагүй амандаа хийгээд хөхөж мэднэ. Тэр харанхуй мунхаг, буруу замаар явагч, хор татагч, архи уугч хүн хэзээ нэг өдөр ухааран сэхээрэх болно.

Учир нь тамхи татаж, архи уугаад л байвал хүмүүсийг улам ядрааж, бие махбод сул дорой, оюун санаа үлбэгэр хойрго болно. Тэд нэг л өдөр ухааран сэхээрээд Бурхан Бодьсадва болон Эзэн Бурханаас тусламж гуйх болно.

Үнэндээ буруутай хүн нэг ч байдаггүй. Хамгийн том нүгэл бол мунхаглал юм. Ямар замаар замнахаа мэддэггүй, үнэн ёс хаа байгааг мэддэггүй болохоор хямдхан орлуулагч эдийг хайдаг. Энэ дэлхийн хүн бүр үнэн ёсыг хүсэн зорьж, ямар хэлбэрийн бясалгалын аргыг сонгож, ямар шашинд ч итгэсэн бай хамаагүй, бүгд бясалгаж суувал дэлхий маань үнэхээр бүр ч илүү гоё сайхан болж, хүмүүсийн сэтгэл бүр ч илүү сайн болж, замбуу тив ариун орон болж хувирна гэж Багш нь боддог билээ. Ариун орон мөн эсэхийг та нарын сэтгэл чинь магадлан тогтооно, харин гаднах дүр төрхөөс нь мэдэх биш.

Хүн бүр бохир усан санг тансаг ордон болгон хувиргаж чадах ер бусын чадвартай. Эзгүй газрыг нөхөн сэргээж, мод тарих, өндөр барилга барих гэхчлэн тархиа чадамгай ашиглан нарийн төлөвлөхийн зэрэгцээ бодитойгоор гүйцэтгэдэг л бол амьдралын орчин улам бүр үзэсгэлэнтэй сайхан болно. Багш нь өчигдөр хэдэн шавиа дагуулж саяхан худалдаж авсан газраа очиж үзсэн юм. Тэнд удтал хүн суугаагүй болохоор хог новш хөглөрсөн байв. Тэгээд Багш нь шавь нартайгаа хэдэн цагийн турш цэвэрлэсний дараа цоо шинэ болж хувиран цэвэрхэн бөгөөд үзэсгэлэнтэй болсон. Багш нь илүү хэдэн хоног энд байвал үнэхээр бүр ч гоё болно.

Гадна талын ид шидийн хүч бохир газрыг цэвэрхэн бөгөөд үзэсгэлэнтэй орон сууц болгоход хэдийнээ хангалттай бөгөөтөл дотоодын агуу билиг ухааны хүч үүнээс бүр ч тоолшгүй олон дахин хүчтэй. Хэрвээ тэр агуу хүчийг төвлөрүүлбэл ямарваа хүсэл, зорилго бүгдийг биелүүлж чадна. “Авид Бурханы судар”-г: Авид Бурхан

бурхан болоогүй байхдаа: Бурханы хутгийг олсны дараа түүний орон ариун дагшин орон болж, зовлон гэж үгүй, эрэгтэй, эмэгтэйн ялгаа гэж үгүй, үхэж төрөх сансрын хүрдэнд эргэлдэхгүй, хүн бүхэн төгс баясгалангийн дунд амьдрах болно гэж андгайлжээ. Энэ нь ямар утгатай вэ? гэвэл Тэр Бурхан болсныхоо дараа билиг ухаанаараа нэгэн Төгс баясгалант орныг бүтээж чадна; яг л нэгэн инженер өндөр сүрлэг орд харш байгуулахтай адил. Бурханы хутгийг олсны дараа маш олон тэнгэрийн орон болон нирвааныг бүтээж, бидний үр хүүхэд, аав ээж, найз нөхөд, хамаатан садан хийгээд өөрсдийн хайрладаг хүн бүхнийг аваачиж амьдруулж болдог бөгөөд тэднээсээ салах шаардлагагүй болно.

Бурханы гүн нууцлаг аугаа их хайр

Бясалгал хийвэл эхнэр хүүхэд болон ахан дүүсээ орхиж тэвчих хэрэгтэй юу гэж зарим хүн Багшаас нь асуудаг. Үнэндээ бясалгал хийх нь үүрд мөнхийн хүслэнт ахуйг байгуулж, өөрсдийн хамаатан садан, найз нөхөдтэйгөө хамт эдлэхийн төлөө билээ. Олон хүн бясалгал хийе гэвэл заавал гэр бүл, эхнэр хүүхдээсээ салж, аливааг огоорч, үүрд хүнтэй уулзахгүй байх явдал гэж үздэг. Энэ бол буруу үзэл. “Нэг хүн мөр ёсыг олбоос есөн үеэр тэнгэрт мэндэлмүй” гэдэг нь бүгдийг нь дээш дагуулан гарахыг хэлнэ. Мэдээж эхнэр, хүүхдийг нь бүр ч ярилтгүй, тэд бүгд хамт дэвшинэ.

Тиймээс эхнэр хүүхэд, хамаатан саднаа хайрладаг хүмүүс Арьяабалын номын цогцсыг бясалгавал зохино. Бясалгал хийхэд садан төрлөө хаях шаардлага байхгүй. Тэгвэл Бурхан Багшийн “Бурханы ном нь эгэл ертөнцийн хуультай салшгүй холбоотой байдаг” гэсэн санааг тэрсэлсэн хэрэг болно. Бид энд байхдаа хамаатан саднаа гэсэн сэтгэлтэй байсан бол дээш гарсны хойно ч гэсэн тийм сэтгэлтэй байх

болно. Дээш гарсны хойно мод, чулуу болчихдог биш. Бясалгагчид зөвхөн өөр төрлийн хайрыг хөгжүүлдэг. Энэ хайр нь эгэл ертөнцийн хайр сэтгэлтэй адилгүй, хүсэл тачаал, занал хорсол гэж үгүй, өмчирхөх сэтгэл байдаггүй. Дээд оронд бид адилхан хүсэл зорилготой хүмүүстэй хамт нэг зүйлийн бүр ч эрхэм дээд, баяр баясгалантай амьдралыг эдэлдэг. Эгэл ертөнцийн хайр сэтгэл харин тун өнгөц гүехэн, хязгаарлагдмал байдаг бөгөөд үргэлж гуниг зовлон авчирдаг. Заримдаа эрэгтэй хүн эмэгтэй хүнд атаархаж байхад өнөөх эмэгтэй нь өөр нэг эмэгтэйд бас атаархаж байдаг.

Хайр сэтгэл бол бидэнд жинхэнэ хайранд суралцаж эхлэхэд урам өгдөг төдий зүйл. Яг л хүүхэд үг ярьж сурахтай адил. Дөнгөж эхэн үедээ аав, ээж гэж ганц хоёр үг ярьдаг байснаа алгуураар тав, гурван өгүүлбэр хэлэх болж, жигнэмэг авъя гэж нэхэх болно. Дөнгөж эхэн үедээ ганц, хоёрхон үг ярьдаг байснаа өсөж бойжих тусам илүү олон өгүүлбэрээр ярьж, өгүүлбэрүүд нь илүү оновчтой болдог. Үүнтэй адил, энэ дэлхий дээр бид аав, ээж, найз нөхөд, хань ижил, үр хүүхэд гэх зэрэг харилцаатай байдаг. Энэ хүмүүс бол бүгд л бидний хайрлаж сурах хичээл юм. Тэгээд алгуураар жинхэнэ, бүрэн бүтэн хайрыг, төгс сайхан хайрыг суралцаж, хайр гэгч юу болохыг ойлгодог. Бид хайр гэх гэрийн даалгавраа сурч дуусах үед Бурханы хутгийг олжээ гэж хэлж болно.

Бурханд түгмэл хайр гэж байдаг, “түгмэл хайр” гэдэг нь үлэмж их хайр гэсэн утгатай. Бүх хүнийг хайрладаг, зуу зуун хүнийг хайрладаг. Тэр хүмүүс бүгд л “Тэр бол намайг хамгаас хайрладаг хүн мөн” гэж боддог. Энэ бол Бурханд байдаг онцгой, гүн нууцлаг, үлэмжийн хайр мөн. Тиймээс нэг Багш бясалгалаар өндөр дээд бол юу ч ярихгүй ч гэсэн шавь нар нь шүтэн дагадаг.

Зарим Багш гадна төрх нь тун сүр жавхлантай, том сүм хийдтэй байдаг ч очих хүмүүс байдаггүй. Очих хүн байлаа ч

тахил өргөхдөө хайнга хандаж, шавийн үүргээ гүйцэтгэсэн болоод буцдаг. Тэнд удаан сууж тогтохгүй, хоргодох сэтгэл төрдөггүй. Багш нь хаашаа очсоныг ч үл анзаарах бөгөөд санан дурсдаггүй. Учир нь тэр багшийн хайр нь дэндүү өчүүхэн, эгэл хүнийхтэй төстэй бөгөөд Бурханы хайр биш байдаг.

Эгэл хүний хайр нь ганц хоёрхон хүнийг л багтааж чаддаг, эсвэл нэг хэсэг бүлэг хүн түүнийг хайрладаг төдий. Харин бусад бүлэг хүн түүнийг хайрлах боломжгүй бөгөөд заримдаа түүнийг хүлцэн тэвчихгүйд хүрдэг. Учир нь түүний хайрын цар хүрээ дэндүү давчуу болохоор өөр хүнийг хайрлахын аргагүй. Тиймээс тэр хүмүүст зовуурьтай санагддаг. Бурханы хайр бол харин үүнтэй адилгүй, хамаг төрөлтийг бүхэлд нь хайрлан гэрэлтүүлдэг.

※ *Бид хайрын тухай хичээлийг бүрмөсөн сурч дуусах үед Бурханы хутгийг олжээ гэж хэлж болно.*

Нөхцөл болзолгүй хайр

Тиймээс энэ дэлхийд бид эхнэр, эр нөхөр, үр хүүхэдтэй байх нь муу биш, тэд бол бидний хайрлаж сурах хичээл мөн. Гэхдээ тэдний дунд төөрөлдөж (үүнд бүү ташуур), тэр хүн бол минийх гэж бодож болохгүй. Харин: тэр бол миний багш мөн, надад хайрлахыг сургаж байгаа гэж бодвол зохино. Тэгээд бид эндээс алгуураар суралцсаар, бүх хүнийг хамгийн дотно хүн шигээ хайрлаж чадах хэмжээнд хүрнэ.

Хүн төрөлхтний хайр нь жинхэнэ хайрын нэг төрлийн бяцхан үлгэр загвар л юм. Үүний оршин байгаа нь яг л одоо бид эр нөхөр, эхнэр болон үр хүүхдээ хайрлахтай адил, хожим хүн болгоныг хайрлаж чадахыг бидэнд ойлгуулахын төлөө юм. Барилгын инженер нэг эмнэлгийн газар, эсвэл нэг

том барилга барихаасаа өмнө эхлээд нэгэн жижигхэн загвар зохиодог. Тэр загварыг харахад тун үзэсгэлэнтэй, олон давхар, гаднаа цэцэрлэгтэй, тун олон цэцэгтэй, жинхэнэ барилгатай ав адилхан байдаг. Дараа нь сая ажилчид хөлсөлж, нэг нэг тоосгоор өрүүлж байж, хамгийн сүүлд нь том байр босдог шүү дээ.

Үүнтэй адилаар энэ дэлхийд бидний суралцдаг хайр нь бас нэг үлгэр загвар төдий бөгөөд бид энэ загварт түшиж өсөн бойждог. Дараа нь дахин Бурханы түгмэл хайрыг суралцдаг. Тиймээс бид эгэл ертөнцийн хайр сэтгэлд ташуурч болохгүй, гэхдээ бас Бурханы түгмэл хайрыг суралцахын төлөө эхнэр хүүхдээ хаях буюу аав ээж, хамаатан садан чинь хүлээс тушаа болоход эгдүүцэх дургүйцэх шаардлагагүй. Эгдүүцэх нь буруу. Хэрвээ “эгдүүцэх”, эсвэл “хүлэгдэх” сэтгэл танд байвал, аль аль нь буруу. Учир нь тэд бол зөвхөн бидний хайрлаж сурах хичээл юм.

Тиймээс багшаасаа суралцахын тулд аав ээж, садан төрлөө огоорох шаардлагагүй. Гэхдээ бид нэгэнт бясалгал дадуулж буй тул, эхнэр, нөхрийн хоорондох асуудалд дэндүү их санаа зовох хэрэггүй. Хэрэг учрыг дэндүү ээдрээтэй бодож хэрэггүй. Гэрлэчихсэн бол үргэлжлүүл, гэрлээгүй бол ганцаар амьдар! Ямар ч нөхцөл байдалд байлаа гэсэн бид бүгд бясалгаж болно. Санаа зовних болон эргэлзэн тээнэгэлзэх нөхцөл байдал нь бас сайн талтай. Үсээ хусуулаагүй бол хусуулах хэрэггүй. Учир нь бидний дэргэдэх хүн бүхэн бүгд Бурхан. Тэд энд бууж ирсэн нь бидэнд зааж сургахын төлөө билээ. Ердөө л сурлагын зэрэг тийм өндөр биш учраас “бага сургууль”-ийн хичээлийг л заахтай адил. Тэд бидэнд хайрын тухай жаахан хичээлийг л сургаж чаддаг.

Бид хайрыг илүүхэн шиг суралцъя гэвэл бүр өндөр дээд дэсийн Багш буюу маш олон хүнийг хайрлаж чаддаг түгмэл хайртай, Бурханы хутагт хүрсэн Багшийг

хайх хэрэгтэй. Бид түүнээс суралцсаны дараа гэрийнхээ хүмүүсийг бүр ч илүү их хайрлах болно. Бусдыг хайрлахыг суралцсанаах дараа гэр бүлийн хүмүүсээ огоорох биш юм. Өөрийн тань гэр бүл мөн л мэдэрхүйт төрөлтөн болохоор тэр хайрын дотор багтах ёстой. Бүхнийг огоорох гэдэг бол буруу үзэл.

Гэхдээ хүмүүс яагаад гэрээс гарагчдыг тун их эрхэмлэн дээдэлдэг вэ? Тэд урд төрөлдөө түгмэл хайрын тухай хичээлийг биднээс илүү сурсан ч байж мэднэ. Тиймээс энэ төрөлдөө ямар ч санаа зовох зүйлгүй, хувь хүний хайр сэтгэлийн хүлээс ч гэж байхгүй, аливаа хүнийг өөрийн садан төрлөө гэж үзэж, санан дурсахгүйгээр, өмчлөхгүйгээр, хүн болгонд эрх тэгш ханддаг. Тэд урьд нь хайрын тухай хичээлийг сайтар сурчихсан ч байж мэднэ, тиймээс тэд гэрээс гарч чаддаг.

Гэр бүлтэй хүмүүс ч гэсэн бусдыг уучлах, бусдыг хайрлахыг адилхан суралцаж чадна. Сурч дууссанаах дараа бас гэрээс гарагчтай адилхан билиг нээгдэж, ёс суртахуунтай болж болно. Цорын ганц адилгүй тал нь гэвэл бид үсээ хусуулаагүй, гэртээ суугаа төдий нь билээ. Хэрвээ сайн сурч дуусаагүй бол өөрийгөө гэрээс гарагчтай адилхан гэж битгий дэвэргэж яриарай! Сурч дууссанаах дараа бид аав ээж, найз нөхөд, хамаатан саднаа хайрладаг шигээ хамаг төрөлтнийг аяндаа хайрлах болно. Тэр үед бидний хайрын сэтгэл нэгэнт хөгжин тэлсэн байх болно.

Тиймээс зарим хүн: бясалгал хийсний дараа хүсэл тачаал багасаж, арвань хоёр хувь төдий л болжээ гэж хэлдэг. Яагаад вэ гэвэл хайрын сэтгэл нь өргөжчихжээ. Хүсэл тачаал нь зөвхөн нэг зүйлийн өмчирхөх шунал юм. Хайр сэтгэлийн цар хүрээ нь харин бүр ч өргөн байдаг. Эхнэр, нөхөр бие биеэ хүндэт зочин шиг харилцан хүндэтгэж, өмчирхөх болон нэг нэгнээ ашиглаж, хүсэл тачаалаа хангах бодолгүй болдог. Хэдийгээр хамтдаа амьдарч байгаа ч харилцан нэг

нэгнийгээ хүндэтгэдэг. Санаа сэтгэл хангалуун болохоор өмчирхөх сэтгэл аяндаа багасдаг.

Хүсэл тачаал гэж юу вэ? Энэ бол тэр хүнээ өмчилж, тэр бол “миний” эр нөхөр, тэр бол “миний” эхнэр, “надад” хамаарагдана, бусадтай холбоотой байж болохгүй гэдгийг хүмүүст мэдүүлэхийг хүссэн сэтгэлийн айдсаас үүдэлтэй. Харин нөхцөл болзолгүй хайр бол аливаа бүхнийг уучлан багтааж, хязгааргүй уудам саруул байдаг. Яг л бид үр хүүхдээ нөхцөл болзолгүй хайрладагтай адил. Үүнээсээ бага зэрэг өргөжин хөгжвөл хамаг төрөлтнийг нийтэд нь түгмэл хайраар хайрлах болно.



БУРХАН ЕРӨӨЛ БАРИЛДЛАГАТАЙ ХҮМҮҮСИЙГ Л ГЭТЭЛГЭДЭГ

*Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Америкийн Техас мужийн Хьюстон хот
1991 оны 2 дугаар сарын 28
(Эх нь вьетнам хэлээр)*

※ Бид хэрвээ бүр илүү үзэсгэлэнтэй ертөнцөд амьдрахыг хүсдэг бол, мөн итгэл үнэмшилтэй байж, туулан гэтэлхийг хүсдэг бол энэ нь хэцүү бэрх биш...

Арьяабалын номын цогцос бол хамгийн дээд номын цогцос мөн

Багш нь ирж ном уламжилсны хойно л сая ойлгож байгаа биш, Вьетнамчууд угаас бясалгал хийхийн чухал чанарыг мэддэг байсан. Шагжамуни Бурхан ярихдаа Бурханы номд наян дөрвөн мянган номын цогцос байдаг гэжээ. Тиймээс тун олон хүн гэртээ сууж бясалгахад ямар аргаар бясалгавал хамгийн тохиромжтойг мэддэггүй. Эцсийн эцэст дэлхийн ихэнх хүн бүгд л гэрээс гараагүй энгийн хүмүүс байдаг. Харин Арьяабалын номын цогцос бол гэрээс гарсан хүн бясалгахад тохирохоор барахгүй гэрээс гараагүй

хүмүүс ч бясалгахад тохирох бөгөөд бясалгахад хялбар, тийм их цаг болон мөнгө төгрөг зарцуулахгүй. Сүмд очвол л сая бясалгаж чаддаг юм биш, харин аав ээж, үр хүүхэд, ахан дүүсээсээ салах ч шаардлагагүй, аглаг уул, балар ойд очихын ч хэрэггүй.

Баатараа Явагч Их Хөлгөний номын хуралд Шагжамуни Бурхан хорин таван Бодьсадваг цуглуулж, тус тусынх нь бясалгалын номын цогцсыг нь яриулж, дэлхийн хүмүүст хамгийн сайн, хамгийн хялбар бөгөөд ач тустай номын цогцос аль нь болохыг хэлэлцүүлжээ. Тэр номын цогцос нь Анандыг Бурханы хутагт амархан хүргэж чадахаас гадна тухайн үеийн хүмүүс болон хожмын хүмүүс бясалгахад тохиромжтой байх хэрэгтэй байж. Хорин таван Бодьсадва өөр өөрийн бясалгалын номын цогцсоо танилцуулж, хорин хэдэн адилгүй номын цогцсыг дурдсан байна. Хамгийн эцэст Арьяабал Бурхан Арьяабалын номын цогцос (Арьяабал бурхан Арьяабалын номын цогцсыг бясалгаж Бурханы хутаг, Бодьсадвагийн хутагт хүрсэн болохоор хүмүүс түүнийг Арьяабал Бурхан гэж нэрлэжээ)-ыг танилцуулав. Арьяабал Бурхан танилцуулж дууссаны хойно Шагжамуни Бурхан ч гэсэн Арьяабалын номын цогцос бол хамгийн дээд, хамгийн сайн номын цогцос гэж, мөн хүн болгон бясалгахад тохиромжтой бөгөөд аль ч цаг үеийн хүмүүс, тэр ч байтугай ном балрах цаг үеийн хүмүүсийн хэрэгцээнд тохирсон номын цогцос мөн гэж хүлээн зөвшөөрчээ.

Ном балрах цаг үе гэдэг нь ямар утгатай вэ? гэвэл Шагжамуни Бурхан таалал төгссөний дараа жинхэнэ номын уламжлал тасарч, ном балрах цаг үед орохыг хэлж буй юм. Уламжлал тасрах гэдэг нь номын судас (бясалгалын жинхэнэ арга) утсан гэсэн хэрэг биш, харин жинхэнэ ном өөр оронд шилжиж, хөгжиж чадахгүй, хүмүүсийн дунд өргөнөөр уламжлагдаж чадахгүй буюу хүмүүс гүнзгий

ойлгох хувь барилдлагагүй болохыг хэлнэ.

Ном балрах цаг үед жинхэнэ номыг олж сонсох нь тийм хүнд бэрхшээлтэй байдаг ч Шагжамуни Бурханы “Баатараа явагч их хөлгөн судар” дахь айлдвар нь хожмын хүмүүст тун их итгэл найдвар үлдээжээ. Шагжамуни Бурхан хэлсэн нь: Тэр өөрөө бас Арьяабалын номын цогцсыг бясалгаж байж Бурханы хутагт хүрсэн гэжээ. Тиймээс Багш нь сая уул давж, ус гатлан маш олон улс орноор, маш олон газарт хүрч суралцсаар, Арьяабалын номын цогцсыг уламжлан сургадаг Багшийг хайснаар энэ номын цогцсыг сурч чадсан билээ.

Багш нь Арьяабалын номын цогцсыг бясалгасны дараа Шагжамуни Бурханы айлдвар үнэн зөв болохыг нотлон гэрчилсэн бөгөөд бясалгал хийж бурхан болох нь “Мянга нэгэн шөнийн шидэт үлгэр” биш, Энэтхэгийн ардын аман үлгэр ч биш гэдгийг жинхэнээр ойлгосон юм. Арьяабалын номын цогцос нь нээрэн хүн болгон бүгд бясалгаж амжилтад хүрч чадах номын цогцос бөгөөд хөгшин залуу, эрэгтэй эмэгтэй, сул дорой хүмүүс бүгд бясалгаж болно. Тэр нь аливаа гэдийг угаан цэвэрлэж чаддаг, яг л нэг тасалгаа хэдэн мянган жилээр гэрэл гэгээгүй байтал гэрэл асаамагц тэр байшин дорхноо гэрэлтэж, хэдэн мянган жилийн харанхуй бүрмөсөн арилдагтай адил.

Багш нь Арьяабалын номын цогцсыг бясалгахаас өмнө өөр бусад шашин Бурханы шашнаас дор гэж ихэвчлэн буруугаар боддог байжээ. Хожим нь хичээнгүйлэн бясалгаж, энэ төрлийн шашны судар номыг судлан уншсаны дараа, үнэндээ бүгд л адил зүйлсийг ярьсан байхыг нь мэдсэн. Шашнууд хоорондоо үнэндээ ондоо биш, харин хүмүүсийн бясалгалын түвшин өөр өөр байдгаас ялгаа зөрөөг бий болгосныг Багш нь одоо ойлгосон. Яг л манай Вьетнамчуудын ярьдагчлан: ягаан өнгийн шил зүүвэл харагдах үзэмж нь ч ягаан өнгөтэй болно, хар өнгийн шил

зүүвэл харагдах үзэмж нь хар хөшгөөр халхалсантай адил аж.

Хэн нэг хүн билиг нээгдээгүй, мэдрэмж муутай бол юуг харсан ч тод харж чадахгүй, ойлгож чадахгүй байдаг. Гэтэл тэр билиг нээгдсэн хүмүүс бол юуг харсан ч амархан ойлгож, саад харш байдаггүй. Багш нь урьд нь бясалгал хийх нь нэг зүйлийн хүнд бэрх бөгөөд хязгааргүй гайхалтай том хэрэг, энгийн хүн бараг бясалгахын аргагүй гэж боддог байв. Арьяабалын номын цогцсыг бясалгасныхаа дараа би ингэж бодохоо больсон. Багш нь одоо хамаг төрөлтөн бүгд л Бурхан чанартайг хардаг. Хэн ч бай, бясалгахыг хүсдэг л юм бол, цөм туулан гэтэлж, Бурханы хутагт хүрч чадна.

Гэхдээ тэр урьд нь хэр их муу хэрэг үйлдэж, хэр их хар сэтгэлтэй байсан, хэр их идэж ууж, жарган цэнгэж, ичгүүр сонжуургүй, донтож байсан нь хамаагүй, алдаа буруугаа гэмшиж, ухааран сэхээрч, хүн бүхэн бүгд л бурхан чанартай гэдэгт итгэн Арьяабалын номын цогцсыг бясалгавал, тэр хүн туулан гэтэлж чадах төдийгүй туулан гэтлэх нь маш түргэн байх болно. Ганц хоёрхон хоног бясалгамагц өөр зүйлээс ондоо болсон санагдаж, долоо хоног, хоёр долоо хоног бясалгасны дараа өөрийнх нь дэвшил маш их болсноо мэддэг. Дахин нэг сар, хоёр сарын дараа харин энэ ертөнцөд сэтгэл хоргодохоо болино. Аливаа бүхэн бүгд л зүүд зэрэглээ мэт байдаг хэдий ч бүхнийг огоорч, юуг ч хамаарахгүй байж болохгүй, өөрийн үүрэг хариуцлагаа мөн л сайхан гүйцэтгэх хэрэгтэй юм байна гэдгээ мэддэг.

Та нар Багшийгаа гурван зуу гаруй гэрээс гарагч шавьтай гэдгийг сонсоод Багш маань хүмүүсийг гэрээс гарахад урамшуулдаг гэж бодож магад. Үнэндээ тэд өөрсдөө гуйдаг, Багшийг нь шахаж байж гэрээс гарагч болсон юм. Багш чинь ихэвчлэн зөвшөөрөхөөс татгалздаг, гэвч тэд гуйгаад байхаар нь Багшийн чинь толгой өвдөж, сэтгэл шаналдаг.

Авшиг уламжлахад ч мөн адил. Маш олон хүн Багшийг нь шахаж, өөрсдөд нь авшиг уламжлахыг хүсдэг. Гэхдээ тэднийг алгуур эхлүүлж, урьдаар веган хоол идэхэд дадуулна, тэгээд хоёр, гурван сар өнгөрөөд бүрмөсөн веган хоолтон болж чадсан хойно нь авшиг хүртээхийг Багш нь хүсдэг. Зарим хүн амь хороодог ажилтай болохоор бас эхлээд ажил төрлөө солихыг туршиж үзэж, аажмаар өөр төрлийн ажил олохыг хичээх хэрэгтэй! Хэрвээ одоохондоо ажлаа солих дургүй бол хожим ажлаа сольсныхоо дараа бясалгасан ч болно. Зарим хүн харин янз янзын арга хэрэглэн Багшийг чинь шахаж, авшиг уламжлахыг уйлан гуйдаг.

Гаднах хүмүүс заримдаа бодит байдлыг ойлгохгүй, Багшийг нь та нарыг хүчээр, эсвэл ямар нэгэн арга заль хэрэглэн өдөөн татаж, гэрээс гарагч болгодог гэж үздэг. Багш нь хэрвээ нээрэн арга заль хэрэглэх гэсэн юм бол тэр мөнгөтэй хүмүүсийг л өдөөн татна биз дээ. Харин дүрвэгсдийг өдөөн татахын хэрэг юу билээ? Ерөнхийлөгчид хандвал ядаж дайныг зогсоож болно, эсвэл мөнгөтэй хүмүүсийг хуурч мэхэлбэл тэднээр мөнгө гаргуулж, ном дэлгэрүүлж болно. Харин халаас нь хов хоосон дүрвэгсдийг хуурч мэхлэх хэрэг юу билээ? Тэд ядарч тураад арьс яс л үлдээд байхад хуурч мэхлээд юу хийх вэ? Ингэж ярихыг Вьетнамчууд “ясгүй хэл” (хэлэнд яс байхгүй болохоор санаан дураар эргэлдүүлэхэд маш хялбар, өөрөөр хэлбэл юу гэж ярьсан ч болно гэсэн утгатай) гэж ярьдаг.

Вьетнамчуудийн сав нь эд мөнгө хураадаг, Багшийнх нь сав бол харин мөнгө алддаг сав. Багш нь дүрвэгсдийг таньж мэдсэнээс хойш мөнгөө бүгдийг нь дуусгачихсан юм чинь “мөнгө алддаг сав” гэхгүй, өөр юу гэх вэ? (Багш инээв). Ихэнх хүн бясалгагчдын ажлын арга хэлбэрийг ойлгоход тун бэрх хэцүү байдаг бөгөөд бясалгал хийдэг хүмүүс нээрэн тун ховор. Гэхдээ Багш нь өөрийн шавь нараа, эсвэл өөрийн биеэ сайшаан магтаж байгаа юм биш, зүгээр л бид бусдаас

нээрэн тун ондоо билээ.

Бурханы “Очир эрдэнийн номын цогцос”

Жинхэнэ номыг бясалгавал сая үнэнхүү дэвшиж чаддаг, сая бүрмөсөн билиг нээгдэж чадна. Энгийн номын цогцсыг бясалгавал бас билиг нээгдэнэ, гэвч билиг нээгдэх нь бага зэрэг бөгөөд бүрмөсөн билиг нээгдэж чадахгүй. Танилт, ойлголт нь хангалттай төгс төгөлдөр биш, нэвтэрхий гүн биш. Аливаа номын цогцос бүгд л маш сайн, маш сүрхий байсан бол Шагжамуни Бурхан Арьяабалын номын цогцсыг онцгойлон сайшаан магтахгүй байсан. Гэтэл яагаад Арьяабалын номын цогцсыг мэддэггүй бясаллагчид ийм олон хэвээр байдаг вэ? гэвэл тэд мэдэх хувь заяагүй юм.

Жишээлбэл, энэ дэлхийд хамгийн үнэтэй эрдэнийн чулууны тухай ярихад хүмүүс бүгд л алмаас чулуу гэж боддог. Гэтэл бид гудамжаар явахдаа анзаарвал эмэгтэй хүн болгон алмаас эрдэнийн чулуу зүүж яваа харагдахгүй бөгөөд хэн ч биедээ олон тооны алмаас зүүдэггүй. Эмэгтэй хүн болгон бүгд л алмаас эрдэнэд тун дуртай байдаг ч жинхэнэ алмаас эрдэнийн чулууг хүн болгон зүүж чаддаггүй. Ихэнх хүн хуурамч алмаас чулууг л зүүдэг. Хуурамч алмаас чулуу хямдхан, энгийн хүмүүс ч гэсэн худалдаад авч чадах бөгөөд хулгайд алдсан ч харамсахгүй. Жинхэнэ төгс сайхан алмаас чулуу маш үнэтэй, баян чинээлэг хүмүүс л сая худалдан авч чаддаг, ядуу хүмүүс энэ талаар бодох ч юм биш.

Тиймээс ховор нандин номын цогцос - Бурханы “Очир эрдэнийн номын цогцос”-ыг хүн болгон мэдэх боломжгүй. Хэрэв тийм амархан байсан бол Бурханы хутагт хүрсэн хүмүүс сүм хийдэд аль хэдийнээ байж байх байсан бөгөөд өглөө, оройд тэгж ядарч чилж, чангаар ном уншиж, тогшуур тогших шаардлагагүй байсан. Арьяабалын номын цогцсыг тийм амархан ойлгодог бол Бурхан Багш нирваандаа

буцсанаас хорь, гучин жил, ихдээ зуун жилийн хойно энэтхэгчүүд бүгдээрээ Бурханы хутагт хүрч, нирваандаа буцчих байсан. Багш нь энд ирж хоолойгоо хатгал ярих шаардлагагүй байсан. Гэвч ярьсан ч та нар ойлгодоггүй.

Энэтхэг бол ариун дагшин орон, Бурхан Багшийн мэндэлсэн орон, үеийн үед жинхэнэ бясалгагчдын орон байсан. Бусад Их Багш нарыг ярилгүй, ганц Шагжамуни Бурханыг дурдахад л ойлгомжтой. Түүнийг амьд сэрүүн байх үед Түүнд шавилсан хүмүүс бас тийм ч их байгаагүй, хожим нь Бурхан Багш нирваандаа буцсаны дараа номын уламжлал тасарч, өөр оронд шилжжээ.

Эрхэм нандин номын цогцсыг угаас хүн болгонд мэдүүлж болдоггүй, энэ нь тун үндэслэлтэй, зүй ёсны хэрэг. Тиймээс зарим хүн: Би яагаад Арьяабалын номын цогцсыг мэддэггүй, харин Багш та мэддэг юм гэж асуувал өөрийнх нь асуултад өөрөөр нь хариулуул, ойлгож байна уу? (Багш инээв) Арьяабалын номын цогцос бол нандин эрдэнэ, харин замын хажуугийн хаягдал хог новш биш.

Харин одоо Багш нь Арьяабалын номын цогцсыг ил тод танилцуулж, та бүхний бясалгалыг цаг үргэлж заан чиглүүлэхэд бэлэн байна. Үнэ төлбөргүй уламжилдаг тул та нараас ямар ч төлбөр авахгүй. Би өөрийн биеэр та нарын гэрийн чинь өмнө ирээд хаалга тогшиж байгаа бөгөөд та нар эртний хүмүүс шиг Багшийг эрж хээр хонож, хэц дэрлэн мөр ёсыг хайх шаардлагагүй. Ийм хялбар дөхөм байгаа ч гэсэн сурах хүмүүс тун цөөн. Номын цогцсыг үнэ төлбөргүй илээр өргөн дэвшүүлж байгаа атал бас бусдад шүүмжлүүлдэг. Би та нараас мөнгө хураасан, эсвэл ямар нэгэн ажил хийлгэсэн байвал намайг шүүмжлэх нь бас зүй ёсны хэрэг байж болно. Гэтэл би та нарт хэрэггүй учрыг сургаагүй. Багш чинь та нарт хулгайлах, булаах, бусдын эр нөхөр, эхнэрийг булаахыг заасан байвал Багшийгаа шүүмжлэх нь зөв, гэтэл Багш нь ёс суртахууныг сөрсөн хэрэг явдлыг бусдад ер зааж сургаагүй

билээ.

Үүнээс бид Бурхан Бодьсадва хамаг төрөлтнийг аврахгүй байгаа биш, харин хамаг төрөлтөн авруулахыг хүсдэггүй болохыг харж болно. Арьяабалын номын цогцос бол хамгийн ховор нандин нь гэж Бурхан Багш ярьсан байтал сүм хийдийн хуврагууд болон өндөр дээд гэгээнтэн лам нараас суралцсан тэр бясалгагч нар яагаад Арьяабалын номын цогцсыг мэддэггүй юм бэ? гэж надаас асуух хэрэггүй. Тэд тоодоггүй, эсвэл сэтгэлээ зүдрээж байж ойлгохыг хүсдэггүй байж ч магад. Тиймээс л Арьяабалын номын цогцос байдгийг мэддэггүй хэрэг.

Багш нь аль хэдийн та нарын өмнө ирчихээд ийм тодорхой тайлбарлаж байхад, өргөл барьц хураадаггүй, ганц мөнгө, аяга будаа ч хүлээж авдаггүй байтал та нар мөн л сурах дургүй байдагтай адил. Сүм хийд, аглаг уул, гүн агуйд суун өөрөө бясалгадаг тэр хүмүүсийг дурдалтгүй. Тэд хэнтэй ч уулздаггүй, судар ном уншиж нотолгоо эрдэггүй, ямар ч багшаас суралцдаггүй, зөвхөн зарим судар ном дахь үг болон тарнийг байнга ахин дахин уншдаг болохоор тэд Арьяабалын номын цогцсыг яаж мэдэж чадах билээ? Маш олон хүн өөрсдөө судар номоос лавлан сураад гуч, дөчин жилээр бясалгасан ч жинхэнэ Төгс Гэгээрсэн Багштай тааралддаггүй.

Төлөгч үзмэрчээр жишээ болгон яривал тун амархан ойлгоно. Заримдаа та нар хувь заяагаа үзүүлдэг, хэн нэг хүн заяа төөрөг үздэг гэж сонсвол түүн дээр очиж, хувь заяагаа үзүүлдэг. Ийш тийш гүйсээр байгаад мөнгөө үрж дуусгадаг. Мэргэн төлөгчийг хайж ололгүй, буруу мэргэлүүлэх нь бүр ч элбэг. Төлөгчтэй уулзлаа ч гэсэн тэр гарын чинь алгыг байн байн шинжиж, ойлгогдохооргүй хачин үг ярихаас хэтрэхгүй. Тэгээд л та мөнгөө үрээд барахгүй түүний мэргийн үр дүнгийн төлөө санаа зовдог. Өвчнөө эмчлүүлэхэд ч бас адилхан. Сайн эмчийг хайж олохгүй бол мөнгөө дэмий үрэх

бөгөөд өвчнөө ч эдгээж чадахгүй, эсрэгээрээ бүр ч дордох болно, тийм биз?

Тиймээс гол асуудал нь бид Бурханы хутгийг олж чадахгүйд байгаа юм биш, бид өөрсдийгөө Бурхан болж чадна гэдэгт итгэдэггүй, энэ төрөлдөө Бурхан болж чадна гэдэгт итгэдэггүйд байгаа юм. Та нар бүгд л Арьяабалын номын цогцос буюу туулан гэтэлгэх номын цогцсыг сурахад хялбар биш гэж үздэг. Үнэндээ та нар сурах хүсэлгүйд л жинхэнэ бэрхшээл нь байгаа бөгөөд, зүгээр л гадна зогсчихоод: “Ийм зүйл яаж байж болох вэ?” гэж эргэлзсээр байдаг. Өөрсдөө жигнэмэг идэхгүй атлаа үргэлж: “Жигнэмэг яаж чихэрлэг амттай байж болох вэ?” гэж асуудаг, чихэр идэж үзээгүй юм чинь мэдээж чихэрлэг амттай гэж ярьж чадахгүй, идсэнийхээ дараа бол аяндаа мэдчихнэ. Ялангуяа өөр хүн чихэр авчраад бидэнд үнэгүй идүүлэх гэхэд хэрвээ идэхгүй бол бид өөрсдөө л хохирох болно.

Урьд нь Багш нь илээр шавь сургадаггүй байсан. Тэгэхэд маш олон хүн Багшийг нь нигүүлсэнгүй сэтгэлгүй, Арьяабалын номын цогцос бол хамгийн сайн номын цогцос болохыг тодорхой мэдэж байгаа атлаа ихээр уламжилж хамаг төрөлтөнд мэдүүлдэггүй, ийм юм бол бясалгал хийсний хэрэг юу байна гэж хэлдэг байсан. Багш нь илээр ном уламжлахыг татгалздаг байсны шалтгаан нь хүмүүс юу ч мэддэггүй юм чинь яаж сургах юм бэ? Гэтэл зарим хүн үүнд итгэхгүй, Багшид сургах арга лавтай байгаа гэж үздэг тул ном тайлах газар түрээсэлж, Багшийг нь тайзан дээр гаргаж ном тайлуулахыг хүсдэг.

Ерөнхийдөө, нэг номын Багш ихдээ зөвхөн хэдэн мянга, хэдэн арван мянган шавь сургадаг бөгөөд бүх дэлхийн хүмүүсийг сургах боломж байдаггүй. Жишээ нь, ном тайлахыг сонсоод хэдэн зуугаад хүн ирдэг хэдий ч: “Арьяабалын номын цогцсыг сурах хүсэлтэй хүн байна уу?” гэж Багш нь асуухад хэдэн аравхан хүн сурах хүсэлтэй

байдаг. Үүнээс үзвэл Арьяабалын номын цогцос хэдийгээр эрхэм нандин бөгөөд амжилтад амархан хүргэдэг хэдий ч бясалгахыг боддог хүмүүс тун цөөн, тиймээс Бурханы хутгийг ологчид маш цөөн байдаг. Дэндүү амархан олчихвол, нандигнадаггүй. Бид ээдрээ төвөгтэй хэрэгт дасчихсан болохоор дэндүү амархан хэрэг учрыг сонсвол, эсрэгээрээ харин хүлээн зөвшөөрөх бодол төрдөггүй.

Гэхдээ бид: Шагжамуни Бурхан амьд сэрүүн байх үедээ маш олон ээдрээ төвөгтэй номын цогцсыг бясалгаж, мөр нүцгэн, гэдэс өлсгөлөн явж, гэр бүл, хөвгүүнээ огоорч, баян тансаг амьдралаа хаясан. Өөрөө арьс яс болтлоо эцэж туран тамир тэнхээ тасрахдаа ус уухаар голын хөвөө рүү мөлхсөн. Тэр үед нэгэн залуу охин аяга сүү уулгасны ачаар тэнхээгээ сэлбэн бясалгаж суусны дараа сая үр дүнтэй болсон бөгөөд туулан гэтэлхэд хатуугаар бясалгах мэтийн тиймэрхүү ээдрээ төвөгтэй номын цогцост найдаж болохгүй гэдгийг ухааран ойлгосныг мэднэ.

Одоо бид ч бас, хатуугаар бясалгахад дадаж, зовлон зүдгүүр амсаад сурчихсан болохоор дэндүү амархан номын цогцсыг хараад ийм байх боломжгүй гэж үзэж байна. Гэхдээ хэрэг учир тийм биш. Бид угаас нэг зүйлийн буруу үзэлтэй, гэм нүгэл маш хүнд, юу хийсэн ч гэмтэй гэж боддог болохоор бясалгал хийн Бурханы хутгийг олох боломжгүй гэж үздэг, эсвэл Шагжамуни Бурхан л зөвхөн Бурханы хутгийг олж чадсан, харин бид хэзээ ч Бурханы хутагт хүрэх боломжгүй гэж боддог.

Гэтэл та нар Шагжамуни Бурхан яаж мэндэлсэн тухай ерөөс боддоггүй. Уламжлалт яриагаар Тэрээр Тушита тэнгэрийн орноос эгэл ертөнцөд бууж ирсэн гэдэг. Гэтэл түүхэн тэмдэглэлийг үндэслэвэл тэр эхийн хэвлийгээс мэндэлснийг мэдэж болно. Бурхан Багшийн эх нь мөн л есөн сар түүнийг тээж төрүүлсэн. Бурхан Багш ч гэсэн өөрийгөө угаас нэгэн эгэл хүн байсан, бясалгал хийснээр л

сая Бурханы хутагт хүрч чадсан гэж ярьсан байдаг.

Та нар Буддын шашинтан болохоор энэ бүх учрыг мэдэж байгаа байх. Үүнийг хүртэл мэдэхгүй бол өөрийгөө бурхны шашинтан гэж яаж хэлж болох вэ? Багш нь асуух үед толгой дохисон хүн хэдхэн байна, ихдээ л гурав, дөрвөөс хэтэрсэнгүй. Гэтэл Багшийгаа шүүмжлэх үед харин бүр идэвхтэй гэж жигтэйхэн. Зарим хүн Багшийг нь Буддын шашны номыг сургаагүй, жинхэнэ бурхны шашныг ярьдаггүй гэж шүүмжилдэг. Үнэндээ тэд Бурхан Багш ямар ямар сургаал ёсыг айлдсаныг ч мэддэггүй.

Та нар шүүмжлэхдээ түргэн. Гэвч шүүмжлэхээсээ өмнө эхлээд өөрийгөө болон бусдыг ойлгон таньж байж л сая дайн тулаан бүртээ ялж чадна гэдэг. Хэрвээ сохор балайгаар дайрвал нөгөө этгээд чинь яагаа ч үгүй байхад та өөрөө харин эхлээд ойчно. Мэдрэл нь гэмтсэн хүн л ингэдэг. Өөрийгөө ядрааж цуцаахаас хэтрэхгүй. Архинд согтсон, эсвэл мэдрэл нь муудсан хүмүүсийг та нар харж байсан уу? Сүүдрээсээ айж, сүүлээсээ цочин хамаа намаагүй цохиж өшиглөж байснаа эцэстээ өөрөө ухаан алдан унадаг. Багшийг нь шүүмжилдэг тэр хүмүүс юу ч мэддэггүй, эсвэл бага сагахан л мэддэг. Гэхдээ мэддэггүй хэрнээ сурахыг хүсдэггүй, бусдыг сургаж байгаа хүнийг хармагц санаан зоргоороо шүүмжилдэг. (Багш инээв.)

Энэ дэлхийн хүмүүс тун хөөрхийлөлтэй, Вьетнамчууд бас тун хөөрхий, тийм болохоор л уруудан дордож, туулан гэтэлж чаддаггүй. Өдөр бүр маш олон шинэ судар ном, сургаал ёс болон шашны урсгал бүлэг бий болдог боловч энэ ертөнцийг мөн л аврахын аргагүй, үхэж төрөх сансрын хүрдэнд эргэлдэх хүмүүс улам олширч байна, учир нь туулан гэтэлж чадаагүй болохоор л энэ дэлхийн хүн ам нэмэгдсээр байна. Хэрвээ туулан гэтэлчихсэн бол бүгдээрээ аль хэдийн энэ дэлхийгээс салж одчихсон байх байсан. Хэрвээ бурхны шашин нээрэн муу гэвэл наад зах нь бас католик шашин

байна, гэтэл тэр католик шашинтнууд ч гэсэн ямар байна? Хүнийх нь тоо мөн л улам улам нэмэгдэж байна, шашны бүлгүүд хоорондоо бас харилцан дайтаж, мэтгэн маргалдаж, эмх замбараагүй болов.

За! Яах вэ! Юу ярина, зөнгөөрөө л болог. Бид бясалгал хийхийг үнэнхүү хүсвэл, нэгэн тогтвортой бөгөөд бидний хүсэл, үзэл бодолд нийцсэн номын цогцсыг хайж олох хэрэгтэй! Харин юу ч хийхгүй мөртлөө бусдыг шүүмжлээд л байвал тэнгэрт даатгахад тэнгэр таг чиг, бурханд залбирахад бурхан ч таг чиг болж мэднэ. Тиймээс үнэн бодитойгоор бясалгаж үзвэл зохино.

※ Бурхан Бодьсадва хамаг төрөлхтнийг авран тусалдаггүй биш, харин хамаг төрөлтөн аврагдах хүсэлгүй байна.

“Чин Хай даатгалын компани” энэ төрөлдөө туулан гэтлэхийг батална

Бид хэрвээ судар номд дуртай, бурхны шашинд дуртай бол судар номыг судлан уншаарай! Тэгээд судар номд биднийг бясалгахыг сануулсан номын цогцсыг бясалга, дараа нь алгуур аажмаар дэвших болно. Хэрвээ юу ч хийхгүй, энэ нь сайн биш, тэр нь ч сайн биш гэж шүүмжилдэг атлаа өөрөө харин юу ч ойлгохгүй бол үнэхээр сэтгэл зовмоор хэрэг болно.

Зуун жил урт биш, одоо та нар нэгэнт хорь, гуч, дөч, тавь насалчихаж, хадан гэртээ харих цаг холгүй байна, тийм биз дээ? (Багш инээв), Багш чинь ч бас хөгширчихжээ. Цаг төр ороо бусгаа, хаа очсон ч дайн дажинтай, өнөөдөр амьд байснаа маргааш нас барж ч мэднэ. Урьд нь та нар дайн дажин, гай зовлонгоос зайлж Вьетнамаас америкт ирсэн. Гэтэл одоо харин америкт бас дайн үүсэв, харав уу? Хаана очвол аюулгүй бол? Бясалгал хийхгүй бол ямар ч баталгаа

байхгүй.

Биднийг үхэхгүй гэж баталж чадах даатгалын компани нэг ч үгүй, үйл түйтгэргүйг маань баталж чадах компани ч байдаггүй. Та арван сая төгрөг төлбөл үйлийн үрийг чинь угааж цэвэрлээд өгөх даатгалын компани гэж байдаггүй, зөвхөн “Чин Хай даатгалын компани” л энэ бүхнийг баталж чадна (Бүгд алга ташив), гэхдээ Чин Хай даатгалын компани та нараас нэг төгрөг ч хураахгүй. Ингэж батлаад байхад та нар бас сурах дургүй байдаг нь үнэхээр гайхмаар шүү!

Бид ээдрээ төвөгтэй номын цогцсыг сураад дадчихсан болохоор хэн нэг нь: “Бясалгал хийхэд зовж зүдрэх шаардлагагүй, бясалгал хийх нь тун амархан хэрэг” гэж яривал итгэхэд тун бэрх. Багш нь дөнгөж эхлэн бясалгах үедээ мөн л ингэж боддог байсан бөгөөд аргагүй эргэлзэж байсан. Өөрийгөө яагаад ийм их буянтай байж болох вэ? гэж сэрдэж сэжиглэж байсан. Үнэндээ бид Багшдаа, эсвэл номын цогцост итгэдэггүй биш, харин өөрийн биедээ итгэдэггүй юм.

Яагаад вэ? гэвэл бид аль хэдийн урт удаан хугацааны турш тархиа угаалгачихсан, өөрийнхөө үйл түйтгэрийг үнэнхүү тун хүнд, төрөл төрөлдөө бясалгал хийсэн ч лавтай зургаа, долоон зуун галав өнгөрч байж л сая Бурханы хутгийг олж чадна, гэхдээ галав бүртээ заавал маш олон сайн үйл, маш олон Бодьсадвагийн үйл үйлдэж байж л сая Бурханы хутгийг олж чадна гэж үздэг. Тиймээс Багш нь: “Энэ төрөлдөө туулан гэтэлж чадна” гэж ярихаар харин итгэдэг хүн байдаггүй. Олон хүн энэ төрөлдөө туулан гэтэлж чаддагт итгэхэд тун бэрх, учир нь бидний толгой тархинд өнө эртнээс буруу үзлийг дүүртэл чихчихсэн байна.

Бид бас Арьяабалын номын цогцсыг ойлгодоггүй, эсвэл Багшийг нь ойлгодоггүй тэр хүмүүсийг зэмлэн буруушааж болохгүй. Учир нь тэдний толгой тархи аль

хэдийн дүүрчихсэн болохоор хөөрхийлөх л хэрэг, харин зэмлэж болохгүй. Та нар бас Багшийг нь гүтгэсэн маш олон үгийг сонссон. Сонсоход чих өвдөм төдийгүй ихээр сүрдүүлэх үгийн хариуд Багш нь юу ч ярьдаггүй. Багш нь тэднийг өрөвдөөд амжихгүй байтлаа яалаа гэж зэмлэн буруушаах билээ? Тэд тун хөөрхийлөлтэй, сэтгэл нь дэндүү харанхуй мунхаг, зааж жолоодох хүнгүй дэндүү удчихаж, өөрийн гэрэл гэгээтэй талаа аль хэдийн бүрмөсөн мартчихжээ.

Хэдий чинээ их шүүмжилдэг хүн бол төдий чинээ хөөрхий, шүүмжилж эхлээгүй байгаа хүмүүсийн өмнөөс бол айх хэрэггүй. Багшийг нь шүүмжлэх тусам дэсээр доор болно. Багш нь зөвхөн тэднийг дээш татаж амжихгүйгээсээ л санаа зовохоос биш, яалаа гэж тэднийг зэмлэн буруушаах билээ? Багш нь яримагц ойлгочихдог хүний хувьд илүү их юм ярих шаардлагагүй байдаг, ном тайлахыг сонсоод ойлгодоггүй боловч эсэргүүцдэггүй тийм хүмүүсийг бас аврах арга байдаг бөгөөд алгуур аажмаар сонсоод байвал тэд бас ойлгочихно. Гагцхүү тэр ойлгодоггүй хэр нь эсэргүүцдэг хүмүүс л үнэхээр хөөрхийлөлтэй. Аль нэг төрөлдөө сая нэг ойлгож чадахыг нь мэдэхгүй юм, тэд мөр ёсноос дэндүү хол зайтай болчихжээ!

Шагжамуни Бурхан дөнгөж Бурханы хутгийг олох үедээ бас: “Больё доо, больё! Хамаг төрөлтнийг аврахын арга байхгүй юм чинь нирваандаа буцах нь илүү дээр” гээд толгой сэгсэрч байжээ. Нирваан гэж юу билээ гэвэл Бурхан Багш таалал төгсөж, нирваан дүр үзүүлэхийг хэлж байгаа биш, Бурхан Багш өөрөө тэнгэрийн оронд хүрээд газар хайж, амьдран суухыг хэлж байгаа ч биш, нирваан гэдэг бол нэг хүн хангалттай билиг ухаантай, төгс төгөлдөр болж, төрөл төрөлдөө хүссэн хүсэл нь бүрэн төгс биелэн хүсэл тачаалаасаа ангижирсны дараа нэг зүйлийн сэлүүн тунгалаг байдалд хүрэхийг хэлж буй юм.

Хоёр төрлийн хүслэнт ахуйгаар эрх дураар зорчин аялахуй

Иймэрхүү амарлингуй баяслыг бийр бэх, үг хэлээр дүрслэхийн аргагүй. Зөвхөн дотоодын ахуй ойлголтоороо гэрчилж чаддаг. Ярьж хэлсэн ч өөр хүн итгэхэд тун бэрх. Яг л яст мэлхий болон загас шиг. Загас бол хэзээд усанд амьдардаг, харин яст мэлхий бол усанд амьдарч чаддаг атлаа бас хуурай газар дээр ч амьдарч чаддаг. Хэрвээ яст мэлхий эрэг дээрх байдлыг загасанд яривал загас яаж итгэж, яаж ойлгож чадах билээ? Загасанд хуурай газрыг харж чадах завшаан олдлоо ч аль хэдийн газар хэвтэн амь нь тэмцэх болно, та нар ойлгож байна уу?

Бясалгадаггүй тэр хүмүүс ч үүнтэй адил. Нас барсны хойно л сая хүний ертөнц гэж зөвхөн түр зуурын нэг зүйлийн хуурмаг үзэгдэл болохыг ойлгож, орчлонгийн өөр нэг талыг сая л нэг мэддэг. Гэсэн ч дэндүү оройтчихсон байдаг. Бид тогтсон үйлийн үрийнхээ эрхээр өөрийн дургүй оронд очдог, тэр үед л сая эргэлзэн тээнэгэлзэж, харамсан гэмшиж, зовж шаналахын эрхээр үнэхээр ухааран сэхээрдэг бөгөөд дараа төрөлдөө лавтайяа бясалгал хийж, өр тооцоогоо төлж дуусгана, харанхуй мунхгаа угаан цэвэрлэнэ гэж андгайлдаг. Гэтэл эхийн хэвлийд ормогцоо бид дахиад л мартчихдаг.

Хүний биеийг олоход тун бэрх, жинхэнэ номыг сонсож чадна гэдэг бүр ч хэцүү. Яагаад вэ? гэвэл нэгт, ном уламжлах хүн маш цөөн, хоёрт, жинхэнэ номыг ойлгодоггүй болохоор итгэж чаддаггүй, хүнд бэрх гэдэг нь үүнд л байгаа хэрэг. Харин Бурханы хутгийг олоход хүнд бэрх биш, та нар ойлгож байна уу? Гуравт, жинхэнэ номыг сонсоогүй, ойлгодоггүй хүмүүс бас бидний итгэлийг гуйвуулдаг. Тиймээс ном уламжлахад маш олон төвөг бэрхшээл байдаг, Бурхан Бодьсадва хамаг төрөлтнийг заан жолоодох дургүй

биш, бас жинхэнэ номын уламжлал тасарсан, эсвэл оршихгүй болсон хэрэг биш, жинхэнэ ном нь үнэт эрдэнийн чулуу шиг эрхэм нандин болохоор зах дээр аваачиж арилжаалж болдоггүй.

Бясалгагч хүн нас барсныхаа дараа, тэр ч байтугай амьд сэрүүн үедээ ч гэсэн үнэн байдлыг мэдчихдэг. Ядаж л нэг хэсгийг нь мэдчихдэг. Яг л яст мэлхий усанд сэлж чаддаг хэр нь хуурай газарт ч мөлхөж гараад тоглож наадаж, дараа нь дахин усандаа ордогтой адил. Яст мэлхий хоёр төрлийн орчинд адилхан амьдарч чаддаг. Бясалгагчдын байдал бас үүнтэй адил. Тэд дээд хүслэнт ахуйгаар зугаалан амар амгалан, сэлүүн тунгалаг жаргалыг эдэлж, дараа нь самадигаас гарч, эгэл хүний биедээ буцаж ирдэг. Бясалгал хийдэггүй хүмүүс бол харин загастай адил, зөвхөн усан доторх ертөнцөө л мэдэхээс биш, хуурай газрыг мэддэггүй.

Загас яст мэлхийг усанд сэлэхийг хараад: “Яст мэлхий! Та чинь бас надтай адил усанд сэлдэг, гэхдээ надад огторгуй байдаг, хуурай газар байдаг, байшин байдаг, хүн төрөлтөн байдаг гэж ярьсан. Гэтэл энэ бүхнийг би ер харж байгаагүй!” гэж хэлдэг. Гэтэл яст мэлхий нээрэн харсан байдаг. Бясалгагчдын хүрсэн хүслэнт ахуй болон тэдний ярьдаг хэрэг учрыг ертөнцийн хүмүүс ойлгоход тун бэрх. Хүмүүс арга хэрэгсэл, ойлгох чадвар ч байхгүй, тиймээс итгэхэд тун бэрх. Шалтгаан нь иймхэн төдий байхад хүмүүс харин үүнээс болж харилцан буруугаар ойлголцдог.

Бурханы хутгийг олоход хүнд бэрх биш, Бурханы хутгийг олох нь маш амархан хэрэг. Бид хэрвээ бүр илүү үзэсгэлэнтэй ертөнцөд хүрч амьдрах хүсэлтэй бол, зөвхөн итгэж, туулан гэтлэхийг хүсдэг л юм бол хэцүү бэрх биш. Яах гэж Бурханы хутгийг ольё гэх юм бэ? гэж бүү асуу. Арьяабалын номын цогцыг бясалгавал мэдчихнэ. Битгий хаалганы гадна зогсчихоод л тэр номын цогцос нилээд сайн, нөгөө номын цогцос нь тийм ч сайн биш гэж мэтгээд

байгаарай! Номын цогцсын сайн, мууг бясалгаж байж л сая мэдэж чадна.

“Агшин зуур гэгээрч, энэ төрөлдөө туулан гэтэлнэ” гэдэг нь амьд байхдаа туулан гэтэлж, хоёр төрөл зүйлийн адил бус хүслэнт ахуйд амьдарч чаддаг бясалгагчийг хэлж буй хэрэг. Яг л яст мэлхий шиг усанд сэлж чаддаг атлаа бас хуурай газарт тоглож наадаж чаддаг. Судар номд зарим Бодьсадва өрөөндөө сууж байгаад Бурханы орныг харж чаддаг гэж ярьсан байдаг. Вайдахи хатан арын ордонд хоригдож байх үедээ Шагжамуни Бурханаас аврал гуйжээ. Тэгэхэд Бурхан Багш хувилгаан биеэр ирж түүнийг дагуулан Төгс баясгалант орныг харуулсан. Ийм үйл явдал эртний хүмүүст тохиолдож байсан юм бол одоогийн хүмүүст ч гэсэн тохиолдож болно.

Учир нь эртний хүмүүс болон одоогийн хүмүүсийн бодол санаа, оюун ухааны хэмжээ, ойлгох чадвар зэрэг нь тийм ч их зөрөөгүй. Зөрөө байлаа ч одоогийн хүмүүс эртний хүмүүсээс бүр ч илүү тодорхой ойлговол зохилтой билээ. Яагаад гэвэл одоо цаг нь бүр ч илүү соёлжин дэвшиж, мэдээлэл дамжих нь бүр ч түргэн болжээ. Тиймээс бид өөрсдийгөө эртний хүмүүсээс доор гэж үзэж болохгүй. Ойлгож байна уу? Би вьетнам хэлээр сайн ярьж чадахгүйгээсээ санаа зовж байна. Ертөнцийн үг хэлээр хангалттай сайн илэрхийлж чадахгүй болохоор та нараас ойлгож байна уу? гэж байнга асуудаг. Хэрвээ ойлгохгүй бол дараа нь Багшаасаа дахин асууж болно.

Дээдийн Номыг үг хэл хэрэглэхгүйгээр, сургаалаас ангид уламжилдаг

Багш нь одоо Арьяабалын номын цогцсыг бясалгах аргыг ярья. Бясалгалд хоёр зүйлийн арга байдаг: нэг нь онол, нөгөө нь бодитойгоор гүйцэтгэж дадуулах. Та нарыг

Арьяабалын номын цогцсыг бясалгахаас өмнө Багш нь эхлээд бясалгах аргыг заавал тайлбарлах, эсвэл яаж бясалгаж суух, анхаарлаа хаана хандуулах, хүслэнт ахуйн үнэн болон хуурмаг болохыг яаж ялгах гэх зэргийг миний өмнөөс тайлбарлаж өг гэж шавьдаа даалгах хэрэгтэй болдог. Тэгээд бүгдийг тодорхой ярьсны дараа дахин сахилаа чанд бөгөөд хичээнгүйлэн сахихыг анхааруулж, хамгийн эцэст сая үл үзэгдэх хүчээр ном уламжилдаг. Харин та нар тэндээ сууж байгаад аяндаа хүртдэг. Энэ бол сэтгэлээс сэтгэлд уламжлах арга юм.

Онол нь яг л анхааралдаа авах чухал зүйлстэй адил. Бодитойгоор гүйцэтгэн дадуулах нь онолд орохгүй. Гэхдээ л энэ хоёр холбоотой. Жишээлбэл, Багш нь та нараар цахилгааны залгуурыг залгуулбал гэрэл дорхноо асаж, цахилгаан сэнс эргэлдэж, бид халууцахаа болино. Цахилгааны залгуурыг залгах үйлдэл нь өөрөө цахилгаан биш - хэрвээ цахилгаан байхгүй бол залгуурыг залгасан ч сэнс эргэхгүй, чийдэн асахгүй. Чийдэн болон сэнсийг ажиллуулдаг зүйл бол цахилгаан хүч мөн. Ойлгож байна уу? Тиймээс сая үг хэл хэрэглэхгүйгээр сургаалаас ангид ном уламжилдаг гэж хэлдэг. Судар ном нь шашин суртахууны хамгийн чухал зүйл биш, зөвхөн биднийг хамгийн чухал зүйлийг хайж олоход чиглүүлдэг төдий зүйл билээ.

Жишээ нь, умард оронд суугаа нэг эрэгтэй болон өмнөд оронд суугаа нэг эмэгтэй харилцан хайр сэтгэлтэй болжээ. Эрэгтэй нь өдөр бүр, эсвэл долоо хоногт нэг удаа хайртай эмэгтэйдээ захидал бичдэг. Захидлын агуулга нь ямар болохыг та нар үнэндээ Багшаасаа илүү тодорхой мэднэ. Эхнэр нь, эсвэл найз бүсгүй нь захидлыг хүлээж аваад маш жаргалтай санагдаж, захидлыг элгэндээ тэвэрч, нүдээ алгуурхнаар аньж, аз жаргалдаа мансууран согтдог. Ингэдэг нь захидал дахь үг үсэг нь түүнийг баярлуулж жаргуулж байгаа хэрэг биш, харин үг үсгийн цаана агуулагдаж байгаа

сэтгэлийн хөдлөл, амраг хайр нь л жаргааж байгаа хэрэг юм.

Хэрвээ агуулга нь ав адилхан атлаа түүний хайртай хүнээс ирсэн захидал биш бол, эсвэл хайртаас нь ч илүү бичсэн зохиолоос ижил төстэй өгүүлбэрүүдийг олж харсан бол, тэр эмэгтэй баярлахгүй, сэтгэл нь хөдөлж нулимс унагаахгүй. Сэтгэлийн амрагийнх нь захидал л мөн бол энгийн үгс байлаа ч гэсэн тэр маш дуртай уншина. Та нар одоо ойлгосон уу? Гэтэл хайртай хүн нь нас барсан байвал тэр өнөөх захидлуудыг дахин уншсан ч урьдынх шигээ бал бурам амталсан мэт санагддаггүй, ойлгож байна уу?

Нэгэн цагт Хятадад нэгэн хос байжээ. Эр нөхөр нь цэрэгт татагдан явсны дараа эхнэр нь түүнийг машид дурсан санадаг боловч захидал бичиж чадахгүй болохоор санаж мөрөөдөж байгаагаа яаж илэрхийлэхээ мэдэхгүй байв. Тиймээс тэр дөрвөн зүйлийн амьтан зурж, амьтан болгоноор нэг үсгийг төлөөлүүлж, өөр нэг хүнээр тэр зургаа дайны газарт байгаа эр нөхөртөө хүргүүлжээ. Түүний эр нөхөр нь өнөөх захидлыг хараад доош суучихаад нүдээ аньж, хязгааргүй жаргалдаа мансуурсан байдалд оржээ.

Хажуудах найз нь өнөөх захидлыг хараад: “Эхнэр чинь зөвхөн дөрөвхөн амьтан зурсан байхад та яагаад тэгж ихээр баярлан жаргав” гэж асуужээ. “Миний эхнэрийн зургаар илтгэсэн үгийг та ойлгохын аргагүй!” гэж найздаа хариулжээ. Ойлгосон уу? Өгүүлэл зохиол буюу үг өгүүлбэр нь хүмүүсийн сэтгэлийг догдлуулдаг биш, харин бичсэн хүний тэр үгэндээ шингээсэн үнэн бодитой сэтгэлийн урсгал л сая бидний сэтгэлийг догдлуулдаг.

Бурхнаас суралцахад мөн л ийм. Заавал нэгэн амьд сэрүүн Бурхан байх хэрэгтэй, тэгж байж л биднийг удирдан жолоодно. Зөвхөн судар ном уншсаар өөрөө Бурханы хутагт хүрчихдэг юм биш. Гэрлэхэд ч гэсэн заавал нэгэн амьд сэрүүн хүнтэй гэрлэх хэрэгтэй. Харин түүх болж

үлдсэн нэр алдартай үзэсгэлэнтэй бүсгүйтэй гэрлэж болдог биш, нас барчихсан хүн хэдий гоё сайхан байсан байлаа ч хэрэгцээгүй, ойлгож байна уу? Эсвэл бидний гэдэс өвдвөл амьд сэрүүн эмчид хүрч эмчлүүлэх хэрэгтэй, харин Хуа Туо, Биан Чүе зэрэг агуу эмч нар бидэнд тусалж чадахгүй. Тэд хэдийгээр анагаах ухааны маш олон ном бичиж үлдээсэн боловч бидний өвчнийг эмчлэх аргагүй.

Анагаах ухааны ном өвчин анагааж чадахгүй, харин туршлагатай, өрөөлийг өөрийн бие шигээ хайрладаг сэтгэлтэй, бусдыг авран туслах эрхэм зорилготой эмч л бидэнд хэрэгтэй. Үхлээс аврах шидэт гартай эмч гэдгийн утга нь бусдын өвчнийг анагаах хүсэл болон эрхэм зорилготой төдийгүй, өвчтөн хүнтэй хувь барилдлагатай байхыг хэлж байгаа хэрэг. Зарим эмч адилхан л анагаах ухааны сургууль төгссөн боловч өвчтөнийг үхлээс аварч чаддаггүй, харин үхэл тийш хөтөлдөг. Ийм явдал байдаг уу? (Сонсогчид инээлдэхийн зэрэгцээ байдаг гэж хариулав). Та нарт баярлалаа! Би дур зоргоороо ярьчихлаа гэж бодсон чинь харин зөв ярьж байжээ.

Зарим эмчийн анагаах чадвар маш сайн, нэн алдартай байдаг тул хүн бүхэн түүн дээр очиж өвчнөө эмчлүүлдэг. Хэдийгээр удтал хүлээдэг, төлбөр нь тун үнэтэй байсан ч түүн дээр очиж эмчлүүлдэг. Түүнийг эрдэг хүмүүс дэндүү олон, дараалалд жагсан хүлээж байж л сая нэг эмчтэй уулздаг. Гэхдээ эмчийн гарыг атгамагц өвчин дорхноо сайжирсан мэт санагдана. Заримдаа бид өвчлөөд нилээд удсаны дараа эмч дээр очдог. Эмч бидний царайг харах төдийд өвчин нилээд хөнгөрсөн шиг санагддаг. Дараа нь эмч эм бичиж өгөхөд, эсвэл илүүхэн шиг халамжилж асуух үед өвчний байдал бүр ч илүү сайжирдаг. Яагаад ийм байдаг вэ? гэвэл эмч нэг зүйлийн уур амьсгал цацрааж, бидэнд тодорхой нэгэн түвшний намуун тогтуун хүч олгодог. Энэ хүмүүс бол эмч болох заяа буянтай бөгөөд бусдыг авран

туслах үүрэг хариуцлагатай хүмүүс юм. Ийм хүн тэнгэрийн хөвгүүн, эзэн хааны заяа буянтай, тэр хүн тийм ийм үүрэг хариуцлагыг гүйцэтгэх заяатай гэж бид байнга ярьдаг, тийм үү, үгүй юу?

Бурханы дэст хүрсний дараа тогтсон хувь заяанаасаа мултарчихдаг биш, харин энэ дэлхий дээрх ажил төрлөө хийхийн зэрэгцээ Бурханы орон дахь үйл хэргээ зэрэг гүйцэтгэж байдаг, яг л яст мэлхий усанд амьдрахын зэрэгцээ бас хуурай газарт амьдарч болдогтой адил. Жишээлбэл, нэгэн эмч Арьяабалын номын цогцсыг бясалгаад Бурханы хутагт хүрснийхээ дараа эмчийн ажлаа хаях шаардлагагүй, харин хоёр төрлийн ажил - эмч болон Бурханы ажлыг хамтад нь хийж болно. Энгийн эмч бол зөвхөн эмчийн ажлаа л хийж чадахаас биш, Бурханы ажлыг хийж чадахгүй. Зарим хүн хоёр, гурван төрлийн мэргэжлийн ур чадвартай бөгөөд хоёр, гурван төрлийн ажил хийдэг. Миний урьдын эр нөхөр бол хоёр, гурван өөр ажил хийдэг байсан. Учир нь тэр хоёр төрлийн анагаах ухааны мэргэжилд суралцсан болохоор мэс заслын эмч, бас шүдний эмчээр ажилладаг байсан. Ихэнх хүн ердөө зөвхөн ганцхан төрлийн мэргэжлийг суралцаад тэр ганцхан төрлийн ажлаа л хийдэг. Энэ бол тун энгийн хэрэг, ойлгохын аргагүй зүйл биш.

Тиймээс бид тэр бясалгал хийж билиг нээгдсэн хүмүүсийг харахад гадна талдаа бидэнтэй адилхан боловч дотооддоо бага зэрэг өөр байдаг. Тэд бүр ч илүү авьяас чадвартай, билиг ухаантай болсон байдаг. Бясалгал хийдэггүй зарим хүнийг гаднаас нь харахад бясалгал хийдэг хүмүүсээс ч илүү сайн ажилладаг боловч зөвхөн энэ ертөнцийн тал дээр л тийм байдаг төдий. Диваажингийн талын үйл хэргийг тэд харин хийж чаддаггүй.

Та нар Арьяабалын номын цогцсыг бясалгасны дараа Багшийнхаа өнөөдрийн ярьсан үгийн утга чанарыг ойлгох болно. Заримдаа та нар ном сонсохоор компаниасаа энд

яарч ирдэг. Магадгүй хоол ч идээгүй болохоор их өлсдөг байх. Тэгээд Багш нь удтал ном тайлсан ч та нар харин тэнд талх, хоол унд л бодоод суудаг. Тиймээс тодорхой сонсож чадалгүй, Багшийнхаа ярьсны агуулгыг ойлгоход тун бэрх санагддаг. Учир нь та нар бясалгал хийдэггүй болохоор тэр. Арьяабалын номын цогцсыг бясалгасны дараа Багш нь ярихгүй байсан ч гэсэн та нар ойлгох болно.

Дөнгөж авшиг хүртсэн хүнд ер нь асууж дуусахгүй олон асуулт байдаг, зуун найман асуулт, бүр мянган асуулттай сууж байдаг. Гэтэл хэсэг хугацаагаар бясалгасны дараа асуулт асуух шаардлагагүй болж, Багшийгаа харвал зөвхөн баярлахаас өөр яримаар үггүй болдог. Тэр үед бидний сэтгэл нэгэнт нам тайван болж, гэгээрч, хүсэл тачаал алга болж, өөрөө энэ төрөлдөө туулан гэтэлхээ тун баттай мэдчихсэн байдаг. Гэхдээ ихэнхдээ зөвхөн мэддэг төдий биш, бас харж чаддаг. Бид бясалгаж суугаад самадид орох үеэр дотооддоо тодорхой харж чаддаг.

Зарим хүн Багшийнх нь шавь нарыг Багшдаа дэндүү их автаж шүтэж байна гэж ярьдаг. Үнэндээ шавь нар маань эндүүрээгүй ташуураагүй, харин ухаан бодол тун саруул сэргэг болохоор үнэхээр бясалгал хийхийн чухлыг ойлгодог. Мухар сохроор шүтдэг хүн үүнийг яаж ойлгож чадах билээ? Тэд мөнгө олж, гоё том машин худалдан авч, үзэсгэлэнтэй хүүхнүүдийн араас хөөцөлдөж, идэж уун жаргаж цэнгэхийг л мэдэхээс биш, Багшийг нь дагаж бясалгал хийж яаж чадах билээ. Багшийгаа дагаж бясалгах нь тун зүдгүүртэй, веган хоол идэх хэрэгтэй болох бөгөөд ном дэлгэрүүлэхээр явахдаа бас өөрөө мөнгө гаргадаг. Багшийгаа дагаж олон газраар явахдаа тоног төхөөрөмж үүрч явна. Оройдоо үргэлж шалан дээр унтаж, тогтсон цагаар хооллож ч чаддаггүй. Заримдаа хахир хүйтэн оронд хүрч, тэндхийн цаг агаарт зохицож амжаагүй байтал дахин аагим халуун оронд очих болчихдог. Ингэж өдөржин яардаг болохоор бие нь тун ядардаг.

Тиймээс Багшийгаа дагадаг нь харин Багшдаа дэндүү автаж шүтсэнээс болсон биш, бодол санаа нь саруул сэргэг болохоор тэд үнэндээ салалгүй дагадаг. Тэд ухааран сэхээрч, энэ ертөнцийг хараад ном дэлгэрүүлж, хамаг төрөлтнийг гэтэлгэх, билиг нээгдэхэд нь бусдад туслах, санаа сэтгэлийг нь өдрөөс өдөрт уужуу тайвуу болгох, алдагдаж орхигдсон ёс суртахуунаа эрж олоход нь туслахаас өөр эрхэм дээд хэрэг байхгүйг хардаг.

Өчигдөр зарим авшигтан онгоцны буудал дээр ирж, Багшийгаа тоссон бөгөөд дараа нь бас Багшийгаа дагаж, Багшийнхаа суугаа газарт очсон. Тэдний дунд хорин хэдэн насны нэгэн залуу хүү байв. Багш нь онгоцны буудлаас яваад урьдаар нэгэн номын эгчийн гэрт амсхийгээд жаал жуул хоол идэв. Өнөөх номын эгч Багшийг нь гэртээ хоноглоно бодсон боловч гэр нь жаахан давчуу, Багш нь болон ном дэлгэрүүлэх багийн авшигтнуудаас гадна бас тоног төхөөрөмж энэ тэрийг багтаах зайгүй болохоор бид нилээд уужим байр эрэхээр болсон.

Тэгээд тэндээс арай хөдлөөгүй байхад өнөөх залуу хүү эхэр татан уйлж эхэлсэн. Багш нь түүнээс юунд уйлсныг асуухад тэр хүү зөвхөн: Багшдаа сайн яваарай гэж л хэлсэн. Чи яагаад бидэнтэй хамт явахгүй байгаа юм гэж намайг асуухад явж чадахгүй гэж хариулсан. Маргааш нь бид дахин уулзах байтал чи яагаад ингэж сүрхий уйлж байгаа юм бэ? гэж намайг асуухад тэр: Би маргааш бас энд ирж чадахгүй гэв. Яагаад тэр вэ, ажил чинь тун яаруугаас болсон уу? гэж Багш нь асуухад: Тийм гэж тэр хүү хариулсан билээ.

Хэрвээ өдөр ажиллах хэрэгтэй юм бол оройдоо Багштайгаа уулзахаар ирж болно. Хэрвээ орой ажиллах хэрэгтэй юм бол өдөр ирж болно. Уйлах хэрэг юу байна гэж Багш нь түүний сэтгэлийг засаж хэлэхэд: өдөр ч, орой ч ажиллаад завгүй болохоор Багштай уулзаж чадахгүй, гэр бүлээрээ арилжаа хийдэг тул бүгдээрээ Багштай уулзахаар

ирвэл эрхбиш хаалгаа хааж, ажлаа зогсоох хэрэгтэй. Ингэвэл орлого багасаж, амьдрал хүндэрнэ. Тиймээс би өөрийнхөө хүслээр өөрийгөө зориулж, гэрийнхнийгээ ирүүлэн Багштай уулзах завшаан олгодог гэж залуу хүү хариулсан.

Багш нь үүнийг сонсоод сэтгэл ихэд хөдөлж, түүнийг машиндаа суулгаж хамт явсан билээ. Ингэвэл ядаж Багштайгаа нэг, хоёр цаг ч гэсэн хамт байж чадна. Тэр хүү Багшид чинь: Ойрын хоёр хоногт Багштайгаа уулзахаар ирж чадахгүй, бас Багшийг явах үеэр ч үдэн мордуулж чадахгүй болохоор л уйлж байна гэж хэлсэн. Багш нь түүнийг дагуулан хамт хоол идэж, ус ууж, жигнэмэг идэв. Ингэвэл тэр буцсаныхаа дараа тэгж ихээр харамсахгүй болно. Тэр хүү Багшид нь: Урьд нь би дур зоргоороо аашилдаг дэггүй хүүхэд байсан гэсэн. Дэггүй хүүхэд гэдгийг Багш нь сайн ойлгоогүй, бодвол тэр урьд нь ямар ч муу хэрэг үйлддэг задарсан монди байсан байх. Одоо харин тэр засарч, ургамал хоол идэж, бясалгал хийдэг болжээ. Хэд хоногийн өмнө нэг хүн түүнийг зодсонд хариуд нь гар хөдөлсөнгүй, хожим нь тэр хүн нь түүнээс буруугаа хүлээсэн гэсэн. Энэ бүхнийг сонсоод Багш нь маш их баярласан. Яагаад вэ? гэвэл энэ нийгэмд илүү нэг сайн хүн, сайн хүүхэд нэмэгдсэн байна, илүү нэг сайн ах дүү, сайн найз, сайн иргэн нэмэгджээ.

Билиг нээгдвэл сая хүлэгдэхгүй болж чадна

Багшийнх нь ажил тун зүдгүүртэй, тун хүнд бэрх, яг л урсгал сөрдөг усчин шиг байдаг ч үр дүн нь харин тун тод харагдана. Эхлээд ирээдүйн диваажингийн тухай ярихаа больж, одоогийн тухай ярья! Хэрвээ одооноос эхлэн хүн бүхэн веган хоол идэж, өдөр бүр хоёр цаг хагас бясалгаж суувал харилцан өшөөрхөж, дайн үүсгэх хүнгүй болно. Багш нь ямар ч төрлийн номын цогцсыг сургасан бай, хүмүүсийг веган хоолтон болгож, сахил сахиулж, бясалгал хийлгэж

чадаж байгаа бол та нарын бодлоор Багшийнх нь сургадаг номын цогцос нь сайн уу, эсвэл муу юу? (Муу номын цогцос мөн гэж нэг хүн хариулав).

Багш: Муу номын цогцос мөн гэж хэн хэлэв? Яагаад муу гэдгийг та босож зогсоод хариулна уу? (Нэг сонсогч босож зогсоод: мөн л ургамал хоол идэх талд хүлэгдээд... гэж хариулав).

Багш: Та яагаад бид ургамал хоол идэх талд хүлэгдэж байна гэж үздэг вэ? Тэгвэл та яагаад махтай хоол идэх талд хүлэгддэг юм бэ?

Өнөөх хүн: Бурханы сургаалыг мөрдөхөд ургамал хоол иддэггүй, махтай хоол ч иддэггүй.

Багш: Бурханы сургаалд ийм зүйл байдаг юм уу? Ямар сударт ингэж хэлсэн байна? Та яримаар байгаа юм бол гэрч баримт дурдаарай!

Өнөөх хүн: “Билгийн чанагуух Очир огтлогч судар”-т дурдсан байна.

Багш: “Очир огтлогч судар”-т юу гэж ярьсан бэ?

Өнөөх хүн: Сайныг ч бодохгүй, мууг ч бодохгүй.

Багш: Бурхан Багш хэлэхдээ ургамал хоол идэж байж л тийм түвшинд хүрч чадна гэжээ. “Баатараа явагч их хөлгөн судар”-т Бурхан Багшаас махтай хоол идэх нь ад чөтгөрийг дагаж байгаагаас биш, бурхныг дагаж байгаа биш гэж номлосон байдаг, та уншаагүй юу? “Сайныг ч бодохгүй, мууг ч бодохгүй” гэдэг нь тэр Бурханы хутагт хүрсэн богд гэгээнтнүүдэд хандаж ярьсан үг. Тэд нэгэнт Бурханы түвшинд хүрч, хүний амьдрал нь тэдний хувьд хий бодол төдий болсон байдаг. Одоо бусад хүн биднийг зодоход бид мөн л өвдөх мэдрэмжтэй, хүн бидний амийг хөнөөвөл бид мөн л занан хорсдог юм чинь яаж “Сайныг ч бодохгүй, мууг ч бодохгүй” гэж ярьж болох вэ? Тэгвэл хүн алах болон алахгүй хоёр нь адилхан гэж үү? (Бүгдээрээ алга ташив)

Багш нь таны санааг ойлгож байна, гэхдээ та хараахан тийм түвшинд хүрээгүй, зөвхөн Бурханы ярьсан үгийг л давтан ярьж байна. Ингэх нь бас тун сайн хэрэг, бусдад сануулан сэрэмжлүүлж чадна. Гэвч бид өөрсдөө бясалгал хийж, тийм дэст хүрвэл сая тэгж ярьж болно. Жишээ нь, доктор аль хэдийн их сургуулийн хичээлээ сурч дуусаад нэгэнт профессор болчихсон болохоор мэдээж дахин сургуульд сууж, хоёр дээр хоёрыг нэмбэл дөрөв болно гэж суралцах шаардлагагүй. Учир нь үүнийг тэр нэгэнт сураад дуусчихсан.

Одоо хэрвээ хэн нэг хүн түүгээр “Хоёр дээр хоёрыг нэмбэл хэд болох вэ?” гэж бодуулбал тэр мөн л “дөрөв болно” гэнэ, харин “хоёр дээр хоёрыг нэмбэл тав болно” гэхгүй. Гэхдээ тэр энэ бүх хичээлийг дахин сурах шаардлагагүй. Учир нь нэгэнт бүгдийг сурчихсан. Хэрвээ сурагч нь түүнээс: “Та яагаад өдөржин гадагш яваад ном уншихгүй, суралцах ч үгүй байдаг юм бэ? Яагаад бидэнтэй адил сургуульд суралцдаггүй юм бэ?” гэж асуувал: “Ай хөөрхий! Суралцмаар зүйл бас юу байх вэ дээ” л гэж хариулна.

Тэр нэгэнт бүгдийг сураад дуусчихсан, харин бид сурч дуусаагүй болохоор профессортой адилхан үг ярьж яаж чадах вэ. Хэрвээ түүнийг дуурайж яривал, өсгөж дэврүүлж ярьж байгаа, бусдын үгийг ахин дахин ярьж байгаа хэрэг. Харин бид өөрөө ойлгосон хэрэг биш болно. Жишээ нь, Багш нь: Бурхны сургаалд сайныг ч бодохгүй, мууг ч бодохгүй байх нь сая туулан гэтэлсэн болно гэж ярьдаг нь би үүнийг нэгэнт ойлгочихсон учраас тэр. Гэвч энэ нь та нар бас ойлгочихсон гэсэн үг биш. Тиймээс Багш нь өөр нэгэн газар ном тайлахдаа: веган хоол идээд Бурханы хутагт хүрч чадахгүй, зөвхөн бидэнд Бурханы хуггийг олоход туслах төдий зүйл юм гэж ярьсан.

Бид нирваанд буцах, туулан гэтлэх гэх мэтийн үгийг хэрэглэхгүй өөр үгээр орлуулсан ч бас л адилхан. Хэрвээ

дэлхийн хүмүүс бүгдээрээ веган хоолтон болж, бясалгаж суун Бурхныг дурсвал дайн дажин үүсгэх хүнгүй болж, хүний ертөнцийн гаслан зовлон багасах болно. Та ойлгож байна уу? Багш нь маш олон агуулга болон хүслэнт ахуйг ярихдаа зөвхөн ургамал хоол идэхийг л чухалчлан шаардсан биш, гэтэл та зөвхөн ургамал хоол идэх талд л хүлэгдээд байгаа ч харин хүлэгдээгүй гэж ярих юм. Багш нь ийм олон талаар ярьсан байхад та яагаад ганцхан талд нь л хүлэгдэнэ вэ? За! Тантай дахин маргалдахаа больё! (Багш инээв, бүгдээрээ алга ташив.)

Сэтгэл ариун бол улс орон амар амгалан

Багшийнх нь ярьсан санаа бол: бясалгагч хүн нирвааны дэсийг хараахан олоогүй боловч энэ дэлхийд байхдаа нэгэнт диваажинг харж чаддаг. Хүмүүс хэрвээ хэрэлдэж зодолдвол нэг хүн нь нөгөө хүнээ зодоход зодуулсан хүн нь эргүүлээд ихэд зоддог. Тэгээд өшөө хорсол нь улам гүн болж, муу үйл хэрэг тасралгүй эргэлдэн зузаардаг. Тиймээс бидний ертөнц гаслан зовлонтой байдаг. Хэрвээ хүн болгон цөм веган хоолтон болж, бясалгаж суувал бид Бурханы оронд очих шаардлагагүй. Багш нь та нарт тодорхой хэлье: тэр үед бидэнд Бурханы ариун оронд очих шаардлага байхгүй. Учир нь бидний энэ ертөнц Бурханы орон болчихсон байх болно. Ойлгож байна уу? Багшийнх нь гаргасан дүгнэлт гэвэл: “Сэтгэл ариун бол улс орон амар амгалан”. Хэрвээ хүн болгон ариун тунгалаг болчихвол Бурханы орныг хайх хэрэг юу билээ? Бурхны орон энд байх бөгөөд нас барсны дараах хүслэнт ахуй ч мөн сэтгэлээс бий болдог. Бид одоо энэ ертөнцөд амьдрахдаа өдөр бүхэн булаалдан тэмцэлдэж, алалдаж хядалцаж байвал нас барсныхаа дараа амьддаа хийсэн аливаа үйлийн нөлөө тусгал маань бидний өмнө тасралтгүй илрэн гарч ирээд биднийг уяж хүлж, биднийг

туулан гэтлэж чадахгүй болгодог.

“Сайныг ч бодохгүй, мууг ч бодохгүй” гэдэг нь Бурханы хутагт хүрсний дараа бусдаар загнуулах нь харин бусдад магтуулахтай адил санагдахыг хэлж байгаа хэрэг билээ. Бид дахин хэнийг ч шүүмжлэхээ больж, бусдад зодуулсан ч өш хонзон боддоггүй. Энэ нь сая “сайныг ч бодохгүй, мууг ч бодохгүй” гэдэг болно. Жишээлбэл, Есүс Христ, Тэрээр нэгэнт Бурханы хутгийг олчихсон болохоор: хүн бидний зүүн хацрыг алгавал баруун хацраа ч алгадуул гэж хэлсэн байдаг. Энэ бол сая “сайныг ч бодохгүй, мууг ч бодохгүй” гэдэг болно.

“Сайныг ч бодохгүй, мууг ч бодохгүй” гэж ярих атлаа бодитойгоор гүйцэтгэж чадахгүй буюу бага зэрэг ойлгосны дараа бусадтай хэрүүл үүсгэн нөхөрсөг биш байж болохгүй гэдгийг бид тодорхой ойлговол зохино. Гэвч таныг ингэж ярьсанд Багш нь тун их баярлаж байна. Ингэснээр Багшид нь илүүхэн шиг тайлбарлах завшаан олдлоо. Зарим хүн хэдийгээр яриагүй ч мөн тан шиг ингэж бодож байж ч магад.

“Сайныг ч бодохгүй, мууг ч бодохгүй” гэдэг нь хүн болгонд адил тэгшээр хандах гэсэн утгатай. Бусад хүн бидэнд яаж хандсан ч яг л ямар ч хэрэг явдал үүсээгүй юм шиг хандах явдал юм. Бид тамын оронд очих нь яг л газрын зүрхэн Бодьсатва тамын оронд очдогтой адил: халууцахгүй, шатахгүй, тэнд очиж байгаа нь зөвхөн хүн аврахын л төлөө юм. Одоо бидний бясалгалын хүч хараахан хангалттай биш, хэрвээ одоо биднийг тамын оронд очуулбал дорхноо галд шатаж үхэх болно. Тиймээс “сайныг ч бодохгүй, мууг ч бодохгүй” гэж бардаж болохгүй.

Нэгэнт Бурханы хутагт хүрсэн тэр хүмүүсийн хувьд бол тэнд очих нь яг л очоогүйтэй адил байдаг. Тэд тамын оронд очих нь яг л диваажинд очихтой адил. Учир нь тэдний бясалгалын хүч аль хэдийн асар их болчихжээ.

Тэдний сэтгэл нь ариусчихсан болохоор улс орон нь ч амар амгалан. Та нар Бурханы хутагт хүрсэн хүн хүн алж, бор хоол иддэгийг харсан уу? Шагжамуни Бурхан хүртэл бас ургамал хоол иддэг байжээ. Тиймээс бид бясалгахад бор хоол, веган хоол гэж хүлэгдэх хэрэггүй гэж хэлж болохгүй.

Хүлэгдэхгүй бол дэлхий дахин ихэд самуурах болно. Бидний мөнгө бол бас бусдын мөнгө мөн гэх юм бол ажил хийж мөнгө олох хэрэг юу байна? Бусдын эхнэр нь мөн л бидний эхнэр мөн гэх юм бол гэрлэх шаардлага байхгүй. Энэ ертөнцөд амьдарч байгаа болохоор эрхбиш эндхийн хууль дүрмийг дагах хэрэгтэй. Бидний туулан гэтлэх сэтгэл дотоодод маань байгаа билээ. Та нар ойлгож байна уу? Ерөнхийлөгч ч гэсэн бас улсын хууль дүрмийг даган сахих хэрэгтэй. Тэр хуулийг зөрчвөл мөн л ял хүлээж, шоронд орно. Хэн нэг хуулийг хэрэгжүүлэгч нь шударга ёсны хэмжүүрийг гартаа атгаж байгаа атлаа өөрөө харин дур зоргоороо юу хийнэ гэснээ шууд л хийнэ гэвэл энэ нь бүтэхгүй хэрэг болно.



ЗУРГААН БИЛИГ БАРАМИД

*Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Америкийн Техас мужийн Хьюстон
1991 оны 3 дугаар сарын 1 (Эх нь вьетнам хэлээр)*

※ Алхах, зогсох, суух, хэвтэх нь бүгд л бясалгал мөн. Зөвхөн завилж суухыг л сая бясалгал гэдэг биш. Билиг нээгдсэн хүний амьдрал бүхэлдээ бясалгал мөн. Амьсгалах нь бясалгал, хоол идэх нь бясалгал, унтах нь бясалгал, ажиллах нь бясалгал, аяга тавгаа угаах нь бясалгал, хэзээд ч бүгд бясалгал мөн.

Шинэ он гараад удаагүй байна. Та нарын санасан бүхэн чинь сэтгэлчлэн бүтэж, гэр хотлоороо элэг бүтэн, арилжаа наймаа цэцэглэн хөгжиж, үр ач нар тань ухаан цэцэн, ажил үйлс дүүрэн амжилттай, бясалгал тань түргэн дэвшиж, Бурханы хутагт хүрэхийг хүсэн ерөөе! (Бүгдээрээ алга ташив).

Ойрд дэлхий дахинд даяан бясалгал ихээр дэлгэрч, бясалгалд дуртай хүмүүс их болжээ. Зарим улс орон дайн дажин үүсгэхийг завддаг боловч тэр нь хүмүүст ач тусаар тун бага гэдгийг хүмүүс ойлгосон байна. Тиймээс Багш нь өнөөдөр дэлхий дахины хүмүүс бясалгалд шамддаг болсон гэж ярьж байгаа юм. Өнөөдөр Вашингтон муж дахь

Үндэсний Телевизээс ирж Багшаас нь ярилцлага авсан. Тэд: “Таны бодлоор танай хийж буй үйл ажлууд бүх дэлхийн үндэстэн бүрийг нэгтгэж чадна гэж бодож байна уу? Энэ нь дайн дажныг зогсоож чадах уу?” гэж асуусан.

Багш нь: “Хэрвээ хүн болгон миний ярьж байгаа бүхнийг ойлгож, үүнд итгэж, бясалгал хийвэл энэ нь боломжтой зүйл билээ. Хэдийгээр хэрвээ бүх дэлхий нэгдэж чадахгүй юм гэхэд бид ядаж л урт харанхуй шөнө хэдэн бамбар асаасан. Ганц хоёр бамбар ч болтугай байх нь оргүйгээс дээр” гэж бодож байна. Энэ харанхуй дэлхийд бамбар асаах гэж хэлсэн юм. Дараа нь тэд: “Таны бодлоор дэлхий дахин одоо яг харанхуй цаг үед байна уу? Эсвэл гэгээрэл, гэрэл гэгээтэй үе рүү орж байна уу?” гэж асуухад Багш нь: “Миний бодлоор дэлхий дахин одоо гэрэл гэгээтэй үе рүү дэвшиж байна” гэсэн. Тэгэхэд сурвалжлагч: “Яагаад?” гэж асуухад Багш нь: “Та хар л даа! Одоо дэлхийн улс орон бүрт, тухайлбал Америк улсад бясалгах хөдөлгөөн хаа сайгүй өрнөж байна” гэж хариулсан.

Бясалгал дэгжирхэл болоод буй

Багш нь Зэн бясалгал гэж ярих дургүй. Ингэж ярихаар хүмүүс энэ бол Бурханы шашин гэж бодоод биднийг Бурханы шашныг ухуулж, сурталчилж байна гэж бодно. Гэсэн ч Багш нь бас зөвхөн Зэн бясалгалын дадуулалтын тухай ярина, эс тэгвэл өөр юунд сургах билээ? Бясалгал болгон Зэн-тэй адилгүй. Ау Лакын Зэнтэй ч адил биш.

Бясалгал гэдэг ер нь бол бясалган суухыг багтаадаг сүнслэг дадуулалт юм. Тийм учраас хүмүүсийг сургадаг аливаа байгууллага нь нам гүм суух, дотоодын Би дээрээ бясалган төвлөрөх юмуу эсвэл Бурханы Нэрийг дурсаж, ямар нэг маани тарни уншихыг бясалгал гэдэг. Тэгэхлээр, бясалгал гэдэг нь зөвхөн Бурханы шашны төлөө ч, зөвхөн

Ау Лакчуудын төлөө ч биш, эсвэл надтай хамт бясалгал дадуулагчдын төлөө зүйл биш юм. Бид юу чин шударга, үнэн зөв байна, түүнийг л ярих ёстой. “Бясалгал” гэдэг үг Ау Лакт ч, Бурханы шашны алинд ч хамаардаггүй. Бид Самгарьд, Пали хэлний “Дхьяна” гэдэг үгийг зээлдэж авсан. Тэгсэн мөртлөө хожим нь бид бусад дадал бясалгалыг буруу номынх гэж хэлдэг. Гэвч бид бас л бусдаас зээлдсэн шүү дээ. Бурханы шашны бичвэрээс бидний уншдаг маань тарни, судар ном нь үндсэндээ энэтхэгчүүдэд хамаарна. Хэрвээ та нар надад итгэхгүй байгаа бол Энэтхэгт очоод хинди хэл сур, тэгвэл та нар мэдчихнэ.

Жишээлбэл, бид судар ном аялгуулан уншихаасаа өмнө “Ан Лан” гэж уншиж бие, хэл, сэтгэлээ ариусгадаг. Энэ бол Энэтхэгийн Бярманы шашны гол үндсэн тарни! Тэд ер нь бол “Ом Рам” Om Ram гэж нэрлэдэг. Энэ нь Эзэн Бурханыг сайшаан магтмуй гэсэн утгатай. “Рам” Ram гэдэг нь Эзэн Бурхан гэсэн утгатай.

Жишээлбэл, бид сүм хийдэд очих үедээ “Амитаба Бурхан” гэж уншиж байхыг үргэлж сонсдог. Энэтхэгт бол Рам Рам (Ram Ram) эсвэл Ом Ом Ом Ом), Рам Ом Ом Рам Рам Ом Ом Рам гэдэг. Рам-ыг хятад хэл рүү орчуулах гэхэд хятад хэлэнд R гэх авиа байхгүй болохоор Рам нь Лам lam болоод Ом Рам нь Ан Лан an lan болж хувирчээ. Бас жишээлбэл, “Ха ли Ха ли, Хэ ри Хэ ри” Ha Li Ha Li, He Ri He Ri . Тэнд “Хари Хари” нь Хари Кришна Hari Krishna гэдэг шиг.

Одоо дэлхийн ихэнх сүнслэг бясалгалын бүлгийнхэн бүгд л даяан бясалгалаар бясалган сууж байна. Та нар Америкт, тус орны хүмүүсийн дунд дэлгэрч байгаа йогийн бясалгалыг анхаарч, даяан бясалгалын төвүүдийг харсан бол даяан бясалгал нэгэнт түгээмэл үзэгдэл болсныг мэдэж болно. Ургамал хоолны (веган) тухай ном бичиг, мэдээлэл тоолж барамгүй олон болжээ.

Багш нь Канадад очоод тэнд хэдэн хүнд авшиг хүртээсэн юм (тайлбар: Багш саяхан Канадад ном тайлж дуусаад Америкт ирсэн байв). Тэдний дунд нэгэн залуу ургамал хоолны газар ажиллуулдаг бөгөөд ургамал хоолтон болоод хэдэн арван жил болсон байсан. Дэлхийн бөмбөрцгийн цаад хязгаарт, хахир хүйтэн, бөглүү хойд туйлын ойролцоо улсад ургамал хоолтон байгаад та нар гайхахгүй байна уу? Өнөө залуу бие бялдар сайтай, улаа бутарсан царайтай, өндөр том биетэй ганган эр байна лээ. Харахад мах иддэг Вьетнамчуудаас ч царайлаг. Аа! Уучлаарай! Үгүй, Вьетнамчууд дэлхий дээр хамгаас үзэсгэлэнтэй үндэстэн шүү дээ! (Багш инээв)

Үнэндээ бас нээрэн тийм шүү! Багшийг нь дагаж Канадад очсон хүмүүс бүгд л түүнийг харсан. Өндөр том биетэй байсан. Багш нь тэндээс буцах өдөр тэр бас нийтийн бясалгалд оролцсон бөгөөд Багшийг нь үдэж өгсөн. Тэр ургамал хоолны бизнес эрхлээд зогсохгүй, бас сонин хэвлүүлж хүмүүст ургамал хоол идэхийг уриалан дууддаг. Тэрээр сониндоо ургамал хоолны тухай тун олон мэдээлэл нийтэлснийг та нар бүгд (Багш дагаж явсан шавь нараа заав) харсан, тийм ээ. Тэр канад залуу Буддын шашинтан биднээс ч илүү сайн байна. Тэрээр ингэж ажиллаад олон жил болж байгаа бөгөөд ургамал хоолны зоогийн газраа өргөтгөж байгаа гэсэн. Түүний удахгүй нээх гэж байгаа шинэ хоолны газар нь одоо байгаа хоолны газраас нь хэд дахин том бөгөөд бүгдийг нь өөрөө ажиллуулна гэж байна лээ.

Тиймээс одоогийн хүмүүс ургамал хоол болон бясалгал хийх тухай нэгэнт сайн мэддэг болсон бөгөөд нууц, сүрхий зүйл мэт санахаа больж, үүний тухай мэтгэж маргалдахаа ч больжээ. Бид ахиухан лавлаж, судлан суралцвал зохино. Тэр тусмаа, гадаадад ирсэн азтай Вьетнамчуудад шашин шүтлэг чөлөөтэй иргэншсэн улсад амьдрахдаа шинэ мэдлэгт суралцах нь бүр ч илүү хялбар

байх болно.

Энд ирсэн Вьетнамчууд дэлхий дахины шинэ үзэл санааны урсгалд түргэн нэвтэрч, боловсон цагийн өнгө аясыг дагаж, өөрийгөө хөгжүүлэхийг Багш нь сануулж байна. Харин хуучин, ойлгомжгүй судар ном уншиж, ямар ч үр дүнгүй бясалгалын аргадаа хүлэгдэж болохгүй. Бясалгал дадуулаад амжилтад хүрсэн, санаа бодол нь нилээд дэвшингүй шинэ хүмүүсийг буруушаан зэмлэж болохгүй. Ингэх нь өөрт чинь болоод улс үндэстэнд тань аль алинд хортой бөгөөд ач тусгүй.

Бурхан тэнгэрийн нинжин сэтгэл

Гадаад улсад амьдарч байгаа Вьетнамчууд хожим эх орондоо буцаж очоод элэг нэгтнүүддээ үлгэр дуурайл болно. Тогтсон үйлийн үрээс, эсвэл нөхцөл боломж хангалтгүйгээс болж гадаадад суралцаж чадаагүй тэр элэг нэгтнүүддээ бид туслах хэрэгтэй. Эзэн Бурхан, Эцэг Тэнгэр та нарыг гадаад улсад жарган цэнгэж, мөнгө төгрөг олуулахын төлөө л ирүүлээгүй шүү! Эцэг Тэнгэр бүр ч чухал төлөвлөгөө, үүрэг даалгаврыг та нарт даалгасан байж ч магад.

Урд нь Вьетнамчууд зөвхөн Вьетнамдаа л амьдардаг байсан. Одоо тэд нэгэнт дэлхийн аль ч оронд амьдрах болжээ. Хожим бидний аав ээж, ах дүүс, хамаатан садан Австрали, Америк, Испани, Португал, Франц, Герман, Танамарка, Норвег иргэд болж ч мэдэх бөгөөд бидний хамаатан садан дэлхийн орон бүрт байх болно. Энэ нь тун сонирхолтой шүү дээ. Бид үндэстэн бүрийн шилдэг талуудыг уусган шингээж, тэдний соёл иргэншлээс суралцана. Тэр үед манай улс юугаар ч дутахгүй болно.

Тиймээс та нар одоо энд байхдаа мөнгө олж амьдрах, аав ээжээ ачлах, ах дүүсдээ туслахаас гадна бас бусад улсын хамгийн шилдэг зүйлсээс суралцаж, хожим завшаан олдож,

эх орондоо буцсаны хойно Вьетнамын гэрэл цацарсан нэгэн гэрэлт од болох хэрэгтэй (Бүгд алга ташив). Багш нь хэдийгээр дэлхий дахины олон улсаар аялж явсан боловч мөн л Вьетнамд мэндэлж, Вьетнам хоол идэж өссөн бөгөөд Вьетнам улсын сурган хүмүүжлийн ач ивээлийг хүртсэн. Багшийнх нь одоо хийж байгаа аливаа үйл хэрэг нь бүгд л ач хариулж буй төдий билээ.

Багш нь олон улсын сайшаал үнэлэлтийг хүртсэн байвал тэр нь мөн л Вьетнамчуудын яруу алдар болно. Та нар Вьетнамын эх оронч иргэн болохыг хүсвэл хичээнгүйлэн суралцвал зохино. Багшийнхаа өнөөдрийн ярьсанд итгэхгүй байлаа ч хамаагүй, хожим алгуураар ойлгох болно. Одоо итгэж чадахгүй байгаа хэдий ч битгий дорхноо үгүйсгээрэй! Тийм биз? Багшийнх нь ярьсан бүхэн үнэн болохыг нотлох гэрч баримт хангалттай их байгаа.

Урьд нь Руан Чангзуо Франц улсад очоод буцаж улсдаа ирсний дараа хаан болон их түшмэддээ: “Франц улс болон манай улсын зөрөө асар их, тэдний ашигладаг ус нь хананаасаа урсан гардаг, гэрэл нь доош дүүжлээстэй, тэрэг нь мориор чирүүлдэггүй” гэхчлэн ярьсан байдаг. Хаан эзэн үүнийг сонссоны дараа хааныг хуурч мэхлэн улсаа гутаан доромжилсон ял тулгаж толгойг нь цавчжээ. Хаан эзэн болон төрийн их түшмэд бүгдийн мэддэггүй хэргийг Руан Чангзуо яаж мэддэг юм? Урьд нь хэн ч гэрэл нь доош дүүжлэгдэн гэрэлтдэг, ус нь хананаасаа урсан гарч ирдэг, тэрэг нь мориор чирүүлэлгүй давхидаг гэж дуулж байгаагүй тул тэд Руан Чангзуог алах ялаар шийтгэжээ.

Эрт дээр үед хүмүүс “эзэн хаан”-ыг тэнгэрийн хөвгүүн, юу ярьсан ч бүгд зөв, төрийн олон их түшмэл бүгд улсын гарамгай чадвартай хүмүүс, улсын бүх иргэнийг угаас хаан болон их түшмэд захирдаг гэж үздэг байсан. Тиймээс тэдэнд мэдэхгүй зүйл байдаг гэж тэд төсөөлж ч чадахгүй байжээ. Энэ хэрэг ердөө тэд франц улсад очиж

байгаагүйгээс болсон байна.

Тэд хэрвээ франц улсад очиж үзсэн бол бас гэрэл нь доош дүүжлээстэй асаж, ус нь хананаас урсан гардаг байдлыг харах болно. Одоо бол энэ бүхнийг хүн бүхэн мэддэг. Гэтэл хэдэн зуун жилийн өмнө хааны угсааныханд нийслэл хотоосоо гарах тохиолдол ерөөс байгаагүй, ихдээ л ой шугуйд хүрч, ан ав хийдэг байсан бөгөөд гадаад орны шинэ бүтээлүүдийг битгий хэл өөрийн орны үндэсний нөхцөл байдлын талаар сайн мэдэхгүй байсан байж ч мэднэ.

Та нарын үүрэг хариуцлага бол суралцах явдал

Вьетнамчууд олон зовлон зүдгүүр амссаны учир гэвэл олон буруу зүйл хийснээс болсон. Бид өөрсдийнхөө бурууг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Вьетнамчууд ард иргэдийнхээ нөхцөл байдал болон улс төрийг үл хайхарсан, мөн бусад улсын соёл иргэншлийг үл хайхарснаас өнөөдрийн байдалд орсон байна. Гэхдээ бид бас зовлон зүдгүүрийг нэг зүйлийн хичээл гэж үзэж, хүн төрөлхтний хувьсал хөгжлийн замаар бүр ч илүү хичээнгүйлэн чармайн зүтгэж, орчлонгийн хамгийн дээд түвшин рүү дэвшвэл зохино.

Бид сонор сэрэмжгүй байж, бие биеэ харилцан гүтгэж, нэг нэгнийхээ муу талыг дэлхий нийтэд дэлгэсээр байх юм бол Багш нь дэлхийн бүх оронд, орчлон ертөнц даяар Вьетнамчуудыг хичнээн сайшаан магтсан ч, дүрвэгсдийн хуарангаас хичнээн Вьетнам хүнийг чөлөөлсөн ч ямар ч нэмэргүй. Тиймээс та нар өөрсдийн үүрэг хариуцлагаа сайтар биелүүлэх нь чухал бөгөөд та нарын “үүрэг хариуцлага” бол суралцах явдал юм шүү.

Багш нь та нарт нэгэн суралцах аргыг санал болгож байна! Зүй ёсонд нийцнэ гэж бодвол суралцахаар ирээрэй! Үүнд мөнгө төгрөг авдаггүй, үнэгүй сургана. Энд бол чөлөөт ертөнц, Багш нь улс болон нийгмийг хордуулах, ёс

суртахууныг доройтуулах ямар нэгэн зүйлийг сургахгүй, тиймээс та нар Багшийгаа зэмлэн буруушаах зүйлгүй.

Өнөөдөр улс орон болгонд тун олон бүлгэм цуглаан болж даяан хийж байна. Даяан бясалгалд тун олон төрлийн арга байдаг бөгөөд өөр өөрийн зохион байгуулалттай, зарим нь мөнгө хураана, зарим нь хураахгүй, зарим бүлгэмийнхэн дэлхийн бүх оронд хүрч ном дэлгэрүүлж, зарим нь харин тогтсон нэгэн оронд суурьшиж, хүмүүс сураглан хайж очдог. Мөнгө хураах эсэх, ном дэлгэрүүлэхээр явах, эсвэл хувь барилдлагатай хүмүүс хайж ирэхийг хүлээх аль нь ч бай, энэ бүх байгууллагын бясалгалын арга нь ямар ч байсан ялгаагүй бүгд л энэ ертөнцөд амар амгалангийн соронзон талбайг бий болгоход хувь нэмрээ оруулахын төлөө билээ. Сүнслэг бясалгалын бүлгэм олон болох тусам дэлхий дахин төдий чинээ соёлжин иргэншиж, хөгжин дэвшиж, амгалан тайван болдог.

Багш нь ч гэсэн зөвхөн тэдний доторх нэгэн жижигхэн бамбар мөн. Тухайн үед эцэг Тэнгэр Багшийг нь шахаж ном дэлгэрүүл гэхэд Багш нь үүнээс олонтоо татгалзсан ч тэр болгонд хүмүүст танигдаж, бусад улсад хүрч нуун далдаллаа ч дахин танигдаж, дахин гурвантаа, дөрвөнтэй нуугдсан. Дөрөв дэх удаа нуугдахын аргагүй болохдоо бууж өгөх л хэрэгтэй болж, энэ үүргийг хүлээн авсан юм. Багш нь огт хариуцлагаасаа бултан зайлсхийсэн бус, харин өөрийгөө энэ дэлхийд хандивлах чадвараар хангалтгүй гэж бодсоноос тэгсэн юм. Тэгээд энэ үүргийг хүлээж авсан хойноо л сая өөртөө ийм чадвар байдгийг мэдсэн билээ. Чадвар маань маш их гэж ярьж зүрхлэхгүй ч, ядаж чадах чинээгээрээ зарим зүйлийг хийж хэрэгжүүлсэн.

Америк дахь Вьетнамчууд америк болон бүх хүн төрөлхтний сүнслэг талын хөгжлийг хурдан түргэн гүйцэж, хөл нийлүүлэх хэрэгтэй. Та нар амь насны аюулыг сөрж энд ирсэн байтлаа харин зөвхөн мөнгө олохыг л бодох нь дэндүү

харамсмаар хэрэг. Вьетнам бол дэлхий дээрх хамгийн баян тансаг улсын нэг. Бидэнд алт, уран, мөнгө, цайр, хар тугалга, цагаан тугалга гэх мэтийн орд уурхай олон бий. Франц улсад эзлэгдэхээс өмнө маш олон төрлийн хүдрийг ар араас нь тасралтгүй олборлож байсан. Хожим нь дайнаас болж үргэлжлэн олборлож чадахгүйд хүрсэн. Вьетнам юугаар ч дутахгүй, элбэг баялаг нөөцтэйгөөс гадна бас эрхэм дээд ёс суртахуун болон уламжлалт ачлал журмын оюун ухаантай.

Вьетнам бараг дөрөв, таван мянган жилийн өнө удаан түүх соёлтой, хамгийн ахмад, эртний гүрнүүдийн нэг бөгөөд уг нь дэлхийн үлгэр жишээ болж байх учиртай улс. Тиймээс та нар эрх чөлөөт ертөнцөд ирсэн атлаа битгий мөнгө олж, Вьетнам руу гуйвуулахыг л бодоод байгаарай. Харин бүр ч их үүрэг хариуцлагатайгаа санаж яв. Үүнийг зарим хүн мэдэхгүй байгаа бол Багш нь өнөөдөр та нарт хэлье: Бурхан Бодьсадва, Эзэн Бурхан та нарыг энэ дэлхийн бүх улсаар зохицуулан байрлуулсны зорилго нь мөнгө олуулахын төлөө биш шүү!

Урьд нь Вьетнамд бас дайн үүссэн түүхтэй, гэвч бид өлсөхийн зовлонд өртөөгүй. Эдийн засгийн шалтгаанаас болж цагаачилж дүрвэсэн хүн ерөөс байгаагүй. Үүнийг хэн бүхэн мэднэ. Багш нь сургуульд сурч байсан урьдын байдлаа бас санаж байна. Пинг янг, Лонг Чэнгийн зам дагуу янз бүрийн жимсний мод тарьсан байх бөгөөд бид дураараа идэж болдог, мөн худалдаж авсан ч хямдхан байдаг байсан. Вьетнамын цагаан будаа зүүн өмнөд Азид, тэр ч байтугай бүх дэлхийд тун алдартай, өөрсдөө идэж барахгүй тул гадаадад борлуулдаг байсан. Вьетнамын будаа хамгаас амттай байдгийг хүн бүхэн мэднэ. Махтай хоолны талаар гэвэл Вьетнамын загасны мисо соус дэлхийд алдартай. Вьетнам энх тайван байдалдаа дахин орсны дараа бид нөөц баялгаа бүгдийг нь нээн ашиглавал бүх дэлхийгээрээ хэрэглээд барахгүй.

Гадаад гүрэнд байгаа вьетнамчууд өөрийгөө ахиухан төгөлдөржүүлж, шинэ мэдлэгт суралцан хожим эх орондоо буцсаны хойно Вьетнамын соёл иргэншил болон эдийн засгийг хөгжүүлэх хэрэгтэй. Та бүгд энэ үүрэг хариуцлагаа битгий мартаарай! Суралцахын хамгийн сайн үр ашгийг олоход зөвхөн сурах бичигт найдах биш. Ном унших нь мэдлэгийг дээшлүүлж, бидний үзэл бодлыг давчуу болгодоггүй нь үнэн хэдий ч бидний санаа сэтгэл бас хүлээцтэй, уужим бөгөөд хурц сэргэг байх хэрэгтэй. Гэхдээ хамгаас чухал нь харин сурсан зүйлсээ бодитойгоор хэрэгжүүлэх явдал болно.

Бясалгал - зургаан билиг барамид

Хэрвээ амжилтад түргэн хүргэх, сурахад хялбар бясалгалын аргыг сурья гэвэл даяан бясалгалын аргаар бясалгаарай! “Очир огтлогч судар”-т Бурхан Багш зургаан билиг барамидыг: өглөг үйлдэх, сахил сахих, доромжлолыг хүлцэх, хичээнгүйлэн дэвших, даяан агуулах, билиг ухаантай болох гэж тайлбарлажээ. Энэ бол даяан бясалгалын арга болно.

Өглөг үйлдэх гэдэг нь ямар утгатай вэ? Бид аав ээж, ахан дүүс, хамаатан садандаа өгөөмөр хандах, мөн ядарсан хүмүүст туслахыг хэлнэ. Бид хэрвээ бурхны сургаалыг ойлговол тэдгээр хараахан ойлгоогүй хүмүүст тайлбарлан өгч, өөрсдийнхөө мэддэг хэмжээгээр боломжийнхоо хэрээр ойлгуулна. Мэдэхгүй бол мэдэхгүй гэж ярина, “худгийн мэлхийн нүдээр хорвоо дэлхийг тайлбарлах”, өөрөө мэддэггүй байтлаа харин: “Та ингэж яривал буруу номтон болно” гэж зөрүүдлэн мэтгэж болохгүй. Бид өөрсдийнхөө харанхуй мунхгаа нуун далдлахыг санаархаж болохгүй, мэдэхгүй бол шууд л хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Хэрвээ Арьяабалын бясалгалын арга, эсвэл бусад бясалгалын аргаар

бясалгаж, билиг нээгдэн цэцэн сэргэлэн болсон байвал, түүнийгээ бусадтай хуваалцан бусдыг бидэнтэй адилхан сэргэлэн ухаантай болгоход тусалж болно. Энэ бол “ном”-ын өглөг юм.

Бид эд мөнгө, хүч хөдөлмөр, оюун ухааны өглөг болон “ном”-ын өглөг үйлдэж болно. Бурхан Багшийн сургаалд “бясалгалын арга”-ын өглөг бол хамгийн эрхэм дээд үйл мөн гэжээ. Гэхдээ өлсөж үхэж байгаа хүнд сүнслэг бясалгалын тухай л яриад байвал, сонсох хүн байх уу? Ийм үед мөнгө болон идээ ундаагаар өглөг үйлдэх хэрэгтэй. Хүмүүс өвчин эмгэг, зовлон зүдгүүрт өртөж, эд мөнгө, материаллаг зүйлс шаардлагатай үед бид бас энэ бүхнээр туслах хэрэгтэй. “Оточ Бурханы судар”-т Оточ Бурхан Бодьсадвагийн мөрийг бясалгаж байхдаа хэн юу хүснэ түүнийг нь өгдөг, үүнд материаллаг зүйл ч багтдаг, зарим хүн хөнжил, хувцас хунар, хоол унд гэх мэт юу шаардана, түүнийг нь өгдөг, тэгээд цатгалан болсны хойно нь сая дээд зэргийн бясалгалын аргыг сургаж, тэднийг үхэж төрөхийн сансрын хүрднээс гэтэлгэж байдаг.

Бид бол Бурхны шашинтнууд гэж нэрлэгддэг хүмүүс тул боломж байвал бас ингэж хийвэл зохино. Хийж чадахгүй бол тийм сайн үйл үйлддэг хүмүүсийг сэтгэлээрээ дэмжиж байгаарай! Харин сайн үйл үйлдэж буй бусад хүнийг харчихаад жөтөөрхөж, зэмлэн буруушаах буюу сэжиг төрж, тэдний санаа сэтгэлийг нь үймүүлж, нэр хүндийг нь бууруулж, хүсэл зорилтоо тууштай баримтлахын аргагүй болгож болохгүй! Ингэвэл маш хүнд үйл түйтгэр зохиох болно.

“Өглөг үйлдэх”-ийг тайлбарлах гэвэл хэд хоног ч яриад дуусахгүй байж магад. Өглөг үйлдэх арга тун олон байдаг. Жишээлбэл, бусдыг загнахгүй, бусдыг урамшуулж, итгэл өгөх нь бас өглөг үйлдэх юм. Бусдыг уучлах, сэтгэлийг нь тайвшруулах, түүнийг өс хонзон авна гэж биднээс айхыг

нь болиулах нь мөн л нэг төрлийн өглөг үйлдэж буй явдал болно. Өглөг үйлдэхэд тун олон хэлбэр байдаг бөгөөд Багш нь товчхон л ярилаа.

Сахил сахих талаар гэрээс гараагүй хүмүүс таван сахилыг л сахих нь тун хялбар байж таарна. Та нар сахилаа хичээнгүйлэн мөрдвөл зүйтэй бөгөөд боломжийнхоо хэрээр мөрдөх нь ч гэсэн ач тустай. Нэгдүгээр сахил бол амь хороохгүй байх. Та нар боломжийнхоо хэрээр сахиарай! Үнэндээ аливаа сахил нь бүгд үүн дотор багтаж байдаг. Амь хороохыг цээрлэхийг самгарьд хэлээр Ахимса гэдэг бөгөөд бусдад бие, хэл, сэтгэлийн алинаар ч хор хүргэхгүй гэсэн утгатай.

Хор хүргэхгүй гэдэг нь зөвхөн амь хороохгүй байх явдал биш юм. Жишээлбэл, амьтныг хөнөөхгүй, хүн алахгүй боловч махтай хоол идэх нь бас ч нэг зүйлийн дам байдлаар амь хороож байгаа хэрэг. Хэрэв мах идэхгүй бол яалаа гэж амь хөнөөх үйлдэл гарах билээ? Бурхны сударт амь хорооход шууд болон шууд бусаар амь хороох гэж байдаг гэж ярьсан байна. Шууд гэдэг нь өөрөө амь хөнөөхийг хэлнэ, шууд бусаар гэдэг нь харин бид мах иддэг болохоор өөр хүн бидэнд амь хороож идүүлж байгаа хэрэг. Тиймээс махтай хоол идэх нь амь хороож байгаа биш гэж битгий бодоорой! Сүм хийд дэх гэрээс гарагсад бүгд л тун тодорхой тайлбарладаг. Гэтэл та нар сүм хийдээр тун цөөн очдог, эсвэл сүм хийдэд очсон ч гоё хээнцэр хувцсаа гайхуулж, наадаж тоглохын төлөө очдог, та нар жинхэнээсээ ном сонсохыг боддоггүй.

※ *Хэрвээ бид Бурханы сургаал ёсыг ойлгосон бол хараахан ойлгоогүй хүмүүст өөрсдийнхөө мэдэхийн хэрээр тайлбарлаж өгөөрэй!*

Арьяабал Бурхан болохын төлөө мэрийхүй

Та нар сүм хийдэд очиж, бурханд мөргөн гагц хоёр зулын мөнгө хандивлаж, хэдэн ширхэг жимсний өргөл өргөхдөө харин хамаатан садныхаа нэрсийг уртаас урд жагсаан бичээд Бурхан Бодьсадвагаас аврал гуйдаг. Бурхан Бодьсадвагийн ажил төрөл дэндүү их, тэд бидний өргөлийн хэдэн мөнгөний төлөө өөрийгөө яалаа гэж үхтлээ ядрааж байх билээ.

Ихэнх хүн сүм хийдэд очихдоо ламын нараас мөр ёсны тухай асуудаггүй болохоор тэдэнд өөрийн билиг ухаанаа харуулах завшаан олддоггүй. Үнэндээ та нар асуулт асуух тусам лам нар улам их суралцана. Тиймээс тэднээс илүүхэн асуулт асуух нь үнэн хэрэгтээ лам нарын судар номоо улам сайн суралцахад нь тусалж байгаа хэрэг болно. Хүмүүс үргэлж асуулт асуудаг байвал лам нар ухаан чадвараар увш нараас доогуур болохоос айж, бүр ч илүү хичээнгүйлэн суралцах болно. Сүм хийдэд очихдоо та нар хэрвээ лам нараас асуулт асуухгүй бол тэднийг хордуулаад зогсохгүй өөрийгөө ч хордуулж, сүм хийд гэж байхын ач тусыг алдагдуулна.

Сүм хийд бол хайр ивээл хүсэж гуйдаг газар биш, билиг ухаанаа хөгжүүлэхийн төлөө очдог газар байвал зохино. Харин Арьяабал Бурхан болон хамаг Бурхан Бодьсадва бидэнд энэрэл хайр ивээх болоосой гэж хүсэн даатгаад л байж болохгүй. Өөрсдөө Арьяабал Бурхан болохыг хүсэж тэмүүлэх нь зүйтэй. Хичээнгүйлэн чармайн зүтгэж байж Арьяабал Бурханы мөрийн хутагт хүрч, газлан зовлонг арилгах хэрэгтэй. Орчлон даяар ганцхан Арьяабал Бурхан байж, Ганга мөрний элс шиг үй түмэн төрөлтөн түүнд даатгавал, Тэрээр үнэхээр хөөрхийлөлтэй нэгэн болчих биш үү? Бид түүний сүсэгтэн болсны хувьд тийм хар сэтгэлтэй байж, Тэрээр хүмүүсийн янз бүрийн даатгалыг эрхбиш ганцаар үүрэх хэрэгтэй байхад өр өвдөх ч үгүй байж яаж болох билээ?

Вьетнам, Хятад, Тайланд, Энэтхэг, Шриланка зэрэг улс, цаашилбал бүх дэлхийн бурхан шүтдэг хүмүүс бүгд л Арьяабал Бурханаас аврал гуйдаг боловч өөрөө Арьяабал Бурхан болж, Түүний ажилд туслахыг хүсдэг хүн харин байдаггүй, чармайн бясалгаж Түүний хутагт хүрэх дуртай хүн байхгүй, тиймээс Түүний үүрч байгаа үйл түйтгэрийг хуваалцаж чадах хүн байдаггүй. Бидний нигүүлсэнгүй сэтгэл гэгч чухам хаа байгаа юм бэ? Бид зөвхөн бурханд тусалж, гутлаас нь зүүгдэж л чадна гэж үү? Бурхны хөлөөс л тэврээд байх уу? Төрөл төрөлдөө бурхны боол болох гэж үү? Бурхны боол боллоо ч гэсэн мөн л нэгэн боол төдий, тийм ч их өнгө гэрэлтэй хэрэг биш.

Та нар чин сэтгэлээсээ сүмд очиж мөргөвөл санаачилгаараа асуулт асуувал зохино, сүмд очиж, чин сэтгэлээсээ Эзэн Бурханыг хайя гэвэл номлогч нараас сургаал хүсвэл зохино. Суралцах хүсэлтэй бол илүүхэн асуух хэрэгтэй. Сүм хийд, дуган байгуулсны зорилго нь хүмүүст мөр ёсыг сургаж, нам сэлүүхнээр бясалгал хийлгүүлэхийн төлөө, ороо бусгаа тоост ертөнцөд хүмүүс сэтгэл тайвуу бясалгаж суухад тун бэрх, гэхдээ сүм хийд бол үнэхээр даяан бясалгалын сайхан орон билээ. Харамсалтай нь одоогийн сүм хийд аль хэдийн ганган залуу, хээнцэр охидын хувцас заслаа гайхуулах үзмэрийн газар болчихжээ.

Бид сүм хийдэд очиж мөргөх нь хэдэн ширхэг хүжээ бойпорт хатгахын төлөө гэж үү? Сүмд очсоны дараа ямар ч өөрчлөлт гэмээр зүйлгүй бол тэнд очсоны ач тус юу байх вэ? Бурхан Бодьсадвагаас аврал гуйдаг хэдий ч харин тахилын ширээн дээрх бурхан чухам хариу хэлдэг эсэхийг мэддэггүй. Бид амандаа ямар нэг юм бувтнан даатгахаа л мэдэхээс биш, харин Бурхан хариу хэлдэг эсэхийг тоох ч үгүй гэртээ харьдаг. Хариулт гэмээр юу ч олоогүй байж юунд буцна вэ? Ингэх нь тахилын идээгээ дэмий үрж байгаа хэрэг биш үү?(Бүгд алга ташив.)

Одоо Багш нь та нарт нэг зүйлийг сануулъя: сүм хийдэд очиж бурханд мөргөхдөө модон бурхан хариу хэлсний дараа сая салж яваарай! Та нар бурханд мөргөхдөө ер нь толгой бөхийн мөргөх л төдий байдаг, тахилын идээг бурхан амсахгүй гэдгийг тодорхой мэдэж байгаа мөртлөө харин ёс заншлын дагуу л хийдэг. Бурхан Бодьсатва нээрээ амаа ангайн жимс идсэн байвал та нар тэр дороо ухаан алдаж мэдэх буюу: “Чөтгөр байна! Чөтгөр байна, модон бурханд чөтгөр наалджээ” гэж цочин хашхирах болно.

Та нарт зөн совин мэдэгдэхгүйг тодорхой мэддэг хэр нь мөн л модон бурханд мөргөдөг бөгөөд модон бурхан юу ч ярьдаггүй. Бясалгалын тухай асуулт байвал лам нар болон номлогч нар дээр очиж асуу, тэгвэл лам хуврагт үүрэг хариуцлагаа гүйцэтгэх тохиол олгох бөгөөд тэднийг суралцахаа эрчимжүүлэхэд нь тусалдаг. Энэ бол сая сүм хийдэд очихын утга чанар мөн гэж Багш нь та нарт сануулъя! Тийм биш бол сүм хийд нь зөвхөн нэг зүйлийн засал чимэглэлд л тооцогдож, “үндэстэн ястны оюун сүнсийг хамгаалах орон” гэж нэрлэгдэх эрхгүй болох бөгөөд бид өөрсдийгөө “эртний өвөг дээдсийнхээ амьдралын арга хэлбэрийг мөрдөн дагагч” гэж магтах эрх ч байхгүй.

Бидний өнөөдрийн амьдралын хэлбэр нь өвөг дээдсийн маань амьдралын хэлбэртэй аль хэдийн адилгүй болчихсон. Бидний өвөг дээдэс угаас Буддын шашны даяанч байсан бөгөөд Буддын шашны өвөг дээдэс нь Бурхан Багш билээ. Бид өвөг дээдсийнхээ бясалгалын талаарх уламжлалыг хамгаалах хэрэгтэй. Гэтэл одоо зөвхөн зарим шашин суртахууны “үндэстний оюун сүнсийг хамгаалдаг сүм хийд, өвөг дээдсийн өнө удаан жилийн амьдралын хэлбэр” гэх уриа лоозон төдий болж үлджээ. Уриа лоозон хашхирснаар үндэстэн ястны оюун сүнсийг аварч чадах уу? Вьетнамаас сүм хийдүүдийг нь нүүлгээд авчирчихвал өөрсдийнхөө оюун сүнсээ аварч хамгаалж чадна гэж үү?

Чадахын аргагүй байх аа!

Энэ бүхэн нь бүгд л бид бурхны номыг зөв оновчтой суралцаагүйгээс болж байгаа хэрэг. Тиймээс өвөг дээдсийнхээ уламжлалыг хамгаалж чадахгүй байна. Буддын шашны өвөг дээдэс нь тэр их даяанч багш нар байсан. Та нар гэртээ хариад их багш Ши Чинг Зи-гийн “Вьетнамын даяанч” гэдэг номыг уншвал урьдын тэр их даяанч багш нар, ихээр гэгээрэгсэд яаж бясалгаж байсныг ойлгох болно. Буддын шашны түүх болон үлгэрийг уншвал Шагжамуни Бурханы бясалгал хийсэн зам мөрийг ойлгож чадна.

Гэтэл одоогийн хүмүүс махтай хоол идэж, архи уун Буддын шашны уламжлалыг огт ойлгодоггүй. Сүм хийдэд очиж мөргөл хийдэг ч лам нараас асуухыг боддоггүй. Сүм хийдээс буцсаныхаа дараа мөр ёсыг бусдаас асууна гэж бүр ч байдаггүй хэрэг. Ийм юм чинь яаж “өвөг дээдсийн өнө удаан жилийн амьдралын хэлбэрийг мөрдөгч” гэж онгирч болох вэ? Бид өвөг дээдсийнхээ амьдралын арга хэлбэрийг дээдлэн мөрдөж байгаа биш болно.

※ Бид хичээнгүйлэн чармайж, Арьяабал Бурханы мөрийн хутагийг олж, гаслан зовлонг арилгавал зохино.

Доромжлолыг хүлцэн тэсвэрлэх билиг барамид

Багш нь бас боломжийнхоо хэрээр: “Та нар тун сайн, тун сүрхий, тун ухаантай шүү дээ! Та нар бол Буддын шашны сайн сүсэгтнүүд” гэж сайшаан магтаж, та нарт таалагдахыг хүсдэг. Гэтэл ингэж яривал яг л ногооны зах дээр бараа зардаг хүнтэй адил болчихно, өөрөө ашиг олохын тулд зочдодоо саймширдаг, бараагаа зарахын тулд бусдад ач тустай үг ярьдаггүй. Миний шуудхан ярьсныг уучлаарай! Зарим хүн үүнээс болж Багшид нь дургүй болдог. Гэвч Багш нь тэднийг буруутгахгүй. Үнэн үг угаас чихэнд аягүй хойно.

Бид суралцах дуртай, баатарлаг цог золбоотой байвал бусдын шулуун шударга ярихыг эсэргүүцэхгүй. Шулуухан ярьдаг хүн бол сая бидний сайн найз мөн, жинхэнэ сайн найз л сая бидний үзэл бодлыг сөрөхөөс айдаггүй. Бидний эрх ашиг, ач тусын төлөө шууд ярихад бэлэн байдаг. Хэрвээ бид мөнгөтэй, эрх мэдэлтэй байгаад уран сайхан үг сонсохыг хүсвэл хэн ч гэсэн хэлнэ шүү дээ.

Өнөөдрийн Вьетнамчууд урдынх шиг харь оронтой харилцдаггүй байдлаа больжээ. Та бүгд нэгэнт гадаад улсад ирсэн тул бусдын сайн талаас суралцвал зүйтэй. Вьетнамын шилдэг сайхан зан заншлаа хая гэсэн биш, нэг талаар өөрсдийн уугуул соёлын содон зүйлсийг нь хадгалан үлдэж, нөгөө талаар бусад улсын сайн зүйлсийг шингээн авч, Вьетнамын соёлыг бүр ч баялаг агуулгатай болгоно. Вьетнамчуудын хувийн чанар зүүн өмнөд Азийн өөр бусад үндэстнээс илүү шилдэг байдгийн гол шалтгаан нь Вьетнамчууд өөр өөр улсын соёл иргэншлээс өөртөө шингээж авснаас болсон.

Гадаад улсад эзлэгдсэн нь үнэхээр үндэстний эмгэнэл боловч харь улсын соёл нэвчих боломж нээгддэг тул Вьетнамын соёл сая тийм элбэг баян агуулгатай болж чаджээ. Хятад, Франц улсад эзлэгдсэн тэр хугацаанд Вьетнамчууд үнэхээр их гаслан зовлон амссан, гэтэл бид бас тун олон үйл хэргийг сурч чадсан байна. Үүнээс гадна Япон, Орос, Америк зэрэг улс түрэмгийлэн орж ирсний дараа бас Вьетнамын соёлд эрч хүч нэмэрлэжээ. Миний бодлоор Вьетнамчуудын үндэстний онцгой шинжийг Бурхан Бодьсадва зориудаар зохицуулжээ. Бид өөрийгөө ойлгохын зэрэгцээ үргэлжлэн хөгжвөл зохино, сүнслэг бясалгалын талд ч бясалгагч нарын оюун ухааныг ашиглан өөрсдийнхөө соёлыг хөгжүүлбэл зохино.

Гадаад гүрэнд байхдаа өөрсдийн хүний мөс болон эрдэм мэдлэгээ төгөлдөржүүлж, хожим хэзээ ч бай

Вьетнамдаа буцсаны дараа түүнийгээ хэрэглэх болно. Ийм өдөр удахгүй ирж ч магад. Бид бүх улсын соёлын сод гэсэн бүхнээс суралцаад буцсаны дараа эх орондоо хандивлана. Энэ хүсэл зорилтоо биелүүлэхийн төлөө та нар нэгэн гол чухал зүйлийг үргэлж санаж бай! Энэ нь юу гэвэл: өөрийгөө түргэн хурдацтайгаар хөгжүүлж, тун түргэнээр бусад улсын соёл иргэншлийг ухааран ойлгож, эрхбиш эхлээд билиг ухаантай болох хэрэгтэй. Гэхдээ билиг ухаан хаанаас ирдэг вэ? Билиг ухаан бол даяан бясалгалаас ирдэг. Тиймээс Шагжамуни Бурхан сая зургаан билиг барамид: өглөг үйлдэх, сахил сахих, доромжлолыг хүлцэх, хичээнгүйлэн дэвших, даяан агуулах, билиг ухаантай болохыг номложээ.

Өглөг өгөх, сахил сахих, дараагийнх нь доромжлолыг хүлцэхийг тайлбарлая. Өөр хүн чамайг зодоход хүлцэн тэсвэрлэж юу ч ярихгүй байхыг та нар “доромжлолыг хүлцэх” мөн гэж бүү бодоорой! Жинхэнэ доромжлолыг хүлцэх гэдэг нь хүлцэж тэвчих шаардлагагүй болж, өөр хүн биднийг зодох, загнах үед тийм ч чухал биш санагдах нь л сая “доромжлолыг хүлцэх”-эд тооцогдоно. Доромжлолыг хүлцэх нь бясалгалын билиг ухаанаас ирдэг. Бясалгал хийгээд билиг ухаантай болсны дараа нигүүлсэнгүй сэтгэл ч өргөжин тэлдэг. Тиймээс Библи сударт: “Эхлээд дотоодын диваажингаа хайж ол, ингэвэл аливаа бүхэн аяндаа ирэх болно” гэжээ.

“Диваажинг хайх” гэдэг нь өөрсдөө нирваанаа хайх, өөрсдийн бурхан чанараа хайх, өөрөөр хэлбэл дотооддоо хандан уг чанараа сонсох, дотогшоо ажин өөрийгөө тольдох, өөрийгөө хэн болохоо ойлгохыг хэлнэ. Энэ бол хамгийн дээд дэсийн даяан бясалгалын арга болох бөгөөд хамгаас үр ашигтай, хамгаас түргэн байдаг даяан бясалгалын арга болно. “Сонсох” гэдэг нь чихээрээ сонсох биш, үнэндээ уг чанараа “ажих”, “таних” гэж ярих нь сая зөв. Учир нь бид бясалгаж суугаа үедээ дотоодын аялгууны урсгал, бурханы

аялгуугаа сонсдог болохоор л “сонсох” гэдэг үгийг зээлэн хэрэглэдэг.

※ Жинхэнэ доромжлолыг хүлцэх гэдэг нь хүлцэн тэвчих шаардлагагүй болж, өөр хүн биднийг зодох, загнах үед тийм ч чухал биш санагдахыг л сая “доромжлолыг хүлцэх” гэнэ.

Түгмэл хайрын түвшинд хүрэхүй

Хүмүүс яагаад гэсвэр гэвчээртэй байж чаддаггүй вэ? гэвэл энэ бүхэн нь бид жинхэнэ хайраа хөгжүүлээгүйгээс, Эзэн Бурхан, Бурхан Бодьсадвагийн цаглашгүй хайрын дэст хараахан хүрээгүйгээс болжээ. Зарим Вьетнамчууд буюу Буддын шашинтнууд: “Эзэн Бурхан бол Бурхан биш”, эсвэл “Эзэн Бурханы дэс нь Бодьсадвагийнхаас доор” гэж ярихыг та сонсож байсан байх. Тэд юуг үндэслэж тэгж хэлдэг юм бэ? Эзэн Бурханы дэст хараахан хүрээгүй байтлаа Эзэн Бурхан дээд, эсвэл доор гэдгийг яаж дүгнэж чадах вэ? Эзэн Бурхантай адилхан дэстэй болсны дараа сая үнэлж цэгнэж ярих эрхтэй болно. Хараахан хүрээгүй үед дураар магадлан үнэлж болохгүй. Есүс Христ загалмайд цовдлогдсон бөгөөд эцсийн мөч хүртлээ өөрийг нь зовоосон тэр хүмүүсийг өршөөгөөч! гэж Эзэн Бурханаас гуйж байсан.

Ийм уужуу, өршөөнгүй, цаглашгүй нигүүлсэнгүй сэтгэлтэй байдаг болохоор бид тэр бол Бодьсадвагийн хувилгаан гэдгийг мэдэх ёстой. Эгэл хүн байсан бол яахин ийм өршөөнгүй байж чадах билээ? Эгэл хүмүүсийг тарчлаан зовоох үед нөгөө этгээдээ харааж загнахгүй байх тохиолдол тун ховорхон байтал Эзэн Бурханаас өөрийг нь цовдолсон тэр хүмүүсийг уучлан өршөөхийг гуйж яаж чадах вэ? Шагжамуни Бурхан хэрвээ Есүс Христийн ингэж байхыг харсан бол лавтай сайшаан магтах байсан. Арван зүг, гурван цагийн Бурхан Бодьсадва нар Есүс Христ хүмүүст

сайн үйл үйлдэхийг сургаж, хамгийн эцэст үнэний төлөө амь үрэгдсэн, бусдад буруугаар ойлгогдон нас барсан, тэр ч байтугай нас барахаасаа өмнө дайснаа өршөөхийг гуйж, дайсныхаа төлөө даатгаж байсныг харсан бол лавтай Есүс Христтэй найзлахыг хүснэ. Төгс баясгалант оронд эзгүй хоосон орд харш маш олон бий. Ийм хүмүүсийг тэнд хүрч, амьдрахыг хүлээж байдаг.

Өчигдөр нэг авшигтан, энэ ертөнцийн хүмүүсийн дуудлагаар бол Багшийнх нь шавь гэсэн үг. Хэрвээ хамт бясалгагч гэж хэлбэл та нар Багштай чинь хамт суралцаж байгаа хүн гэж бодох болно. Тиймээс сая шавь гэж хэлж байгаа юм. Тэр шавь: “Багш аа! Нэг өдөр би бясалгаж суух үедээ аль ертөнцөд хүрснээ мэдсэнгүй, тэндхийн хот, гэр байшин тун үзэсгэлэнтэй, гэвч хүнгүй эзгүй байлаа” гэсэн. “Бясалгадаг хүн байгаагүй болохоор л сая эзгүй байгаа хэрэг, дээд түвшний гэр байшин үзэсгэлэнтэй бөгөөд мөнгө авдаггүй, тансаг сайхан бөгөөд уужим өрөөтэй, та нартай шахцалдах хүн байхгүй. Гэтэл бясалгал хийж дээш гарч тэнд очих хүнгүй болохоор л эзгүй хоосон байдаг” гэж Багш нь хариулсан, тэгээд Багш нь: “Байшинг чинь бүгдийг бэлэн болгочихсон, та нарыг очиж амьдрахыг л хүлээж байгаа шүү!” гэж тоглоом хийсэн.

Есүс Христ ертөнцийн хүмүүсийн төлөө өөрийгөө зориулахад бэлэн байгааг Бурхан Бодьсадва хараад дорхноо Түүнийг дээш гарахыг урих болно гэж Багш нь боддог. Учир нь Төгс баясгалант орон яг ийм хүнээр дутаж байна. Есүс Христ бол нэгэн Бурхан, нэгэн Бодьсадва мөн гэдгийг бид ойлговол зүйтэй. Зарим хүн Есүс Христ бол нэгэн агуу хүн мөн гэж үздэггүй тул Түүнийг чухам хэн болохыг батлахыг хүсдэг. Есүс Христ жинхэнээр бясалгал хийгээгүй бол өөрийн уг чанар болон дотоодын диваажингаа таниагүй бол Тэрээр тарчлан зовохын туйлд тулах үедээ бусдыг уучлан өршөөж яаж чадах билээ? Хэрвээ тэрээр жирийн нэг энгийн

хүн байсан бол тийм уужим сэтгэлтэй байж чадахгүй.

Өөр хүн та нарыг гутаан доромжилж, хавирга руу чинь хутгалах, жадлах, дараа нь өргөстэй төмөр утсаар толгойг чинь ороож, бас хадаасаар хадах ийм хэцүү байдлыг хүлцэн тэсвэрлэж чадна гэж үү? Та нар хадаас хадахдаа санамсаргүй алдаад гарын хуруугаа цохичих үедээ ер тэсэж чадахгүй болчихдог. Есүс Христ загалмай модонд өдөр шөнийн туршид хадуулж, тийм зовуурьтай байдалд байсан ч Эзэн Бурханаас тэр хүмүүст өршөөл гуйж байсныг дурдах ч хэрэггүй. Үүнээс ийм хүн лавтай амьд бурхан мөн гэдгийг мэдэж болно. Бид Бурхан Багш дэсээр Есүс Христээс өндөр дээд гэж хэлж болохгүй. Тэр хоёрын байр суурь нь адилхан.

Бид жинхэнэ хайрын сэтгэлтэй бөгөөд Есүс Христтэй адилхан болохыг хүсвэл “Би бол хайр мөн” гэдгээ ойлгон таних хэрэгтэй. Бид Бурхан Багшийг их нигүүлсэнгүй, Есүс Христийг агуу их хайрын сэтгэлтэй гэж сайшаан магтдаг. Эзэн Бурхан бол агуу их хайр, их нигүүлсэнгүй мөн гэдэг үг байдаг биз дээ? Эзэн Бурхан хүмүүсийг хязгааргүй энэрэн хайрладаг, бид өөрсдөө ийм хайрын сэтгэлтэй байдгаа ойлгохгүй бол Эзэн Бурханаас маш хол зайтай байгаа гэсэн үг. Ийм хүн өөрийгөө Бурханы Хүүхэд мөн, Эзэн Бурханыг дагаж байгаа гэж ярьж болохгүй.

Бясалгагч хүн өөрийн ач буянаа хэр их, өөрийгөө ямар түвшинд байгаагаа ажиж мэдэх хэрэгтэй. Бусдыг л хараад байх биш, өөрөө тунгаан бодож, алдаагаа ухаарахгүй, хэн нэг хүн нэрд гарч, сайн үр дүнд хүрч, маш олон дагагчтай болохыг хармагцаа атаархаж, түүнийг гүтгэн, хов жив ярьж үл болно. Бясалгагч хүн өөрийн зэрэг дэсээ хянан шүүхгүй, өөрөөсөө ямар сайн үйл үйлдэж чадахаа асуухгүй, өөрөө ховдог, мунхаг, уур хилэн зэргээ эзэмдэн захирч чадах эсэхээ тоохгүй, аминч бодол, атгаг сэтгэлээ эзэмдэн захирч чадах эсэхээ хамаарахгүй атлаа бусдыг шүүмжлэхийг л мэдэж, өөрийгөө шүүхгүй бол энэ эрхэм нандин хүний

биеийг дэмий үрж тун харамсмаар хэрэг болно.

Одоо даруйхан бясалгахгүй бол хэдэн арван жилийн дараа хүн болгон бүгд л хадан гэртээ буцах болно. Бусдыг зэмлэн буруушаасан болон зэмлэгдэн буруушаагдсан хоёр хүн энэ дэлхийд байх үеийн түвшин нь нэгэнт ялгаа зөрөөтэй болчихдог, ертөнцөөс салсны хойно ялгаа зөрөө нь бүр ч их болно. Бясалгагч хүн диваажинд очиж, билиг ухаан саруул тунгалаг болдог байхад бясалгадаггүй хүмүүс харанхуй бүдэг түвшинд унаж төөрөх болно. Материаллаг ертөнцийн сансрын хүрдэнд эргэлдэж, заримдаа хүн болж, заримдаа амьтан болж, заримдаа сахиус болж, заримдаа чөтгөр болох гэхчлэн олон дүрд ээлжилж, туулан гэтэлж чаддаггүй.

Бурхан Багш болон Есүс Христ гутаал доромжлолыг хүлцэн тэвчиж чаддаг ч бас тийм бодол төрдөггүйн шалтгаан нь тэд нэгэнт агуу их хайрын түвшинд хүрчихсэнээс болж байгаа юм. Бидний уг чанар бол агуу их хайр мөн. Бид уг чанар, бурхан чанараа хайж олсны хойно аяндаа хүлцэн тэвчиж чадах болно. Хүлцэнэ, гэвч хүлцэж байна гэж боддоггүй болно. Есүс Христ загалмайд цовдлогдсон ч өөрийг нь гутаан доромжилсон гэж мэдрээгүй, харин зөвхөн тэр харанхуй мунхаг хүмүүс удалгүй үйлийн үрээ амсах болно гэж өрөвдөж, Эзэн Бурхан, Бурхан Бодьсадвагаас өршөөл гуйсан байна.

Есүс Христэд би гэх үзэл байхгүй, бусдыг хайрлахын эрхээр өөрийгөө умартаж, загалмайд цовдлогдон туйлын их зовлон тамлалыг амсаж байгаагаа мартаад нэгэн үзүүрт сэтгэлээр бусдын төлөө санаа зовж залбиран даатгаж байсан гэдгийг бид мэдэх ёстой. Эгэл хүмүүс бол зөвхөн өөрсдийнхөө төлөө даатгадаг, Есүс Христ харин өөрийнхөө зовлон шаналлаа умартан, тэр харанхуй мунхаг хүмүүс удалгүй муу заяанд унахын төлөө л санаа зовж байжээ. Тиймээс тэдний төлөө даатгаж байж. Үүнээс тэр бол амьд бурхан мөн, ийм агуу их хайрын сэтгэлтэй хүн лавтай маш

дээд дэсийн бурхан мөн гэдгийг мэдэж болно. Одоо та нар Бурхан Багш болон Есүс Христ хоёрын адил талыг мэдэв үү? (Мэдлээ гэж бүгд хариулав), Баярлалаа! (Бүгд алга ташив).

Хоёр туулай хөөсөн хүн хоосон хоцорно

Одоо “хичээнгүйлэн дэвших” тухай ярь! Хичээнгүйлэн дэвших гэдэг нь ямар утгатай вэ? гэвэл бид бясалгах аргаа нэгэнт сонгон тогтчихсоны дараа бясалгалын замд чинь ямар шалгалт тохиолдож, хэн нэгэн биднийг уруу татах, бясалгалын аргыг чинь муу гэж шүүмжлэх, Багшийнх нь тухай хов жив ярьсан ч бид үүнээс болж урам хугарч, бясалгалаа хаяхгүй байхыг хэлнэ.

Нэгэн хэлц үгэнд: “Холын аянд морины сайныг мэднэ, хоногийн удаанд нөхрийн сайныг танина” гэж байдаг. Хэрвээ бид дандаа ийш тийш гүйгээд л байвал бясалгалын арга маань шилдэг гэдгийг хэзээ нэвтэрхий мэдэж чадах билээ? “Багш аа! Би нэгэнт ийм ийм бясалгалын бүлэгт шавилчихсан, одоо Багшаас Арьяабалын бясалгалын аргыг сурах хүсэлтэй байна, гэхдээ бас үргэлжлэн угийн аргаараа бясалгасан хэвээр байж болох уу?” гэж олон хүн Багшаас нь асуудаг, “Бидэнд тийм их цаг зав хаанаас байх вэ дээ? Заавал нэг тийш нь шийдэх хэрэгтэй. Хэрвээ та Арьяабалын бясалгалын арга сайн гэж бодож байвал Багшаасаа л сур! Хэрвээ мөн л урьдын олон төрлийн бясалгалын аргадаа сэтгэл татагдаад байвал тэндээ л үргэлжлүүл!” гэж Багш нь хэлдэг.

Хоёр завинд нэгэн зэрэг дөрөөлбөл дорхноо усанд унах болно. Нэг хүн хоёр дугуйг зэрэг унахын аргагүй бөгөөд хоёр машиныг зэрэг жолоодох боломжгүй. Багш нь та нарыг шавиа болгох гэж сурталчилаагүй, эсвэл Арьяабалын бясалгалын аргаар бясалга гэж албадаагүй, та нар сонголтоо чөлөөтэй хийж болно. Арьяабалын бясалгалын аргад

итгэвэл наашаа ирж сур! Итгэхгүй бол үргэлжлэн тэндээ бай! Нэг төрлийн бясалгалын аргыг сонгосон бол сэтгэл төвлөрч бясалга. Өөрийн нөхцөл байдлаа харж, түүндээ зохицож, хичээнгүйлэн бясалга. Ийш тийш гүйх хэрэггүй, тэгвэл юу ч үгүй хоосон хоцорно.

Жишээлбэл, бага сургуулийн сурагч өөрийгөө дунд сургуульд суралцаж болно гэж бодсоноос тэнд сууж суралцсан хэрэг, гэхдээ мөн л бага сургуульдаа сэтгэл татагддаг. Бага сургуулийн өрөө нь гоё тансаг, зүлэг ногоо, зулзаган модтой, теннисийн ширээтэй, багшийн заадаг хичээл нь нилээд амархан байхаас болоод тэгдэг ч байж магад. Дунд сургуулийн багш нь сурагчдадаа тун хатуу хандаж, ерөөс сонсоогүй зүйлсийг сургадаг болохоор тун ядаргаатай санагддаг. Бага сургуулийн хичээлийн төрлийг тэр бүгдийг нь ойлгочихсон болохоор сурахад тун хялбар, тиймээс тэргүүн эгнээнд жагсаж болно, ойлгож байна уу?

Зөвхөн бага сургуулийн хичээл хүмүүжлийг сурах хүсэлтэй бол бага сургуульдаа үлд! Ийш тийш дэмий гүйгээд байвал бага сургуулийн гэрчилгээ үнэмлэхээ ч авч чадахгүй бөгөөд дунд сургуулийн олон төрлийн хичээлийг ч сурч чадахгүй болно. Багш нь шавьд шунахгүй, та нар зам мөрөө өөрсдөө сонго, сонгосны дараа хичээнгүйлэн чармайх хэрэгтэй. Хичээнгүйлэн дэвших гэдэг нь хичнээн их саад тулгарсан ч даван туулж, урагшаа зоригтой тэмүүлнэ, нохой хуцахаараа хуцаг, хамаагүй хэрэг, урагшилж дээшлэхийг чинь саатуулах хүмүүс их байлаа ч үргэлжлэн урагшлахыг хэлнэ. Шалтаг эрж хойш ухарч болохгүй, гэдрэг буцаж болохгүй, жишээлбэл, нэгэнт ургамал хоолтон болчихсон байтлаа одоо дахин махтай хоол идэхийг хүсэх нь хайнга хандаж байгаа хэрэг болно.

“Би Багшаас авшиг хүртэж бясалгахыг тун их хүсдэг, гэтэл хожим бор хоолтон болчихвол яах билээ?” гэж олон хүн урьд нь Багшаас нь асуухад би: “Та гэрлэхгүйгээр сүйт

бүсгүйгээсээ: Би чамтай гэрлэхийг тун их хүсдэг боловч гэрлэсний хойно хэзээ нэг цагт нууц амрагтай болчихвол яадаг билээ гэж байнга асуухтай адил. Тийм юм бол гэрлэхийн хэрэг юун?” гэж хариулдаг (Бүгд алга ташив). Бясалгал дадуулах гэж байж Багштайгаа үнэ хаялцана, яг л та нар бясалгал хийвэл Багшийнх нь мах мариа нэмэгдэж, баян тансаг болж, гоё хээнцэр болдог юм шиг л байдаг. Бясалгах нь өөрсдийнхөө төлөө гэдгийг та нар ойлговол зүйтэй.

Хамаг төрөлтнийг гэтэлгэхэд бэрх байдаг нь тэд мөнх бусын материаллаг зүйлсэд дэндүү их шунадгаас болж байгаа юм. Өнөөдөр байснаа маргааш алга болчихдог тэр эд зүйлс нь сүнслэг чанарт ямар ч ач тусгүй. Хүмүүс хэрвээ бясалгал хийхгүй, ёс суртахуунгүй бол нас барсны дараа сүнс нь зовлонгийн далайд живдэг, тэр үед хэн ч тэднийг аварч чадахгүй. Мэдээж хичээнгүйлэн дэвших гэдэгт бас бусдад бясалгал дадуулахад нь туслах багтана. Зөвхөн өөрөө хичээнгүйлэн бясалгах төдий биш, зөвхөн өөрийн ашиг тусыг л хамаарч, өлсгөлөн, ядарсан, ядуу дорой хүмүүсийг тоох ч үгүй байх нь хичээнгүйлэн дэвшиж буй явдал биш. Хичээнгүйлэн дэвших гэдэг нь маш олон үйл хэргийг багтаадаг.

Сав суулгаа угаахдаа ч бас самадид орж болно

Одоо “даяан агуулах” талаар ярья! Юуг даяан агуулах гэдэг вэ? Та нар бүгд мэддэг. Даяаныг мэддэг гэж хүн бүр ярьдаг. Даяан бол ийм, даяан бол тийм, эсвэл даяан бол хөлөө завилж: “Би хэн бэ? Би хэн бэ? Би хэн бэ?” гэхийг, эсвэл “Юуг Бурхан Чанар гэдэг вэ?” гэж уншихыг, эсвэл номын Багш нь шавиа барьж “тасхийтэл” гэж зодохыг хэлдэг гэдэг гэнэ. Энэ бол даяан мөн үү? Даяан гэдэг нь маш олон үйл хэргийг багтаадаг, харин зөвхөн дээрх зүйлийг л

хэлдэг биш.

Бид өөрийн сэтгэлээ тод харж, сэтгэлдээ амарлингуй амьдарч; алхах, зогсох, суух, хэвтэх бүхий л үедээ сэтгэлдээ, бурхан чанартаа, диваажинд төвлөрөхийг л сая “даяан агуулах” гэж хэлдэг. Харин янз төрх гаргаж цэх суухыг хэлдэг биш. Бид өөрийн сэтгэлээ таних үеийг даяан агуулах гэдэг. Бидний сэтгэл тайвширч, хүн бүхнийг хайрлаж, оюун санаа амар тайван болж чадах үеийг л сая “даяан” гэнэ. Ийм түвшинд хүрэх үед сая “явах, зогсох, суух, хэвтэх бүгд даяан мөн” гэж ярьж болно.

Нүдээ аньж, хөлөө завилж төв суухыг л “даяан” гэхгүй, нүдээ аньж, хөлөө завилах нь бие махбод дэндүү их хөдлөхөөс зайлсхийж, анхаарал амархан төвлөрч, самадид амархан орохын төлөө юм. Гэхдээ энэ нь зөвхөн дөнгөж эхлэх үеийн байдал болно. Бясалгал хийгээд хожим нь аяга сав угаах үед ч гэсэн бүгд даяан болдог. Нэг талаар аягаа угааж, нөгөө талаар бясалгах гэсэн биш, харин аяга угаах явцад бас бясалгаж байдаг гэсэн үг. Аяга угаахдаа бас самадид орж болно, тиймээс аяга угаах нь ч даяан мөн гэж хэлдэг. Аливаа бүхэн бурхны ном мөн гэдгийг ойлгох үед бид сая аяга угаах нь ч даяан мөн гэж хэлж болно. Одоо бол хараахан ойлгоогүй болохоор аяга угаах нь зөвхөн аяга угаах төдий л байдаг.

Коста Рика-д Багшийнх нь нэг шавь байдаг, мариалаг, бор царайтай, өндөр биетэй, гадаад төрх нь энгийн бүсгүйтэй адилхан, онцгой гэмээр зүйлгүй, царайлаг биш бөгөөд олноос хэтийдсэн сэргэлэн ухаантай ч биш, Вьетнамчуудын таалдаг магнай уужим, хамар том, хацар төвгөр, хээнцэр бүсгүй биш. Тэр бол энгийн нэгэн бүсгүй, гэтэл одоо тэр юу хийсэн ч бүгд л даяан болжээ. Нэг удаа тэр саваа угааж байх үедээ гэнэт хувилгаан Багшаа харжээ. Тэрээр дэндүү их баярласнаас болж саваа хагалчихсан байна. Ийм байвал л алхах, зогсох, суух, хэвтэх бүгд даяан мөн.

Багшийнх нь тун олон шавь унтаж байдаг ч үнэндээ унтаагүй байдаг. Шөнөжингөө гялалзсан гэрэл болон зарим түвшний хүслэнт ахуйг үздэг болохоор сэтгэл нь өөр газар татагддаггүй, анхаарал нь сарнидаггүй, ойлгож байна уу? Жишээлбэл, бид эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хоорондын хүсэл тачаалын тухай бодвол төвлөрөл тээр доошоо унадаг. Харин билгийн мэлмий дээрээ төвлөрвөл материаллаг ертөнцийн бүхий зүйлд шунахаа больж, Бурханыг харж, өөрийн Бурхан Чанараа мэдэрч чадна. Эд мөнгө, гоё хүүхэн, тансаг байшин, машин тэргийг бодох үед бидний сэтгэл гадагшаа тэнэж оддог.

Тиймээс алхах, зогсох, суух, хэвтэх бүгд даяан мөн, харин завилж суухыг л даяан гэдэг биш. Билиг нээгдсэн хүн даяан дотор амьдарч байдаг, амьсгалахдаа даяан, хооллохдоо даяан, унтахдаа даяан, ажиллахдаа даяан, сав угаахдаа даяан, хэзээ ямагт бүгд даяан. Зарим шавь маань ийм билиг нээгдсэн байдалд хараахан дадаагүй болохоор айх бодол төрдөг. Тэр: “Багш аа! Унтах үед минь өрөө яагаад тийм гэрэлтэй харагддаг вэ?” гэж хэлдэг, юу болчихов? гэж боддог. Бид харанхуй бүдэг байдалд дадчихсан болохоор эсрэгээр хурц гэрлээс эмээдэг. Гэрэл гэдэг нь мөн л бидний уг чанараас үүсэлтэй, хүн угаас хэзээд ч гэсэн гэрэл гэгээтэй байж таарна, юунд нь эмээх юм бэ? Энэ ертөнц бол хий хуурмаг, тонгоруу ертөнц, харыг цагаан гэж, цагааныг хар гэж ярьдаг. Дөнгөж эхлээд бясалгаж суугаа хүмүүс гэрэл гэгээтэй ертөнцөд дадаагүй болохоор сонин санагддаг. Гэтэл энэ бол мэдэх ёстой үндсэн мэдлэг мөн. Бидний уг чанар угаас гэрэл юм. Тиймээс авшигтнууд бясалгал хийж гэрэл ажсаны дараа ажил хийх нь тун түргэн, бодол санаа хурц сэргэг болдог, ингэснээр өөрийнх нь санаа сэтгэлд ач тустай бөгөөд ажлынх нь үр ашиг дээшлэхийн зэрэгцээ ажил амьдралын чанар чансаа сайжран бүх нийгэм болон дэлхийд ач тус хүртээдэг.

Бурхан болон Маяагийн ялгаа

Сахил сахиж, даяан бясалгал хийдэг боловч өглөг үйлдэхгүй, доромжлолыг хүлцэхгүй, хичээнгүйлэн дэвшихгүй байвал сөрөг хүчинд автсан бясалгал болно, хэдийгээр жаахан зөн билигтэй, жаахан билиг нээгдэх боловч төгс гэгээрч чадахгүй. “Та юунд Арьяабалын номын цогцсыг бясалгаж, өөр бясалгалын аргаар бясалгадаггүй вэ?” гэж олон хүн Багшаас нь асуудаг. Өөр бясалгалын арга нь яг л бага сургуульд суралцаж байгаатай адил, харин Арьяабалын бясалгалын арга нь их сургуульд суралцаж байгаатай адил.

Бага сургууль болон дунд сургуульд суралцаад унших, бичих болон тоо бодох хичээлийг сурч чаддаг боловч мэргэших хэмжээ нь их сургуулийн оюутантай огт адилгүй. Бид өөрөө уншиж, бичиж сурснаа харин их сургууль нь дунд сургуультай адил, дунд сургууль нь бас бага сургуультай адил гэж батлан тогтоож болохгүй. Яаж адил байж болох вэ? Бид их сургуульд суралцвал сая ялгаа зөрөөг нь мэдэх болно. Их сургуульд суралцаагүй ч гэсэн тэр оюутнуудыг нарийн ажвал биднээс ямар ондоо байдгийг мэдэж болно.

Ихэнх хүн угаас Багшид нь итгэдэггүй байснаа хожим нь Багшийнх нь шавьтай байнга харилцсаны дараа тэд доромжлолыг хүлцэн тэвчиж байхыг хараад сэтгэл хөдөлсний улмаас Багшид нь итгэж эхэлжээ. Шавь нарын үг яриа, үйл ажиллагаа нь багшийнхаа сурган хүмүүжүүлсний үр дүнг төлөөлдөг болохоор шавь нар нь сайн бол Багш нь сайн болохыг мэддэг. Та нар хүүхдээ сургахад мөн л адилхан, Вьетнамчууд: хүмүүжил муутай айлын хүүхэд гэж байнга загнадаг. Энэ нь аав, ээж нь хүүхдээ сайн сургаагүй гэсэн утгатай. Харин дуулгавартай томоотой, боловсрол сайтай хүүхдийг харвал аав, ээж нь хатуу чанга, зөв сургаснаас л сая эрхэмсэг ааш зантай болгож хүмүүжүүлжээ гэдгийг

мэдчихдэг. Ийм хүүхдийг сургаал хүмүүжилгүй хүүхэд гэж хэн ч хэлж чадахгүй.

Билиг ухаан нь өглөг үйлдэх, сахил сахих, доромжлолыг хүлцэх, хичээнгүйлэн дэвших, даяан агуулахтай хамт байх учиртай. Яагаад өглөг үйлдэж, сахил сахих хэрэгтэй вэ? Нэг хүн билиг ухаантай, олноос хэтийдсэн сэргэлэн ухаантай хэдий ч нигүүлсэнгүй сэтгэлгүй бол бас Маяатай ямар ч ялгаагүй. Маяа бас эрх мэдэл, билиг ухаан болон цэцэн сэргэлэн ухаантай боловч хайрын сэтгэлгүй, харин Бурхан Бодьсадвад билиг ухаан байдаг бөгөөд бас хайрын сэтгэл байдаг. Тэр хоёрын ялгаа нь тун их. Бурхан билиг ухаанаа хайр нигүүлсэлд уусган шингээж, тохиромжтой цагт, зөв газарт, зөв нөхцөл тохиолдолд ашигладаг. Хэрвээ билиг ухаангүй бол заримдаа бусдыг хайрлаж байна, сайн үйл үйлдэж байна гэж өөрөө бодсон ч үнэндээ харин эвдэх сүйтгэх ажиллагаа хийж байдаг.

Жишээлбэл, хүүхэд чинь мууг сурч, хар тамхи татдаг хүнтэй найзалж байхыг та нар мэдэж байгаа хэр нь харин хүүхдээ дэндүү хайрлаж эрхлүүлдэг болохоор тэдний аясыг дагалдаж, огт хориглолгүйгээр хүссэн болгоноо хийхийг зөвшөөрдөг. Дээр нь бас мөнгө өгч хор татахыг нь дэмждэг. Ингэх нь хайрын сэтгэлтэй боловч билиг ухаангүй хэрэг бөгөөд энэ нь зөвхөн хүүхдийг тань доройтуулж, бие махбодыг нь дордуулж, оюун санааг нь сүйрүүлэхэд хүргэнэ. Эцэг, эх бологсод ингэж болохгүй, энэ нь хүүхдээ хорлож байгаа хэрэг бөгөөд эцэг, эхийн үүрэг хариуцлагаа сайтар гүйцэтгэхгүй байгаагийн шинж юм.

Чөтгөрийн эзний ертөнц бол яг ийм. Чөтгөрийн эзний ажил бол хүмүүсийг хий хуурмаг зүүд зэрэглээний дотор төөрөгдүүлж, өнөөдөр байснаа маргааш нь алга болчихдог мөнх бус хэрэг бодист ташууруулдаг. Юу хүснэ, түүнийг нь өгнө, архи хүсвэл архи өгнө, гэргий хүсвэл гэргий өгнө, мөнгө хүсвэл мөнгө өгнө, гэр байшин хүсвэл гэр байшин өгнө,

алдар нэр хүсвэл алдар нэр олгоно, ингэснээр л хүмүүсийг уруу татан доройтуулж, мунхруулан төөрөгдүүлж, оюун санааг нь сүйрүүлж, бие махбодыг нь сул дорой болгодог. Энэ бол чөтгөрийн эзний ертөнц мөн, материаллаг зүйлсээр бидний бие махбод, оюун сүнснийг доройтуулдаг. Чөтгөрийн эзэн яг ингэж биднийг төөрөлдүүлдэг.

Эцэг, эх бологсод хүүхдээ дэндүү их эрхлүүлж, зөв аргаар сургаж хүмүүжүүлээгүй болохоор муу хүүхэд болдог. Бурхан Бодьсадва бол үүнтэй адилгүй, хүмүүст юу хүснэ, түүнийг нь өгдөг биш, юу шаардлагатайг нь өгдөг. Энэ бол сая сурган хүмүүжүүлэх зөв арга юм. Бид гаднаа хатуу чанга хандахын зэрэгцээ дотроо хайрлах ёстой, яг л Бурхан Бодьсадва шиг хайрын сэтгэлтэй бөгөөд бас билиг ухаантай байх хэрэгтэй. Бид зөвхөн хайрын сэтгэлтэй ч билиг ухаанаар дутмаг байвал энэ нь бидний сул тал болно. Хүүхдийг эрхлүүлэх тусам амархан муу хүүхэд болчихдог. Билиг ухаан байгаад хайрын сэтгэлгүй бол чөтгөрийн эзэн л болохоос хэтрэхгүй, хийх арга нь дэндүү хатуу ширүүн, үхширмэл, цагийн уртад хэн ч хүлцэхийн аргагүй. Хайр хомсодсон нөхцөл байдалд билиг ухаанаа үргэлжлүүлэн хөгжүүлж чадах хүн байдаггүй. Хураангуйлбал, гадаадад суугаа Вьетнамчуудын үүрэг хариуцлага нь эх нутагтаа байгаа ахан дүүсээсээ бүр ч чухал байдаг. Харийн гүрэнд амьдрахад бидэнд суралцах аз завшаан нилээд олон олдоно. Бид эргэн тойрныхоо нөөц бололцоог гүйцэд ашиглаж, өөрийн санаа сэтгэл, оюун ухаан, авьяас чадвараа оргилд нь тулгал хөгжүүлбэл зохино. Бурхан Бодьсадва болон Эзэн Бурхан биднийг эрхэм дээд үүрэг хариуцлага гүйцэтгүүлэхээр томилсон ч байж магадгүй. Тиймээс та нар цаг ямагт бэлэн байх хэрэгтэй. Хожим эх орон тань энх тайван болох үед бид бүгд л улс орондоо хүчээ хандивлах ёстой. Бясалгалын хүчээ ашиглаж, улс орноо жинхэнээр хайрлавал зохино. Багш нь та нарт амжилт хүсэж байна!



БЯСАЛГАЛ ХИЙХ БОЛОН САХИЛ САХИХУЙ

*Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Америкийн Орегон муж, Портланд хот
1991 оны 3дугаар сарын 3(Эх нь вьетнам хэлээр)*

*※ Хэрвээ Тэнгэрийн бошгийг жинхэнээр ойлгож, нэгэн
цэвэр цайлган багаж болохыг чин сэтгэлээсээ хүсэж,
хүн төрөлхтөн болон дэлхий дахинд ач тус хүртээе гэвэл
бид өөрийн бие, хэл, сэтгэлээ ариусгаж, ургамал хоолтон
болж, сахил сахих хэрэгтэй.*

Та бүхэн маань сайн байцгаана уу? Хэдийгээр бороо орж, цаг агаар тун хүйтэн байгаа ч та нар мөн л энд ном сонсохоор ирсэн байгаад Багш нь тун их баярлаж байна. Гэхдээ зөвхөн Вьетнамчууд төдийгүй, тэр сэргэлэн ухаантай Америкчууд ч ном сонсохоор ирсэн байгаа нь бидний ирээдүй, бидний ертөнцөд итгэл найдвар байна, Америк болон Вьетнамд итгэл найдвар байна гэж Багш нь бодож байна.

Вьетнамчууд дүргэлж бясалгал дадуулдаг бөгөөд ихэнх нь сүм хийд болон шашны дуганд очих буюу гэртээ сууж,

ямар нэгэн бясалгалын арга, ямар нэгэн шашны урсгалын аргаар бясалгасан байдаг. Одоогийн Америкчууд ч ийм. Тэд даяан бясалгал, бурхны ном, библи судрыг суралцсан, эсвэл ямар нэгэн шашны бүлэг, ямар нэгэн алдартай багшийг шүтэн дагаж бясалгал хийдэг. Багш нь шавь нарынхаа урилгаар энд ирснээс гадна бас нэг зорилго нь дэлхий ертөнцийн үймээн самуун, дайн дажин, хүчирхийллийг багасгахын тулд та нар бүр ч илүү хичээнгүйлэн бясалгах хэрэгтэй гэдгийг сануулах гэсэн билээ.

Хүсэл зорилгодоо нийцсэн Төгс Гэгээрсэн Их Багштай учрахуй

Бясалгалын арга тун олон байдаг бөгөөд бясалгагчдын хооронд ч зэрэг дэсийн ялгаа зөрөө их байдаг. Зарим нь ургамал хоолтон болж, шатам халуун шал дээр хэвтэж, махан биеэ дасгалжуулах гэхчлэн зүйл зүйлийн хатуу бясалгал хийх хэрэгтэй гэдгийг санаачилдаг, зарим нь сахил сахих хэрэгтэй гэдэг, зарим нь ийм тийм хэлбэрээр бурханд мөргөж байж л бодь мөрийг олж чадна гэж хэлдэг. Энэ бүх аргаар бясалгавал хэдийгээр Бурханы хутгийг олж чадахгүй боловч ядаж бясалгалын тухайд нэгэн зам нээж, нэгэн зорилго руу чиглүүлж, бясалгал хийхийг огт бодож байгаагүй хүмүүст лавлагаа болгодог.

Яагаад Орегано мужийн ийм олон америк хүн ном тайлахыг сонсохоор ирсэн бэ? Учир нь тэд нэгэнт бясалгалын тухай ойлголттой болсон байсантай нь холбоотой. Хэрвээ ном тайлах тухай ерөөс сонсоогүй бол энд ирж ном сонсохгүй ч байж магад. Тиймээс бясалгалын зам нээсэн тэр хүмүүс бүгд л гавьяа зүтгэлтэй, хүн төрөлхтнийг удирдан дагуулсан багш нар бүгд л гавьяа зүтгэлтэй. Гэхдээ багш болгонд өөрийн гэсэн заах арга бий, тэд шавь нарынхаа бясалгалын суурь, дэс түвшин болон суралцах зорилгыг нь

үндэслэн заах аргаа тогтоодог.

Бид ургамал хоол идэх, сахил сахих, хичээнгүйлэн бясалгах тухай сургасан багштай учирсан байвал эдгээр зүйлийг өөрсдөө хүсэн мөрөөдсөнөөс болсон хэрэг. Бид ийм хүсэл зорилгод дуртай бөгөөд бясалгал хийхийг тун эрхэмлэн дээдэлж, эртний их багш нарыг дуурайхыг хүсдэг. Бясалгал хийхэд заавал нямбай няхуур байх хэрэгтэй гэж үздэг болохоор өөрийгөө хүчилж, сахил дүрмийг журамлан бясалгаж, жаргаж цэнгэхээ багасгадаг.

Бясалгалаа үргэлжлүүлж байгаа тэр хүмүүс хэзээ нэгэн өдөр өөрийн хүсэж санасан Төгс Гэгээрсэн Их Багштайгаа учрах бөгөөд түүнийг дагаж бясалгал хийх болно. Ийм багш нь бидний эрж хүсэж байсан зүйлс, бидний хүсэл зорилгыг ярьдаг болохоор ихэнх хүн түүнд дорхноо дуртай болдог бөгөөд сургаал ёсыг нь даруй хүлээн зөвшөөрдөг.

Гэтэл зарим хүн бясалгалдаа няхуур ханддаггүй, хэдийгээр бас Эзэн Бурхан, орчлон ертөнц, үйлийн үр, байгаль орчин болон тэнгэр газрын хууль дүрэм, хүн төрөлхтний хувьслын хууль дүрмийг нягтлан судлахыг хүсдэг боловч харин сахил сахих дургүй, өөрийгөө хүчлэх дургүй, ургамал хоолтон ч болох хүсэлгүй, хичээнгүйлэн бясалгадаггүй, сахилаа тодорхой сахьдаггүй, бясалгал хийхийн зэрэгцээ жарган цэнгэхийг хүсдэг. Ийм хүмүүс бас хэзээ нэг өдөр ингэж бясалгахыг сургадаг багштай учрах болно.

Ийм багш бас бидэнд эрт дээр үеийн Төгс Гэгээрсэн Их Багшийн дээд дэсийн сургаал номлолыг сургадаг бөгөөд Бурхан Багш нирвааны тухай яаж тайлбарласан, Есүс Христ диваажинг яаж дүрсэлсэн, эсвэл Күнз ингэж ярьсан, Зэнз (орч: Күнзийн нэг шавь) тэгж ярьсан гэж эш татан ном тайлдаг. Гэхдээ дээд дэсийн сургаал ёсыг бидэнд тайлбарлан мэдүүлэхийн зэрэгцээ та өөрөө л шийд, идэж

уун жаргаж цэнгэж болно, юу хүснэ, тэгж болно. Учир нь Эзэн Бурхан тун өршөөнгүй, Бурхан Бодьсадва биднийг зэмлэн буруушаахгүй гэж та нарт ярьдаг. Ингэж сургах нь бас зөв гэж би үздэг. Гэтэл яагаад ихэнх Төгс Гэгээрсэн Их Багш тун болгоомжтой, няхуур, сахилаа маш тодорхой сахиж, ургамал хоол идсэний эцэст хамгийн дээд мөрийн хутгийг олж чадсан байдаг вэ? гэвэл Эзэн Бурхан хүмүүсийг хязгаарладагтаа биш, хүмүүсийг уучилж өршөөдөггүйдээ биш, эсвэл Бурхан Бодьсадва хамаг төрөлтөн сахил сахих эсэхийг хамаардагтаа биш, харин бид өөрсдөө алдаагаа тэвчдэггүй учраас тэр юм. Төгс Гэгээрсэн Их Багш яаж тайлбарлаж ярьсан ч бид өөрийгөө уучилж чадахгүй байж мэднэ.

Хамгийн дээд дэст хүрье гэвэл сахил сахиж, ургамал хоолтон болох хэрэгтэй

Саяхан ярьсан хоёр зүйлийн бясалгалын арга нь цөм зүй ёсонд нийцдэг бөгөөд хамгийн дээд зорилгод хүргэж чаддаг. Үр дүн нь адилхан, сургаал ёс нь ч адилхан, цорын ганц ялгаа нь гэвэл дүрэм журам болон өөрийн биеэ хязгаарлах талаар л ондоо байдаг. Багшийнх нь бодлоор дүрэм журамтай, сахил санваартай, ургамал хоол идэх зам мөр нь бүр ч илүү ач тустай бөгөөд эрх дураар байж, сахил дүрэм баримталдаггүй зам мөрөөс бүр ч илүү үр дүнтэй, хурдан түргэн байдаг.

Эгэл хүмүүсийн санаа сэтгэл тун давчуу, төрөл төрөлдөө хэдийн тархиа угаалгачихсан, ийм үйл үйлдэх нь сайн гэх үзэл бодол тогтчихсон болохоор гэнэт тэдэнд ингэж хийх нь сайн биш гэж яривал хүлээн зөвшөөрөхгүй, Төгс Гэгээрсэн Их Багшид итгэхгүй байж мэднэ. Ойлгож байна уу? Эзэн Бурхан бидний ял гэмийг уучлан өршөөхгүй биш, харин бид өөрийгөө уучилж чадахгүй байж магад.

Багш нь хаа очсон ч гэсэн “Бясалгал хийж хамгийн дээд дэсэд хүрье гэвэл сахил сахиж, ургамал хоолтон болох хэрэгтэй, хүн байх үндсэн ёс суртахууныг дагах хэрэгтэй гэдгийг сурталчилдаг. Хожим бид бясалгал хийж, дээд түвшинд хүрч, аливаа бүхэн цөм зүүд зэрэглээ, хий бодол болохыг ухаарч ойлголоо ч гэсэн, энэ зүүдэн дотор, энэ хий бодлын дунд байгаа үедээ эндхийн хууль дүрмийг сахих хэрэгтэй. Багшийнхаа ярьж байгаа Вьетнам хэлийг ойлгож байна уу? Та нарын ойлгож чадаж байгаа үгүйд санаа зовж байгаа биш, харин Багш нь Вьетнам хэлээр сайн ярьж чадахгүй, энэ ертөнцийн хязгаарлагдмал үг хэлээр орчлонгийн хэргийг хангалттай сайхан илтгэж чадахгүйгээсээ л санаа зовж байна.

Одоо Багш нь үхрийн тухай нэгэн хэргийг ярья! Вьетнамд ер нь үхрийн хамрыг нүхлэн дөрлөдөг, яагаад вэ? гэвэл үхэр тун зөрүүд, зодоод ч явдаггүй, чангаасан ч хөдөлдөггүй болохоор хамрыг нь нүхлэн дөрлөөд хөтөлж явбал өвдөхийн эрхээр эзнээ дагаж явдаг.

Энэ ертөнцийн хүн бас ийм. Муу хэрэг үйлддэг тэр хүмүүсийг залхаан шийтгэж, сайн үйл хийдэг хүмүүсийг дэмжин урамшуулахгүй бол ард иргэдийн амь нас, эд хөрөнгө, сэтгэл санааг айлган сүрдүүлж, эсвэл булаадаг. Тиймээс энэ ертөнцөд дэг журам сахиулахын тулд үйл үрийн хууль дүрэм эрхбиш орших хэрэгтэй. Бид энэ ертөнцөд амьдрахдаа яг л хамраа дөрлүүлсэн үхэр шиг байдаг. Хэрвээ цулбуурын чиглэлийг дагаж явахгүй бол ихэд өвдөж шанална. Дөрөө тастах хүч чадалтай бол эрх дураар болж чадна, тэр үед юу хийсэн ч болно. Үүнээс өмнө бид мөн л энэ ертөнцөд оршин амьдарч, бие махбодын шоронгоос мултарч чаддаггүй болохоор заавал нөхцөл байдалтайгаа зохицох хэрэгтэй.

Иймээс эртнээс эдүгээ болтол аливаа Төгс Гэгээрсэн Их Багш бүгд л шавь нараа сахил дүрмээ сахиж, нийгмийн

дэг журмыг хүндэтгэх хэрэгтэй гэж шаарддаг. Ингэснээр л хамгийн эрхэм дээд зорилгод хүрч, оршин амьдарч байгаа ертөнцөө туулан гэтэлж чадна гэж сургадаг. Багшийнхаа санааг ойлгож байна уу? Ойлгож байгаа нь цэцэн сэргэлэн хүн мөн шүү.

“Энэ ертөнц мөнх бус, хүний амьдрал зүүд зэрэглээ байтал Багш та яагаад ургамал хоол идэх болон сахил дүрмийн тухай асуудлыг чухалчлаад байдаг юм бэ?” гэж олон хүн асуудаг. Тэгэхэд Багш нь: “Хэрвээ ургамал хоол бол бор хоол, бор хоол бол ургамал хоол мөн гэж үзвэл өөрийн чинь эхнэр бол мөн л бусдын эхнэр мөн гэсэн үг үү? Ийм юм бол гэрлэх хэрэггүй шүү дээ! Дахиад хэлбэл бидний мөнгө бол бас бусдын мөнгө гэвэл ажил хийж мөнгө олох шаардлагагүй, аль банк их мөнгөтэй байна, шууд л ороод авчихвал болчихно. Бүгд л бидний мөнгө юм чинь! Ингэж болно гэж үү?” гэж хариулдаг. Ялгаварлах сэтгэлгүй түвшинд хүрэхээс өмнө хүн биднийг зодвол мөн л өвдөхийн эрхээр ихэд уурлаж, хариуд нь түүнийг зодох бодол төрдөг. Хүн бидний зүүн хацрыг алгадвал Есүс Христ шиг баруун хацраа ч дуртай алгадуулах тэр үед л сая сахилд хүлэгдэх шаардлагагүй гэж ярьж болно. Шагжамуни Бурхан болон Есүс Христ насан туршдаа ургамал хоол идсэнийг та нар бурхны судар, библи судрыг нягтлан уншвал мэдэх болно. Бид өөрсийгөө Бурхан Багш болон Есүс Христээс бүр ч илүү, тиймээс ургамал хоол идэх, махтай хоол идэх ямар ч ялгаагүй гэж ярьж үл болно.

Зургаадугаар үеийн өвөг багш Хүй Нэн бол эртнээс эдүгээ болтол хамгаас алдартай номын багш нарын нэг мөн. Тэрээр бясалгаж байх үедээ бас ургамал хоол иддэг байсан. Тэр анчдын дунд нуугдан байхдаа бас арван зургаан жил заавал тэдэнтэй хамт амьдрах хэрэгтэй байжээ. Ийм байдал доор тэр мөн л ургамал хоол иддэг байв. Зарим анчин түүнээс яагаад мах иддэггүй юм бэ? гэж асуухад тэр: “Миний ходоод

муу, махыг шингээж чадахгүй” гэж хариулдаг байжээ. Тухайн үед багш (тавдугаар өвөг багш Хүн Рэн) нь түүнийг зургаадугаар өвөг багшаар өргөмжилчихсэн байсан, гэвч ном дэлгэрүүлэх цаг нь хараахан болоогүй байсан тул ойд нуугдах хэрэгтэй байжээ.

Тэр үед зургаадугаар үеийн өвөг багш Хүй Нэн нэгэнт гэгээрчихсэн бөгөөд орхимж болон бадар аягыг залгамжилсан байсан ч амь насаа хамгаалж, номын уламжлалыг (бясалгалын жинхэнэ аргыг) хамгаалахын төлөө мөн л ургамал хоол идэхийг баримталж байв. Бид хараахан гэгээрээгүй болохоор ургамал хоол идэх, махтай хоол идэх нь ялгаагүй гэж гэж ярьж үл болно. Нэгэнт билиг нээгдсэн хэр нь орхимж, бадар аягыг залгамжлан авсан хүн байтлаа бас ургамал хоол идэхийг баримталдаг байжээ. Гэхдээ тухайн үед Хүй Нэн сүм хийдэд биш, харин анчидтай хамт амьдарч байв. Өөр дээр нь ирдэг сүсэгтнүүдэд үлгэр жишээ болохын тулд, эсвэл багшдаа зэмлүүлэх, сүсэгтнүүдэд шүүмжлүүлэх, уршиг яршигт ороогдох зэргээс болгоомжлохын тулд хүчээр ургамал хоол иддэг биш аж. Ойлгож байна уу?

Харин ч эсрэгээрээ, сүм хийдэд суудаг тэр хүмүүс угаас ургамал хоол идэх ёстой байдаг ч элдэв шалтаг эрж ургамал хоол иддэггүй. Гэтэл Хүй Нэн Багш ой шугуйд арван зургаан жил нуугдан мах идэх нь тун энгийн хэрэг гэж үздэг хүмүүстэй хамт амьдрахдаа мөн л сахилаа сахиж, ургамал хоол идэхийг баримталж байжээ. Үүнээс ургамал хоол идэх нь бясалгалд маш их тус дэм болдог тул хамгийн дээд мөрийн хутагт хүрье гэвэл эрхбиш ургамал хоол хэрэгтэй гэдгийг мэдэж болно. Хэрвээ энгийн нэгэн мөрийн хутагт хүрч, нэгэн хязгаартай түвшинд гэгээрье гэвэл дураараа идэж ууж болно.

Бие, хэл, сэтгэлээ ариусгаж, цэвэр ариун багаж болохуй

Нэгэн бүр ч өндөр дэс, бүр ч ариун тунгалаг түвшинд хүрье гэвэл бие, хэл, сэтгэлээ ариусгах хэрэгтэй. Жишээлбэл, нэгэн усны хоолой цэвэр ч бай, бохир ч бай, ус залгуулдаг л бол устай болно. Гэхдээ усны хоолой бохир бол усыг нь байнга уувал бие махбод асуудалтай болно, усны хоолой маш цэвэр бол усыг шууд ууж болдог бөгөөд бие махбодыг хордуулахгүй.

Үүнтэй адилаар, ховор нандин хүний биеийг олж төрсөн нь нэгэн эрхэм дээд ариун дагшин хэрэг билээ. Бие махбодоо хордуулж, түүнийг бохирдуулбал угаас энэ ертөнцийг адисалдаг бие махбодоос үүсэлтэй тэр ариун дагшин хүчийг саатуулж, гэрэл гялбаа, ач тусыг нь алдагдуулж, тэр ч байтугай заримдаа энэ ертөнцийг хордуулж мэднэ.

Тэнгэрийн бошгийг жинхэнээр ойлгож, нэгэн цэвэр ариун багаж болохыг чин сэтгэлээсээ хүсэж, хүн төрөлхтөн болон орчлон ертөнцөд ач тус хүртээ гэвэл бид бие, хэл, сэтгэлээ ариусгаж, ургамал хоолтон болж, сахил сахих хэрэгтэй. Ингэснээр л бидний бие махбодоор дамжин цацрах аливаа уур амьсгал цэвэр байж чадна. Эс бөгөөс тэр бохир усны хоолойтой адил болно. Хэдийгээр цэвэр устай адил харагдах шиг боловч үнэндээ цэв цэвэр биш байдаг.

Жишээлбэл, урьд нь та нар бор хоол идэж байснаа хожим нь ургамал хоолтон болсон бол, энэ хоёрын ялгааг мэдэрдэг. Харин ерөөсөө ургамал хоол идээгүй, бор хоол идсээр ирсэн хүний хувьд ямар ч ойлголт байдаггүй, зөвхөн маргалдах төдий бөгөөд үр дүн байхгүй. Багшийнх нь ярьж байгаа ургамал хоол идэх гэдэг нь албадаж байгаа хэрэг биш, харин сайн дурын үндсэн дээр байдаг. Ургамал хоол

идэхийг ухааран ойлгох нь маш энгийн хэрэг, нэг зүйлийн хэрэгцээ мөн. Чин сэтгэлээсээ, өөрөө дурлан ургамал хоол идэх нь сая сайн.

Гэхдээ зарим хүн “хүч”-ээр ургамал хоол иддэгийг Багш нь мэднэ. Жишээлбэл, Вьетнамын хэдэн дүрвэгч их далайд хөвөн тэнэж явахдаа дэндүү их өлсөхийн эрхээр Арьяабал Бурханд: “Үр тань хэрвээ эрэгт гарч, аюулгүй улс оронд хүрч чадвал нэг жил, эсвэл хоёр жил чармайн байж ургамал хоол иднэ” гэж даатгажээ. Хожим нь аюулгүй улсад хүрсний дараа харин бүтэн жилээр ургамал хоол идэх дургүй болсон тул: “Урьдын андгайлсан тангараг хүчингүй, үр тань сар болгон нэг удаа ургамал хоол идье, ингэж нэг жил идэж болохыг зөвшөөрнө үү?” гэж даатгасан байна. Эцэст нь ганц бүтэн өдөр ч ургамал хоол идэж чадаагүй гэдэг.

Өчигдөр Багш нь дөнгөж энд ирсэн, бараг шөнийн арван хоёр цагийн үед авшигтнуудтай ярилцаж суусан. Нэгэн эмэгтэй авшигтан Багшид нь: тэрээр Багштай нь уулзахаас өмнө ургамал хоол иддэг, гэхдээ сар болгоны гучин болон шинийн нэгэнд л ургамал хоол иддэгээ найз нартаа гайхуулдаг бөгөөд одоо хоёр хоног ургамал хоол идэхийг түүнд сануулж байгаарай гэж бусдад захидаг. Ургамал хоол иддэг тэр хоёр хоногтоо цагийн зүүг нүд салгалгүй ширтэн шөнийн арван хоёр цаг болмогц тэр дорхноо махтай хоолоо зооглодог. Хожим нь Багштай нь тааралдсан бөгөөд Багшийн номыг уншсаны дараа сая юунд ургамал хоол иддэгийг ойлгож, аяндаа сэхээрэн ухаарчээ. Одоо махыг харавч дахин идэх хүсэлгүй болж, тэр ч байтугай махны үнэрээс эмээх болж, үнэртвэл дотор нь муухайрч, тавгүй болдог ажээ.

Тиймээс Бурханы хутагт хүрсний дараа бор хоол, ургамал хоол хоёрыг харахаар адилхан санагддаг гэж та нар битгий яриарай! Тийм биш, мах харлаа ч гэсэн сэтгэл

татагддаггүй, гэхдээ бусдыг зэмлэн буруушаадаггүй, ургамал хоолтон гэж өөрөө онгирдоггүй, махан хоолтнуудыг зэмлэн буруушаадаггүй. Бид өөрийн дуртай зүйлдээ бусдыг хүчээр хүлээн зөвшөөрүүлж болохгүй, ургамал хоолтон гэдгээ бусдад зориудаар мэдүүлж болохгүй. Ийм хандлага нь бусдыг тавгүйтүүлдэг.

※ *Чин сэтгэлээсээ, өөрөө дурлан ургамал хоол идэх нь хамгаас сайн.*

“Сайныг ч бодохгүй, мууг ч бодохгүй” байх түвшин

Муу хэргийг сайн гэж, сайн хэргийг муу гэж ярьж болохгүй, нэгэнт Бурханы хутагт хүрчихсэн, эсвэл гэгээрчихсэн хүмүүсийн хувьд муу нь муугаар, сайн нь сайнаараа ялгардаг. Зүгээр л муу ч бай, сайн ч бай түүнийг хамаардаггүй, ялгаварладаггүй, ойлгож байна уу? Сайн хэргийг сайшаан дэмжиж, сайн хэрэг үйлдэгсдийг магтдаг. Муу хэргийг аяар нь байлгаж, муу хэрэг үйлдэгсдийг ч хамаардаггүй, зориудаар ямар нэгэн үйл хэрэг хийж, тэднийг өөрчилдөггүй, зөвхөн сургаал ёс тайлбарлаж, ёс суртахуун, сахил дүрмийн талаар тэднийг заан жолооддог. Ингэх нь сая сайныг ч бодохгүй, мууг ч бодохгүй байх явдал юм. Харин “Сайныг ч бодохгүй, мууг ч бодохгүй”-н түвшинд хүрвэл муу хэрэг үйлдэж болно гэсэн хэрэг биш.

Нэгэнт сайн ч биш, муу ч биш болчихсон юм чинь муу хэрэг үйлдэх боломж яаж байж болох вэ? Ихэнх хүн бурхны судрыг буруугаар ойлгож, бясалгагч хүн сайн, муугийн талд баригдаж хүлэгдэж болохгүй гэж үздэг. Сайн, муугийн талаар баригдахгүй гэх юм бол бурхны шашинд яагаад амь хороож болохгүй, хулгайлж болохгүй, худал ярьж болохгүй, муу үйл үйлдэж болохгүй, архи ууж болохгүй, мах идэж болохгүй гэж тодорхой тогтоосон бэ? Шагжамуни

Бурхан яагаад бас шавь нартаа ямар нь сайн зам мөр, ямар нь муу зам мөр гэдгийг тодорхой заан сургаж байсан бэ? Бурхны шашны сүсэгтнүүд арван сайн үйл үйлдэж, католик шашинтнууд арван зарлигийг дагадаг, ийм байхад юунд “сайныг ч бодохгүй, мууг ч бодохгүй” гэж ярьж чаддаг юм бэ?

“Сайныг ч бодохгүй, мууг ч бодохгүй” гэдэг нь эгэл ертөнцийн сайн, муу үйл хэргийн тухай бодол сэтгэлээс хэтийдсэн тэр хүмүүст л хандаж хэлсэн хэрэг. Тэд ертөнцийн үйл хэргийг зөвхөн харах төдийд л сэтгэл татагдан шүүмжлэх, хараан загнах буюу гүтгэн дайрдаггүй. Зөвхөн хайрын сэтгэл, учир зүйгээр ерөөл барилдлагатай, сонсох хүсэлтэй, даган суралцах хүсэлтэй хүмүүст л тайлбарлан ярьдаг, ингэх нь сая “сайныг ч бодохгүй, мууг ч бодохгүй”-д тооцогдоно. Нэгэнт Бурхан Бодьсадвагийн түвшинд хүрсэн хүн л “сайныг ч бодохгүй, мууг ч бодохгүй” байж чаддаг, сэтгэл тайвуу, ертөнцийн аливаа сайн, муу үйл хэргийг харсан ч сэтгэл татагддаггүй.

Сайн, муу нь зөвхөн үйлийн үрийн үр дагавар болохыг нэгэнт мэдчихсэн болохоор алуурчныг сэтгэлийн хөөрлөөр шүүмжилдэггүй бөгөөд бас алагдсан хүнийг өрөвддөггүй. Зөвхөн амь хөнөөж болохгүй, хөнөөгдсөн хүн ч хорсол занал өвөрлөж болохгүй гэж бусдыг ятгадаг. Харин аливаа бүхэн бүгд л үйлийн үрээс үүсэлтэй гэдгийг ойлгож, хожим харилцан хөнөөлцөж болохгүй, эс бөгөөс үйлийн үрийн холбоост гүн орооцолдож, өөрийгөө аврахын аргагүй болно гэж сануулдаг. Тэд аль алинд нь ч сэтгэл татагддаггүй, үүнийг л сая “сайныг ч бодохгүй, мууг ч бодохгүй” гэж хэлнэ.

“Сайныг ч бодохгүй, мууг ч бодохгүй” гэдэг нь сайн, мууг үл ялган дур зоргоороо өдөөн хатгаж, амь хороож, булаан дээрэмдэхийг хэлдэг биш. Бурхны оронд сайн, мууд баригдаж хүлэгддэггүй гэдэг нь үнэн хэдий ч бид энэ

түвшинд хараахан хүрээгүй байж, дураараа тайлбарлаж, бусдыг эндүү буруу ойлгуулахгүй байвал зохино. Өөрөө буруугаар ойлгох нь угаас маш муу байтал бас өөрийн буруу ойлголтоо бусдад ярьж, элдвийн арга хэрэглэн үгэндээ оруулах нь бүр ч муу нөлөөтэй. Бусад хүн биднийг аяндаа дагавал бас тийм ч хүнд ноцтой биш. Хэрвээ зориудаар туйлширч, албадлагын, эсвэл хууран мэхлэх арга ашиглаж, бусдад нөлөөлж, өөрийгөө итгүүлэн дагуулбал үйл түйтгэр нь бүр ч хүнд байдаг.

“Хуурмаг эрх чөлөө” болон “жинхэнэ эрх чөлөө”-ний ялгаа

Одоо та нар сахил сахих болон сахихгүйн ялгааг нэгэнт мэдлээ. Бурхны сударт: Бурхан сахил дүрэмд баригддаггүй, сахил дүрмийг журамлах шаардлагагүй гэж өгүүлсэн байдаг, энэ нь зөв боловч өөр ертөнц дэх байдал болно. Жишээлбэл, та нар бясалгаж суугаа үедээ бурхны оронтой холбогдож, өөрөө бурхан болчихсон шиг санагддаг, тэр үед ямар нэг сахилын тухай хаанаас санаж олох билээ? Эсвэл дээд түвшинд хүрэх үед булаан дээрэмдэх, бусдыг хөнөөх тухай хэрэг гардаггүй газарт, сахил сахих тухай хэрэг явдал хаанаас гарах билээ? Дээд түвшин угаас дэг журамтай, сахил сахих шаардлагагүй.

Гэтэл энэ доор дэсийн ороо бусгаа хүний ертөнцийг дүрэм журам болон сахил санваараар хязгаарлахгүй бол бүр ч илүү самуурч, тэр ч бүү хэл, тамын орон, дайны талбар болж хувирна. Тиймээс энэ ертөнцөд сахил сахих шаардлагагүй гэж ярьж болохгүй. Үзэсгэлэнтэй сайхан энэ дэлхийгээ бид хайрлан хамгаалахгүйн дээр бүр ч ихээр самууруулбал хүн болсны үүрэг хариуцлагаа сайтар биелүүлээгүй хэрэг болно. Энэ ертөнцөд бид гахай, үхэр зэрэг амьтныг бүтээж чаддаггүй байтлаа харин алж хөнөөдөг. Бид өөрсдөө үхрийг

бүтээж, хээр талаар тоглуулж чаддаг бол бас яах вэ, тэднийг алах эрхтэй гэж үзэж болно. Гэтэл ингэж чадахгүй байтлаа харин алж нядалбал амь насыг хулгайлж, бүтээгчийн өмчлөх эрхийг хулгайлсанд тооцогдоно, яг л хөршийнхөө жимсийг хулгайлсантай адилхан хэрэг мөн.

Сургаал ёс, сахил дүрмийг тайлбарлахад тун бэрх, өөрийгөө хүчилж сахил сахих буюу сургаал ёсыг бодитой гүйцэлдүүлэх дуртай хүн тун цөөн. Хүн болгон цөм би өөрийн гэсэн эрх чөлөөтэй, юу хийсэн ч миний дур, “Энэ бол эрх чөлөө мөн” гэж үздэг. Гэтэл эрх чөлөө болон жинхэнэ эрх чөлөө хоёр адилгүй. Яг л та нар би эрх чөлөөтэй, хулгайлах, булаан дээрэмдэх эрхтэй гэж ярьдаг, гэхдээ ийм байдал нь бусдын эрхэнд халдсан хэрэг болдогтой адил. Тиймээс та нар ерөөс жинхэнэ эрх чөлөөтэй байж чаддаггүй. Та нарын нинжин сэтгэл чинь ингэх нь буруу, бусдын эрхэнд халдаж байна гэж мэдэрдэг. Иймээс жинхэнэ эрх чөлөө болон хуурмаг эрх чөлөөний хооронд ялгаа бий.

Жинхэнэ эрх чөлөө гэдэг нь өөрийн амьдарч буй орчиндоо хийсэн бүх зүйлдээ хариуцлагатай байж, үүргээ тууштай гүйцэтгэхийг хэлнэ. Эрх чөлөө гэдэг нь юу хүснэ, түүнийгээ хийнэ гэсэн үг биш. Бид жинхэнэ эрх чөлөөтэй больё гэвэл хууль дүрмийг хүндэтгэх хэрэгтэй. Заримдаа бид: “Засгийн газар маш олон хууль дүрэм тогтоодог, хэтэрхий ядаргаатай болохоор надад эрх чөлөө алга. Яагаад ингэж ч болохгүй, тэгж ч болохгүй гэж хориглодог юм бэ?” гэж гомдоллодог. Хэрвээ энэ хууль дүрмийг зөрчин эрх чөлөө гээчийг эдэлбэл бид хууль дүрмийг зөрчиж, эцэс сүүлдээ шоронд орж, бүрмөсөн эрх чөлөөгүй болно. Хууль дүрмийг хүндэтгэвэл биднийг хязгаарлах хүн байхгүй, хаа хүрье гэвэл хүрч, аль ч хоолны газарт очиж хооллосон болно, хичнээн мөнгө олж, яаж хэрэглэх нь бүгд таны дур. Үүнээс та нар хуурмаг эрх чөлөө болон жинхэнэ эрх чөлөөний ялгааг харж чадаж байна уу?

Орчлон ертөнц ч гэсэн өөрийн гэсэн хууль дүрэмтэй. Хэрвээ ертөнцөд ямар ч хууль дүрэм байдаггүй бол яаж хувьсаж өөрчлөгдөх вэ? Хэдийгээр бид хүн болж энэ дэлхийд амьдрахдаа эрх чөлөө эдлэх ёстой гэж үздэг ч хууль дүрмийг дураар зөрчиж болохгүй. Үүнтэй адилаар орчлонгийн хуулийг сөрсөн хэрэг үйлдвэл шийтгэгдэх болно. Яг л нэгэн улсын иргэн хуулийг зөрчвөл эрт орой хэзээ нэг өдөр шийтгүүлдэгтэй адил.

Багш нь энгийн үед сахилын тухай тийм их тайлбарладаггүй, гэтэл одоо илүүхэн тайлбарлах шаардлагатай гэж Багш нь бодож байна. Энэ муж улсад нэг зүйлийн онцгой шаардлага байдаг болохоор сахил санваарын тухай илүүхэн ярилцах хэрэгтэй, та нар гайхах хэрэггүй шүү! Багш нь аль ч улсад ном тайлсан бүгд л тухайн орны шаардлагад тулгуурлаж, сонсогчдын хүсэл сэтгэлд нийцүүлж ярьдаг. Гэхдээ ерөөс эх ноорог бэлтгэдэггүй бөгөөд тайлах сэдвээ урьдчилан тогтоодоггүй. Тэр ч байтугай уг нь ярья гэсэн зүйлээ тухайн газраа хүрсний дараа ярихаа больж, огт өөр зүйл ярьж, Эзэн Бурханы санаа зорилтыг дагаж, Дээд Тэнгэрийн зохицуулалтаар ном тайлдаг. Ийм хэлбэрийн ном тайлалд дуртай хүмүүс олон байдаг бөгөөд дургүй хүмүүс ч их байдгийг та нар ойлгох болов уу? Та нар өөрсдийн хүсэж байгаа учраа сонсох хүсэлтэй бол дараа асуугаарай! Тэгэх үү? Олон хүний цуглаанд ном тайлах үеэр хүн болгоны хүслийг хангах боломж байхгүй.

Хоёр хуврагийн үлгэр

Багшийнх нь саяхан ярьсан сахил нь бас үнэмлэхүй зүйл биш бөгөөд эрхбиш газар орон болон орчин тойрны байдлыг харж, үйл хэргээ зохистой шийдвэрлэх хэрэгтэй. Эрт урьдын цагт сахилаа маш чанга сахидаг хоёр хувраг байжээ, хувраг хүн эмэгтэй хүнтэй ойр дотно байж болдоггүй, эхнэр

хүүхэдтэй байж болохгүй. Нэг удаа хоёр хувраг голын хөвөөнд очих үед нэгэн охин гол гаталж чадахгүй тэнд арга барагдан сууж байжээ. Учир нь голын урсгал тун догшин бөгөөд цаад эрэгт ээж нь гэртээ түүнийг хүлээж буй ажээ. Завь байхгүй, гүүр ч байхгүй болохоор охин хоёр хуврагаас түүнийг гол гатлуулж өгөхийг гуйжээ. Үүнд нэг хувраг нь сахилаа эвдэхээс болгоомжилж, гол гатлуулахаас татгалзав. Нөгөө хувраг нь харин зөвшөөрч, охиныг үүрч, гол гаталган цаад эрэгт хүргээд цааш явжээ. Тэгээд нэгэн газар хүрч, хоёр хувраг жаахан амсхийж унтахаар болов. Охиныг үүрч гол гаталсан хувраг хэвтмэгц унтчихав, гэтэл нөгөө хувраг нь унтаж чадахгүй баахан бодол болж, ийш тийш хөрвөөсөөр унтаж байсан хуврагаа сэрээчихэв. Тэгээд: “Хүндэт ламтан минь ээ! Та өнөөдөр яагаад сахилаа зөрчиж, эмэгтэй хүнийг үүрч гол гатлав аа” гэж асуужээ. Тэгэхэд нөгөө хувраг: “Өө, Бурхан минь! Би голын эрэг дээр түүнийг нэгэнт тавиад орхичихсон байхад та яагаад одоо болтол охиныг үүрсэн хэвээр байна вэ?” гэжээ.

Чухам хэн нь баригдаж хүлэгдэж байгааг та нар мэдэв үү? Сахилд тэгж ихээр хүлэгдэх нь буруу. Тэр хувраг хэдийгээр охиныг үүрсэн боловч үүрээгүйтэй адил байж. Харахад сахилаа зөрчсөн шиг боловч муу бодол өвөрлөөгүй, зөвхөн бусдад тусалсан төдий бөгөөд тусалж дуусчихаад мартжээ. Гэтэл нөгөө хуврагийг харахад сахилаа сахиж байгаа шиг боловч сэтгэл нь ариун биш, угаас цэвэр ариун хэргийг харин муугаар бодсон байна, ойлгосон биз?

Тэр хувраг зөвхөн бусдын өнгөн талын үйл хэргийг харснаас биш, харин бусдад туслах гэсэн цэвэр цайлган сэтгэлийг нь ойлгоогүй байна. Бүр хар муухай сэтгэлээрээ бусдыг магадлан шүүмжилж, тэр ч байтугай нойр нь хулжихдаа тулжээ. Нөгөө хувраг үүрсэн охиноо голын эрэгт тавиад цаашаа хэдэн километр явах зуураа аль хэдийн мартсан бөгөөд амсхийх үедээ тайвуу сайхан

нойрсжээ. Гэтэл нөгөөх нь харин бухимдан уурлаж, өнөөх охиныг сэтгэлдээ хэдэн километр алс тээж, огтхон ч тавьж явуулаагүй байж. Энэ бол сая сахилаа зөрчиж байгаа хэрэг мөн.

Нөгөөх хуврагийг харахад сахилаа зөрчсөн шиг боловч зөрчөөгүй байна. Учир нь тэр олон зүйлийг бодоогүй бөгөөд сахилаа зориудаар зөрчөөгүй, зөвхөн бусдад туслахыг л бодсон байна. Гэтэл өнөөх хувраг хэдийгээр сахилаа зөрчөөгүй боловч бодол сэтгэл нь тайвшраагүй, унтах нойргүй, хэдэн километрийн турш өнөөх охиныг сэтгэлдээ тээсээр явжээ. Ийм байдал нь бас л сахилаа зөрчиж байгаа хэрэг болно.

Багш нь яагаад тэр хуврагийг сахилаа зөрчлөө гэж хэлж байна вэ? Мэдэх хүсэлтэй бол эхлээд юунд сахил сахих хэрэгтэй вэ?, сахилаа зөрчих нь яагаад муу байдаг вэ? гэдгийг ойлгох хэрэгтэй. Жишээлбэл, урьд нь ярьсанчлан, хамрыг нь дөрлөн хөтөлж явдаг үхэр шиг, хэрвээ хөтөлж байгаа хүнийг дагаж явахгүй бол хамар нь өвдөнө.

Сахил сахиж, бясалгал хийдэг хүмүүсийн хувьд ч бас үүнтэй адил. Сахилга батад дассан, сахил дүрмүүдийг нэгэнт сахиж хэвшсэн байдаг бөгөөд энэ ертөнцөд амьдрахдаа ингэж хийвэл сайн, тэгж хийвэл муу гэдгийг ойлгочихсон байдаг. Тэгээд муу үйл мөн гэдгийг тодорхой мэдсээр байж хийчихвэл нинжин сэтгэлийнхээ зэмлэл буруутгалыг хүртэж, санаа сэтгэл тогтворгүй болдог бөгөөд өвчилсөн ч ихэвчлэн шалтгааныг нь мэддэггүй. Энэ бол сахил сахидаггүйн муу тал болно.

Сахилаа сахиж, өөрийн хийсэн бүхий л үйл хэргээ бүгд зөв бөгөөд нийгмийн болон шашин суртахууны талын магтаал сайшаалыг олно гэдгийг мэдэж байвал, санаа сэтгэл амар амгалан байх болно. Сэтгэл тогтуун байвал бясалгал ч тогтвортой байж, эргэлзээ төрөхгүй. Бодол сэтгэлд эргэлт буцалт, тээнэгэлзээ байхгүй болж, есөн шидийн юм бодохоо

больдог. Ингэснээр нэгэн үзүүрт сэтгэлээр бясалгаж, маш түргэнээр самадид орж дээд түвшинд хүрэх болно. Санаа сэтгэл тээр дараатай байвал доош татагдан унах болно. Энэ бол сахил сахиу хэрэгтэй байдгийн шалтгаан юм.

Нөгөөх хувраг сахил сахиу шаардлагагүй. Тэр сахил сахиугүйгээр сахилаа сахидаг, учир нь түүний сэтгэл нэгэнт юунд ч хүлэгдэхгүй болжээ. Нэгэн охиныг үүрч гол гаталгах нь яг л нэг мод, бяцхан хүүхэд, эсвэл өөрийн ачаагаа үүрч байгаатай адилхан санагддаг болсон хэрэг. Өнөөх хувраг бол албадлагын эрхээр сахил сахиж байгаа төдий, яг л саяхан ярьсан эмэгтэй авшигтантай адил. Авшиг хүртэхээс өмнө ургамал хоол идэх хоёр хоногтоо цагийн зүүг нүд салгалгүй ширтэж, оройн арван хоёр цаг болмогц тэр дорхноо бор хоол руугаа яаран гүйдэг. Ийм хүн бол жинхэнээр ургамал хоол идэж, сахил сахиж байгаад тооцогдохгүй.

Сэтгэлдээ ургамал хоол идвэл болчихно гэж зарим хүн хэлдэг, яагаад ингэж ярина вэ? Сэтгэлдээ ургамал хоол идэх гэдэг нь бясалгал хийж, ургамал хоол идэхийг чин сэтгэлээсээ хүсэхийг хэлдэг. Харин ургамал хоол иднэ гэж ярихаас цаашгүй, бор хоол идэхийг хүсдэг бол энэ нь буруу. Гэвч маш олон хүн ингэж боддог, энэ бол сахил сахиж байгаа хэрэг биш.

Багш нь яагаад өнөөх хувраг тэр охиныг үүрээгүй байтлаа сахилаа зөрчив гэж ярьсан бэ? гэвэл тэр өөрийн бие, сэтгэлээ амарлингуй байлгаж чадсангүй. Найзынхаа үйлдлийг зэмлэн буруушааж, найздаа уурласан байна. Ингэх нь тэр өөрийгөө хорлож, бясалгалын талдаа сахилаа зөрчсөнтэй адил билээ. Ойлгож байна уу? Бид сахил сахидаг нь сэтгэлийг маань амарлингуй тайвуу болгодог, гэтэл тэр тэгж чадаагүй болохоор сахилаа зөрчжээ, ийм л төдий. Тиймээс бид сахил сахиж байгаа эсэхийг нь өөр өөр нөхцөл байдлын дагуу тогтоох хэрэгтэй.

Есүс Христийн билиг ухаан

Есүс Христийг амьд сэрүүн байх үед нэг бүсгүй нууц амрагтай болсноос ялд унажээ. Есүс Христ үүнийг яаж шийдвэрлэх бол гэж хүмүүс анхаарч байв. Тухайн үед нууц амрагтай болсны ял шийтгэл нь олон хүн түүн рүү чулуу шидэж алдаг, хамгийн багадаа хүнд шархдуулдаг байв. Есүс Христ өнөөх бүсгүйг гэмгүй гэж яривал хүмүүс түүнийг дураар чалчиж байна, хууль дүрэм, ёс суртахууныг хүндэтгэхгүй байна гэж шүүмжлэх болно. Гэмтэй гэж яривал мөн л түүнийг нигүүлсэнгүй биш, эгэл хүн шиг бусдыг залхаан шийтгэдэг гэж ярих болно.

Тэд Есүс Христийг арга барагдуулахаар санаархжээ. Гэтэл Есүс Христ хүүхэд биш хойно арга барагдаж яаж болох вэ? Өнөөх бүсгүй яагаад ялд унасан гэдгийг тэр мэднэ. Тэр бүсгүйн ярьснаас харахад эр нөхөртэй боловч үнэндээ ямар ч хайр сэтгэлгүй гэжээ. Түүний нөхөр нь эрх сүр, эд мөнгөө ашиглан бүсгүйг угийн хайр сэтгэлтэй хүнээс нь, өөрөөр хэлбэл нууц амраг гэгдэх нөгөө эрээс нь салгаж, хүчээр эхнэрээ болгожээ.

Гэрлэсний хойно бас өнөөх эр нөхөр нь бүсгүйд сайнаар хандсангүй, өдөр бүр хүнд ажил хийлгэж, хэдэн жилээр байнга загнан зодож, тэвчихийн аргагүй болгожээ. Бүсгүй ихэд гуньж зовдог ч чухам хаа очихоо мэддэггүй. Урьдын хайрласан эр нь удаж удаж нэг удаа ирдэг бөгөөд уулзсаны дараа ихэд баярлаж, зөвхөн харилцан тэврэлцдэг төдий л байжээ. Энэ бол хүн бологсдын энгийн хайр сэтгэл. Тиймээс бүсгүй өөрийгөө ял гэмтэй гэж бодоогүй. Есүс Христ түүнийг хэлмэгдсэнийг мэддэг болохоор ял гэмгүй гэжээ. Энэ нь ийм нөхцөл байдалд л ял гэмгүй гэдгийг л илтгэж байгаагаас биш, харин нууц амрагтай болсон бүхэн бүгд л ял гэмгүй гэсэн хэрэг биш.

Гэтэл өөр хүмүүс үүнд яаж итгэж чадах билээ? Тэд

ял гэмийн гэрч баримт нэгэнт хангалттай болчихсон гэж ярина, тус орны хууль дүрмийг үндэслэвэл өнөөх бүсгүй олон хүний шидсэн чулуунд зодуулна. Есүс: “За! Та нар хэрвээ түүнийг ял гэмтэй гэж бодвол чулуу шидээрэй! Гэхдээ өөрийгөө хар багаасаа өдийг хүртэл огт гэм зэм хийгээгүй, ямар ч муу хэрэг үйлдээгүй гэж үздэг хүн байвал эхний чулууг шидээрэй!” гэж хэлжээ. Хүмүүс үүнийг сонсоод цөм толгойгоо ганзагалаад дув дуугүй зайлж оджээ.

Багш нь энд, эсвэл өөр ямар нэгэн газарт очдог нь хүмүүсийн үйл ажиллагааг шүүж шалгахын төлөө биш, зөвхөн та нарт хялбар дөхөм бөгөөд шулуун түргэн нэгэн зам бий гэдгийг сануулахын төлөө билээ. Энэ замыг эртнээс эдүгээ болтол Төгс Гэгээрсэн Их Багш нар нэгэнт засан тэгшилж явахад бэлэн болгочихсон байдаг. Хэрвээ даруй түргэнээр диваажинд буцахыг хүсэж байгаа бол яагаад энэ замаар явахгүй байна вэ?

Мод чулуунд хашигдаж, бут сондуул хөглөрсөн энхэл донхол замаар явах нь тун аюултай бөгөөд цаг завьг ихэд үрнэ, зорьсон газартаа чухам хэзээ хүрч чадахыг мэдэхийн аргагүй. Гэхдээ бас ихэнх үед зорьсон газартаа хүрэхээс өмнө амиа алдаж ч мэднэ. Тиймээс Багш нь сая зам зааж өгч, та нарт сануулж байгаа билээ. Багш нь бусдын ял гэмийг шүүж, эсвэл шүүмжлэн дайрч байгаа биш. Бусдын ял гэмийг ямар ч алдаагүй шүүн тогтоож чаддаг туйлын эрхэм дээд хүн байдаг гэж Багш нь үздэггүй. Өөрийгөө ч гэсэн ямар ч ял гэмгүй бөгөөд өөрөөсөө дэсээр доор хүмүүсийг зэмлэн шүүмжилж чаддаг гэж үздэггүй, ерөөс ингэж бодоогүй.

Энэ ертөнцөд хамт амьдрахдаа бид бага зэрэг ч гэсэн нийтийн үйл үрийг хуваалцдаг, нэг хүн алдаа гаргавал бүгдээрээ хариуцах ёстой. Харин ганцхан тухайн хүний алдаа биш. Тухайлбал, сонин хэвлэл уншиж, нийгэмд гарсан зарим хэргийг уншиж байхад эмэгтэйчүүдийг хүчирхийлж, шүүхээр ял сонссон олон хүн харагддаг. Залхаан шийтгэх

нь зөв, гэхдээ зөвхөн ялтан л буруутай биш, улс даяараа цөм хариуцах ёстой байж таарна. Учир нь тэр шалиг завхай кино болон бие махбодынхоо нууцгай хэсгээ дэндүү ил болгож, хүмүүсийн сэтгэлийг татаж, ил задгай хувцасладаг эмэгтэйчүүд эрчүүдийн шунал хүслийн уг чанарыг өдөөдөг.

Тиймээс алдаа гаргасан хүмүүс залхаан шийтгүүлэх нь зүйтэй хэр нь өөр хүмүүс ч гэсэн ухааран сэхээрч, үүрэг хариуцлагаа биелүүлж, ойр хавийн амьдарч буй орчин тойрноо хамгаалж, ял гэм хийгсдийг өдрөөс өдөрт багасгах хэрэгтэй. Үр хүүхдээ сурган хүмүүжүүлж, ах дүүсээ удирдан дагуулж, нийгмээ сайжруулах хэрэгтэй. Боломжийнхоо хэрээр чармайвал гэмт хэрэг үйлдэгсэд яриангүй багасах болно. Бид энэ нийгэмд оршин амьдрахдаа нийгэм болон дэлхий ертөнцийн ялзармал байдалд зохих хариуцлага үүрэх нь зүйтэй гэж Багш нь үздэг. Багш нь олон орноор тойрон ном тайлж, уламжлан дэлгэрүүлж байгаа нь боломжийнхоо хэрээр гараг дэлхийг авран туслахын төлөө билээ. Харин өөрийгөө эрхэм дээдээр үзэж, ондоо хүсэл зорилготой хүмүүсийг дур зоргоороо шүүж шүүмжлэхийн төлөө биш юм гэдгийг та нар ойлгож байна уу?



ГУРВАН ЭРДЭНЭД АВРАЛ ОДУУЛАХ БОЛОН АВШИГ АВАХ ЁСОН

*Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Аризона мужийн Финикс хот
1991 оны 3 дугаар сарын 10 (Эх нь вьетнам хэлээр)*

*※ Хувь хүний алдар нэр, нэр хүнд бүхнээ алдаж, өөрийн
бүхнээ зориулан байж бусдад үйлчилж, ямар ч хариу
харамж хүсдэггүй байхыг л гэрээс гарагч гэдэг.*

Насан туршийн бясалгал агшин зуурын гэгээрэл

Багш нь өчигдөр Колорадо мужийн Боулдер хотод ном тайлсан. Тэндхийн хүмүүс тун халуун дотно, орчин тойрон нь дөрвөн талаараа Хималай уул шиг хэдэн мянган метр өндөр уулаар хүрээлэгдсэн аж. Хэдийгээр өвлийн улирал боловч нарс, буйлс гүн хөх, цагаан цас болон хөх нарс өнгө ялгаран үзэмж байдал туйлын гоё. Тэндхийн хүн ам бараг арван найман мянга орчим боловч харин гурван зуун хүн ном сонсохоор ирсэн байна. Гэхдээ шавь нар маань хоёрхон долоо хоногийн хугацаанд тэр удаагийн ном тайлах ажлыг бэлтгэн төвхнүүлжээ.

Ойрын хоёр жилд бас Багшийг нь Колорадо мужид

ном тайлахыг урьсан хүн бий. Нэг нь Еврей хүн, нөгөө нь Америк хүн. Гэхдээ Багш чинь зөвшөөрөөгүй. Энэ удаад Багшийг нь урьсан нь хоёр Америк хүн байлаа. Тэд Багшийг нь яг саяхан, Америкийн олон мужаар тойрон ном тайлахын зэрэгцээ Вьетнам ахан дүүстэйгээ уулзаж байгаа гэдгийг сонссон болохоор даруй Багшийг нь “зам дагуу” өнжөөд явна уу гэж урьжээ. Гэхдээ ийм өв тэгш сайхан утгана гэж ер бодсонгүй.

Өчигдөр ирж ном сонссон хүмүүсийн ихэнх нь Америкчууд. Вьетнам хүмүүс арван тав орчим байсан. Ном тайлж дууссаны дараа дал орчим хүн авшиг авахаар гуйжээ. Тэд харин Вьетнамчууд шиг “элдэв бусын”, эсвэл “бусдыг гацаах” асуулт (Багш инээв) асуугаагүй. “Бусдыг гацаах” асуулт ч бас тийм хэцүүд тооцогдохгүй. Манай Вьетнамчуудад өөр улс оронд байдаггүй уран сайхан тэмдэг нэр их байдаг. Америкчуудын асуулт нь бүгд л бясалгалын тухай асуулт. Жишээлбэл: “Би өөр бусад бясалгалын аргаар бясалгаад нэгэнт залхаж, үргэлжлүүлэн бясалгах дургүй болсон. Яавал зохих вэ?” гэж асуудаг. Харин: “Багш аа! Та яагаад цагаан өнгийн хувцас өмсдөггүй, харин шар өнгийн хувцас өмсдөг юм бэ?”, “Яагаад ийм янзын малгай өмсөхгүй, харин тийм янзын малгай өмсдөг юм бэ?”, “Хувцасны чинь ханцуй яагаад ийм нарийхан юм бэ? Яагаад жаахан урт байж болдоггүй юм бэ?”, “Багш та яагаад хувцсаа ч тайлалгүй усанд шуудхан орчихдог юм бэ?” (Багш инээв) гэх мэтийн асуулт асуудаггүй. Та нар усанд орохдоо хувцсаа тайлдаггүй гэж үү? Ийм асуулт асуудаг хүнийг нээрээ аврахын аргагүй, тийм үү? Аврах арга байна уу? (Аврах арга алга гэж бүгд хариулав). Нээрээ аврах арга алга уу? (Багш болон бүгд инээв) үүнийг та нар хэлсэн шүү. Харин Багш нь хэлээгүй.

Өчигдөр Багш нь тун их баярласан. Ном тайлах хурлын танхимаас онгоцонд суух хүртлээ инээсээр л явлаа. Дэндүү их инээсэн. Иймээс өнөөдөр жаахан ядарсан шиг

санагдаж байна. Сонсогчид хэлэхдээ асуулт, хариултын дундаас бага сага гэгээрэл олсон гэсэн. Гэтэл миний хувьд тун зугаатай санагдсан. Багш нь асуултад хариулах болгонд сонсогчдын инээх дуу хурлын танхимыг доргиулаад тэднийг ажиг нь ээ хүмүүс хоорондоо харилцан ойлголцдог юм шиг.

Зарим хүний дэс нь нэг их зөрүүгүй. Хүсэл зорилго нь ойролцоо байж, ярингуут ойлгож, ахиухан ярихад дотно найз шиг санагддаг. Хувь барилдлагагүй хүнд л удтал тайлбарлах шаардлага гардаг. Тийм байдлыг Вьетнамд “нугас аянгын дууг сонсох” гэж хэлдэг. Яагаад ийм зөрүүтэй байдаг вэ? Бурхан шүтдэг Вьетнамчууд зарим хүн төрөлхийн мэргэн ухаантай, урьд төрөлдөө бясалгал хийсэн гэдэгт итгэдэг. Гэвч ингэж ярьдаг хэдий ч хэн нь чухам урьд төрөлдөө бясалгаж байсныг мэдэж чадахгүй. Зарим хүн өмнөх төрлөө харж чаддаг. Төвөдийн нууц тарнийн бясалгалыг бясалгавал урд төрлөө мэдэж чаддаг гэнэ. Гэвч олон жилээр бясалгаж байж л мэдэж чадна. Харин бясалгамагц мэдэж чаддаг юм биш.

Одоо парапсихологи (parapsychology) гэх нэгэн төрлийн шинжлэх ухаан бий болж, хүмүүсийг урьд төрлөө мэдэхэд тусалдаг болсон. Саяхан Багш нь урилгаар олон улсын холбооны байгууллагад ном тайлсан. Багшийг нь урьсан хатагтай бол парапсихологи судалдаг тусгай мэргэжилтэн. Багш нь түүнээс өөрийн урьд төрлөө мэдэх үү гэж асуухад тэр харин: “Мэдэхгүй” (Багш болон бүгд инээв) гэж хэлсэн. Иймээс тиймэрхүү бясалгалын аргаар бясалгадаг бүхэн урьд төрлөө харж чаддаг биш.

Багш нь бас Аргентинд нэг профессортой тааралдсан. Тэрээр нэгэн их сургуульд багшилдаг бөгөөд ямар нэртэйг нь санахгүй байна. Тэр парапсихологи судалдгаар барахгүй, бас энэ мэргэжлийг заадаг байна. Гэтэл Багшаас нь байнга: “Ямар аргаар өөрийн урьд төрлөө харж чадах вэ?” гэж асуудаг. (Багш болон бүгд инээв) Тиймээс өнгөрснөө мэдэж

чадах арга байлаа ч гэсэн хүн болгон бясалгаж амжилтад хүрч чаддаг юм биш. Хэрвээ сайн багштай учрахгүй бол хичнээн жил бясалгасан ч нэмэргүй. Зөвхөн урьд төрлөө мэдэхэд ийм удаан жилээр бясалгах хэрэгтэй юм чинь орчлонгийн нууцыг хайж шинжлэхийн тухайд хэлэх хэрэг юун?

Вьетнамчууд: “Энэ хүн урьд төрөлдөө бясалгаж байсан, гэгээн мэргэн ухаан билигтэй” гэж байнга ярьдаг. Энэ нь олон төрөлдөө бясалгаж байсан гэсэн утгатай. Хүн болгон үүнийг мэддэг хэдий ч хэн нэгэн хүн мөр ёсыг олсон гэхийг сонсмогц харин: “Юу? Яаж тэгж болох вэ? Дөнгөж эхлэн бясалгаж байгаа хүн мөр ёсыг хэрхэн олж чадах вэ?” гэж боддог. Түүний дөнгөж эхлэн бясалгаж байгаа гэдгийг та яаж мэдсэн юм? Урьд төрөлдөө аль хэдийн бясалгаад маш удчихсан ч байж мэднэ. Вьетнамчууд: “Насан туршийн бясалгал, агшин зуурын гэгээрэл” гэж байнга ярьдаг биш үү?

Гурван эрдэнэд аврал одуулах болон туулан тонилохуй

Вьетнамчууд, Хятадууд болон зүүн өмнөд Азийнхан байнга: буддын шашин, католик шашин юмуу бумбын шашныг мэддэг л бол нас барсны дараа туулан гэтэлж чадна гэж үздэг. Яг л бид аврал одуулах үедээ: “Шавь чинь Бурханд аврал одуулбал тамд унахгүй, Үнэн Номд аврал одуулбал бирд болохгүй, Хуврагийн чуулганд аврал одуулбал адгуус болохгүй” гэж ярихтай адил. Өөрөөр хэлбэл тамд унахгүй, бирд болохгүй, адгуус болохгүй гэсэн утгатай. Зөвхөн сахил мөрдөж, өвдөг сөхрөн мөнгө хандивлавал гурван муу заяанаас гэтэлж чадна гэж бүх хүмүүс ярьдаг.

Багш нь одоогоор зөв, буруу гэж шүүн ярихгүй, шуудхан л явдал учирт хандаж ярина. Ийм юм бол хүмүүс яагаад нас барсан хүндээ цаасан мөнгө шатааж өгдөг вэ?

Цаасаар хийсэн гоёмсог байшин, цаасан машин шатаах нь Эрлэг номун хааныг хахуульдаж байгаа биш үү? (Багш болон бүгд инээв) Хятадууд бас ном гүрэм үйлдэж, нас барсан хүмүүсийн сүнсийг гэтэлгэх, тахилын идээ өргөх мэтийн зан үйл хийдэг. Гэхдээ үүний зэрэгцээ бас хаалганыхаа өмнө галын наадмын пуужин асаан сүнсийг хөөж, “зүс буруу сүнс”-энд идүүлэхгүй, зөвхөн өөрийн гэрийн сүнсэнд л идүүлдэг. (Багш болон бүгд инээв) Чи үнэхээр аминч, бүр сүнстэй ч хуваалцаж чадахгүй аж! Та нар одоо ч цаасан мөнгө шатаасаар байх юм. Зөвхөн сүнс л тэр цаасан мөнгийг хэрэглэж чадна. Тийм юм бол туулан гэтлэх хэрэг байгаа юм уу. Багшийнхаа санааг ойлгож байна уу?

Нэг талаараа энэ хүмүүс Бурхан болон Дээдийн номд аврал одуулбал туулан гэтэлж чадна гэж ярьж байгаа ч үүнийхээ зэрэгцээ туулан гэтэлж чадахгүйгээ мэддэг, тиймээс цаасан мөнгө шатааж, ном гүрэм үйлдүүлэхийн тулд лам хувраг залж, хөл үймээн болж, зайгуул сүнснүүдийг хөөж зайлуулах гэж галын наадмын пуужин тавьдаг. Хэрвээ нас барагсад үнэхээр туулан гэтэлчихдэг юм бол нас бараад тэр дорхноо диваажин, эсвэл Бурханы оронд оччих ёстой, тэгэхлээр хэн тэнд суучихаад та нарын тахилын идээг идэж байгаа хэрэг вэ? Тахил өргөж байгаа нь тэд туулан гэтлээгүйг нь харуулж байгаа хэрэг бөгөөд зөвхөн сүнс л цаасан мөнгө хэрэглэдэг. Үүнээс үзвэл лавтай “Эрлэг”-т очсон байж таарна. Ойлгож байна уу? (Багш болон бүгд инээв.) Энэ нь бидний итгэл усанд хийнгүүт хэлбэр дүрсээ алдчихдаг Ау Лакын цагаан будааны гурилын гоймон шиг зөөлөн нунжгар гэдгийг батлахад хангалттай.

Тиймээс үг ярихдаа хичээн болгоомжлох хэрэгтэй. Сайтар ойлгоогүй бол чармайн суралц. Эх захгүй олон юм ярьж, өөрөө ч ойлгохгүй байх нь хэл амаа билүүдэж байгаагаар үл барам бусдын санаа сэтгэлийг зовоож байгаа хэрэг болно. Ингэснээр хоногийн удаанд дадал сууж, хүнтэй

уулзмагц “төрөл төрөлдөө бясалгаж байсан”, “насан туршийн бясалгал, агшин зуурын гэгээрэл”, “нэг хүн мөр бүтээвэл есөн үеэрээ дээшээ дэвшинэ” гэх мэтийн хий хоосон уран сайхан үг их ярьдаг. Үнэндээ өөрөө юу ч мэддэггүй бөгөөд мэдэхийг ч хүсдэггүй. Гэхдээ бас жинхэнээр мэддэг хүнийг элэглэж, “агшин зуур гэгээрч, энэ төрөлдөө туулан гэтлэх” боломж болон дөнгөж саяхан бясалгасан хүн Бурханы хутагт хүрч чадна гэдэгт сэжиг төрж, өөрөө өчигдөрхөн л: “насан туршид бясалгаж, агшин зуур гэгээрэх” гэж ярьж байснаа мартчихдаг.

Багшийгаа дагаж бясалгавал таван үеэрээ төрөл дэвшинэ гэдгийг сонсоод зарим хүн: “Ийм боломж байж болох уу? Өөрөө бясалгаж өөрөө дэвшинэ, таван үеэрээ төрөл дэвшиж яаж чадах вэ?” гэж хэлдэг. Вьетнамд: “Нэг хүн мөр бүтээвэл есөн үеэрээ тэнгэрт мэндэлнэ” гэдэг хууч үг байдаг биш үү? Есөн үеэрээ шүү дээ! Багш нь даруухнаар таван үе гэхэд та нар харин итгэдэггүй. (Бүгд алга ташив) Өөрөө ярьж, өөрөө үгүйсгэхийг Вьетнамчууд: “Өөрийн шийдмээр өөрийгөө зодох” гэж хэлдэг.

Хүмүүс яагаад маргалдаад дуусдаггүй вэ? гэвэл бүгд л өөрсдөө нотолж чаддаггүйгээс болж байгаа юм. Өөрөө ойлгодоггүй болохоор бусдын ахуй ойлголтод итгэдэггүй. Өөрөө нотолж чадахгүй байгаа нь бусад хүн бас нотолж чадахгүй гэсэн үг биш билээ. Нотолж чадах хүн байгаагүй бол энэ бүх эртний үг оршиж чадахгүй байхсан.

Ахуй ойлголттой болж болно гэж итгэдэггүй юм бол бусдын ахуй ойлголтын тухай яах гэж ярих ёстой гэж? Хэрвээ өөрөө ахуй ойлголттой болоогүй бол түүнээс татгалзах нь илүү дээр, ойлгож байна уу? Хэрвээ энэ нь боломжтой гэж та бодож байгаа бол судлан суралцахад цаг заваа зарцуулж болох бөгөөд “агшин зуур билиг нээгдэж, энэ нэг төрөлдөө туулан гэтлэх”, “нэг хүн мөр бүтээвэл есөн үеэрээ тэнгэрт дэвшинэ”, “гурван эрдэнэд аврал одуулбал

гурван муу заяанд унахгүй” гэдэг нь юу гэсэн үг болохыг өөрөө ойлгочихно.

Ер нь тэгвэл сахил хүртэх гэгдэх зүйл нь зөвхөн сөгдөж мөргөх, судар ном аялгуулан унших, харин дараа нь өнгө өнгийн мөнгөн дэвсгэрттэй улаан дугтуй өгөх явдал болно. Ийм л төдий, бүр ургамал хоол идэхийг ч шаарддаггүй. Зарим сүм хийд нь бас хүний мөстэй байж: “Сар болгон хоёр хоног ургамал хоол идэх хэрэгтэй” гэж бичсэн байна. Багш нь үргэлж сонин уншдаггүй. Хааяа нэг уншихад зарим сүм хийд: “Хэрвээ сахил хүртэх хүсэлтэй бол сар болгон хоёр хоног ургамал хоол идэх хэрэгтэй” гэж уриалсан байхыг харсан. Ингэх нь ер нь тун сайн хэрэг, урьд нь энэ тухай огт дурддаггүй байлаа. Хүн болгон сард хоёр хоног ургамал хоол идвэл тамд унахгүй болно. Бурханаас сахил хүртвэл бирд болохгүй, хуврагаас сахил хүртвэл адгуус болохгүй, ийм юм бол тун сайн болох биш үү? Та нар юунд түргэн сахил хүртэхээр очихгүй байна вэ? Сар болгон хоёрхон хоног ургамал хоол иднэ шүү! Багш нь эдгээр сүм хийдэд тусалж зар сурталчилгаа хийнэ ээ. Гурван муу заяанд унах дуртай хүн байдаггүй, ядаж л хүний төрөл олохыг хүсдэг. Тийм биз?

Хөлийн алчуур ба гуранз билүү

Сард хоёр хоног ургамал хоол идэх нь тийм сүрхий хэрэг үү? Ийм байхад та нар мөн л түүнд итгэж, шүтэн дагаж, сонсголонтой сайхан номын цол олдог. Багшийгаа шүтэн дагавал юу ч олохгүй. Бүгд эрх тэгш, та эмч, эсвэл инженерийн аль нь байсан ч, хэр өндөр байр сууринд байсан ч мэдэх хүн байхгүй. Өөрөө ярьчихвал дараа нь Багшдаа зэмлүүлж, арын суудал руу туугдаж ч мэднэ.

Багшдаа шавилбал ямар ч нэр цол олохгүй. Урьд нь нэг хүн өөрөө дуртайдаа Багшийг нь дагаж, гэрээс

гарч бясалгаад удалгүй бясалгахаа больсон. Энэ хүн ийм зантай байж. Урьд нь тэр өөр нэгэн шашны бүлгийг дагаж бясалгахдаа мөн л замын хагасаас бясалгахаа больжээ. Багш нь урьд нь шавь авахдаа тун амархан, бясалгах дуртай л бол боломж олгож, гэрээс гармагц л орхимж нөмрүүлчихдэг байж дээ. Одоо бол нилээд хялбар биш болсон бөгөөд хичээн болгоомжлох болжээ. Үнэнийг хайх сэтгэл бат бэх биш бол авдаггүй. Багш нь урьд нь өөрөө чин сэтгэлээсээ бясалгал хийдэг байсан болохоор одоо ч гэсэн бусдыг хүндрүүлэх дургүй. Хүн бүхнийг өөртэйгөө адил мөр ёсыг хайх сэтгэл нь бат чанга гэж боддог. Гэхдээ маш их зөрүүтэй байдгийг мэдээгүй явжээ. (Багш инээв) Багш нь ер нь хүн болгоныг бурхан гэж үздэг. Харин одоо харах тусам биш шиг байна. Бурхан мөн, гэхдээ харанхуй мунхаг бурхан, гэгээрээгүй бурхан. Яг л зарим улс орныг хоцронгуй улс, нээж ашиглаагүй улс гэж үздэгтэй адил. Эдгээр улс орны аль аль нь иргэншсэн дэвшингүй улстай адил ерөнхийлөгчтэй, засгийн газартай, гэтэл нэг нь хоцронгуй улс, нөгөө нь дэвшсэн улс юм.

Тэр Багшийг нь дагаж бясалгасан. Гэхдээ царай төрхийг нь санахгүй байна. Авшиг өгсний дараа тэр гэрээс гарч бясалгана гэж Багшийг нь байнга дагав. Хожим нь Багшаас нь салж одсон бөгөөд тухайн үед Багшид нь “мэхлэгдэв” гэж ярьжээ. Тийм том хүн, эр нөхөртэй, хүүхэдтэй байтлаа бусдад мэхлэгдэв гэж ярих нь үнэхээр нүүрээ барсан хэрэг (Багш болон бүгд инээв). За! Багшид нь “мэхлэгдсэн”-ээр бодчихъё, тийм ээ! Гэхдээ гэрээс гарсан юм чинь хичээнгүйлэн бясалгах л ёстой байж таарна. Гэтэл гэрээс гараад хоёр гуравхан долоо хоног болмогц зугтчихсан. Шалтгаан нь, тэр бол гадаадад суралцсан хүн байтал харин олвоос зохих хүндэтгэл хүртэж чадсангүй гэнэ ээ.

Тэрээр авшиг хүртмэгцээ гэрээс гарч ер нь ямар ч туршилт шалгалтад ороогүй. Вьетнамчууд дэндүү их зовлон

зүдгүүрийг туулж, хүний амьдралын мөнх бусыг аль хэдийн нэвт харчихсан байх ёстой гэж Багш нь бодсон болохоор тэгж ихээр туршиж шалгаагүй. Ер нь бусдаас илүү хайрлаж, хятадууд шиг Багшаараа байнга “сэлбэн засуулаагүй». Тайваний төвд байгаа хүмүүс Багшийнх нь өөр улсын хүмүүст хэр зэрэг хатуу чанга ханддагийг харсан.

Багш нь Вьетнамчуудыг ихэд туршин шалгаж, дэндүү ихээр сургаж дадуулах шаардлагагүй гэж бодсон юм. Учир нь тэд нэгэнт туршиж сорих шалгалтыг туулчихсан шүү дээ! Гэтэл харин ийм мэтийн хүмүүс байж, гэрээс гараад хоёр гуравхан долоо хоног болмогц зугтаж гараад: “Би бол гадаадад суралцсан хүн, Багшийг дагаж бясалгавал намайг чухал ажил хийлгэж, өндөр байр сууринд байлгана гэж бодсон чинь санаснаас гадуур харин шалны алчуур болгосон” гэж ярьжээ. (Багш инээв.) Гэрээс гарч бясалгах нь угаас шалны алчуур л болдог, тийм биш үү? Багшийнхаа байдлыг хараагүй юм уу? Олон газраар хэрэн тэнэж, ном дэлгэрүүлэн заримдаа шалны алчуураас ч доош ордог, шалны алчуурыг шал арчихад ашиглаж болдог. Гэтэл бид түүнээс ч долоон дор, өөрийгөө гэрээс гарсан гэж бодох нь хангалттай.

Сайн байвал муу бас байдаг. Зарим хүн сайшаан магтахад зарим хүн харин бухимдан шүүмжилдэг, уурлах хэрэг юун? Нохой хуцахад та бас дагаж орилон чарладаг гэж үү? (Бүгд алга ташив.) Гэрээс гарах нь нэг хэсэг хуучирч илжирсэн давуу, хивс шиг байж, бусдын гутлыг цэвэрхэн байлгаж, тав тухтай алхахад нь тусална. Гуранз билүү болж, хутгыг нь хурцалж, өөрөө харин улмаар үрэгдэж барагдана. Үүнийг л сая “гэрээс гарагч” гэдэг.

Гэрээс гарагч гэдэг нь гурван ертөнцийг даван туулж, ховдог шунал, хилэн мунхгаас мултрах гэсэн утгатай. Харин нэг байшингаас гарч, нөгөө байшинд шилжих гэсэн хэрэг биш. Сүм хийд нь байшинтай ялгаа зөрүү байхгүй.

Гэхдээ өөрийн чинь гэрээс бүр ч үзэсгэлэнтэй, цэвэр цэмцгэр, үймүүлчих хүүхэд ч байхгүй, өр тооцоо нэхэх хүн ч байхгүй. Ус, цахилгаан, утас гэх мэтийн зардлын хуудас гэмээр ч юм байхгүй, ийм байранд суух нь гэртээ суухаас бүр ч баяр жаргалтай, тийм биз! Ийм амьдралд дургүй байх нь гэрээс гарах биш.

Гэрээс гарах гэдэг нь хувийн алдар нэр, нэр хүнд бүхнээ золиосолж, өөрт буй аливаа бүхнээ зориулж, нөхцөл болзолгүйгээр бусдад үйлчилнэ. Үүнийг л сая гэрээс гарах гэдэг. Та гадаадад суралцсан, эсвэл ямар нэгэн мэргэжлийн чадвартан болохоор Багш нь эрхбиш хүндлэн тахих хэрэгтэй биш. Гэрээс гарах ийм бодол нь буруу. Тиймээс тэр эндээс салах ёстой. Өөрөө салахгүй бол Багш нь хөөхгүй байлаа ч үл харагдах ном хамгаалагчдад хөөгдөх болно. Хэрэг явдал ийм л гайхамшигт нууцлаг байдаг шүү! Буруу үзэл ойлголттой хүн Багшийгаа дагаж бясалгаж чадахгүй, бясалгалын газарт сэтгэлийг чинь татмаар зүйл алга, Багш нь тэнд хүлэгдмээр зүйл өгөх учиргүй. Чамд мөнгө хадгалах боломж олгохгүй. Багшийн гэрээс гарсан шавь нарын халаасанд сохор зоос ч байдаггүй. Өөр сүм хийдэд газар унасан мод навчийг цэвэрлэвэл сар бүр таван зуун төгрөг авдаг. Багшийнх нь энд цэвэрлэмээр модны навч байхгүй. Учир нь мод гэж байдаггүй, байлаа ч цэвэрлэмээр газаргүй, авшигтнууд хэдэн мянгаараа ирдэг болохоор юу ч ургуулсан гишгэгдээд замхардаг. (Багш инээв)

Багш нь Тайваний бясалгалын газар амтат төмс болон өөр зүйлийн ургамал тарьж туршсан. Тэгсэн чинь ургуулсан ногоогоо хараахан идэж амжаагүй байхад шавь нар ирэнгүүт амтат төмсний навчин дээр майхан босгосон болохоор бүгдээрээ газар наалдчихсан. Тийм олон хүн ирнэ гэж ч бодоогүй. Зарим шавь алс холоос шөнө дүлээр зүүд зүүрмэгийн дунд ирдэг болохоор хаана амтат төмс байгаа, хаана навч нь байгаа гэдгийг тод харж чаддаггүй. Зөвхөн

зүлэг ургасан зөөлөн газар байна гэж баярлан майхнаа босгочихдог. Гэхдээ шөнө дүл, ном хамгаалагч нар ч унтчихсан. Харах хүн байхгүй юм чинь. (бүгд инээв) Тэгээд маргааш өглөө нь Багш нь босоод баларсан хэрэг болсныг мэддэг. Гэвч бас хамаагүй, авшигтан майхнаа босгомоор газартай бол болчихно.

Хожим нь хүн хар явдаггүй өндөр шиг ууланд бэл, эсвэл хөтөл газар хайж тарьсан. Гэхдээ одоо тарихаа больсон. Учир нь тийшээ гэрээс гарагч мацан гарч чадахгүй. (Багш болон бүгд инээв) Хэрвээ үнэнхүү тарих хүсэл байвал эрхбиш маш түргэн ургаж, хоёр гурван хоногийн дараа хурааж болох ногоо тарих хэрэгтэй. Тэгэхгүй бол авшигтнууд ирж, майхан босгомогц идмээр ногоо олдохоо болино.

Багшийгаа дагаж гэрээс гарч бясалгавал эрхбиш аливаа бүхнээ огоорох хэрэгтэй. Гэрээс гарчихаад мөн л нэр алдар, байр суурийг бодоод байвал яаж бясалгаж чадах вэ? Гэрээс гарч бясалгал хийсэн байтлаа мөн л байр сууринд хүлэгдэн бусдаар хүндлүүлэхийг хүсэх нь нэр ашигт шунаж байгаа хэрэг, жинхэнээр огоорч байгаа биш, бүгдээрээ ойлгож байна уу? Бясалгалд олон төрөл зүйл болон зэрэг дэс байдаг. Хүмүүс бидний орхимж өмссөнийг харвал чин сэтгэлээсээ мөр ёсыг бясалгах хүсэлтэй гэж үздэг, гэтэл тийм биш байж мэднэ.

Жинхэнэ Төгс Гэгээрэн Их Багштай уулзсан азтай тохиолдол

Бясалгалын явцад хэрвээ харш саад тохиолдвол яагаа бол гэж өөрөөсөө асуух хэрэгтэй. Эцэг тэнгэр маш шударга, юу бясалгана, түүнийгээ олдог. Бясалгал амжилтгүй, Бурханы дэст хүрч чадахгүй бол өөрийнхөө бясалгалын арга зөв эсэхийг нягтлан шалгах хэрэгтэй. Гэрээс гарч чадаагүй

хүмүүсийн тал хувь нь гэрээс гарах ойлголт нь зөв биш, эсвэл чин сэтгэл хангалтгүйгээс болжээ.

Өөр хүн бясалгаж чадаж байхад би яагаад чадахгүй байна вэ? гэж бүү бодоорой! Хүн болгон адилгүй, зарим хүн саятан болдог байхад нөгөө хүн түүнтэй адилхан ажил хийдэг ч харин дампуурдаг. Тиймээс зарим хүн мөрийн хутгийг олдог байхад зарим нь харин бясалгаад амжилтад хүрч чаддаггүй гэдэгт бид итгэх хэрэгтэй. Яг л шалгуулахтай адил, зарим хүн шалгалтад ялж, зарим нь ялагддаг, энэ нь тун энгийн хэрэг билээ. Мөрийн хутгийг олох боломжгүй биш, сэжигт сэтгэлээсээ болж өөрийгөө саатуулж, Төгс Гэгээрсэн Их Багшийг дагаж бясалгах ховор нандин аз тохиолыг алдаж болохгүй.

Бурхнаас суралцвал лавтай Бурханы хутагт хүрч чадна, яг л эмчийн мэргэжилд суралцвал мэдээж эмч болж чаддагтай адил. Зарим хүн муу багшийг дагаж, буруу аргаар бясалгаснаас болж, үр дүнд хүрч чаддаггүй. Бас багшийгаа зэмлэн буруушааж болохгүй. Харин өөрөө чин сэтгэлээр хангалтгүй, хувь барилдлага хараахан бүрэлдээгүйгээс л Төгс Гэгээрсэн Их Багшийг ойлгож чадаагүй гэдгээ мэдэх хэрэгтэй.

Бид эхлээд төгс гэгээрсэн их багш бол ийм байх ёстой, тийм байж таарна гэсэн тогтсон үзэлтэй байвал яриангүй тийм багштай тохиолдох болно. Харин хуучин үзэл ухамсраа таягдан хаяж, чин сэтгэлээсээ Эзэн Бурхан, Бурхан Бодьсадвад: “Нэгэн Төгс Гэгээрсэн Их Багшийг надад хүргэж таниулах болов уу? Царай төрх, нөхцөл байдал, өмсгөл засал нь ямар байсан ч хамаагүй” гэж даатгавал Эцэг Тэнгэрээс биднийг жинхэнэ Төгс Гэгээрсэн Их Багштай уулзуулах болно. Хэрвээ эхлээд ямар нэгэн хүсэл найдвар өвөрлөвөл мэдээж өөрийн хүссэн тийм багштай л тааралдах болно. Хамаг төрөлтөнг аялдан дагах юм чинь! Үгүй бол энэ ертөнц аль хэдийн диваажин болчих байлаа, одоогийнх

шиг ороо бусгаа биш.

Хүний ертөнц яагаад баяр жаргалтай, гуниг зовлонтой байдаг вэ? гэвэл хамаг төрөлтний бие, хэл, сэтгэл өөр өөр байдгаас болж, адил бусын үйлийн үр бий болдог. Сайн үйл үйлдэгсэд буяны үр хурааж, муу үйл үйлдэгсэд нүглийн үр хураадаг. Зарим хүн муу хэрэг үйлдэж, зарим нь сайн үйл үйлддэг болохоор дэлхий ертөнц сайнтай, муутай байдаг. Зарим хүн урьд төрөлдөө сайн үйл үйлдсэн болохоор энэ төрөлдөө муу хэрэг хийдэг ч эхлээд буянаа эдэлж, нас ахисны хойно, эсвэл дараа төрөлдөө муу үйлийн үрээ амсдаг.

Вьетнамд “Тэнгэрийн гэсгээл хатуугаас хатуу, гэвнийн хэртэй ч цагаадахгүй” гэдэг хууч үг байдаг нь тэнгэрийн шүүлт хэдийгээр өргөн уужим боловч юу ч түүнээс мултарч чадахгүй гэсэн утгатай. Энэ бол тэнгэр, газрын үйл үрийн хууль дүрэм. Үйл үрийн хууль байхгүй бол дэлхий ертөнц самуурч, хүмүүс дураараа булаан дээрэмдэж, алж сүйтгэж, санаагаараа зүтгэж, жолоогоороо гуядах болно. Үр дагавар байсаар байтал ер айхгүй юм чинь хэрвээ байхгүй бол ямаршуухан болох бол?

Энгийн сахил хүртвэл сар болгон хоёрхон хоног ургамал хоол идвэл болчихно гэж Багш нь саяхан ярьсан. Сахил хүртэх ёслолдоо гэрээс гарагч: “Бурханыг шүтэн дагавал тамд унахгүй, бирд болохгүй, адгуусны төрөл авахгүй” гэж уншдаг. Тун ч баталгаатай, гэхдээ бас буруу уншихгүйг хичээж, гурав дөрвөн удаа нурушдаг. Дараа нь сахил хүртэхдээ: “За! Би үүнийг биелүүлж чадна” гэж хариулдаг. Ингэснээр л сая сахил хүртэж дууссанд тооцогддог. Одоо Багш нь: “Багшийгаа дагавал энэ төрөлдөө туулан гэтлэх болно!” гэж хэлэхэд хүмүүс эргэлзээд итгэдэггүй. “Ийм хэрэг байж болох уу? Тийм хялбар гэж үү?” гэж маш олон хүнд сэжиг төрдөг.

Тэгвэл яагаад сар болгон хоёрхон хоног ургамал хоол

идээд л харин гурван муу заяанаас мултарч чадах юм бэ? Тэгээд гэртээ харьсныхаа дараа юу ч хийх шаардлагагүй, хааяа нэг сүм хийдэд очиж, ганц удаа мөргөөд хоёр гурван төгрөг, хоёр гурван алим хандивлаад маш олон нэр бичиж тэмдэглээд Үүнийг авраач! Түүнд туслаач! Гэр бүл удам угсаа маань мандан дээшлэх болоосой! гэж Бурханаас гуйдаг. Жаахан өргөл өргөснийхөө хариуд харин Бурхан Бодьсадваг тэгж ихээр зовоох гэж та нар! (Багш болон бүгд инээв.) Та нарын бодлоор ингэх нь логикт нийцэх үү? Багшийгаа дагаж бясалгавал энэ төрөлдөө туулан гэтэлж чадна гэж Багшийгаа ярихаар та нар харин логикт нийцэхгүй гэнэ. Яагаад ингэж ярина вэ?

Багшийгаа дагавал энэ төрөлдөө туулан гэтэлнэ. Гэхдээ заавал ургамал хоолтон болох бөгөөд Багшдаа итгэх хэрэгтэй. “Итгэл бол аливаа ач буяны эх мөн”. Багшдаа итгэх нь хялбархан хэрэг биш. Багшийгаа дагаж, Багшдаа итгэдэг хүмүүсийн дэс тун өндөр байдаг, билиг ухаан ихэд нээгдвэл л сая Багшдаа итгэж чаддаг юм. Эмэгтэй хүн бурхан болж чаддагт итгэж чадна. Та нар ер нь зөвхөн эрэгтэйчүүд л сая бурхан болж чаддаг, эмэгтэйчүүд бол хог новш гэхийг сонсдог. Хэрвээ үнэхээр ийм юм бол бурхан хаанаас ирсэн юм? Хаан эзэн, ерөнхийлөгч хаанаас ирсэн бэ? (Бүгд алга ташив.) Зарим хүн ер нь эмэгтэйчүүдийг дорд үздэг. Гэхдээ өөрсдөө том болоод эмч, инженер, эсвэл нэр төртэй хүн болсон ч бүгд л эх хүний төрүүлж өсгөсөн хайр халамжаас салж чаддаггүй. Бурхан багш болон Есүс Христийг бас эх хүн л тэжээж өсгөсөн билээ.

Багшийгаа дагаж бясалгал хийвэл өдөр бүр хоёр цаг хагас бясалган сууж, насан туршид ургамал хоол идэж, жаахан ч болтугай архи ууж болохгүй. Өндөг огт идэхгүй, элбэрэл журмыг дагаж, гурван хэлхээ (эзэн түшмэл, эцэг хүү, нөхөр гэргийн хэлхээ) таван үүрд (өршөөл, журам, ёслол, ухаан, итгэл)-ийг бат сахидаг байхад энэ төрөлдөө туулан

гэтэлж чадахгүй гэж үү? Өр тооцоогоо төлж дуусгачихдаг болохоор мэдээж туулан гэтэлж чадна. Ийм байдал нь маш ёс зүйтэй. Та нар ойлгож байна уу? Ёс зүйтэй биш гэж үү? (Тийм гэж бүгд хариулав.) Баярлалаа!

Багшийн хэлж байгаа нь ёс зүйд нийцэхгүй гэж үзэх нь сүм хийдийн сахил дүрэмд эргэлздэг гэсэн үг. Өөрөөр хэлбэл “Өөрийн шидсэн чулуу өөрийн толгой дээр” гэсэн санаа билээ. Сар болгон хоёр хоног ургамал хоол идэж, хэдэн төгрөг хандивласныхаа дараа өвдөг сөхрөн: “Би сахил хүртэх дуртай” гэж яриад сахилын нэр авснаа харин гурван муу заяанаас мултарч чадлаа гэж боддог. Ийм хялбар мултарч чадна гэж үү? Төрөл төрөлдөө тийм хүнд үйл түйтгэр зохиосны дээр энэ төрөлдөө бас мах идэж, архи уугаад байхаар гурван муу заяанаас хэрхэн мултарч чадах билээ? Ийм юм бол үйл үр гэж оршихгүй болчих биш үү? Хэрвээ чамд тусалж, өр тооцоог чинь төлөх хүнгүй бол та яаж өрнөөсөө мултарч чадах вэ? Жишээлбэл, энэ төрөлдөө та бусдаас зуун мянган төгрөг зээлж, төлж чадахгүйгээсээ болоод шоронд оржээ. Гэтэл чамд хэрвээ нэг их мөнгөтэй найз юмуу аав ээж, хамаатан садан байж, чиний өмнөөс өрийг чинь төлбөл та өр ширнээсээ мултрах болно. Тийм биш үү? (Бүгд алга ташив.)

Энгийн хүн бол зөвхөн өр ширтэй, ач буян байдаггүй болохоор өр ширээ төлж дуусгахад тун бэрх. Гэтэл өр тооцоогүй, зөвхөн ач буянтай нэг хүн чиний өмнөөс өр тооцоог чинь хичнээн төлсөн ч чадна. “Цаглашгүй их ач буян” гэж үүнийг л хэлдэг. Тиймээс яагаад төлж дуусгаж чадахгүй байж болох вэ? Их бясалгалтан цаглашгүй их ач буянтай, яг л үлэмж их мөнгөтэй хүн шиг. Чамайг хайрлаж, чамд тусалж өрийг чинь төлөх гэвэл түүний хувьд тун хялбар хэрэг болно. Тиймээс ач буянтай нэгнийг даган бясалгаж, түүнд итгэвэл энэ төрөлдөө туулан гэтэлж чадна. Энэ нь тийм ч гайхалтай, эсвэл ёс зүйд үл нийцэх хэрэг

биш. Багшийн ярьсан нь буруу, сүм хийдийнх шиг байх нь л сая сахил хүртэж байгаа хэрэг болно гэж та нар үзвэл нь харилцан зөрчилдсөн хэрэг мөн. Тиймээс хүмүүс юу ярьсан ч Багш нь маргалддаггүй. Нэг гэрэл асчихвал хүмүүс аяндаа түүнийг харчихна. Асахгүй бол: “Би үнэхээр гэрэлтэй, үнэхээр гялбаатай” гэж хичнээн хашхирлаа ч үнэмших хүн байх уу?

Өнөөдөр энд ирэхийн далимаар энэ бүх хэргийг ярьсан нь та нарт чухам үнэнийг ойлгуулахын төлөө юм. Харин Багш нь тодорхой ойлгохгүйгээс болоод өөрийгөө саатуулж байгаа биш. Хэрвээ би, тодорхой тайлбарлахгүй, зөвхөн та нарыг зэмлэн буруушаавал Багш нь буруудна шүү! Одоо нэгэнт тодорхой тайлбарлачихсан байхад та нар бас л ойлгохгүй байгаа бол бас яах ч аргагүй шүү! (Багш инээв.)

Сүнслэг бясалгал дадалд маш олон дэс түвшин байдаг

Зарим хүн олон жилээр бясалгал хийж, ач буян үлэмж их, ярмагц л ойлгодог. Лууз Багшийн “Мөр ёсны судар”-т: “Дээд дэсийн хүн мөр ёсыг сонсвол хичээнгүйлэн гүйцэтгэдэг, дунд дэсийн хүн мөр ёсыг сонсвол заримдаа санаж, заримдаа мартчихдаг, доод дэсийн хүн мөр ёсыг сонсвол шоглон инээдэг. Шоглон инээгчид байхгүй бол мөр ёсон биш болно” гэж тэмдэглэсэн байдаг. Үүнээс: мөр ёсны үзүүр хязгааргүй боловч хүмүүсийн сэтгэл, зэрэг дэс өөр өөр байдгийг гэрчилж болно. Муу хэрэг үйлдэгсэд зовлон зүдгүүрийг ханатлаа амсдаг байтлаа Төгс Гэгээрсэн Их Багш, эсвэл түүний шавь нартай учирч, тэдний сурталчилгааны хуудсыг уншдаг боловч мөн л тэдэнд итгэдэггүй бөгөөд гүтгэдэг. Гэвч ингэх нь бас барилдлагатай болсонд тооцогдоно, “гүтгэлэгийн барилдлага”-тай болсон

хэрэг. Бусдыг гүтгэвэл бусад хүн бас чамайг таньж авна, тэгэхээр үүнийг найзлал нөхөрлөл гэж тооцож болно. Хожим энэ харилцааныхаа улмаас харилцан нэг нэгнийгээ дахин тамлан зовооно. Тэгээд ханатлаа зовж гүйцээд ядарч туйлдсаныхаа дараа сая үнэн ёсыг жаахан ч гэсэн ойлгож эхэлнэ гэж үү.

Амьтан болон тамын орноос дөнгөж ирэгсдийн билиг ухаан өөр байдаг. Дөнгөж хүний төрөл авах үед хараахан хангалттай цэвэршээгүй байдаг. Ийм хүмүүсийг нилээн догшин галаар түлж, угааж цэвэрлэжээ. (Зарим хүнийг усаар угаасан ч цэвэршиж чадахгүй, заавал галаар угаах хэрэгтэй. Галаар угаавал нилээд хална, усаар угаавал харин сэрүүн таатай санагдана.) Тиймээс бүх бие нь маш халуун байх бөгөөд хөдөлмөгц гал бадардаг. Юу ярьсан ч ярьсныг чинь ойлгохгүй. Муухай ааш, ширүүн зантай. Уужуу тайван биш, яагаад гэвэл түлэгдсэн шарх нь эдгэрээгүй болохоор хэдэр догшин зантай.

Адгууснаас хүн болбол билиг ухаанаар мөн л бядуу тэнэг байдаг. Үүнээс гадна өвс ургамлаас хүн болдог. Өвс ургамал бол үнэндээ дэс алгасаж хүн болж болохгүй. Гэтэл гайхалтай хувь барилдлагын шалтгаанаар тэд бас хүн болж чаддаг. Зарим нэгэн тун авьяаслаг сурагчийг бид гоц авьяаслаг хүүхэд гэж нэрлэдэг. Цэцэн сэргэлэн болохоор бага сургуулиасаа шууд оюутан болдог. Тэд урд төрөлдөө нэгэнт сурчихсан, эсвэл нилээд дээд түвшнээс бууж ирсэн ч байж мэднэ. Тиймээс билиг ухаанаар гүн гүнзгий. Тэд дунд зэргийн ой ухаантай сурагчдаас шилдэг байдаг.

Багшийнхаа ном тайлахыг сонсмогц ойлгож, бясалгаж суухад дорхноо ахуй ойлголттой болдог тэр хүмүүс бүгд л дээд түвшнээс бууж ирсэн байна. Урд нь тэд хамгийн дээд түвшинд хүртэл бясалгаагүй болохоор дахиад хүний төрөл авч үргэлжлүүлэн бясалгадаг. Тоост ертөнцөд бясалгал хийвэл нилээд хурдан. Учир нь энд үйлийн үр

дагавар байдаг. Дээд түвшинд бясалгавал дэндүү эрх дураараа байдаг тул ач буянаар бага, зүтгэл чармайлтгүйгээр яаж ач буян хурааж чадах билээ? Тиймээс нилээд удаан.

Дээд түвшнээс бууж ирсэн хүмүүс нилээд түргэн бясалгадаг бөгөөд машид гэгээрсэн байдаг. Гэвч сонсох нь ээ, өвс ургамлаас хүн болсон гэдэг нь онцгой тохиолдол болно. Жишээлбэл, нэгэн амьд сэрүүн байгаа бурхан нэг модноос нэг хүйс цэцэг таслан авах буюу жимсийг нь идсэн, эсвэл энэ бурханы шавь нь модон дээрх цэцэг буюу жимсийг таслан бурханд өргөл өргөсөн гэх мэт. Чин сэтгэлтнийг шавь гэдэг. Харин авшигтныг л шавь гэж хэлдэг биш. Бурхан бол шавь мөн эсэх талаар ер ялгаварладаггүй, чин сэтгэлтэй л бол шавь гэж хэлдэг.

Шавилсан эсэх нь хамаагүй, чин сэтгэлээсээ цэцэг жимсээр нэгэн амьд сэрүүн байгаа бурхныг тахисан байвал энэ мод дараа төрөлдөө хүн болж чадна. Гэхдээ тийм ч сэргэлэн ухаангүй боловч ядаж л Төгс Гэгээрсэн Их Багштай тааралдаж бясалгал хийж болно. Хэдийгээр Төгс Гэгээрсэн Их Багштай учирдаг боловч илүү нэг төрөл бясалгаж байж л сая туулан гэтэлж чаддаг. Энэ төрөлдөө бясалгахаас гадна бас дахин нэг төрлийнхөө туршид бясалгах хэрэгтэй. Яагаад тэр вэ? гэвэл тэрээр сурахдаа удаан болохоор билиг ухаанаа давтах цаггүй. Төгс Гэгээрсэн Их Багш юу ярьсан ч ойлгодоггүй, ухаардаггүй.

Энэтхэгийн нэгэн үлгэрт: нэг айлын хүү нь хүнд өвчинд нэрвэгджээ. Түүний аав, ээж нь нэгэнт авшиг авчихсан болохоор: Хүүг минь өвчнөөс нь авраач! Ядаж хэдэн жилийн насан хутаг соёрхоно уу гэж багшдаа даатгажээ. Гэтэл хүүгийнх нь өвчин эдгэрээгүй хэвээр байсан тул тэд ихэд бухимдан багш маань зөн билгийн чадваргүй гэж боджээ. Сонсох нь ээ, багш маань юуг ч бошиглож зөгнөдөг гэсэн. Одоо хүү минь өвдөөд байхад аварч чадахгүй байна гэж өнөөх аав, ээж сэтгэл зовнин

уйлж, багшдаа гомдолложээ.

Тэр үед хүү нь: “Багш маань бошиглож зөгнөж чаддаггүйдээ биш, ингэж хэлж болохгүй, буянаа барагдуулна. Үнэндээ би урд төрөлдөө нэгэн мод байжээ. Нэг хүн над дээрх цэцгийг таслан сэтгэлдээ багшид тахин өргөсөн болохоор энэ төрөлдөө би хүн болж чадсан байна. Гэхдээ хүн боллоо ч билиг ухаанаа нээн ашиглаагүй, заавал дахин төрөл авч байж л бүрмөсөн туулан гэтэлж чадна. Та нар бухимдан зовох хэрэггүй. Би одоо явбал хамгаас сайн шүү!» гэж аав, ээжийнхээ сэтгэлийг засжээ. Ярьж дуусаад хүү нь нүд аньж, таалал төгсжээ. Аав, ээж нь ч ухааран сэхээрчээ.

Энэ бол өөрийн урьд төрлөө хараад ярьсан жишээ болно. Гэхдээ ихэнх хүн урьд төрлөө харж чаддаггүй болохоор хэн нь чухам бясалгал хийснийг нотлоход үнэхээр тун бэрх. Гадна талыг нь хараад бусдын үнэнхүү бясалгал хийдгийг мэдэхийн аргагүй. Багшийн чинь ярьсан өнөөх гэрээс гарагч шиг Багшийгаа түүнд муугаар хандаж байна, хүндэтгэхгүй байна гэж бодоод хуврагийн бүлгэмээс гарчээ. Үнэндээ жинхэнэ шалтгаан нь түүний гэрээс гарсан зорилго нь цэвэр цайлган бишээс болсон хэрэг. Ойлгож байна уу? Тиймээс үсээ хусуулан бясалгадаг хүмүүсийг харвал тэд юуг ч бүгдийг мэднэ гэж бүү бодоорой! Тийм биш ч байж мэднэ. Нэг хэсгийг нь л ойлгож, бүрэн бүтнээр нь ойлгоогүй байж мэднэ. Бясалгаад нилээд удсаны дараа сая бясалгалын нарийн ширийн талыг бүрмөсөн ойлгож чадна. Тэр үед л зэрэг дэсийн хоорондох ялгаа зөрүү хэр их гэдгийг мэдэх болно.

Өчигдөр Колорадо муж дахь америкийн хэдэн шавь спиртийн найрлагагүй веган шар айраг худалдан аваад Багшдаа уулгасан. Багш нь жаахан уув. Хэдийгээр спиртгүй ч бидний толгой эргээд тэнгэр газар дайвалзах шиг санагдсан. (Багш болон бүгд инээв.) Багш чинь байнга

уудаггүй болохоор бас ч яахав. Гэтэл тэр Америкчууд өмнө нь шар айргийг ус шиг уудаг байсан мөртөө өчигдөр харин толгой нь сүрхий эргэсэн байна. (Багш болон бүгд инээв.) Тиймээс бид ийм веган архинд чухамдаа спирт байхгүй эсэхийг судлая гэж бодсон. Найрлагынх нь тайлбарт бичээгүй хэдий ч мөн л бага зэргийн хольцтой.

Бясалгал хийсний дараа бидний бие, хэл, сэтгэл аажмаар ариусдаг. Гэхдээ өөрөө мэддэггүй, ондоо зүйлстэй харилцах үед л бид сая сэрж мэддэг. Тиймээс та нар нэгэнт авшиг авчихсан юм чинь сэтгэлээ төвлөрүүлэн бясалгавал зохино. Хэрвээ ер нь “бясалгалдаа шулуудахгүй” бол Багш нь даахгүй шүү! Багш нь хүмүүсийг аялдан дагадаг. Бусдын харанхуй мунхаг болохыг нь хорьдоггүй. Онцгойлон илээр ном уламжилж байгаа цаг эринд ингэхгүй бол хүмүүс хараах болно. (Багш болон бүгд инээв.) Хориогүй байхад хараадаг юм чинь хорихыг хэлэх хэрэг байна уу?

Чин сэтгэлээсээ бясалгадаг хүн мах буюу өндөгтэй идээг эндүүрч идвэл гэдэс нь өвдөх үед буруу идээ идсэнээ мэдэх болно. Олон жилийн өмнө Багш нь Нью-Йоркд байхдаа бясалгал хийгээд удаагүй, төгс гэгээрсэн их багш болоогүй байлаа. Нэгэн өдөр нэг хүн надад хоол авчирч өгөв. Далайн замаг болон гурилын найрлагатай, үнэхээр ургамал хоол мөн гэж Багшийг нь шахсаар идүүлсэн. Би идээд хоёр долоо хоног гэдэс өвдсөн. Хожим нь утсаар лавлаад сам хорхойн найрлагатай байсныг нь мэдлээ. Сам хорхойг нунтаглаад дахин шарахад маш тэжээлтэй гэнэ. (Багш болон бүгд инээв.)

Заримдаа тэд Багшийг нь үүнийг идээрэй, түүнийг идээрэй гэж шахдаг. Би цэвэр биш гэдгийг нь тодорхой мэддэг боловч хүндэтгэн зочлох халуун сэтгэлээс нь татгалзахад бэрх бөгөөд идсэний дараа үр нөлөөг нь мэддэг. Зарим хүний өргөл барьцыг нь харахад тун сайн шиг байвч үнэндээ зовоохоос хэтрэхгүй. Гэхдээ тэр бол урьдын хэрэг.

Одоо би татгалздаг болсон. Идмээргүй байвал иддэггүй, олон дахин нуршихгүй, бусдын сайхан сэтгэлийг хөсөрдүүлэх нь өөрийн гэдсээ өвтгөхөөс илүү дээр, бусдыг хөсөрдүүлэхгүй гэвэл гэдсээ өвтгөнө. (Багш болон бүгд инээв.)

Бясалгагч хүн угаас цэвэр цэмцгэр байж таарна. Гэтэл Багшийнх нь эд зүйлс харин улам их болж байна. Учир нь урьдаг хүмүүс их. Багш нь байнга тойрон аялдаг бөгөөд онгоцонд суухад хүн бүр зөвхөн хорин килограммын ачаа авч явах зөвшөөрөлтэй. Хүн бүхэн өргөл авч ирвэл Багш нь эрхбиш гурав, дөрвөн суудал захиалж, ачаагаа ачих хэрэгтэй болно. Тиймээс та нар ийм өчүүхэн явдалд сэтгэл зовох хэрэггүй. Багш нь бясалгал хийхгүй, бусдад туслахгүй, хамаг төрөлтөнд үйлчлэхгүй байвал та нар харин сэтгэл зовбол зохино. Багш нь та нараас юу ч аваагүй ч чин сэтгэлийг чинь хүлээж авдаг, тиймээс гуних хэрэггүй. Гуниглана гэдэг чинь дэндүү нялхамсаг зан, ойлгож байна уу?

Багшийнхаа нөхцөл байдлыг ойлгох хэрэгтэй. Шавь нар дэндүү олон бөгөөд хүндэтгэн хайрлах хүн ч дэндүү олон. Хэрвээ хүн болгоны бэлгийг хүртэхэд хүрвэл Багш нь хадгалах газаргүй болно. Багшийнх нь хувцас халаасгүй болохоор “хувийн хадгаламж”-тай байхын аргагүй (Багш болон бүгд инээв.) Ер нь хуврагийн хувцасны хоёр талд халаас байдаг. Гэвч Багш нь халаас хийгээгүй, учир нь түргэн оёж дуусгахын тулд шууд л хайчлаад гадна нь оёчихсон. Хэрвээ халаастайг оёвол нилээд цаг орно. Халаасаар юу хийх вэ? Үйл түйтгэрээ хийх үү?

Бясалгалд маш олон төрөл зүйл болон зэрэг дэс байдаг. Хэдэн арван жилээр бясалгал хийж, олон төрлийн шашны бүлгийн бясалгалын аргаар бясалгасан гэж өөрийгөө магтдаг хүмүүс их байдаг. Үнэн хэрэгтээ тэд өөрсдийгөө Үнэн номыг дадуулж буй эсэхээ шалган шинжвэл зохино. Өөрийн өдөр тутмын үйл ажиллагаагаа

хянан байцаавал зөв бясалгаж байгаа эсэхээ мэдэх болно. Бусад шашныг шүүмжилж гүтгэж байгаа эсэх, насан туршид бусдад ач тустай үйл хийсэн эсэхээ; Бусдын төлөө өөрийгөө яажшуухан зориулсан эсэхээ; Бусдыг аврахын тулд ямаршуухан зардал гаргасан бол гэж өөрийгөө сайтар ажих хэрэгтэй. Эдгээр асуултыг хариулсны дараа өөрийгөө зөв бясалгаж байгаа эсэхээ мэдэх болно. Өөрийн биеэ хянан шүүхгүй, харин бусдыг хянан шүүж яах юм бэ?

Өөрийгөө хөгжүүл гэж Шагжамуни Бурхан хүмүүст сургасан. Лууз, Күнз нар бас “өөрийгөө хөгжүүл”, «гэр бүлээ цэгцэлж дэвшүүл”, дараа нь сая “улсаа засна”, “дэлхий дахиныг төвшитгөнө” гэж зааж хэлсэн. Өөрийн биеэ сайжруулна, харин өрөөл бусдыг хянаж зас гэсэн биш. Ойлгож байна уу? Өөрийгөө сайжруулна гэдэг нь өөрийн биеэ өөрчилж сайжруулахыг хэлнэ. Зургаадугаар үеийн өвөг багш Хүй Нэн бас: “Би бясалгаж суугаа үедээ зөвхөн өөрийнхөө алдаа буруугаа хардаг. Бусдын алдаа бурууг хардаггүй” гэжээ. Энэ бол сая “харах” болно. Бясалгаж суухдаа хэрвээ Төгс баясгалант орныг хардаг боловч харин мөн л бусдыг шүүмжлэх дуртай бол бясалгал нь бурууджээ! (Бүгд алга ташив.)

Зарим хүн биднээс суралцахаар ирж шавилсан болохоор хурдан дэвшүүлэхийн тулд заавал хатуугаар сурган загнах хэрэгтэй. Зарим хүний дэс нь дэндүү доор тул эрхбиш сайн загнаж байж л сэхээрүүлэх хэрэгтэй. Гэхдээ үг авахгүй бол бас аргагүй, шавь олон болохоор ганцхан удаа хэлчихвэл болчихно, олон удаа ярих зав байхгүй. Бидэнтэй холбоогүй тэр хүмүүсийг мөн л харааж загнах нь тэд сайтар бясалгаагүй байгаагийнх. Бусдаар хэлүүлэх шаардлагагүй, өөрөө ойлгох хэрэгтэй. Тиймээс бясалгал хийхэд Багшийгаа дагах эсэх хамаагүй, эрхбиш өөрийн биеэ хянан шүүх хэрэгтэй. Багшийгаа дагаж бясалгахад хувь барилдлага хэрэгтэй, албадаж болохгүй.

Амгат жимс ургадаг л бол сайн мод

Багшийнх нь уламжилдаг энэ төрөлдөө туулан гэтлэх “Арьяабалын номын цогцос” нь дотогшоо хандан ходоод гэдэс мэтийн таван цул эрхтнээ ажих, эсвэл дотоодын ямар нэг хэлбэр дүрсээ ажих явдал биш. Харин дотоодын аялгуу, өөрийн уг чанар, бүтээгчийн гайхалтай хэлбэлзлийн хүчээ ажихыг хэлнэ. Энэ бие махбод бол хэлбэлзлийн хүчний нягтрал юм. Хэрвээ дөрвөн махбод задарвал бие махбод хөдөлж чадахаа больдог. Өөрийн үндэс сурвалжаа хайж олохыг “сэтгэлээ ажих,” эсвэл “уг чанараа ажих,” өөрийн оройн дээд мөр ёсны чанараа ажих гэдэг гэж судар болгонд өгүүлсэн байдаг. Багшид нь ном судраас цээжилснээ ярьж, өргөн мэдлэгтэй гэж онгирох шаардлага байхгүй.

“Сэргэлэн ухаантай хүн бага ярьж, илүү сонсдог”, “сэргэлэн хүүхэд ургуулан бодож мэддэг”. Нэгэнт тийм ихээр сургачихсан байхад дахиад сургах шаардлага байна уу? Хүч тамираа ихэд баран бага сургуулийн сурагчийг сургаад л байж болох уу? Их сургуульд дэвшиж чадах нь оюутан болно, дэвшиж чадахгүй бол бас аргагүй. Зарим хүн ном тайлахыг сонсоод үл ойлгож, ерөөсөө номын агуулгатай холбоогүй, сонсогч хүнд ой гутам асуулт тавьдаг. Жишээлбэл, цэцэг яагаад улаан өнгөтэй, харин ногоон өнгөтэй биш вэ? Яагаад Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай гэж дуудан Чин Хай гэлэнмаа гэж дууддаггүй вэ? Сүм хийдэд бүгд гэлэнмаа гэж дууддаг байтал энд яагаад Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай гэж дууддаг билээ гэж асуудаг. “Энэ бол сүм хийд биш, Багшийгаа юунд гэлэнмаа болгоно вэ?» гэж би хариулсан. (Багш инээв)

Хэн ч гэж дуудаж болно. Хичээнгүйлэн бясалгавал л болчихно. Харин ийм, тийм гэлэнмаа гэж дуудахаар сайн болчих биш, ойлгож байна уу? Гэлэнмаа больё гэвэл үсээ хусуулж, орхимж нөмөрчихвөл болчихно, тун амархан.

Ихдээ таван минут, эсвэл арван минутад үсээ хусуулж, нэрээ сольж, тэр, энэ гэлэнмаа гэвэл дорхноо гэлэнмаа болчихно. Тийм биш шүү! Бас тэр хүний ач буян болон бясалгалын үр бүтээлийг харна. Өөртөө болон бусдад ач тус хүртээсэн эсэхийг харна. Нэг хүний бясалгалын үр бүтээлийг үнэлэн шүүх нь яг л аль нэг модыг сайн мод уу, эсвэл муу мод уу гэж магадлан тогтоохтой адил байдаг. Нэг модны сайн, мууг заавал хэдий чинээ жимс ургасан байдлаар нь тогтоохоос биш, ургасан байдал төрхөөр нь тогтоодог биш, ойлгож байна уу? Зарим мод шулуухан ургаж, зарим нь харин мурийчихсан байдаг, гэхдээ үр жимс элбэг ургаж, амтат жимсээр хангадаг л бол сайн мод шүү дээ.

Эмэгтэй хүн яагаад ном дэлгэрүүлдэг юм бэ? Эмэгтэй хүн яагаад бурхан болж чаддаг вэ? гэж зарим хүнд сэжиг төрдөг. Бурхан чанар бол яг л үүл, ус, салхи, агаартай адил угаас эрэгтэй, эмэгтэй гэх хүйсийн ялгаагүй, зөвхөн гадна дүр төрх нь ондоо байдгаас эрэгтэй, эмэгтэйн ялгаатай. Авид Бурханы Төгс баясгалант оронд угаас “эмэгтэйчүүд” гэж байдаггүй, тэр ч байтугай “эмэгтэй” гэх үсэг ч байдаггүй.

Бурханы хутгийг олсон хүн бол нэгэнт эрэгтэй, эмэгтэй гэж байдаггүй, уг чанартаа буцсан байдаг. Тэд эрэгтэй, эсвэл эмэгтэй дүрээр илэрсэн ч бүгд зөвхөн нэг солих хувцас, арьсан хувцас өмсөж байгаа төдий. (Их Багш өөрийн биеэ заав.) Энэ “арьсан хувцас” хэзээ нэг өдөр үхэх болно. Бүгд л адилхан, цаг нь болохоор “арьсан хувцас”-аа орхин дахин хэрэглэж чадахаа болино. Эрэгтэй ч бай, эмэгтэй ч бай бүгдээрээ л адилхан. (Багш болон бүгд инээв.)



БУРХАН БА ХҮН

*Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Америкийн Калифорни мужийн Стэнфордын Их сургуульд
1991оны 3-р сарын 16 (Эх нь вьетнам хэлээр)*

*※ “Амьд бурхан” ариун оронд буцахыг боддог боловч
удирдан дагуулагчгүй тэр бүх төрөлтөнд туслахын төлөө
өөрийгөө амьдралд уусгаж, алаг дэлхийд бохирдохоос
эмээхгүйгээр хүмүүстэй хамт амьдарч, хамаг хүч чадлаа
шавхан ажилладаг.*

Вьетнамын сайн тал гэвэл дунд, өмнө, умард орон нутагт бүгд ижилхэн хэлээр ярьж, хоорондоо ойлголцоход тун хялбар байдаг. Хэдийгээр ийм боловч дайн дажнаас бас зайлж чадаагүй, нүгэлт дайны хар утаа тэнгэр газрыг бүрхсэн.

Библи сударт нэг түүх байдаг: Усан галав юүлсний дараа Ноа-гийн гэр бүлийнхэн ихэд өсөн нэмэгдэж, улам улмаар баян чинээлэг бөгөөд сэргэлэн ухаантай болжээ. Байшин барьж, арилжаа худалдаа эрхэлж, амьдрал нь баян чинээлэг, тав тухтай болжээ. Хожим нь тэд билиг ухаандаа бардамнаж, үр хойч нь үеийн үед тэдний ололт амжилт болон бүтээсэн соёл иргэншлийг санаж яваг гэж бүгдээрээ нийлж өндөр, том цамхаг (Вавилоны цамхаг) байгуулахаар

цуглажээ.

Тэгээд барилгын ажлаа эхлүүлжээ. Тухайн үед бүх гэр бүлээрээ ижилхэн хэлээр ярьдаг байж. Удалгүй алтан гэрэл цацарсан тансаг сайхан барилга сүндэрлэн босов. Тэд улмаар өөрсдийгөө тун гарамгай, агуу их гэж үзэн омгорхог зан нь өдрөөс өдөрт нэмэгдсэн аж. Ажлаа хийхийн зэрэгцээ том төлөвлөгөөтэй байлаа. Гэхдээ тун ээдрээтэй.

Тухайн үед Эзэн Бурхан дээд түвшнээс доошоо харж л дээ. Нэгэн үнэн бодит Эзэн Бурхан байдаг гэж бид бодъё! Гэхдээ энэ бол библи судар дахь түүх болохоос биш Багш нь өөрөө найруулан зохиосон биш, тиймээс намайг буруушааж болохгүй. Эзэн Бурхан хараад: нээрээ муухай хүмүүс байна, нэг суварга босгосондоо ингэж их онгирох нь юу билээ? Тэднийг заавал хориглох хэрэгтэй, үгүй бол өөрсдийгөө тун сүрхийд үзээд Эзэн Бурхан болон бүтээгчийг мартахад хүрнэ гэжээ. Тиймээс Эзэн Бурхан ид шид бүтээн Ноа-гийн гэр бүлийнхнийг дахин нэг ижил хэлээр ярьж чадахгүй, сэтгэл нэгдэн ажиллаж чадахгүй болгосон бөгөөд тэр гайхалтай төлөвлөгөөгөө ч хамтдаа зөвлөлдөхийн аргагүй болгожээ. Ингэснээр бардамнах сэтгэл нь буурчээ. Тиймээс Эзэн Бурханд л ер нь хүн төрөлхтнийг алгуураар удирдан чиглүүлж, өнөөдөрт хүргэх аз тохиол нь байдаг.

Аливаа хувирал хувьсалд зохицож чадах их билиг ухаан

Нэгэн төрлийн үг хэлийг аливаа төрөлтөн бүгд ойлгож чаддаг. Тэр бол Бурханы аялгуу мөн. Библи сударт ярьсан тэнгэр, газар бүрэлдэн тогтох үед нэгэнт байсан “Ариун Аялгуу” юм. Ариун аялгуу нь Эзэн Бурхантай хамт оршдог. Ариун аялгуу бол Эзэн Бурхан мөн. Ийм үг хэл нь хэлбэлзлийн хүч, дотоодын аялгуу болно. Түүнийг шууд сонсож болдог бөгөөд чихээр сонсох шаардлагагүй. Чанагуух ертөнцийн ийм аялгуу болон гэрэл бол бидний

уг чанар мөн. Түүнийг чихээр сонсож, нүдээр харах шаардлагагүй.

Энэ ертөнцөөс сурсан мэдлэг нь уг чанар биш. Харин хувь барилдлагын учрал ерөөл билээ. Жишээ нь, өлсөх үед хүнс хоол хайдаг. Даарах, эсвэл халууцах үед байшин барьж, салхи борооноос далдлахыг боддог. Барилга, тариалан гэх мэтийн мэдлэг нь бүгд л орчин тойронтойгоо зохицохын тулд бий болжээ. Хүн төрөлхтөн оршин амьдрахын үндсэн хэрэгцээндээ тулгуурлаж, төрөл төрлийн мэдлэгийг судлан гаргасан байна. Энэ бүх мэдлэг нь үе уламжлан дамжсаар иргэдийн зан заншил болж хувирчээ. Энэ бүх ердийн мэдлэгийг сайн мэддэг хүнийг бид юм үзэж, нүд тайлсан догь толгой гэж хэлдэг. Гэхдээ энэ зан заншлын тухай мэдлэг нь бүгд л байгаль орчиндоо зохицохын тулд бий болсон болохоор хожим байгаль орчин өөрчлөгдөхөөр хэрэгцээгүй болчихдог.

Эрт урьдын цагт Хятадад малгай худалддаг нэг хүн байжээ. Тэр гоё загвартай малгай хийж худалддаг. Гэтэл тэр орны хүмүүс урт үс үлдээж, үсээ сүлжих дуртай болохоор малгай өмсдөггүй байжээ. Тиймээс малгай нь зарагдахгүй болохоор өөр оронд очиж суурьшин борооны шүхэр хийж сурчээ. Гэтэл тэр оронд шүхэр зардаг хүмүүс их байсан болохоор дахин өөр газар суурьшжээ. Гэхдээ шинээр шилжин очсон тэр орны цаг агаар сэрүүн болохоор шүхэр нь мөн л зарагдсангүй.

Бид ертөнцийн зүйлсэд суралцахдаа заавал нөхцөл байдлыг харах хэрэгтэй. Тэгэхгүй бол нөхцөл байдал өөрчлөгдөхөөр хурдан зохицож чадахгүй болно. Гэтэл “Бурхан чанар”, “Диваажин”, “Эзэн Бурхан” болон “Архад”-ын их билиг ухаан нь бидний уг чанарт угаасаа л байж байдаг. Ямар ч нөхцөл байдалд үргэлж зохицож чаддаг. Үүнийгээ бид мартчихжээ. Хожуу бий болсон мэдлэгийг судалж, түүнд мэргэшиж, түүнийг хэрэгцээндээ ашиглахаар

яарч, өөрсдийнхөө хамгийн гайхалтай, нууцлаг төрөлх чадвар, ямарваа нөхцөл байдалд танд хариулт өгч чаддаг төрөлхийн чадвараа мартчихсан байна. Дотоодын их билиг ухаанаа чадамгай ашиглаагүй болохоор хүний амьдрал сая ийм эмх замбараагүй байдаг.

Та нар саяхан авшигтны ярьсан ахуй ойлголтыг сонссон. Багш нь бас сонссон. Түүний “Бурхан чанар”, “Эзэн Бурхан” гэхчлэн ярихыг сонсоод би тун баярлаж, инээд алдсан. Та нарыг Багш маань мэдрэл нь жаахан асуудалтай, шалтгаангүй байтал яагаад инээд алдана вэ? гэж хэлэхээс эмээж, инээдээ чадан ядан барилаа. Гэхдээ инээхийг үнэхээр их хүссэн шүү. Шогтой ярьсанд нь биш, харин сэтгэл маань баяр баяслаар бялхсанаас болсон хэрэг. Ойлгож байна уу?

Зарим учрыг өөрөө ойлгодог ч харин ярьж илтгэхийн аргагүй, ярилаа ч гэсэн уг санааг нь алдуулчих болохоор Багш нь инээхийг бодсон ч чадсангүй. Энэ нь түүний урмыг хугалах, эсвэл та нарын анхаарал сарних юмуу ухаан алдахаас сэргийлсэн хэрэг. Гэрээс гарсан хүн гэнэт чанга инээхийг та нар огт хараагүй, тийм үү, үгүй юу? Бурхан ердөө цэвэр цэмцгэр хувцаслаж, төлөв төвшин суухаас биш, чанга инээж болохгүй. Тиймээс Багш нь журам дүрмийг дагаж, инээж зүрхлээгүй.

Багш нь энэ баяр хөөрийн сэтгэлээ та нарт тайлбарлахын аргагүй нь үнэхээр харамсмаар юм даа! Зөвхөн ганцхан аргаар л та нарт ойлгуулж чаддаг. Багшаасаа суралцаж, Багшийнхаа заасан аргаар явбал Багштайгаа адилхан үр дүнд хүрч чадна. Ийм төрлийн шинжлэх ухаан нь энэ ертөнцөд байвал зохих бүхнээс хамгийн оновчтой шинжлэх ухаанаас ч оновчтой байдаг. Ертөнцийн шинжлэх ухаан нь өнөөдөр зөв байснаа маргааш нь буруу болж ч мэднэ. Багш нь болон авшигтнуудын дадуулдаг шинжлэх ухаан бол огтхон ч буруудахгүй. Жишээ нь, Арьяабалын бясалгалын аргын дагуу дадуулдаг л бол хүн болгон адилхан

замыг туулах болно. Энэ нь үүний зөв, оновчтой чанарыг хангалттай гэрчилж чадна. Жишээлбэл, арван хүн авшиг авбал тэдний дунд дэсээр адилхан хүмүүсийн хардаг ахуй ойлголт нь адил, эсвэл бараг адилхан. Гэхдээ хүн болгоны түвшин нь ондоо, өөр байдаг. Жишээ нь, дөрвөн хүн нь нэгдүгээр ертөнцийн түвшинтэй, гурван хүн нь хоёрдугаар ертөнцийн түвшинтэй, хоёр хүн нь дөрөвдүгээр ертөнцийн түвшинтэй, нэг хүн нь тавдугаар ертөнцийн түвшинтэй гэх мэт. Түвшин болгон нь өөр өөрийн онцгой тэмдэгтэй. Адилхан дэст хүрсэн хүмүүс адил тэмдгийг хардаг. Үүнээс энэ төрлийн шинжлэх ухааны оновчтой чанар маш өндөр болохыг харж болно.

Ихэнх хүн олон жил, эсвэл олон төрөлдөө бясалгаж байж л сая Бурханы хутагт хүрч чаддаг гэж буруугаар ойлгодог. Олон төрөлдөө бясалгаж байж л сая Бурханы хутагт хүрч чаддаг гэдэгт итгэх шалтгаан бас байж болно. Жишээлбэл, доктор болохоор суралцах гэж шалгалт өгч, цаг заваа зарцуулж, өгүүлэл зохиол бичдэг л бол докторын зэрэг авч болно. Бид үүнийг харахад маш хурдан санагдан тэд суралцаж эхлээд л ийм амжилт олдог гэж үздэг. Үнэндээ тийм биш, суралцах урт хугацааны замыг туулсан байдаг.

Багшийгаа дагаж, Арьяабалын бясалгалын аргаар бясалгадаг тэр хүмүүс урд нь нэгэнт бясалгал хийгээд маш удчихсан болохоор маш түргэнээр ямар нэгэн хэмжээний амжилтад хүрдэг. Энэ нь тийм ч их гайхмаар хэрэг биш. Бид багын явдлаа ч тийм сайн санадаггүй юм чинь урьд төрөлдөө бясалгал хийснээ яаж санаж чадах билээ? Гэхдээ үүнийгээ санаж олох арга байдаг. Бясалгал хийсний дараа санаж олно. Урьд төрөлдөө бясалгал хийсэн болохоор сая өнөөдрийн дэсийг олсон хэрэг. Одоо бол зөвхөн үргэлжлүүлэн бясалгаж байгаа төдий гэдгийг цаанаа тодорхой мэдэрдэг.

Аргыг нь мэддэг л бол

Хүмүүсийн ихэнх нь “Дөнгөж анхлан бясалгаж байгаа хэр нь дорхноо Бурханы хутагт хүрч чадах боломж яаж байж болох вэ?” гэж ярьдаг. Хааяа бас онцгой тохиол байдаг. Жишээ нь, нэгэн том усан санд хүмүүс эрх дураар нааш цааш чөлөөтэй сэлж, шумбадаг ч живдэггүй. Сэлж чаддаггүй хүмүүс усан сангийн шатны бариулаас зуурч хөдөлж ч зүрхлэхгүй, усанд сэлэх гэхээр чөлөөтэй сэлж чаддаггүй. Ингэж зургаа долоо хоног, тэр ч байтугай хэдэн долоо хоногоор заалгасан ч сэлж чаддаггүй. Сураад нилээд удчихсан хүн бол шууд л усанд үсрээд орчихдог. Эсвэл зарим хүн урьд нь бага зэрэг сурсан байвал дахин дасгалжуулбал сэлж чадах болно.

Заримдаа эмч нар саяхан төрсөн нялх хүүхдийг усанд сэлж сургадаг гэдгийг та нар сонссон уу? Тийм бага хүүхэд хүртэл сэлж чаддаг байхад томчууд харин хэдэн сараар сураад ч сэлж зүрхэлдэггүй. Тиймээс насаар бага хүмүүс сурч чаддаггүй юм биш. Харин ямар аргаар сурахаа мэдэх хэрэгтэй. Зарим хүүхэд хар багаасаа сэлж сурдаг. Дөнгөж гурав, дөрөв нас хүрмэгц гуч, дөч, эсвэл жар, далан настай хүмүүсээс ч сайн сэлдэг. Учир нь онцгой аргаар сурдаг болохоор өөр хүн хийж чаддаггүй зүйлийг тэд чаддаг. Бусад хүн аргыг нь мэддэггүй болохоор хэдэн арван жилээр сурсан ч чаддаггүй.

Тиймээс аливаа үйл хэргийг сурах аргыг нь мэддэг л бол тун амархан сурч чадна. Бурханы хутагт хүрч чадах эсэх нь мөн л үүнтэй адил. Зөв аргаар сурвал бурхан болж чадна. Үйл хэрэг гэдэг ийм л хялбар дөхөм. Буруу аргаар сурвал хичнээн галавт сурсан ч үр дүнгүй. Учир нь элсийг чанавч хоол болдоггүй.

Багш нь яаж яривал сая та нарт ойлгуулж чадахаа мэдэхгүй байна. Заримдаа дэндүү их яривал эсрэгээр ойлгуулчих нь, итгэхэд бэрх, харахад тааруухан шиг...

Багшийн ном тайлах нь маш урсам бөгөөд учир зүйд нийцсэн гэж та нар байнга ярьдаг. Гэтэл Багшийнх нь хувьд хангалтгүй. Үг хэлээр, өөрийн ойлгосон зүйлийг бүрэн илтгэж чаддаггүй. Зөвхөн зуун хувь, мянган хувь, сая хувийн нэгийг л ярьж чаддаг байхад та нар харин сэтгэгдэшгүй гэж хэлдэг. Хэрвээ бүрэн бүтнээр нь ойлгуулан ярьж чадвал та нар ухаан алдаж мэднэ.

Ярьж чадахгүй байгаа нь азтай хэрэг мөн. Үгүй бол ном тайлах бүрт зуун эмч, мянган сувилагч хажууд үүрэг хүлээж, хэн нэг нь ухаан алдмагц даруй тариа тарьж, сэргээх хэрэгтэй болно. Ямартаа ч гэсэн та нар хиймээр ажилгүй, тун уйтгартай болохоор, сонсоход нэг хүн Бурханы хутгийг олсон гэнэ шүү! Очиж харсан ч яахав, юу ярьдаг бол? Бас үнэ төлбөргүй, хохирох юм алга гэдэг, тийм биз, та нар? Эхлээд сонсож болно, хэдий хэрийг ойлгосон нь хамаагүй.

Заримдаа “Бурхан чанар” болон “Дотоодын диваажин”-гийн гайхалтай нууцыг бүрэн дүүрэн илтгэж чаддаггүйдээ Багш нь өөрийн ярих чадвартаа тун ч урам хугардаг. “Бурхан чанар”, “Диваажин” гэдэг бол бидний цэвэр тунгалаг билиг ухаан мөн. Төгс төгөлдөр бөгөөд ямар ч нөхцөл байдлыг бүгдийг зохицуулж чаддаг. Үүнийг “Бурхан чанар” гэдэг. “Бурхан чанар” хийж байгаа, харин хэмжээ хязгаартай толгой тархи хийгээгүй болохоор юу ч хийсэн ядарсан санагддаггүй. Та нар Багшийгаа хар л даа! Их ажилладаг боловч ядардаггүй. Та нар Багшаасаа том биетэй хэдий ч ганцхан төрлийн ажил хийж, нэг эхнэр, хоёр хүүхдээ харж хандахдаа харин ядрахын туйлд хүрдэг бөгөөд шим тэжээлээр ихээхэн нөхдөг.

Багш нь ном тайлахдаа зарим үед маш шулуухан ярьж, заримдаа ярьж чаддаггүй. Эрхбиш дэсээ доошлуулж байж л сая тодорхой илтгэж, та нарт ойлгуулж чаддаг. Заримдаа дэсээ доор болгох аргагүй үед ярьж илтгэхэд маш бэрх, харин ном тайлах сонирхолгүйдээ биш. Яг

өнөөдрийнх шиг юу ч ярьж чаддаггүй, зөвхөн сэтгэлд маань тун баяртай санагддаг төдий. Сэтгэгдэл болон ойлголт их байдаг ч харин ярьж чаддаггүй. Та нар ер нь Багшийгаа үнэхээр сайхан ярьж байна гэх үед үнэндээ өнөөдрийнх шиг тийм их сэтгэгдэл төрөхгүй байдаг.

Багш нь саяхан хурлын танхимд орж ирэх үед тэр дорхноо та нар бол Бурхан мөн гэсэн хүндэтгэх сэтгэл төрсөн. Тиймээс сая ярьж чадсангүй. Бүгдээрээ Бурхан юм чинь яримаар юм ч алга. Угаасаа бүхнийг мэддэг юм чинь! Иймээс яримаар зүйл байхгүй гэж бодсон хэрэг. Бидний үзэл бодол, танин мэдэхүй адилгүй. Та нар Багш бол биднийг сургахаар энд ирсэн бөгөөд бид сурах шаардлагатай гэж үздэг. Гэтэл Багшийнх нь хувьд та нар Бурхан, надаас сурах шаардлагагүй болохоор ярьж чаддаггүй. За! Одоо өөр талаар ярилцъя!

Зарим хүн яагаад тун хурдан Бурханы хутагт хүрч, зарим нь харин чаддаггүй вэ? Ялгаа зөрүү нь чухам юу юм бол? Хэрвээ Бурханы хутгийг олъё гэвэл аливаа бүхнийг огоорч чадах хэрэгтэй. Буй бүхий л ялгаварлах үзэл, зөв буруу, үнэн худал гэх мэт бүхнийг заавал таягдан хаяж байж л сая Бурханы хутгийг олж чадна. Гэхдээ аливаа бүхнийг үнэнхүү огоорох гэдэг тун бэрх.

Бхагавад Гита дахь нэгэн түүх

Энэтхэгийн эртний сонгодог бүтээл “Бхагавад Гита”-д ийм нэгэн түүх байдаг. Аржуна гэдэг нэртэй цэргийн дарга нэгэн хүн цэцэн мэргэн Төгс Гэгээрсэн Их Багштай, тэр нь түүнийг үргэлж хажуунаас нь удирдан чиглүүлдэг байжээ. Аржуна бясалгалаар тун сайн болохоор тэгж дотоодын Багшаа байнга хардаг байж.

Бидэнд шаардлага гарах бүрт Төгс Гэгээрсэн Их Багш хэзээд ч гэсэн бидний дэргэд илэрч харагддаг. Үүнийг бид заримдаа харж, заримдаа харж чаддаггүй, гэхдээ Төгс Гэгээрсэн Их Багшийн үл үзэгдэх, ер бусын адислалыг

мэдэрдэг. Энэ нь нэг зүйлийн гайхамшигт сэтгэгдэшгүй зүйл бөгөөд маш тодорхой байдлаар бидний амьдралыг өөрчлөн сайжруулдаг. Ийм Төгс Гэгээрсэн Их Багш бол хаа сайгүй оршдог, ямар ч үед бидэнд туслахад бэлэн байдаг.

Бясалгал сайтай хүн Төгс Гэгээрсэн Их Багш өмнө нь илэрдгийг шууд харж чаддаг. Туслах шаардлагатай бол хэзээ ч гэсэн харагддаг. Бясалгаж суугаа үед тань илрэх юм уу, эсвэл хувилгаан биеэрээ гэрт тань очин найз шиг чинь асуудлыг чинь шийдвэрлэдэг. Ийм Төгс Гэгээрсэн Их Багш бол хаа сайгүй оршиж чаддаг бөгөөд зуун хүн адилхан цагт тусламж гуйвал тэрээр зуун хувилгаан биенд хувилж чадна. Үүнийг л сая Төгс Гэгээрсэн Их Багш гэдэг.

Бхагавад Гита дахь тэр Төгс Гэгээрсэн Их Багш Кришна бол ийм Багш юм. Түүний шавь нь цэргийн том жанжин, өөр нэгэн шашны бүлгийнхэн тэдэн рүү түрэмгийлэн дайрсан болохоор аргагүй дайтжээ. Дайны үеэр Багш нь харагдаж, түүнтэй мөр зэрэгцэн байлджээ.

Төгс Гэгээрсэн Их Багш дайнд оролцдоггүй гэж та нар боддог уу? Мөн л оролцдог. Хэн нэгэн хүн муу болбол түүнд өөр “хувцас” өмсүүлж, ондоо нэг бие махбодоор сольж, бүр ч илүү сайхан сэтгэлтэй хүн болгодог. Тэрээр хүн алдаг хэдий ч тэр алуулсан хүнд шинэ бие махбод олгож чаддаг. Ийм байдал нь эгэл хүмүүсийн дур зоргоороо хүн алж, харилцан өс хонзон зангиддагтай адилгүй. Төгс Гэгээрсэн Их Багш хүн алчихсан ч харин дорхноо шинэ бие махбод олгож, амь насных нь явц, үйлийн үрийг нь өөрчилж, бүр ч сайн, бүр ч төгс төгөлдөр хүн болгож чаддаг чадвартай.

За! Одоо дахин өнөөх Төгс Гэгээрсэн Их Багш Кришна-гийн тухай ярь! Тулалдааны үеэр Кришна илрэн гарч ирэх үед Аржуна жанжин дайнд хүмүүс олноороо алуулахыг хараад сэтгэл шаналж эхэлж байжээ. Үнэндээ дайсан этгээдийн дунд түүнтэй өвөг дээдэс нэгтэй хамаатан садан нь байж ч мэднэ, тиймээс дайтах дургүй болов.

Жанжин сэтгэл шаналан ухаан алдах дөхөж, зугтах бодол төржээ.

Багш нь хамгаас шаардлагатай үед илэрч: “Энэ удаагийн дайнд та заавал дуустал оролцох хэрэгтэй, оролцохгүй байж үл болно. Тэр алуулсан хүмүүсийн насан хутаг нь дуусчихсан болохоор та дайтахгүй ч гэсэн үхлээс мултарч чадахгүй. Гэхдээ дайтахгүй бол улс орон чинь бусдад олзлогдон чухам хэзээ алдар хүндээ сэргээхийг мэдэхгүй болно” гэж хэлжээ. Ингэснээр Аржуна сая үргэлжлүүлэн дайтаж эхэлжээ. Кришна боломжийнхоо хэрээр тайлбарлаж, аливаа бүхэн Бурхан тэнгэрийн зохицуулалт мөн, харин өөрийн чинь үйл ажиллагаанаас болоогүй гэдгийг ойлгуулсан байна.

Хүн чанар буюу нинжин сэтгэлийн шүүх

Үүнийг би хийсэн гэж бодох үед л сая ял гэмтэй болдог. Учир нь хүн чанар, нинжин сэтгэл чинь өөрийгөө зэмлэн буруушаадаг. Хүн чанар, нинжин сэтгэлийн зэмлэлийг “үйл түйтгэр” гэдэг. Хэрвээ тэнгэрийн нүд, их билиг ухаанаараа нэвт тольдон аливаа бүхнийг Бүтээгч л зохицуулж байгааг тод харж чадвал үйл түйтгэрийг угаан цэвэрлэж чадна. Гэхдээ заавал нэг хүн танд тайлбарлаж, жинхэнэ ёсоор ойлгуулах хэрэгтэй. Өөрийн чинь буруу биш гэдгийг хэлэх хүнгүй бол та ойлгож чадах ч үгүй, итгэх ч үгүй. Учир нь өөрөө үнэн бодитоор хүн алж, цуст хэрэгт оролцсон юм чинь. Жишээлбэл, хоёр хүн буруу хэрэг үйлдсэн байлаа гэхэд Арьяабалын бясалгалтан ял гэмд өртөхгүй, өртсөн ч хөнгөн байдаг. Гэтэл Арьяабалын бясалгагч биш бол адилхан үйл үйлдсэн хэдий ч ял гэм нь маш хүнд болдог. Яагаад вэ? гэвэл хүн чанар, нинжин сэтгэл чинь өөрийгөө зэмлэн буруушаадаг. Энэ бол “нинжин сэтгэлийн шүүх» юм. Нинжин сэтгэлийн шүүх нь хаанаас ирдэг вэ? гэвэл харанхуй мунхгаас ирдэг. Харин үнэн ёсны

шударга хуулиас үүсэлтэй биш.

Тэгвэл “харанхуй мунхаг” гэдэг нь юу вэ? Тэнгэр, газрыг Бүтээгчийн хүч тун гайхалтай нууцлаг. Энэ нь аяндаа бүхий л хуучирсан хэрэгцээгүй хүмүүс болоод эд зүйлсийг шигшдэг. Дараа нь энэ шигшигдсэн материалаас шинийг бүтээдэг. Шигших ажлыг гүйцэтгэх ажилтнаар сонгогдсон хүн хэрвээ энэ ажлыг өөрөө хийж байгаа гэж бодвол сая ял гэмтэй болдог. Яагаад өөрөө хийж байгаа гэж боддог вэ? гэвэл бид төрөл төрөлдөө нийгэм, хууль дүрэм, уламжлалт ёс зүйд тархиа угаалгаж, ингэж хийх нь зөв, тэгж хийх нь буруу гэж биднийг сургасан болохоор бусдаас уламжилсан мэдлэг буюу туршлагад хүлэгдэн өөрөө хийсэн гэж бодоод аливаа бүхнийг Бүтээгч зохицуулж байгаа гэдгийг мартчихсан байдаг.

Библи сударт: “Нэг ширхэг үс унах нь ч Бурхан тэнгэрийн зохицуулалт мөн” гэж өгүүлсэн байдаг. Ийм юм бол энэ ертөнцийн аливаа нисваанис, хувьсал хувирал болон гуниг зовлон бүгд л тогтчихсон байж таарна, тийм биз дээ! Тэгвэл муу хэрэг үйлдвэл яагаад бас ял гэмтэй болдог вэ? Эзэн Бурхан хариуцлага үүрэх байтал яагаад хүмүүс тамд унадаг вэ? Ойлгодог хүн байвал Багшдаа хариул, зөв хариулбал арван төгрөгөөр шагнана шүү!

Ингэж удаан тайлбарласан байхад бас л ойлгоогүй юу? Учир нь угаас Эзэн маань биднээр хийлгэсэн байхад бядуу тархитай бид харин өөрсдөө хийсэн болохоор хариуцлагаа үүрэх ёстой гэж үздэг. Угаас Эзэн маань хариуцах ёстой байхад харин өөрсдөө буруутай гэж хүлээн зөвшөөрдөг юм чинь хохирогч мэдээж танаас өр тооцоо нэхэх болно. Та хэрвээ: Би хийгээгүй, миний Эзэн надаар хийлгэсэн шүү! гэж хэлбэл хохирогч Эзнийг чинь эрж өр тооцоо нэхнэ, ойлгож байна уу?

Бясаллагч хүн үйл үрийг нэвт харж, Бүтээгчийн аугаа их төлөвлөгөөг ойлгож чаддаг. Тиймээс үйл хэргийг

маш айвуу тайвуу зохицуулж, зам мөрөөр нь явуулдаг. Тэд Бүтээгчтэй нэг цогц болж, тэнгэрийн нууцыг нэвт ойлгож, аливаа хэргийг тэнгэрийн зарлигийн дагуу хийж, хүн болгон үүрэг хариуцлагаа сайтар биелүүлэх төдий л байдаг. Гэхдээ хувь хүний үүрэг хариуцлага бол дэлхий ертөнцийн хувьд үнэндээ ялимгүй өчүүхэн. Хэдийгээр өчүүхэн боловч бүхий л орчлонтой харилцаа холбоотой. Ийм сэтгэлээр орчлонгийн ажлыг зохицуулбал ял гэмгүй, үйл түйтгэргүй, ариун дагшин, зөв, буруугүй болно.

Бид ер нь буруу хэрэг хийгээгүй гэдгийг Багш нь та нарт хэлье! Аргагүйн эрхээр нийгэм нийтийн хувьд буруу хэрэг хийсэн байвал бас л бидний буруу биш. Учир нь Бүтээгч бүхнийг сайхан зохицуулдаг. Хүн болгоныг төрөхөөс өмнө Бүтээгч аль хэдийн зохицуулчихсан байдаг. Төрсний дараа ямар бие махбодтой болох, ямар үйл хэргийг туулахыг хүртэл.

Багшийгаа дагаж Арьяабалын номын цогцсыг бясалгавал төрөл төрлийн үйл түйтгэр бүгд арилж чаддаг. Яагаад вэ? гэвэл бидний толгой тархи, дотоод ухамсар, тэнгэрийн нүд, сүнс, билиг ухаан маш тод хардаг. Төрөл төрөлдөө маш олон муу хэрэг үйлдсэн байлаа ч тэр нь Бүтээгчийн л зохицуулалт, харин бидний хариуцлага биш. Бидний уг чанар муу биш гэдгийг ойлгочихвол үйл түйтгэргүй болно. Тиймээс сая “Хүний төрөлх чанар угаас ариун цагаан” гэдэг. Буддын шашинд бас “Үйл түйтгэр угаас хоосон” гэж ярьсан байдаг. Үйл түйтгэр гэж угаас байдаггүй, ойлгож байна уу? Яагаад их бясалгалтанд үйл түйтгэр байдаггүй вэ? гэвэл тэд: “Аан! Миний уг чанар муу биш, дээд тэнгэрээс намайг ингэж хийлгэж байгаа юм байна” гэдгийг маш тод хардаг. Гэтэл энгийн хүмүүс угаасаа энэ бүхнийг мэддэггүй, Бүтээгчийн төлөвлөгөөг харж чаддаггүй, сонсож ч чаддаггүй болохоор өөрийгөө зэмлэн буруушааж, жаахан буруу хэрэг хиймэгцээ хүн

чанар, нинжин сэтгэлийнхээ зэмлэлийг хүлээдэг.

“Нинжин сэтгэл” гэж юу вэ? Угаас нинжин сэтгэл гэж байдаггүй. Буй бүхий л дэг жаяг, муу үйлийг цээрлэж, сайн үйл үйлдэх сургаал ёс нь бүгд л анхан шат. Багш нь хэдийгээр та нарт сайн үйл үйлд, муу үйлийг цээрлэ, сахилаа сайтар сахь гэж сургадаг боловч энэ бүхэн нь зөвхөн анхан шат, харин дээд зэргийнх биш.

Бурханы хутагт хүрэхээр хүн чанар алдагдчихдаг биш

Бясалгал хийхэд анхан шатнаас алгуураар дэвших хэрэгтэй болохоор Багш нь таван сахилыг сахихыг сургадаг. Үгүй бол хүн алах, гал тавих, хулгай хийхийг сургах уу? Мэдээж тэгэхгүй. Сахил сахидаг хэр нь нинжин сэтгэлийнхээ зэмлэлийг хүлээдэг юм чинь, муу хэрэг үйлдвэл бүр ч илүү сэтгэл шаналах биш үү? Тиймээс анхан шатнаас эхлэн сургаж, нинжин сэтгэлийг чинь тайвшруулсны дараа, өөрийгөө сайн үйл үйлдсэн, муу үйл хийгээгүй, хүний мөсөөр сайн гэж бодсноор сая бясалгахад сэтгэл самуурахгүй болдог юм. Гэхдээ ёс суртахуун та нарыг төгс төгөлдөр болгодог биш.

Төгс төгөлдөр хүн гэж ямар байдалтай байдаг юм бол? Сонсох нь ээ, Бурхан Багш бол төгс төгөлдөр, бүрэн төгс билиг нээгдсэн, бүхнийг мэдэгч, бүхнийг чадагч, үнэн сайн сайхан хүн гэгддэг. Тэгвэл Бурхан Багшийн хосгүй сайхан, бүхнийг чадагч гэдгийг яаж харж чадах вэ? Нэгэн бурхныг ямар жишиг баримжаагаар магадлан тогтоох вэ? гэвэл энэ нь маш хялбархан шүү! Багш нь та нарт хэлье: Бурханы хутагт хүрвэл хүн чанараа алдчих биш, харин дээр нь Бурханы зан чанар нэмэгдэх болно.

Яг л усан санд сэлэхтэй адил. Хэрэв та усан сангийн шатны бариулаас зуурсан чигтээ хөлөөрөө хичнээн тийчигнэлээ ч нэг л газраа байсаар байвал эрх дураар сэлж

чадахгүй. Гэтэл нэгэн Бурхан бол зөвхөн тэрхэн зайндаа л сэлэх төдийгүй, мөн усан сангийн нөгөө гурван талд ч хүрч, усан сангаар бүхэлд нь эрх дураараа сэлдэг. Бусад тал руу сэлж хүрсэн нь угийн байсан газраа алдчихдаг биш. Тиймээс Шагжамуни Бурхан: “Би энгийн хүн байснаа бясалгалаар дамжин Бурханы хутагт хүрэв, та нар ч бас бүгдээрээ ирээдүйн Бурхад мөн” гэж хэлжээ. Тиймээс бидэнд бас боломж байна. Нэгэнт “хүн” гэх нэг талыг нь олчихсон болохоор дахин хоёр, гурван талыг нэмчихвэл жинхэнэ Бодьсадва, жинхэнэ Бурхан болж чадна. Бурхан, Бодьсадвагийн хутагт хүрлээ ч гэсэн мөн л хүн хэвээрээ байж, хийвэл зохих үйл хэргээ хийж байх ёстой. Тэгэхдээ бас Бурханы үйл хэргийг хийж, Бурханы ойлгодог зүйлсийг ойлгоно.

Хэлэхэд амар ч хийхэд бас бэрх. Учир нь “Ахиухан дадлага хийж, алгуураар суралцвал сэлж чадах болно. Багш нь ямагт хажууд чинь байж, ямар ч байдал үүссэн аюулгүй газарт аваачина шүү!” гэж зоригжуулдаг боловч бид ерөөсөө л өөрийн байгаа газраасаа хөдөлж чаддаггүй. Зарим сурагч хэлснийг ойлгон дагадаг маш дуулгавартай болохоор алгуураар суралцвал хэзээ нэгэн өдөр усан санд ийш тийшээ чөлөөтэй сэлж чадах болно. Зарим нь сэлж зүрхлэхгүй, усан сангийн шатнаас зуурч: “Бурхан минь ээ! Үнэхээр аймаар, би сэлж зүрхлэхгүй, сэлбэл живж үхэхэд хүрнэ” гэдэг. Та нарын бодлоор ийм хүн усанд сэлэхийг сурч чадах уу? Сурч чадах эсэхийн ялгаа үүнд л бий.

Багшаас нь сурдаг хүмүүс бол хэлснийг ойлгон дагадаг шавь мөн. Чин сэтгэлээсээ сурах хүсэлтэй, өөртөө итгэлтэй бөгөөд Багшдаа итгэдэг. Сурдаггүй хүн бол усан сангийн шатнаас зуурч, өөрийгөө усанд сэлж хэзээ ч чадахгүй гэж боддог тэр хүмүүс болно. Хүүхэд хүртэл сэлж чаддаг байхад том хүн болчихоод яагаад чадахгүй байна вэ? Зургаан настай, арван хоёр настай хүүхэд Багшийнх нь

бясалгалын аргыг сураад бүгд ахуй ойлголттой болж, тэнгэр газар, орчлон ертөнцөөр эрх дураараа зугаалдаг байхад томчууд яагаад үүнийг сурч болохгүй гэж?

Бурханы хутагт хүрэх нь жам ёсны хэрэг мөн. Бид төрөхдөө л хэдийн Бурхан чанартай байдаг. Гэхдээ бас суралцаж байж л түүнийгээ таньж чадна. Суралцах гэдэг нь энэ дэлхийн сургаал ёсонд суралцаж, бусдын онол ярихыг сонсох гэж яардгийг хэлдэг биш, онол бүхэн бүгд зөв байдаг биш. Зөв сургаал ёс болохыг нь яаж нотолж чадах вэ? Туршин шалгавал л мэдчихнэ. Хэрвээ гэрчилж чадах арга байвал зөв гэдгийг нь мэднэ.

Багшийнх нь сургадаг бясалгалын арга үнэн зөв гэдгийг Арьяабалын бясалгагчид бүгд гэрчилж чаддаг. Бясалгал хийсэн анхны өдөр бага зэрэг мэддэг, дараа өдөр нь бүр ч илүү мэдэж, гурав дахь өдөр нь улам илүү ойлгож, дөрөв, тав, зургаа, долоо хоног гэхчлэн бясалгах тусам улам ихээр мэдэх болно. Энэ нь тун шинжлэх ухаанч. Үнэндээ бясалгал хийх нь шинжлэх ухаанч, тун үнэн бодит хэрэг мөн. Хэдийгээр ийм байлаа ч бас тун бэрх. Учир нь Багшийгаа дагаж бясалгал хийвэл дорхноо Бурханы хутагт хүрчих юм биш, гэхдээ энэ нэг төрөлдөө амжилтад хүрэх боломжтой. “Боломжтой” гэдгийн утга нь хүн болгон энэ төрөлдөө Бурханы хутагт хүрч чаддаг биш, Багшдаа итгэх итгэлийн түвшин болон огоорч чадах хэмжээнээс нь хамаарна. Яг л усанд сэлж сурч байгаа хүнтэй адил, дасгалжуулагч багш нь түүнд гарыг нь тавь гэвэл дорхноо тавьж, усанд сэл гэвэл даруй сэлнэ, багш нь хажуугаас нь тусалж байгааг тэд мэддэг.

Бид одоо Бурханы хутагт хүрэх бясалгалын аргыг заан сургаж байгаа Төгс Гэгээрсэн Их Багштай уулзаж чадсан тул даруй түргэн бясалгал дадуулах хэрэгтэй. Гэхдээ бүтэлгүйтсэн ч хохирол гэмээр юм огт байхгүй. Бид угаас эгэл хүмүүс, бясалгал хийгээд амжилтанд хүрэхгүй ч гэсэн

алдах зүйлгүй, ихдээ л дахин эгэл хүний дэстээ буцна. Хэрвээ бясалгал хийгээд Бурханы хутгийг олчихвол тун азтай явдал болох биш үү? (Бүгд алга ташив.)

Ялангуяа Багшийгаа дагаж бясалгахад үнэ төлбөргүй бөгөөд өргөл өргөх шаардлагагүй. Тайзан дээрх энэ бүх цэцэг, жимсийг та нар өөрсдөө худалдан авснаас биш Багш нь ав гээгүй. Цэцэг, жимс битгий худалдаж аваарай, их мөнгө үрэгдэх юм, тиймээс оронд нь мөнгөө хэмнэн хадгалаад дүрвэгсдэд туслаарай гэж би олон удаа хэлсэн хэдий ч та нар бас л худалдан авчээ. Та нарын чин сэтгэл хойно Багш нь хүн бүрт, цэцэг битгий аваарай гэж зарлал бичих аргагүй. Битгий аваарай гэж хэн нэгэнд хэлэхэд нөгөө хүн нь худалдан авчирна. Дахин нөгөө нэг хүнд битгий ав гэж захилахад өөр нэг хүн бас л авчирна. Тиймээс Багш нь бууж өгөх л хэрэг болжээ. За тэгээд та нар л баяртай байвал болох нь тэр. Дараа нь та нар энэ бүхнийг авч яваад өөрсдийн гэр орон дахь модон бурхандаа өргөл болгоорой!

Ямар хүн Бурханы хутагт хүрч чаддаг вэ?

Бурханы хутагт хүрсэн хүн болон энгийн хүн хоёрын ялгаа нь эр зоригт байдаг. Учир нь тэд бүхнийг огоорч чаддаг. Огоорох гэвэл огоорч, юу л хийнэ гэнэ, түүнийгээ хийдэг. Тамын орноос айдаггүй бөгөөд диваажинд шунадаггүй. Ийм хүн л сая Бурханы хутагт хүрч чадна. Хэрвээ бас л “нирваан”, “диваажин” буюу “мөнхрөх”-ийн жаргалд шунаж, бас гэгээрэх, эсвэл бясалгалаас ямар нэгэн ач тус хүртэхийг хүсдэг бол Бурханы хутагт хүрч чадахгүй. Хэдийгээр хүсэн хүлээсэн зүйлс нь сайн боловч, мөн л Бурханы хутагт хүрэх эрхийг олж чадахгүй. (Бүгд алга ташив.)

Бурханы хутагт хүрэхэд тун бэрх байдгийн шалтгаан нь тийм баатарлаг зоригтой хүн маш цөөнөөс болдог. Харин Бурханы хутгийг олох нь хэцүү биш, ойлгож байна уу? Ихэнх хүн нэг цайны аягаа удтал хэрэглээд байхаараа

хаяж чадахгүй болчихдог юм чинь аливаа бүхнээ огоорох гэгч нээрээ бэрхээс бэрх билээ. Гэхдээ Багшийнх нь ярьсан санаа бол: Багшаасаа сурсны дараа хувцас гоёлоо бүхнийг хаяж, эд зүйлсээ эвдэлж, мөнгө төгрөгөө далайд урсга гэсэн хэрэг биш. Багшийнх нь санаа ийм биш, харин зүрх сэтгэлдээ огоорохыг л хэлж байгаа билээ. Бүхнийг огоорч чадах эсэхээ мэдье гэвэл сорилт тулгарах үед мэдчихнэ. Үнэнхүү огоорох шаардлагатай үед та харин: “Бурхан минь ээ! Тэгж яаж болох вэ?” гэж гомдоллож магад.

Багшийнх нь саяхан ярьсанчлан, Аржуна жанжин Багш нь түүнд аливаа бүхэн тэнгэрийн санаа мөн, бүр дайны талбарт очиж тэр хүмүүсийг алах нь ч хүртэл Бурханы таалал мөн гэж хэлээд байхад хэлснээр нь хийхгүй л байжээ. Түүний бясалгалын дэс нь хэдийн тун өндөр болчихсон, дотоодын Багшийгаа хэзээ ч гэсэн харж чаддаг мөртлөө мөн л тийм аймхай байсаар, тэгж зүрхлэхгүй! Үүнээс бид хүмүүсийн толгой тархи хичнээн хязгаарлагдмал, эр зориг нь маш өчүүхэн, дэс түвшин нь тун доогуур, юу ч хийсэн өөрийн өрөөсгөл үзэл бодол болон туршлагадаа л түшиглээд орчлонгийн төлөвлөгөөг бүхэлд нь харж чаддаггүй болохоор сая өөрийгөө ял гэмтэй, өөрийнх нь санаа бодлоос үүдэлтэй гэж үздэг. Бүтээгч аливаа бүхнийг зохицуулж байгаа гэдгийг мэддэггүй.

Гэхдээ та нар Багшийнхаа ингэж ярихыг сонсоод юу ч хийсэн хамаагүй, ял гэмгүй байна гэж бодож болохгүй. Ял гэмтэй шүү! Яагаад вэ? гэвэл та нар Багшийнхаа ойлгодог дэст хараахан хүрээгүй байгаа. (Бүгд алга ташив.) Хүн төрөлхтөн хэдэн мянган жилээр тархиа нэгэнт угаалгаж, итгэл үнэмшилд нь суусан ёс суртахууны зарчимд нийцэхгүй зүйл хийвэл мөс чанар нь хэзээ ч тайван амгалан байхыг зөвшөөрөхгүй. Тиймээс хичнээн ярьсан ч гол нь сүнслэг бясалгал хийх хэрэгтэй. Арьяабалын бясалгалын аргаар бясалгаж, билгийн мэлмийгээ нээж, орчлонгийн Бүтээгчийн

төлөвлөгөөг ойлгож, өөрийгөө энэхүү орчлонгийн нэг ажилтан төдий юм гэдгийг тодорхой ойлгох хэрэгтэй. Ерөнхий захиргааны газар дээд талд байгаа бөгөөд зарлиг заавар дээд талаас дамжиж байгаа болохоор бид ямар ч хариуцлага үүрэх шаардлагагүй. Тодруулж хэлбэл ямар ч ял гэмгүй гэсэн үг. Багш нь та нарт дамжуулах хамгийн чухал мэдээ гэвэл та нар огт ял гэмгүй, сэвгүй ариун бөгөөд эрхэм дээд юм. Алдаа буруутай хүн ганц ч байхгүй, цорын ганц алдаа нь өөрийгөө буруугүй гэдгээ мэдэхгүй байгаа явдал юм. (Бүгд алга ташив.)

Өөрийгөө буруугүй гэдгээ ойлгоё гэвэл Багшийгаа дагаж, Арьяабалын бясалгалын аргаар бясалгаж, билгийн мэлмийгээ нээвэл сая тэнгэр, газрын далд нууцыг мэдэж: “Аан за! Уг нь би хийгээгүй, харин Тэр хийсэн болохоор хариуцлагыг Тэр үүрэх нь зөв” гэдгийг ойлгож чадна. Гэхдээ Эзэн Бурхан ял гэмтэй гэсэн үг биш, энэ нь зөвхөн Бүтээгчээс хуучирсан зүйлсийг шигших байгалийн хувьслын явц юм. Яг л өвс мод өвөл болохоор хувхайрч, зун болохоор төлжин ургадагтай адил. Энэ нь Эзэн Бурхан зориудаар даажигнаж байгаа биш, харин орчлонгийн хууль дүрэм нь өвс ургамалд амьсгаа аван бүр ч илүү төлжин ургах аз завшаан олгож байгаа хэрэг билээ.

Энэ дэлхийн амьд бодис бүгд л энэ хууль дүрмийг дагах ёстой. Өөр гарагууд дээр бас өөр өөр хууль дүрмүүд байдаг. Та нар өвөл хувхайрч, зун төлжих байгалийн жамд дургүй бол өөр төрлийн хууль дүрэмтэй бусад гарагт очиж болно. Тиймээс үхэж төрөхөөс ангижиръя гэвэл сүнслэг бясалгал дадуулах хэрэгтэй. Үхэж төрөх сансрын хүрдийг даван туулж, материалаг ертөнцийн хууль дүрмээс мултрах цорын ганц зам бол Арьяабалын бясалгалын аргаар бясалгах зам мөн. Тэр нь яг л тийрэлтэт пуужин дууны хурдаас хэтийддэг шиг биднийг үхэж төрөх сансрын хүрднээс гэтэлгэж чаддаг.

Алаг дэлхий бол дасгалжуулах сургууль мөн

Алаг хорвоо гэж гуниг зовлонгоор дүүрсэн дэлхий юм, учир нь тэр бол нэгэн дасгалжих ертөнц, жаргал зовлон, амьдрал үхэл бүхэн байдаг. Та хэрвээ эндхийн дэг журам болон хууль дүрэмд дургүй бол өөр оронд шилжиж болно, ойлгож байна уу? Дээд зэргийн, эрх дураар байж болох түвшин лүү нүүн суурьшиж болно. Тэнд өөр төрлийн хуультай. Үхэж төрөх сансрын хүрдний эргэлт байдаггүй. Хахир өвөл, аагим зуны ээлж байдаггүй. Зүйл зүйлийн мөнх бусын гуниг зовлон байдаггүй. Ийм төрлийн ертөнцөд дуртай бол тэнд үлдэж болно. Гэхдээ та нар Багшийгаа бусдад туулан гэтэлхийг сургаж байгаа гэж зэмлэн буруутгаж болохгүй. Багш нь зөвхөн бусдад өөр түвшинд хүрэх замыг зааж өгч байгаа билээ. хүрэх замыг зааж өгч байгаа билээ. Маяа (Хий хуурмагийн хаан) Багшийгаа дагаж бясалгадаг хүмүүсийг заавал саатуулдаг. Учир нь энэ бол маяагийн ертөнц мөн. Юуг маяа гэдэг вэ? Хий хүсэл, худал хуурмаг, мөнхийн бус, үнэн бодит биш зүйлс бүхнийг маяа гэж хэлдэг.

Маяа бол үнэн юм шиг боловч үнэндээ худал зүй ёс болон зүүд зэрэглээ шиг хий хүсэл мөн. Жишээ нь: зүүдэн дунд бас хайр сэтгэл байдаг боловч үнэндээ зүүд төдий, үнэн бодит ертөнцийнхтэй адилгүй. Маяагийн ертөнц нь дээд түвшний ертөнцтэй төстэй. Гэхдээ түр зуурын, мөнхийн бус, хувирал хувьсал ихтэй, бусдыг тарчилган зовоодог ертөнц юм. Дээд түвшний ертөнц бол харин үүрд хувирдаггүй, хэзээ ямагт оршиж байдаг. Тэндхийн иргэд маш чөлөөтэй, баяр жаргалтай. Тиймээс Арьяабалын бясаллагч энэ ертөнцөд шунадаггүй, огоорч чаддаг. Багшийгаа дагаж бясалгадаг хүмүүс энэ ертөнцийн үнэн дүр төрхийг нэвт харж, аливаа бүхэнд сэтгэл хоргодохоо больсон байдаг. Хоргодохгүй гэхээр аливаа бүхнээ таягдан хаяад ууланд бүтэх биш, харин эндээ байж, өөрийн ажлаа үргэлжлүүлэн хийдэг.

Гэхдээ сэтгэл хоргодохгүй, эндхийн амьдрал бол мөнхийн бус, хэзээ нэгэн өдөр өөр нэгэн ямар ч аюулгүй, эрх чөлөөт ертөнцөд хүрэхээ мэддэг.

Дээд түвшний ертөнц нь Америк улсаас ч хязгааргүй илүү эрх чөлөөтэй. Америк улс тийм ч сайн биш гэж зарим хүн үздэг. Учир нь эндхээс бүр ч дээд зэргийн ертөнц байгааг мэддэг. Вьетнамаас Америкт очиход онгоцонд суудаг. Гэтэл бидний энэ ертөнцөөс дээд түвшний ертөнцөд хүрэхэд өөрөө нисэж хүрэх хэрэгтэй. “Нисэх” гэдэг нь их билиг ухаанаараа ашиглахыг хэлнэ. Харин далавчаа дэвж, хөөрөн нисэх биш шүү. Дээд түвшин рүү очиход “гүйх” хөл, “харах” нүд, “сонсох” чих шаардлагагүй. Ямар ч тоног төхөөрөмж, багаж зэмсэг ашигладаггүй боловч аливаа бүхнийг мэддэг. Энэ бол “Бурхан чанар” юм. (Бүгд алга ташив.)

“Ажиллаж буй Будда” болон “Унтаж буй Будда”

Асуулт: Бясалгаж эхлээд үхэж төрөх сансрын хүрднээс гэтлэх хүртэл хэдэн үе шатыг туулах вэ, яаж бясалгах вэ?

Багш: Өөрийгөө эгэл хүн гэж үздэг байснаасаа бясалгал хийн Бурханы хутагт хүрэх явцад олон дэсийн түвшин байдаг. Адилхан түвшинд (зэрэг дэс) хүрсэн хүмүүс ижилхэн хүслэнт орныг хардаг. Яг л мөнгөтэй хүмүүс тансаг зусланд амьдарч, ерөнхийлөгч цагаан ордонд суудагтай адил.

Бясалгал хийж эгэл хүнээсээ Бурханы хутагт хүртэл заавал таван үе шатыг туулах хэрэгтэй болно. Бид өнгөрсөн төрөлдөө бясалгал хийж, нэгэнт хоёр, гуравдугаар, эсвэл дөрөвдүгээр ертөнцөд хүрчихсэн байж мэднэ, үүнийгээ авшиг авах үед дорхноо мэдэх болно. «Багш нь та нарт авшиг хүртээх үед урьд төрөлдөө бясалгаж, хэддүгээр ертөнцөд хүрсэн байгаагаа мэддэг бөгөөд дараа нь үргэлжлүүлэн бясалгана. Зарим хүн нэгэнт дөрөвдүгээр ертөнцөд хүрчихсэн, үргэлжлүүлэн бясалгаж, дахин нэг

ертөнц дээшилбэл Бурханы хутагт хүрч чаддаг.

Бурханы хутагт хүрсний дараа хамаг төрөлтийг удирдан чиглүүлэхийг суралцаж байж л сая өөрийн Бурхан чанараа улам их таних болно. Харин Бурханы хутгийг олсны дараа гэртээ хариад унтчих биш. Тэгсэн ч болно, яагаад гэвэл хоёр төрлийн Бурхан байдаг. Нэг нь “Ажиллаж буй Будда”, нөгөө нь “Унтаж буй Будда”. «Унтаж буй Будда»-г бас залхуу Будда гэдэг. Бурхан болсны дараа нирваандаа жаргаж, хамаг төрөлтийн гаслан зовлонг хайхардаггүй. Дэлхий дахин угаас амгалан, юу ч хийх шаардлагагүй.

Хамаг төрөлтөн бүгд Бурхан чанартай байдгаас хойш надад сэтгэлээ чилээх шаардлага алга гээд амар жимэр жаргахаа л бодож, Бурханы хутгийг олохоос өмнө хичнээн ихээр шаналан зовж, байнга уйлан гомдоллож, Төгс Гэгээрсэн Их Багштай бушуухан тааралдаж, билиг нээгдэн гаслан зовлонгоо нимгэлэх юмсан гэж тэнгэр, газарт даатгадаг байснаа мартчихдаг. Одоо өөрийн гаслан зовлон нь арилчихаар урьдын хүнд бэрх явснаа санахаа больдог. Ийм хүмүүсийг “Унтаж буй Будда” гэдэг.

Ажиллаж буй Будда нар дэлхий дахин угаас амгалан, хамаг төрөлтөн бүгд Бурхан чанартай, бүгдээрээ Бурхан мөн гэдгийг мэддэг хэдий ч хамаг төрөлтөн өөрсдөө Бурхан мөн гэдгээ хараахан ойлгоогүй, бас л зовлон амсаж байдаг тул зовж зүдрэн байж, тэднийг заан чиглүүлж, уг чанараа таньж олоход нь тусалж, зөв зам руу удирдан дагуулдаг. Хамаг төрөлтөнд тусалдаг тэр Бурхдыг “Амьд Бурхан” гэдэг. “Амьд Бурхан” өөрийгөө амьдралд уусгаж, байдаг чадлаараа ажиллаж, өөрийгөө бохирдуулахаас халшралгүй, алаг дэлхийтэй хамт байж, хэдийгээр дээш гарах хүсэлтэй боловч удирдан чиглүүлэх хүнгүй тэр бүх төрөлтөнд тусалдаг.



ХҮНИЙ АМЬДРАЛЫН ЗОРИЛГО

*Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Америкийн Калифорни мужийн Ирвайн хотын
Калифорнийн их сургууль
1991 оны 3дугаар сарын 17 (Эх нь вьетнам хэлээр)*

*※ Бидний амьдрал яагаад ийм шаналан зовлонтой
байдгийг та нар мэдэх үү? Бид өөрсдөө ийм байдалтай
болгодог юм. Инээж зүрхэлдэггүй, уйлж ч зүрхэлдэггүй,
хайрлаж бүр ч зүрхэлдэггүй, хайртай хүнээсээ хайраа
нуудаг.*

Бид эхлээд бүгдээрээ энэ дэлхий дээр болон бусад ертөнцөд зовж шаналж буй төрөлтнүүдийн төлөө хэдэн хором залбирья. Баярлалаа!

Эрхэм хүндэт хатагтай, ноёд оо! Юун түрүүнд, өнөөдрийн номын хурлыг зохион байгуулахад цаг зав, хичээл зүтгэл, чин сэтгэлээ зориулсан Лос Анжелесийн авшигтнууддаа талархъя! Ням гараг бол үнэ цэнэтэй амралтын өдөр, хол зам болон тээврийн хүндрэлтэй асуудлуудыг үл хайхран ном тайлахыг сонсохоор та бүхэн маань энд хүрэлцэн ирсэн байна. Тэгээгүй бол энэ удаагийн номын хурал амжилттай болж чадахгүй байсан. Тиймээс зохион байгуулагч талын өмнөөс та бүхэнд талархаж байна.

Ном тайлахад та ач тус хүртэхийг хүсвэл эхлээд зөв, буруугийн талаарх өрөөсгөл үзлээсээ салах хэрэгтэй. Энэ ертөнцөд Бурханы билиг ухаанд найдахаас бусад тохиолдолд юу нь зөв, юу нь буруу болохыг хэн ч мэдэхгүй гэдгийг та нар мэднэ. Зөв, буруу гэдэг нь ихэнх тохиолдолд харьцангуй ойлголт төдий байдаг бөгөөд үнэмлэхүй биш юм.

Орчлон ертөнцөд Есүс Христ болон Бурхан Багшийн хэлсэн үнэнээс өөр үнэмлэхүй үнэн гэж байхгүй. Шинжлэх ухааны судалгааны зарим тоо баримт тодорхой хугацаанд бүрэн зөв мэт санагддаг ч хэсэг хугацааны дараа бусад эрдэмтэн өөр өөр туршилт хийж, онол дэвшүүлэхээр өмнөх өгөгдөлүүд үгүйсгэгддэг гэдгийг бид мэднэ, тийм биз?

Их Багшийн амь нас дээсэн дөрөөн дээр тогтож байдаг

Хэдэн зуун жилийн өмнө, Вьетнам улс хаант засаглалтай байсан үед нэгэн Руян Чанжуу гэдэг нэртэй их түшмэл байжээ. Тэрээр боловсрол сайтай хүн байсан тул тухайн үеийн хаан нь түүнийг Францад суралцуулахаар томилжээ. Ихэнх хүн энэ түүхийг мэддэг байх. Гэхдээ зарим хүн үүнийг сонсоогүй байж магадгүй тул Багш нь товч өгүүлье.

Руян Чанжуу сургуулиа дуусган буцаж ирээд хаанд: Европт маш их соёл иргэншилтэй, чийдэнгээ таазнаасаа өлгөдөг, тэргийг мориор чирүүлэхгүйгээр хөдөлгөдөг. Ус нь хананаас нь цоргоор урсан гардаг гэж ярьжээ. Хаан болон сайд нар үүнд итгэсэнгүй. Европт аль хэдийн цахилгаан гэрэлтэй болсон гэдгийг тэд хараахан мэдээгүй. Бидний сайн мэддэг тосон дэнлүүг толгойг нь дээш нь харуулж байж л асаадаг байтал яаж доош нь харуулан өлгөж болох билээ? Руян Чанжуу эзэн хааныг хууран мэхэлсэн хэргээр ял авч, толгойгоо авахуулсан гэдэг. Эзэн хааныг мэхлэх нь тухайн үеийн хамгийн хүнд гэмт хэрэг байсан бөгөөд гурван үеэрээ цаазлуулдаг байжээ.

Руян Чанжуу үнэн үг хэлсэн байтлаа амиа алдсанаар барахгүй, гурван үеэрээ цаазлуулав. Энэ дэлхий үнэхээр аюултай гэдгийг та нар харж байна уу? Бидний нөхцөл байдал мөн л ийм. Багш нь өөрийн ажиг мэдсэнээ ярьсан байхад аль хэдийн ёс зүйг сөрсөн хэрэг болоод байхад диваажин, тамын орон гэх мэт чанагуух ертөнцийн зүйлсийн талаар бүр ч ярих хэрэггүй. Тиймээс эртнээс эдүгээ болтол: Төгс Гэгээрсэн Их Багшийн амь нас дээсэн дөрөөн дээр тогтдог гэдэг хууч үг байдаг. Гэхдээ азтай нэг хэрэг гэвэл орчлонгийн хууль маш тодорхой, шударга учир Их Багш нар дээд зэргээр хамгаалагдсан байдаг. Тиймээс бид сая ингэж илээр ном тайлж чадаж байгаа билээ.

Есүс Христ ч гэсэн хүмүүсийн хараа, сонорт өртөхгүйн тулд нууцаар ном дэлгэрүүлж байсан бөгөөд шавь нартайгаа уулзахдаа ч бас нууцалдаг байжээ. Одоо ч гэсэн зарим оронд илээр ном дэлгэрүүлэх боломжгүй гэмээр л байна. Та нар Америкт амьдарч буй нь үлэмж их буянтайд тооцогдоно. Энд хүмүүсийн итгэл үнэмшлийн эрх чөлөөг төрөөс дээдлэн хамгаалдаг бөгөөд хүний үндсэн эрхийг хүндэтгэж, хувь хүний үнэ цэнийг эрхэмлэдэг.

Гэхдээ дэлхий дахин улам өөрчлөгдөж, нөхцөл байдал алгуураар сайжирч, итгэл үнэмшил, шашин шүтлэгийн хязгаарлалт бага зэрэг суларч байх шиг байна. Яагаад вэ гэвэл бясалгагч нар улам бүр олон болж байгаа тул гараг дэлхий маань улам сайжирч байна. Багш нь дэлхий даяар илүү их ном дэлгэрүүлэх тусам дэлхийн уур амьсгал илүү гэрэл гэгээтэй болж буйг би мэдэрч байна! Олон газраас Багшийг нь ном тайлуулахаар урьдаг. Хэдийгээр Багш нь бие, сэтгэлээрээ тун ядарч, татгалзахыг хүсдэг ч хүмүүсийн хүртэж буй гайхалтай ач тусыг харахаар өөрийн эрүүл мэндээ золиосолж, эрч хүч, цаг зав, сэтгэл зүрхээ ном түгээн дэлгэрүүлэхэд зориулах ёстой гэж үздэг.

Бидний бие махбод олон зүйлийг хийж чаддаг нь үнэн

хэдий ч цаг нь тулахаар тэтгэвэртээ гарах ёстой. Дэлхийн хүн ам олон, зөвхөн ганцхан хүний хэмжээ хязгаартай бие цогцосоор бүгдэд үйлчлэх боломжгүй. Бие махбод хэзээ нэг өдөр элэгдэж дуусдаг. Яг л машин шиг, хичнээн сайн байсан ч ашиглаад л байвал хэзээ нэгэн өдөр эд анги нь эвдэрч, эрэг шураг нь суларна. Багшийнх нь “эрэг шураг” хэдийгээр сулраагүй ч заримдаа ядардаг гэмээр болох юм.

Тиймээс Багш нь та нарын хүссэн зүйлийг биелүүлж чадахгүй бол битгий гомдоорой! Ном тайлах, эсвэл авшиг хүртээсний дараа Багш нь маш их ядардаг. Гэтэл олон хүн Багштай нь ганцаарчлан уулзах, өөртэй нь гар бариасай гэж хүсдэг. Би үүнээс татгалзвал тэдний сэтгэл эмзэглэнэ. Гэтэл Багш нь үнэхээр тун их ядарсан тул унтаж, амрах шаардлагатай. Тэгж байж л дараагийн өдөр нь үргэлжлүүлэн ажиллах боломжтой болно.

Одоо ярьж байсан гол зүйл рүүгээ орё! Энэ дэлхийд үнэмлэхүй зүйл гэж байдаггүй. Дэлхийн хүмүүс аливаа хэрэг явдлын нэгээхэн хэсэг талыг л харж чаддаг бөгөөд бүх зүйл угаасаа төгс сайхан байдгийг харж чаддаггүй. Жишээлбэл, хүн 100 метр орчимд байх байг л хардаг бөгөөд урагшаа харвал ар талаа харахгүй, зүүн зүг харвал баруун талаа харж чаддаггүй.

Энэ ертөнцөд хүн төрөлтний харах чадвар тун хязгаартай. Одон орны дурангаар хүртэл орчлонгийн одон гарагийн зөвхөн нэг хэсгийг л харж чадна. Орчлонгийн бүх гарагийг харж чадахгүйгээс хойш бид яаж диваажин, тамын орны тухай ярих юм бэ?

Диваажин болон тамын орон нь тодорхой хэлбэлзлэлийн давтамжинд оршдог бөгөөд энгийн нүдээр харж чадахгүй. Яг л бактерийг энгийн нүдээр харж чаддаггүйтэй адил. Угаасаа хол байгаа гарагуудыг дурангаар ч харж чаддаггүй. Энэ ёсыг та нар ойлгох биз. Гэхдээ харж болох нэгэн арга бий. Тэр бол Буддын нүдээр харах бөгөөд үүнийг

билгийн мэлмий гэж нэрлэдэг. Билгийн мэлмий хаана байдаг, түүнийг яаж ашиглахыг бидэнд зааж өгөх нь Төгс Гэгээрсэн Их Багшийн үүрэг хариуцлага юм. Билгийн мэлмий бол бидний дотоодын дуран. Төгс Гэгээрсэн Их Багшийн зааж чиглүүлсэнээр дотоод дурангийнхаа фокусыг тохируулсны дараа бид чанагуух ертөнцийн үзэмжийг харж болно.

Та нар өөрсдийн дотоодын дурангаа хараахан мэдээгүй байгаа. Хэрвээ фокусаа тохируулж чадвал өнгөрсөн болон ирээдүйн тоолшгүй олон төрөл, орчлонгийн тоо томшгүй олон гарагуудыг харж, диваажин болон тамын орны бүх нууцыг мэдэх болно. Ингэснээр бид орчлонгийн бүх зүйлийг гэрийнхээ эд хогшил шиг тодорхой мэдэж болдог бөгөөд тийм ч гайхалтай санагддаггүй.

Амьдралаа улам өнгөлөг болгохуй

Хэдэн хоногийн өмнө Багшийнх нь үеэл дүү нар миний энд байгааг сонсоод утсаар ярьж: “Бурхан минь ээ! Та яагаад Будда болсон гэдгээ бидэнд хэлээгүй юм бэ? Танд шинэлэг мэдрэмж төрж байна уу?” гэж асуухад: “Ямар ч шинэлэг мэдрэмж байхгүй, би үүнд дасчихсан” гэж хариулсан. Үнэндээ Будда болно гэдэг хүүхэд өсгөхтэй адил юм. Бид хүүхдээ өдөр бүр тэвэрдэг тул хүүхэд аажмаар өсөж томордог ч хүнд болсон гэж мэдрэгддэггүй. Хааяа бусад хүн ирж тэврээд л хүүхэд өмнөхөөсөө илүү хүнд болсныг илт мэдэрдэг.

Будда болох нь бидний хувьд гайхмаар хэрэг биш. Хүн бүр өөрсдийгөө угаас Будда мөн гэдгийг мэдэх учиртай. Энэ л сая амьдралын жинхэнэ утга учир юм. Эс бөгөөс хүний эрдэнэт бие дэмий үрэгдэх болно. Хүүхэд өсгөнө гэдэг амаргүй: эх хүн эхлээд есөн сар арав хоног хөл хүнд явна. Дараа нь төрөхийн зовлонг амсана. Үүнд хэн ч

тусалж чадахгүй. Хүүхдээ төрүүлсний дараа бас л хөхүүлж, хооллох шаардлагатай болдог. Хүүхэд нь ханиалгахад эцэг, эх нь ихэд сандарна. Өдөржин санаа зовж унтаж ч чадахгүй. Хүүхдээ өсгөх гэж хорь гаруй жил зүтгэсний эцэст хүүхэд нь дээд сургуульд орно. Дахиад л олон жил завгүй ажиллаж, нэг мэдэхэд л хадан гэртээ буцах болдог. Ийм амьдралын утга учир гэж юу байна вэ? Хүн болж төрөх нь ийм л юм гэж үү? Ингэж бүх зовлонг тэвчихийн төлөө юм гэж үү?

Үгүй ээ, хүн болно гэдэг ийм байх ёсгүй. Амьдрал аз жаргалтай, өнгөлөг байх ёстой. Гэхдээ хүмүүс үүнийг хараахан ойлгоогүй юм шиг байдаг. Бид бусдыг баян тансаг, тав тухтай амьдрал хөөцөлдөж байна гэж шүүмжлэх ёсгүй. Учир нь амьдрал баян тансаг байвал л сая хүмүүс материаллаг хүсэл шуналгүй байх болно. Жаргалтай амьдрал, дотно ханьтай байхаар л аюулгүй, аз жаргалтай санагдан хуурмаг гоо сайханд ташуурахаа болино. Бид зөв арга замыг олж чадахгүй, амьдралаа яаж зохицуулахаа мэддэггүй учраас л төвөг бэрхшээл их, ядуу хоосон, тав тухтай биш байдаг.

Өмнө нь Багшийнх нь гэр бүл ядуу байгаагүй, харахад энгийн л нэг айл хэдий ч аав, ээж хоёр маань хадгаламжтай байсан. Миний санаж байгаагаар бага байхад ээж маань надад нэг уут алтан зоос харуулж, аав, ээжид нь ямар нэгэн төвөг бэрхшээл тохиолдвол үүнээс авч хэрэглэж болохыг мэдүүлж байсан. Гэхдээ манайханд одоо алт байхгүй шүү. Манай гэрээс алт олно гэж битгий бодоорой! (Багш болон бүгд инээв.) Өнөөх алтан зоосыг зарсан ч бидний гэр бүлийг тэжээхэд хүрэлцэхгүй. Коммунист нам өмнөд Вьетнамыг эзлэн авч, манай гэр бүлийн хөрөнгийг хурааж, аав, ээжийг маань ажилд явуулсан. Би нэг удаа гэр лүүгээ мөнгө явуулсан ч маш бага мөнгө байсан. Эцэг, эх маань өвдсөн гэсэн захиа ирсэн тул тэдэнд эм тариа л явуулсан. Тэднийг баяжуулахаар их мөнгө огт өгч тэтгээгүй. Тэд одоо ч ядуу хэвээрээ, зурагт

ч байхгүй, цахилгаангүй ч байж мэднэ. Энэ жилийн цагаан сарын баяраар би эцэг, эхдээ мөнгө илгээсэн. Учир нь тэд нэгэнт хөгширч, ажил хийх боломжгүй болсон болохоор мөнгө шаардлагатай. Гэхдээ би өөрийн гар урлалаасаа зарж олсон мөнгөө илгээсэн болохоос олон түмний хандив биш шүү.

Бид амьдралаа бүр илүү сайхан болгох гэж арга боддоггүй болохоор ядуу байдаг. Миний эцэг, эх мөн адил, яаж баяжихыг мэддэггүй. “Өөрийн гэртээ хэн ч Будда биш” гэдэг үг байдаг. Багш нь гэрийнхээ хүмүүст өөрийн амжилтаа сайрхаж байгаагүй. Тиймээс хамаатан садан маань хорин жилийн дараа л сая Багш дээр нь ирж байна. Би гэр бүлдээ захидал бичиж: “Будда болсон, та нар намайг дагаж суралцах хэрэгтэй” гэж хэлж байгаагүй. Бүх зүйл аяндаа байх нь сайн, цаг нь болохоор тэд над дээр ирнэ. Багш нь зарлаад байх хэрэггүй.

Шавь нараа уруу татаж, өөрт нь итгүүлдэг гэж олон хүн Багшийг нь буруугаар ойлгодог. Үнэндээ Багш нь гэрийнхээ хүмүүст хүртэл хэлдэггүй. Би сүүлийн хорин жилд анх удаа тэдэнтэй дахин уулзаж байгаа бөгөөд энэ хугацаанд өөрийнхөө тухай юу ч яриагүй болохоор Багшийг нь хэн гэдгийг тэд мэддэггүй байсан. Надад хэнийг ч ятгах хэрэг байхгүй. Ялангуяа дүрвэгсдийг, ядарсан тэднийг ятгах нь ямар ач тустай юм бэ? Зарим хүн Багшийг нь дэндүү буруугаар ойлгож, ямар ч учир зүйгүй зүйл ярьдгийг нь жаахан ухаантай хүн л бол огт итгэх ёсгүй.

Өнөөдрийн ном сонсохоор ирсэн хүмүүс билиг ухаантай, гэхдээ ихэнх хүн маш ухаалаг болохоор амархан хууртахгүй. Би ид шидийн хүч, эсвэл ер бусын арга хэрэглэж, өөртөө итгүүлдэггүй бөгөөд шавь нар “хайж” явдаггүй. Ном тайлахдаа ч гэсэн зөвхөн учир зүй болон ёс зүйд нийцүүлж ярьдаг. Та нар Багшийнхаа үзэл бодол, танин мэдэхүйг хүлээн зөвшөөрвөл: “Энэ хатагтай зөв ярьж байна, би ч

бас тэгж боддог, гэхдээ энэ санаа зөв эсэхийг өмнө нь сайн мэдэхгүй байсан, одоо түүний ярихыг сонсонгуут дорхноо ойлголоо” гэж бодох болно. Багшийнх нь ажил гэвэл зөвхөн та нарт угаасаа байгаа билиг ухааныг чинь нотолдог төдий болохоос биш, шинэ зүйл заадаггүй. Ярьсан бүхэн та нарын мэддэг зүйл болохоор сургаал номлолыг минь ойлгодог. Үүнийг нохойд яривал ойлгохгүй, нялх хүүхдэд ярилаа ч ойлгохгүй, тийм биз дээ?

Иймээс Багш нь та нарыг сургадаг ч үнэндээ бас сургаагүй. Будда, Төгс Гэгээрсэн Их Багш, эсвэл ямар нэгэн алдар цолтой гэдгээрээ бардамнадаггүй. Хүн болгонд билиг ухаан байдаг. Зөвхөн нэг хүн эхлээд бамбараа асаавал бусад бамбар ч түүнтэй үрэлцсэний дараа асдаг гэдгийг би сайн ойлгодог. Үнэндээ эхэлж ассан бамбар нь бусад бамбарыг асаасан биш, бүх бамбар угаасаа бас асаж чадна.

Зарим хүн Багшид нь мөргөх гэж ирдэг, тэгээд Багшид нь шавилж суралцахыг хүсдэг, гэвч үнэн хэрэгтээ хэн ч Багш биш байдаг. Би зөвхөн та нарын мартчихсан, эсвэл анхааралтай судлаагүй мэдлэгийг л сануулдаг билээ. Хүмүүс өдөржин амьдралаа залгуулах гээд завгүй, угаас байдаг эрхэм чанараа мартсан байдаг. Багш нь авшиг хүртээж байгаа нь та нарт яаж бясалган сууж, самадид орохыг сургаж, угаас мэддэг зүйлээ санаж олоход чинь туслахын л төлөө билээ.

Би бол Төгс Гэгээрсэн Их Багш мөн, гэхдээ бас биш, би хамаг төрөлтнийг гэтэлгэдэг, гэхдээ гэтэлгэгдмээр төрөлтөн байхгүй. Тиймээс хүмүүс Багшид нь мөргөж сөгдөхийг би зөвшөөрдөггүй. Тайзан дээрх цэцэг, жимсийг та бүхэн Багшийг нь алс холоос ядарч ирсэн гэж хүндэтгэл үзүүлж л бэлтгэжээ. Ийм хүндэтгэлтэй угталт надад шаардлагагүй ч болиулахын аргагүй. Хүн бүр өөрийн санаж дурласан хайртай хүн, зүрхний амрагтаа, эсвэл хүндэтгэн биширдэг шашны зүтгэлтнүүдэд бэлэг хүргэх, тэр ч байтугай булшинд

ч цэцэг өргөх эрхтэй. Та нар бас Багшдаа булшинд цэцэг өргөдөг шигээ цэцэг өргөж болно. Учир нь энэ ертөнцийн хувьд би аль хэдийн таалал төгссөн.

Сэргэлэн цовоо амьдрахуй

Та яагаад уруулаа хазаад инээж ч зүрхлэхгүй байна вэ? (Багш нэг сонсогчид хэлэв.) Инээх гэвэл шууд л хөгжилтэй инээ! Ингэлээ гээд та үхэхгүй шүү! Бид энэ дэлхийд оршин амьдрахдаа тийм ч их эрх чөлөө эдэлдэггүй. Амьдрал яагаад ийм шаналантай байдгийг та нар мэдэх үү? Учир нь бид өөрсдөө ийм болгодог. Инээж зүрхэлдэггүй, уйлж зүрхэлдэггүй, хайрлаж бүр ч зүрхэлдэггүй.

Бид дурлаж хайрласан хүнээсээ хайраа нуудаг. Тэгээд өөр хүний бүсгүй болчихсоны нь дараа л сая тэвчиж чадалгүй уйлж гардаг. Эсвэл өөр бүсгүйтэй гэрлэх үед нь амиа хорлоход хүрдэг. Ингэх нь үнэхээр тэнэг хэрэг, яагаад түүнд шууд хэлдэггүй юм бэ? Хайранд тийм ичгүүртэй зүйл байна уу? Хэн нэгэнд дурласан бол хайртай гэдгээ үнэнээр нь хэлэх хэрэгтэй. Хэрвээ тэр бидэнд хайргүй бол бас тодорхой болгож, дахиад өөр найз эрж болно шүү дээ, амиа хорлохын хэрэг юу билээ?

Бясалгал хийхэд мөн л ийм, зөвхөн Бурханы хутагт хүрэхийн төлөө ч биш. Бас өөдрөг цоглог, сэргэлэн цовоо, агуу мэдлэгтэй, эд баялагтай, баяр жаргалтайгаар амьдрахын төлөө билээ. Өдөр бүр ажилдаа гарна, ажлаасаа тарна, гэртээ харина, иднэ, унтана, сэрээд дахин ажилдаа явна, ингэх нь нэн ядаргаатай. Бид боол болох гэж төрөөгүй бөгөөд сард мянган төгрөг олохын тулд өдөр бүр бетон ханан “шорон»-д хоригдох гэж төрөөгүй. Гэхдээ хүмүүс ингэж зовж амьдрахаас биш, хоёр цаг хагас бясалган сууж, орчлон ертөнцөөр эрх дураараа таатайхан зугаалахыг хүсдэггүй.

Амьдрал гэж тун эмгэнэлтэй, зовлон ихтэй гэж бид

үргэлж гомдоллодог. Үнэндээ энэ бүхнийг бид өөрсдөө бий болгодог. Амьдрал гэж баян тансаг өнгө аястай бөгөөд аз жаргалтай байх учиртай. Өнөөдрөөс эхлэн авшиг хүртсэн эсэх хамаагүй, эрхбиш баатар зоригтой, нугаршгүй, баяр баясгалантай амьдрах хэрэгтэй гэж би та нарт хэлье! Бусдад хохирол учруулахгүй л бол сүнслэг бясалгалд харш саадгүй бүхнийг хийж болно. Дахин бүү эргэлз. Эс бөгөөс аз тохиолыг алдсан үедээ та харамсан зовох болно.

Хэн нэгэнд хайртай болбол түүнд сарнай бэлэглэж: “Би чамд хайртай, та ч бас намайг хайрлах уу? Хэрвээ надад хайргүй бол баяртай! Би өөр нэгнийг эрнэ” гэж шууд хэлээрэй! Түүнээс бүр ч илүү сайхан, үзэсгэлэнтэй, авьяаслаг хүнийг олж чадна. Хорвоо хүнээр дутсан биш, нэг л хүнд тэгж их хүлэгдэх хэрэг юун? Түүнтэй ханилахаар л хайрласан, амьдарсанд тооцогдоно гэж үү? Тэгэх албагүй.

Багш нь ч гэсэн ийм түүхтэй. Би гэрлэсэн, бие биедээ их хайртай байсан. Нөхөртөө би маш их хайртай байсан. (Бүгд инээв) Үнэнээ ярьж байхад битгий шоолоорой! Түүнийг орхиод явахдаа сэтгэл маань нэн гунигтай байсан. Тэр дэндүү их үгүйлэгдэхээр сэтгэлийн гунигтаа дийлдэхээс айж байсан. Гэхдээ би хайр сэтгэлд хэт их ташуурвал хүсэл зорилгоо биелүүлэхийн аргагүй болно гэж бодсон. Гэртээ хоцорвол хамгийн сайндаа л хувцас угаана, гар гараа барилцан хайраа шивнэнэ. Хоёр гурван хүүхэдтэй болж, баяр жаргал дүүрэн амьдарч ч мэднэ. Гэвч хэдэн жилийн дараа санчиг бууралтаж, шүд унаж, нүүрэнд үрчлээ үүсэж, хараа алгуураар муудах үед бие биеэ чимээгүй л ширтэн сууж, булшиндаа орохоо хүлээх л хэрэг болно.

Чадлаараа хичээн хүсэл зорилгоо биелүүл

Тиймээс Багш нь: Амьдралаа жаахан өөрчилж болохгүй гэж үү? Заавал эгэл бүсгүй байх ёстой гэж үү? Олон эмэгтэй аль хэдийнээ ийм ажлыг хийж байна, би юунд

ингэх гэж яарах хэрэгтэй билээ. Ийм ажлын бүсгүй олон байхад ажил булаацалдаж юу хийх вэ? Хэдийнээ байшин дүүрээд шахцалдаж байхад би дээрээс нь чихэж орж юу хийх вэ? Олон хүн эх хүн, эхнэр хүний ажлыг хэдийнээ хийж байна, үүнийг тэдэнд үлдээгээд өөртөө өөр хийх зүйл олсон нь дээр гэж бодсон.

Бүх зүйл адилхан, хэрвээ та ямар нэгэн зүйл хийх хүсэлтэй бол хамаг эрч хүчээ төвлөрүүлж хийвэл амжилтанд хүрэх нь лавтай. Ингэснээр та аз жаргалтай, сэтгэл хангалуун болно. Эргэлзэн тээнэгэлзвэл бүтэмж муутай болдог бөгөөд аз тохиолыг алдах үед харамсан уйлж, гомдоллодог. Үүний улмаас нэг насаа дэмий үрж, өөрийгөө зовооно.

Тиймээс өнөөдрөөс эхлэн хүссэн зүйлээ зоригтой хий. Бусдад хоргүй л бол, орчлон ертөнц, байгалийн хууль дүрмийг зөрчихгүй л бол, үйлийн үр үүсгэж, хүн чанар, хүнлэг сэтгэлээ өвтгөх хэрэг хийхгүй л бол юу ч хийсэн болно. Үйлийн үр гэгч нь яг л замд хөндөлдөх чулуу шиг, эсвэл усанд сэлэх замд босгосон хана шиг урагшлах замын садаа болдог.

Бид хүссэн бүхнээ олж чадна. Эд баялаг, амраг бүсгүй, ухаалаг хүүхэд хүсэх нь шунал биш. Учир нь гэр бүл, орон байшин, машин тэрэг, баян тансаг амьдрал болон амар хялбар ажил гэх зэрэг нь угаасаа байх ёстой зүйл.

Багш нь ном дэлгэрүүлэхээр дэлхийг тойрон аялдаг бөгөөд цаг маш давчуу. Заримдаа шөнөжингөө нийтийн бясалгалд оролцож, өглөөний тав, зургаан цаг хүртэл авшигтнуудын асуултад хариулдаг. Дараа нь үдээс хойш тав, зургаан цаг хүртэл ном тайлж, орой долоо, найман цаг хүртэл авшиг хүртээж дуусаад өөр нэг хот руу явахаар онгоцонд суудаг. Маргааш нь яг ижил маршрутаар үргэлжилнэ. Багш нь тун бага унтдаг бөгөөд хоол ч бага иддэг. Ихдээ л бага зэрэг витамин ууна. Хоолой маань тавгүйтэхээр хааяа эм уудаг, гэхдээ би ядардаггүй.

Та нар зөвхөн ганц төрлийн ажил хийж, ганц эр нөхөр болон хоёр, гурван хүүхдээ харж ханддаг төдий мөртлөө харин тун ядарсан санагддаг. Найз нөхөдтэйгөө уулзах завгүй, ном сонсож, бясалгал хийх цаг зав байдаггүй. Багш нь маш олон ажлыг нэгэн зэрэг амжуулж, олон улс оронд очин ном тайлдаг бөгөөд бас дүрвэгсдэд тусалдаг хэдий ч харин ядарсан санагддаггүй. Гэхдээ Багш нь бас мөнгөтэй байдаг. Бясалгагч хүн өөрийгөө ч тэжээж чадахааргүй ядуу бол энэ дэлхийд бясалгахыг бодох хэн байх вэ?

Бясалгасны дараа гуйлгачин болчихвол бясалгал хийсний ач тус юу байх вэ? Мөнгөтэй байх нь муу хэрэг биш. Мөнгөө хувийн хэрэгцээндээ зориулдаг биш, харин бусдад ач тус хүртээх, ном дэлгэрүүлэх, ядууст туслахад зарцуулна. Хор тариалахад зарцуулдаг бол тэр нь хороос ялгаагүй. Гэхдээ эмийн үйлдвэрт зарим хорыг ерөндөг болгон ашигладаг бөгөөд хэтрүүлэн хэрэглэхгүй бол хор болохгүй. Үүнтэй адил мөнгөөрөө бусдад тусалж, тэднийг баярлуулж байвал мөнгө нь сайн эм, витамин шиг ач тустай.

※ Та хэрвээ ямар нэгэн зүйл хийх хүсэлтэй бол хамаг эрч хүчээ төвлөрүүлж хийвэл лавтай амжилтанд хүрнэ.

Өөртөө цаг гарга

Багш нь яагаад та нараас баян байдгийг мэдэх үү? Учир нь Багш нь мөнгөө зөв зарцуулдаг. “Библи судар”-т: “Эхлээд дотоодын диваажингаа хайж ол, тэгвэл бүх юм таных болно” гэсэн байдаг. Энэ нь эхлээд Эзэн Бурханыг хайж ол, тэгвэл юу хийсэн ч саадгүй болно гэсэн үг юм. “Баатараа явагч их хөлгөн судар”-т: Арьяабалын аргаар бясалгаж, Бурхан чанараа ойлговол юуг ч ойлгож чадна гэсэн байдаг. Гэтэл үүнд итгэж, үүнийг биелүүлдэг хүн байдаггүй.

Бид ер нь өөрсдийн азгүйдээ сэтгэл шаналж, төлж дуусашгүй өр ширтэй гэж гомдоллодог. Зарим хүн 30 жилийн хугацаатай орон сууцны зээл төлдөг гэсэн. Үүнийг сонсоод Багш нь ухаан алдчих дөхсөн. Ганцхан байшингийн төлөө гучин жил зээл төлөх шаардлагатай аж. Бурхан минь! Хүн хэдэн жил амьдрах боломжтой гэж та нар бодно вэ? Гучин жил гэдэг чинь бараг нэг насных нь амьдрал шүү дээ!

Бид өөрсөдөө цаг зав гаргах нь тун ховор: багадаа хичээл ном хийгээд завгүй, том болоод ажил хийгээд завгүй, хөгшрөхөөрөө өвчин зовлонд ороогдоод завгүй. Тиймээс өөртөө цаг зав гаргах нь үнэхээр бага, нэг насаа ингэж л дэмий үрж дуусгадаг. Өдөр бүр 8-10 цаг бетонон ханатай өрөөнд ажиллаж, өдөрт хэдэн арав, эсвэл хэдэн зуун төгрөг л олдог. Бидний үнэ цэнэ яаж ийм доогуур байж болох вэ?

Мэдээж хүн бүр өөрийн хүссэнээрээ амьдарч болно. Гэхдээ өдөр бүр цаг гаргаж, сэтгэлээ тайвшруулж, бясалгаж суух хэрэгтэй, тэгж байж л сая бодь мөрийг олж чадна. Зовж зүдрэлгүйгээр амьдралаа залгуулж чадна. Орчлон ертөнцийг эзэмдэж чадна. Энэ бол Луузын ярьсан “Үйлдэнэ, гэвч бас үйлдээгүй” гэгч мөн. Үүний утга нь “хийдэг, гэвч бас хийгээгүй” болно. Бид ийм дэст хүрч, өөрсдийн цэцэн мэргэн билиг ухаанаа хэрэглэж, түүнийхээ чадварыг бүрэн ашиглаж, өөрсдөдөө, улс орондоо, цаашилбал дэлхий дахин болон орчлон ертөнцөд ач тус хүргэвэл зохино.

Бид толгой тархи (энэ жижигхэн компьютер)-ныхаа хязгаартай чадвараа ашиглан ажилладаг. Өглөөнөөс орой болтол амь насаа ч эрсдэлд оруулан ажиллаж ч мэднэ. Гэхдээ хичнээн галавын турш ингэж ажиллаж ирсэн байлаа ч дэлхий гарагтаа хангалттай тусалж чадахгүй хэвээрээ л байна. Хүн өдөрт наймаас арван зургаан цаг, эсвэл арван найман цагаар ажиллаж, цаашилбал өдөр, шөнө амралгүй ажиллаж чаддаг гэдгийг судалгаагаар баталсан байдаг. Гэтэл нэг хүн хоёр, гурав, дөрвөн төрлийн ажлыг зэрэг хийгээд ч хэрэгцээгээ

хангаж чадахгүй хэвээр л байна. Тиймээс ийм амьдралын хэв маяг найдвартай биш. Материаллаг зүйлсийг хөөцөлдөх нь ихдээ л амьдралыг жаахан тав тухтай болгохоос хэтрэхгүй!!

Дэлхий шинэчлэгдэх тусам соёл иргэншлийн түвшин төдий чинээ буурна. Төрөлт багасна, нөхөр гэргий, эцэг эх, үр хүүхэд хоорондоо хөндийрнө. Бид энэ дэлхийн төлөө зүтгэдэг ч хэнд ч тусалж чаддаггүй. Бидний дэлхий юугаар ч дутахгүй. Нэг хүн таваас долоон нохой, олон тооны муур тэжээж чаддаг атлаа харин ганц хоёр дүрвэгчид тусалж чаддаггүй. Дүрвэгсдийн хуаранд хоол хүнс, хувцас хунараар дутагдаж байгаа энэ ядарсан хүмүүсийн эрх, эрхэм нэр төрийг дурдалтгүй. Гэхдээ хүн төрөлхтний нэр төр гэж маш чухал юм байдаг. Олон төрлийн бүлгэм, нийгэмлэг арга зам судлан ярилцсан ч нэмэр болоогүй. Тэд дүрвэгсдэд тусалсан нь үнэн, гэхдээ гянданд хорьсноос ялгаагүй бүгдийг хамтад нь нэг хуаранд хорьжээ.

Багшийнх нь шавь нар яагаад Багшийгаа тэгж ихээр хүндэтгэн дэмждэгийг та нар мэдэх үү? Багшийнх нь ярьсан бүхэн үнэн, хийсэн бүхэн нь зөв болохоор үнэн бодит зүйлийг хэлдэг гэдгийг тэд мэддэг. Миний шавь нарын ихэнх нь эмч, инженер бөгөөд бүгд ухаалаг хүмүүс. Хараахан төлөвшөөгүй жаахан хүүхдийг хууран мэхэлдэг шиг Багш нь шавь нараа уруу татдаггүй. Энэ буурал үстэй, боржин чулуу шиг хатуу эмгэд бусдад тийм ч амархан итгэдэггүй юм чинь Багш тэднийг уруу татаж хэрхэн чадах билээ? Үнэнийг хэлэхэд тэд л Багшийг нь уруу татсан хүмүүс байх ёстой. Учир нь юуг ч үл харгалзан тэд Багшийгаа дагах ёстой байсан.

Хаана очсон ч олон мянган хүнд анхаарал халамж тавих ёстой тул Багш нь заримдаа маш их ядардаг. Кино одод тэднийг бишрэн шүтэгчид их байдаг хэдий ч олон түмэн цавуу шиг наалдчихдагийг сайн ойлгодог болохоор тоглолт дуусахаар тэднээс холдон зугтаж болдог бөгөөд

тэдэнтэй зууралдахаас айдаг. Гэтэл Багш нь “тоглолт”-ын дараа ч эрхбиш олон хүнтэй гар барилцан дотночлох хэрэгтэй бөгөөд маргааш өглөөний зургаа, долоон цаг хүртэл үргэлжлэн ярилцах ёстой. Ийм байдлаас айхгүй хэн байх вэ? Багш нь ч бас айдаг. Гэвч амь биеэ үл хайрлах, бодь сэтгэл л Багшийг нь эргэлзэлгүйгээр үргэлжлүүлэн ажиллахад хүргэдэг. Бидний зүрх сэтгэлд харамгүй өгөөмөр, бодь сэтгэл байх тэр үед дотоодын билиг ухаан жам ёсоороо нээгддэг.

Орчлон ертөнцийн билиг ухааны энергийг ашиглахуй

Өөрийгөө сул дорой, билиг ухаанаар хангалтгүй гэж бүү бодоорой! Та бүхний дотоодын билиг ухаан хэмжээлшгүй, эрч хүч нь асар их, бүрэн дүүрэн бөгөөд хориглохын аргагүй, зөвхөн та үүнийгээ мэддэггүй л төдий шүү! “Би өдөрт найман цаг ажилладаг. Тэгж байж л амьдрах боломжтой” гэж та нар үргэлж боддог. Тийм биш! Та нар олон зүйлийг хийж чадах мөртлөө ердөө ч хийдэггүй. Учир нь дэндүү завгүй байдаг. Мөнгө олохыг л мэдэж, материаллаг зүйлсэд дэндүү их хүлэгддэгийн улмаас бусад зүйлийг тоодоггүй. Байгаа цаг зав, эрч хүчээ уйтгартай ажилд зарцуулдаг нь хайран амь насаа талаар үрж байгаа хэрэг мөн. Та нар харах өнцгөө өргөжүүлдэггүй болохоор гэгээрсэн болон гэгээрээгүйн ялгаа зөрүүг мэдээж ойлгодоггүй.

Өдөр бүр олон цаг зарцуулан мөнгө олж, дараа нь үрж дуусгана. Шинэ загвараар хувцасласан ч удалгүй цагийн аясаар хоцорч хаягдана. Багш нь их мөнгө олдог хэдий ч бас гамнаж хэрэглэдэг. Өдөрт нэг, хоёр аяга шөл уухад л цадчихдаг. хувцсаа өөрөө эсгэдэг, хар даа! Миний хувцас тун үзэсгэлэнтэй байгаа биз. Та нарын хувцас тун үнэтэй ч Багшийнх нь оёсон хувцас шиг сайхан харагддаггүй.

Бид зөв ажиллах арга замаа мэддэгсэн бол бүх зүйл илүү хялбар болох бөгөөд хүч чадал бага зарцуулж, их үр

ашиг хүртэж чадна. Энгийн хүмүүс Багш шиг нь тийм их ажил төрлийг зохицуулж чадна гэж та нар бодож байна уу? Багш нь гар урлал хийдэг, гэрээс гарагчдыг сургадаг, хүмүүст авшиг хүртээдэг. Дэлхийн олон оронд очиж ном тайлдаг бөгөөд бас Вьетнам ахан дүүсээ харж халамжилдаг. Гэхдээ дүрвэгсдийг харгалзах нь бясалгал дадлаас хамаагүй илүү төвөгтэй боловч Багш нь ядардаггүй. Яагаад гэвэл Багш нь эгэл ертөнцийн хүчийг хэрэглэдэггүй. Харин орчлон ертөнцийн билиг ухааны хүч, өөрөөр хэлбэл Бурхан чанар, эсвэл диваажингийн энергийг ашигладгаас тэр.

Энэ аугаа их цаглашгүй хүчийг ашиглаж чадвал юу хийсэн ч ядардаггүй. Багш нь зөвхөн дүрвэгсдэд тусалдаг төдийгүй, бас нийтийн бясалгалд оролцдог. Гэрээс гарагч болон гэрээс гараагүй шавь нарынхаа олон мянган хүнд бэрх асуудлыг дор нь шийдвэрлэдэг. Гэхдээ үнэнээр хэлбэл тийм шаардлага үгүй бол Багш нь юу ч хийхийг хүсдэггүй. Улс төрийн асуудлыг ерөнхийлөгч, парламент удирддаг. Цэргийн асуудал генаралын хяналтанд байдаг, гэмт хэрэгтнүүд цагдаагийн хяналтанд байдаг, боловсролыг багш нар удирддаг. Багшид нь энэ бүх зүйлийг хийх шаардлага байхгүй.

Үнэндээ Арьяабалын аргаар бясалгавал аяндаа билиг ухаантай болно. Жишээ нь: Багш нь өмнө нь зурж чаддаггүй байсан бол одоо сайхан зурдаг болсон. Багшийнх нь зургийг хүмүүс маш сайхан гэж магтдаг бөгөөд надад ч гэсэн тэгж санагддаг. Үгүй бол хүмүүс Багшийнх нь зургийг юунд тийм өндөр үнээр худалдан авах юм бэ? Тэд тэнэг хүмүүс биш. Энэ дэлхийд уран бүтээлч хүмүүс тун олон байдаг хэдий ч ерөнхийдөө тун ядуу амьдардаг.

Өнөөгийн хөгжин дэвшсэн шинэ эринд бясалгагч хүн заавал хүнд бэрх, зовлон зүдгүүртэй, ядуу хоосон амьдарч, турж эцэтлээ ядран байж л Бурханы хутагт хүрч чаддаг юм биш, энэ бол буруу бодол. Ийм хүйтэн цэвдэг сэтгэлтэй

Бурхан, ийм хар санаатай Христ гэж байдаггүй. Есүс Христ маш нигүүлсэнгүй, Бурхан Багш ч бас тун өгөөмөр бөгөөд хүмүүсийг авран туслаад амжихгүй байгаа хэр нь яаж тэднийг зовлон зүдгүүртэй амьдруулна гэж?

Хүмүүс өдөр бүр гэр бүлээ асран тэжээх гэж ихэд зовж зүдэрч яваа. Хамаг төрөлтөн хүн, чөтгөр, адын төрөлд байнга ахин дахин эргэлдэж, зовлонгийн далайд амь тэмцэн зүтгэж, жаахан ч бай аврагдах боломж байгаа бол духаа цоортол мөргөхөөс буцахгүй. Ийм байхад тэднийг бүр ч илүү залхаан шийтгэх зүрх сэтгэлтэй хүн яаж байж болох вэ? Хэрвээ ийм байвал тэр нь ямар төрлийн Будда, ямар төрлийн Христ вэ? Ойлгож байна уу?

Та яагаад бас мөнгө олох гэж ажилладаг юм бэ? гэж Багшаасаа бүү асуу. Учир нь бясалгал хийх нь төв цэгц хэрэг, нуун далдлах шаардлага байхгүй гэдгийг би нотолж байгаа. Бясалгал нь диваажин болон тамын орон, дүрстэй, дүрсгүй ертөнцөд үлэмж их ач тустай. Их өлсөж байгаа үед тогтуун суугаад бясалгаж чадах уу? Хөдөлгөөнгүй сууж чадлаа ч бодол сэтгэл чинь бууз, талх, будаа бодсоор байхад яаж диваажингийн тухай бодож төвлөрөх вэ? Вьетнам хүмүүс тун ухаалаг, тэд “Цатгалан байж л бодь мөрийг олж чадна” гэж хэлдэг. Ингэж хэлдэг хэдий ч бясалгахаар шийдсэн нэгнийг хармагц харин: ядуу тарчиг амьдар, өдөрт ганц удаа л хоолло, урагдаж муудсан хувцастай явж, айл болгоны хаалга тогшиж, хөл нүцгэн бадарчилбал бүр ч сайн гэж өөрийнхөө бодлыг тулгадаг.

Орчин үеийн нөхцөл нэгэнт өөр болжээ. Бясалгал дадал нь угаасаа эрхэм дээд зүйл. Бясалгагч хүн бие махбодоос сүнслэг цогцос хүртэл, бодол сэтгэлээс үг яриа, үйл ажиллагаа хүртэл, материаллаг зүйлсээс оюун санаа хүртэл “бүх тал”-аараа хөгжин дэвших ёстой. Нийгмийн байр сууриар доор, засгийн газрын тэтгэмжинд түшиж, улс гэр болон нийгмийн дарамт болчихвол түүний ярихыг

хэн сонсохыг хүсэх билээ? Заасан арга нь хүмүүст тустай эсэхийг хэрхэн баталж чадах вэ? Өөрийгөө тэжээж чадахгүй байж яаж бусдад тусалж чадах вэ? Өөрийнхөө ирээдүй нь хүртэл бүүдгэр, баталгаагүй хүн өөрийг нь дагасан хүмүүст яаж гэгээн саруул ирээдүй олгоно гэж баталж чадах вэ?

Жишээлбэл, Африкт одоо ядарч зүдэрсэн хүмүүс олон байна. Тэдэнд хангалттай тусалж чадах хүмүүс байхгүй. Багшийг нь дагадаг Арьяабалын хэдэн арван мянган бясалгагчид бүх хүчээ бясалгалдаа хандуулж, ертөнцийг огоорч, гуйлгачин болчихвол дэлхий дахин бүр ч хүнд байдалд орох бус уу? Хүмүүс дүрвэгсэд болон Африк дахь ядарсан хүмүүст туслахаас гадна бас олон мянган бясалгагчдыг тэжээх арга хайх хэрэг гарна. Та нарын бодлоор ингэх нь зөв үү? Тиймээс бясалгал хийх нь зовлон зүдгүүрийг тэвчихийн төлөө биш, харин амьдралаа илүү аз жаргалтай болгох арга зам хайх явдал гэдгийг Багш нь та нарт сануулж байна.

Чин үнэнч гүн хүсэл: Багшийн бороо оруулсан түүх

Бид аз жаргалтай амьдрах эрхтэй бөгөөд юу хүснэ, түүнийгээ олох учиртай. Аз жаргалын төлөө залбирах нь бясалгалд саад учруулдаг нэгэн зүйлийн нүгэл хилэнц гэж бид бодож мэднэ. Энэ бол буруу бодол шүү. Үнэндээ зарим хүн бясалгалаар сайн биш, амьдрал нь маш хүнд бэрх болохоороо л тэдний үлгэр дуурайлыг дага гэж бусдыг хүчилсэн байдаг. Тэр хүмүүс дээд дэсийн үнэнийг ойлгодоггүй.

Бясалгал хийх нь бидний оюун санааг цагаан цайлган, цэвэр ариун болгож, улмаар хүсэл тачаал, шуналгүй болдог. Өөрөөр хэлбэл сэтгэл хангалуун болдог. Ямар нэгэн хүсэл тачаал байгаа л бол сэтгэл хангалуун байж чадахгүй.

Бясалгал хийхгүй бол дотооддоо ямар ч ач тус хүртэхгүй тул сэтгэл мэдээжээр тайвширч чадахгүй.

Саяхан Багш нь Калифорни мужийн Сан Хосе руу газар үзэхээр очсон юм. Тэр хэсэг газар халцгай, өвс ногоогоор тачир байв. Учир нь Калифорни мужид таван жил бороо ороогүй тул мод цэцэг, өвс ургамал нь бүгд гандаж хатсан байжээ. Багш нь угаасаа л мод цэцэгт хайртай. Тэнд нэгэн нуур байсан ч бараг ширгэх дөхөж, ёроолд нь жаахан шалбааг л үлдсэн байлаа. Тэр газрын даамал Багшид нь: “Бороо оруулж өгөөч, гуйя! Өвс ногоо хатаж хувхайрлаа, хүн ард ажилгүй болоод байна, бороо оруулж өгөхийг танаас гуйя!” гэсэн.

Үүнийг сонсоод Багш нь инээж: “Би салхины сахиус биш, борооны сахиус ч биш, надаас юунд гуйна вэ?” гэлээ. Гэтэл тэр мөн л: “Та л бороо оруулж чадна, гарцаагүй чадна” гэлээ. Тэгээд Багшийг нь өглөөжингөө дагаж гуйгаад л байхлаар нь: “Би явж борооны сахиус, аянгын сахиус нартай зөвлөлдье! Тэд баруун тэнгэрийн хатан эхийн үзэмний архианаас хэтэрхий их ууж согтоод унтаад өгсөн байж магадгүй. Тэнгэрийн орны хоёр, гурван хоног нь хүний ертөнцийн тав зургаан жилтэй тэнцдэг! Би явж хаана унтаж байгааг нь хайя!” гэж хэлсэн. Багш нь зүгээр л тоглосон байхад тэр нээрээ үнэмшиж, гэртээ харьмагцаа бороо орохыг хүлээсэн гэсэн.

Хожим нь нээрээ бороо орсон бөгөөд түүний сэтгэл маш ихэд догдолж, Багш дээр нь ирж, та бороо хур соёрхсон шүү! гээд тасралтгүй талархсан. Дараа нь Багш нь өөр хэдэн газраар явж, дахин Сан Хосе руу буцах үед нөгөөх хүн маань Багшийг нь хараад мөн л маш их баярлаж: “Бороо маш ихээр асгаран орсон шүү! Хэдийгээр нэг долоо хоног л орсон ч борооны хэмжээ хэдэн сар орсонтой дүйцхүйц их байсан. Бид арав гаруй жил ийм аадар бороо үзээгүй, бүх нуур цөөрөм усаар бялхсан шүү!” гэж ахин дахин баярлаж

байлаа. Тэр Багшийг нь дагуулж, нуур цөөрмөө харуулсан чинь үнэхээр бүгд дүүрсэн байсан.

Багш нь түүнд: “Би таны өмнөөс тун баярлаж байна, магадгүй салхины сахиус, борооны сахиус сэрээд өмнө нь ажлаа цалгардуулснаа санаж, алдаагаа даруй залруулснаар бороо оржээ” гэж хэлсэн. Гэтэл тэр харин: “Та дахиад ахиухан бороо оруулаач!” гэж гуйсан. “Бороо хэдийн маш их орсон байхад мөн л хангалтгүй юу? Ойр хавийн хэдэн нуур дүүрснээс гадна Калифорни болон Орегон мужийн нуурууд хүртэл дүүрсэн. Энэ нь хэр их хэмжээний бороо гэдгийг та мэдэж байна уу? Хичнээн хүчтэй салхи, далайн давалгаа хэрэг болж байж л дөрөвхөн өдөрт ийм их бороо оруулж чадна гээч? Энэ борооны ус бүтэн жилийн турш хэрэглэхэд ч хангалттай их байхад та яагаад бас илүү ихийг хүснэ вэ?” гэж би хэллээ. Гэвч тэр бас л: “Дахиад ахиухан, танаас гуйж байна!” гээд л байлаа.

Дэндүү удаан бороо ороогүй болохоор тийм их бороо орлоо ч түүнд хангалтгүй санагдсан байжээ. Цаг агаар хэвийн байж, Калифорни мужид жил бүр бороо ордог байсан бол тэр ингэж их гуйж гувшихгүй байхсан. Нуур цөөрмийн ус аль хэдийн дүүрчихээд байхад бас л хангалтгүй санагдаж: “Их байх тусмаа сайн, их байх тусмаа сайн” гэж маани тарни унших байх мэт давтаад байлаа. Тэр Багшаас нь бие тэнхээ тунгалаг уу, Номын хурал нь амжилт өндөр үү гэж огт асуугаагүй, зөвхөн л “Их байх тусмаа л сайн, танаас гуйя!” гэсээр л байсан.

Яагаад ингэнэ вэ? гэвэл хүсэж мөрөөдсөөр дэндүү уджээ. Тав, зургаан жил дусал ч бороо ороогүй, мод цэцэг, өвс ургамал бүхэн нь хатаж хувхайрчээ. Гэхдээ одоо та нар хар даа, хаа сайгүй ногоон, маш үзэсгэлэнтэй байгаа биз! Ган гачиг нь чин үнэнч гүн хүслийг бий болгожээ. Бороо хур элбэг оронд Багшийг нь ингэж өдөржингөө дагаж хүсэн гүйх хүн байхгүй.

Үүнтэй адил бидэнд яагаад шунал тачаал, занал хорсол төрдөг, ухаалаг байдлаа хэрхэн алддаг вэ? гэвэл хангалттай материаллаг тав тухтай байж чадахгүй үед л маш хүчтэй шунал үүсдэг. Бид угаасаа маш гэрэл гэгээтэй, эрхэмсэг оронд байснаа энэ юм юмаар дутмаг ертөнцөд ирсэн болохоор бүх зүйлийг хүсэж санах нь гарцаагүй. Бид шуналтай, уур уцаартай, нэг нэгнээ занан хорсох дуртайдаа биш, харин шунал тачаалыг маань хангах аргагүй тул сэтгэл гундахын эрхээр үзэн ядах сэтгэл үүсдэг. Сэтгэл гундах нь цэцэн мэргэн билиг ухааныг төөрөгдүүлж, хүмүүсийг ухаалаг байдлаа алдсан, харанхуй мунхаг хэрэг хийхэд хүргэдэг юм.

Харанхуй мунхаг гэдэг нь хэрэг юмын үндэс сурвалжийг ойлгохгүй, өөрийн гэгээн саруул билиг ухаанаа ойлгохгүй байна гэсэн үг. Тиймээс харанхуй мунхаг нь цорын ганц “нүглийн үндэс” юм. Улайрал улангасал, занал хорсол, хэрүүл маргаан, дайн дажин болон түрэмгийлэл гэх мэт нь бүгд л харанхуй мунхагаас үүдэлтэй. Бүх сөрөг зүйл мунхаглалаас болж үүсдэг. Тиймээс ямар нэгэн асуудлаар эцэс төгсгөлгүй маргах шаардлагагүй. Хүн бүр Арьяабалын аргаар бясалгавал дэлхий дахин дорхноо амар амгалан болно.

Гэхдээ Багш нь эрхбиш тэсвэр тэвчээртэй байх хэрэгтэй гэдгийг тодорхой ойлгоно оо. Хэдийгээр аливаа бүхнийг маш тодорхой, ёс зүйтэй тайлбарлачихсан байтал хүмүүс харанхуй мунхаг байдлаараа удаан амьдарчихсан тул ойлгохгүй хэвээр байдаг нь тун харамсалтай. Гэхдээ цөөхөн хэдэн хүн бясалгал хийлээ ч энэ нь оргүйгээс дээр юм. Цөөхөн ч бай хэдэн дэнлүү ассан нь огт дэнлүү асаагүйгээс дээр. Та бүхэн эх орон, ард түмэндээ тусалж, эцэг эхдээ ачлалтай, эх оронч, нигүүлсэнгүй, хүмүүнлэг байхыг хүсвэл билиг ухаанаа олоход тань туслахыг Багшдаа зөвшөөрнө үү? Арьяабалын аргаар бясалгах нь хүн бүрт

дотоодын гэгээн саруул билиг ухаан болон шавхагдашгүй агуу хүчээ эрж олоход туслах болно.

Үгээр илэрхийлж, үзгээр бичишгүй гайхалтай хүч

Хэд хоногийн өмнө, нэг шавь маань Багшаас нь: “Багш аа, та өмнө нь хэзээ ч уран зураг зурахыг сурч байгаагүй мөртлөө яаж ийм гоё сайхан зурж чаддаг юм бэ? Эсвэл та бусдаас суралцсаныг бид ердөө мэдээгүй юмуу?” гэж асуусан. “Үгүй ээ! Би зургийн тухай ном огт уншиж байгаагүй!” гэж би хариулсан. Намайг зураг зурж эхэлсний дараа л шавь нар маань ном авчирч өгсөн юм. Харин миний хэв маягт нөлөөлөх вий гэхээс эмээгээд би дэндүү олон ном уншихыг хүсээгүй. Би өөрөөр зурахыг хүссэн бөгөөд Ван Гог, эсвэл бусад алдартай зураачийн нөлөөнд автахыг хүсээгүй юм.

Багш нь аяндаа ойлгочихдог тул суралцах шаардлагагүй. Шавь нар маань тэвэр дүүрэн ном авчирсан ч би зөвхөн хэдхэн хуудас л сөхөж харсан. Учир нь номын арга нь надад тохирохгүй. Уран зураг гэдэг чинь аяндаа урам онгодоор зурагдах ёстой бөгөөд хэн нэгнийг дуурайх шаардлагагүй. Зарим хүн дөрөв, таван жилээр сурдаг ч тийм ч сайн зурж чаддаггүй. Зурагт нь амин сүнс дутагддаг. Бид тоолшгүй олон өмнөх төрөлдөө олон зүйлийг аль хэдийн сурчихсан байдаг. Одоо шаардлагатай бол тэр чадваруудаа дахин гаргаж ашиглаж болно. Дахин сурах нь дэндүү их цаг үрсэн хэрэг болно.

Та нарт хийж чаддаггүй зүйл гэж байхгүй гэдгээ санаж яваарай. Та нарын мэддэггүй цорын ганц зүйл гэвэл: нэгэнт мэдчихсэн бүх зүйлээ «Хаанаас дахин хайж олж авах вэ!» гэдэг явдал. Оюун бодол, үг хэлээр тайлбарлахын аргагүй тэр гайхалтай хүчийг эзэмшихийг хүсэж байгаа

бол Арьяабалын аргаар бясалгах нь цорын ганц арга зам болно. Үүнийг би бие, сэтгэлээрээ мэдэрч, туршиж үзсэн. Багш нь өөрийн амь нас, чин үнэн сэтгэл, бүх хуримтлалаа золиослон байж, энэ аргыг нотолж гэрчилсэн. Тэгээд би амжилтад хүрсэн бөгөөд үүнийгээ та бүхэнтэй хуваалцах хүсэлтэй байна. (Бүгд алга ташив.)

Багш нь та нарыг шавиа болгох гэж “уруу татаж” байна гэж бүү бодоорой! Багшийнх нь санаа бодол үнэндээ тун энгийн: би та нартай адил энэ дэлхий болон орчлонгийн нэгэн иргэн болохын хувьд өөрөө ямар нэгэн шинэ зүйлийг мэдсэн бол түүнийгээ олон түмэнтэйгээ хуваалцах учиртай. Багшийгаа бүү шүүмжлээрэй! Хайрын сэтгэлтэй хүн бүхэн шинээр мэдсэн зүйлээ бусадтай хуваалцахыг хүсдэг. Та хүлээн авахыг хүсэхгүй бол, хамаагүй л дээ! Гэхдээ яагаад бусдын санал болгож буй өглөгийг шүүмжилнэ гэж? Ингэвэл та өөрийн нэр нүүрээ гутаагаад зогсохгүй, бусад Вьетнамчуудыг эвгүй байдалд оруулж байгаа хэрэг билээ!

Санал шүүмжлэл дэвшүүлэх хүн байгаа бол бүгдийн өмнө ил хэлбэл зохино. Ёс суртахуун сайтай хүн бусдаас далдуур ярьж юу хийнэ? (Бүгд алга ташив.) Багш нь өнөөдөр лекц тавихын өмнөхөн гурван удаа сүрдүүлсэн захидал хүлээн авсан бөгөөд Багшийг нь ном тайлбал ална гэж хэлсэн. Энэ хүмүүс одоо хаана байна? Орж ирээд надад өөрсдийгөө тодорхой харуул. Ямар гэмт хэрэг үйлдсэнийг минь тодорхой хэлж өг! Дараа нь намайг энд нь алж болно! Энэ хорвоод миний хувьд хоргодох зүйл алга. Урт насална гэдэг бол илүү их ажил хийнэ гэсэн үг, надад ямар ашигтай гэж? Энэ хүмүүс одоо хаана байна вэ? Хурлын танхимд сууж байна уу?

Байгаа бол бушуу урд гарч ирээд Багшийнхаа хийсэн гэмийг зарлана уу? Тэгээд олны өмнө Багшийгаа хороож болно. “Би гэм нүгэлтэй, өөрийн хүслээр үхлээ хүлээсэн” гэж би гэрээс бичиж үлдээе. Тэгвэл Багшийг нь алсан хүн ял

авахгүй болно. Хэрвээ нууцаар хорлож, цагдаад баригдвал гэмт хэрэг үйлдсэн болно. Буудах гэж байгаа бол урд гараад ир. Багш нь даруй гэрээс бичихэд бэлэн байна. Тэгвэл цагдаа та нарыг баривчлахгүй. Гарч ирэх хүн байна уу, үгүй юу? Байхгүй юу? Аан?

Та нар аз жаргалтай, баяр баясгалантай, баян чинээлэг амьдрахыг хүсэж байвал эрхбиш бясалгал хийж, билиг ухаан, хүч чадлаа эрж олох хэрэгтэй. Бясалгал хийхгүй бол бодьсадва таныг аварч чадахгүй бөгөөд Эзэн Бурхан ч хамгаалж чадахгүй. Бодьсадва, Эзэн Бурхан аварч чадах байсан бол аль хэдийн аварчих байсан. Эзэн Бурхан, Бурхан бодьсадва нар яагаад биднийг аварч чаддаггүй вэ? Шалтгааныг нь мэдэх үү?

Учир нь хүн төрөлхтөн бол орчлонгийн хамгийн дээд дэсийн төрөлхтөн мөн. Эзэн Бурханыг бид хүсэхгүй байвал Эзэн Бурхан өөрөө ирж зүрхлэхгүй. Хүмүүс өөрсдөө гуйхгүй бол Бурхан бодьсадва нар авран туслах эрхгүй. Учир нь та нар маш эрхэмсэг, агуу бөгөөд хүч чадалтай. Та нар өөрсдөө л зөвшөөрөөгүй бол Бурхан бодьсадва нар ч хөндлөнөөс оролцож авран тусалж чадахгүй. Тиймээс бусдыг ид шидээр толгойг нь эргүүлдэг гэж намайг битгий шүүмжлээрэй! Хэрвээ тэгсэн байвал би дэлхийг бүхэлд нь өөртөө татчихсан байх байлаа. Харин зөвхөн дүрвэгсэд, ахан дүүсээ л татна гэж үү? Хүн төрөлхтөн асар их мэргэн ухаан болон бат чанга хүсэл зоригтой тул хэн ч халдаж чадахгүй.

Өөрсдийнхөө агуу ихээ мэдэхгүй, сул дорой, мухраар сүсэглэх үед, ад чөтгөрийг өөрөөсөө илүү хүчтэй гэж бодох үед л ад чөтгөрт биднийг ашиглах боломж олддог. “Би өөрийгөө ашиглуулахыг зөвшөөрөхгүй, би бол орчлонгийн хамгийн дээд дэсийн төрөлхтөн, надад Бурхан чанар бий, тэр бол орчлонгийн хамгийн дээд хүч мөн” гэж эрс татгалзвал ямар ч чөтгөр таныг захирч чадахгүй. Бурхан бодьсадва хүртэл таныг яаж ч чадахгүй байтал ад чөтгөрийг бүр ч

ярилтгүй.

Тиймээс уй гашуу, хий хүсэл, муу бодол, шаналал зовуурь, азгүйтэл гэх зэрэг нь бүгд л өөрөөс чинь үүсэлтэй. Хэнийг ч битгий буруутга, Эзэн Бурхан шударга бус, Бурхан бодьсадва нигүүлсэнгүй биш гэж гомдоллож хэрэггүй. Өөрөө өөртөө шударга бус, нигүүлсэнгүй бус хандаж, өөрийгөө хэн бэ? гэдгээ мэдээгүй учраас л тэр.

Одоо мэдэх хүсэлтэй бол Багш нь өөрийгөө хэн болохыг ойлгооч гэж урьж байна. Гэхдээ аяган дахь хэдэн зүсэм махаа дүүфүүгээр солих шаардлагатай болно. Тун хялбархан, тийм байгаа биз? Амьтны цустай махыг идвэл хожим “цусыг цусаар төлөх” ёстой болно. Хүн бүхэн эрхэм сайн хүмүүс биеэ яаж авч явж, яаж амьдардгийг мэддэг. Бид бусдад махаа огтлуулж, арьсаа хуулуулахыг хүсэхгүй бөгөөд өвдөж шаналахыг мэддэг мөртлөө яагаад бусад төрөлтний махыг огтлож, арьсыг нь өвчинө вэ? Амьтад зовдог гэдгийг мэддэггүй бол бас яахав, гэхдээ та нар мэддэг! Тийм биз?

Авшиг хүртсэний дараа сүнс тань аяндаа тайвшрах бөгөөд хамаг өрөөсгөл үзэл, энэ ертөнцөөс сурсан бүх зүйлийг мартаж болно. Ингэснээр маш гайхалтай зүйлсийг хийж чадахаа өөрөө мэдрэх болно. Багш нь та нарыг авран тусалдаг гэж битгий бод, үнэндээ та нар өөрөө өөрийгөө авардаг. Жишээлбэл, ямар нэгэн осолд орох буюу асуудал тулгарвал: “Багш аа, намайг авраарай!” гэж хашгирдаг, тэгээд та аврагддаг, тийм үү, үгүй юу? Багш аварлаа гэж та нар боддог, үнэндээ өөрөө өөрийгөө аварсан байдаг.

Та нар гэгээн саруул билиг ухаанаа дуудан сэрээж, өөрсдөдөө үйлчлүүлжээ. Багшдаа хандан залбирах үед Багш нь таны агуу мэргэн билиг ухаантай агшин зуурт холбогддог тул залбирал чинь таны билиг ухааны эх сурвалжаас дэмжлэг авч чаддаг. Бид материаллаг ертөнцөд амьдардаг учраас энэ дэлхий болон билиг ухааны эх үүсвэр хоёрыг холбох гүүр хэрэгтэй. Орчлон ертөнцийн агуу их билиг ухаан нь заавал

биет зүйлээр дамжиж байж л хамаг төрөлтөнд тусалж чаддаг. Зарим хүн энэ биет зүйлийг “Амьд сэрүүн Их Багш” гэж нэрлэдэг юм.

Багш нь энэ бүхнийг ганцаараа хийдэг юм биш, харин бүгдээрээ хамтран ажиллаж байгаа юм. Учир нь хамаг оршихуй нэг цогц билээ. Багшаасаа тусламж гуйх үед үнэндээ билиг ухаанаа гуйн ажиллуулж байгаа хэрэг юм. Өөрсдийнхөө Бурхан чанарыг гуйж ажиллуулж байгаагаас биш, харин гар, хөл, эсвэл эгэл ертөнцөөс сурсан өрөөсгөл үзэлдээ найдан ажиллуулдаг юм биш. Ийм учраас билиг ухаан маань бидний үйлдлийг шууд удирдан чиглүүлдэг. Энэ бол толгой тархины төсөөлөл болон үг хэлний илэрхийллийн цар хүрээнээс хэтийдсэн сэтгэгдэшгүй гайхамшиг билээ.

Хэрвээ толгойгоороо зогсон тоолшгүй олон галавын турш энэ агуу их билиг ухааныг сайшаан магтаж чаддагсан бол Багш нь гарцаагүй тэгнэ. Гэсэн хэдий ч хүн төрөлхтөний ядмаг үг хэлээр хангалттай илэрхийлэх боломжгүй. Багш нь орчлон ертөнцийн агуу билиг ухааныг дүрслэн илтгэе гэвч чадвар мөхөсдөж, үнэн бодитоор оршин байгааг нь та нарт яаж тодорхой ойлгуулахаа мэддэггүй.

Энэ асар их билиг ухааныг Будда, Бодьсадва, эсвэл Диваажин гэж нэрлэдэг. Өөрөөр хэлбэл бидний дотоодод оршдог Эзэн Бурхан мөн юм. Түүнийг яаж ашиглахаа мэддэг л бол хэзээ ч ашиглаж болно. Авшиг хүртээх үед хэрхэн ашиглахыг нь Багш нь заах бөгөөд үүнд үг хэлийг хэрэглэдэггүй. Гадна талын хэлбэр шаардлагагүй. Багш нь үг хэлэхийнхээ зэрэгцээ авшиг хүртээж болох хэдий ч та нарын анхаарал заавал төвлөрч байвал л сая авшиг авч чадна. Тиймээс авшиг хүртээх үеэр Багш нь үг ярьдаггүй. Хүний амьдралын зорилго бол амьд Будда болох явдал

Ер нь хоосон ярианаас үнэн үг дээр байдаг. Энэ хорвоод амьдрах нь яг л тамын оронд байгаа шиг дэндүү

их зовлон зүдгүүртэй гэж үздэг бол энэ дэлхийг бид бушуу түргэн диваажин болгон хувиргая! Ядаж л өөрийн оршин суугаа ертөнц, амьдралын орчноо өөрчилж, бидэнтэй холбоотой хэсэгхэн газрыг диваажин болгон хувиргаж чадвал ингэтлээ аз жаргалгүй санагдахаа болих бөгөөд амь насны үнэ цэнийг аажмаар ойлгох болно.

Бид энэ дэлхийд ирэхдээ зүгээр л сургуульд сууна, ажиллана, дараа нь эхнэр, хүүхдээ тэжээх гэж гав, дөнгө зүүсэн мэт хүлэгдэхийн төлөө биш, сэтгэлээр унан эцэж туйлдан орондоо ордог байх гэж төрөөгүй. Энэ бол хүн байхын утга учир биш! Хүн байхын жинхэнэ утга учир бол амьд Будда болох явдал юм. Хүн бүр амьд Будда мөн гэдгийг та нар яагаад ойлгохгүй байна вэ?

Та бүхэнд Багшаасаа ялгараад байх зүйл байхгүй. Арьяабалын аргаар бясалгахаараа миний хийж чаддаг зүйлийг та нар ч бас хийж чадна. Бясалгал хийх нь нэг төрлийн шинжлэх ухааны мэргэжлийг судлахтай адил хэн ч бай хичээнгүйлэн суралцдаг л юм бол шалгалтыг давж чадна. Дүн нь тийм сайн биш байсан ч ядаж тэнцэж чадна. Бүтэлгүйтсэн ч сураагүй хүмүүсээс илүү мэдлэгтэй байх болно. Ойлгож байна уу? (Бүгд алга ташив.)

За, одоо Багш нь та бүгдийг Арьяабалын бясалгалын аргыг сур гэж урьж байна. Эрт дээр үед мөр ёсыг хайгчид Төгс Гэгээрсэн Их Багшийг эрэхийн тулд заавал уул давж, ус гатлах хэрэгтэй байж. Төгс Гэгээрсэн Их Багшаа хайж олсны дараа бас Багшийгаа хүндлэн дээдэлж, Багш нь гурав, дөрвөн жилийн турш ажил хийлгэж байж л сая авшиг хүртээж, ном уламжилдаг байжээ. Заримдаа Багш нь бас шавийнхаа авшиг хүртэх эрхтэй эсэхийг туршин шалгадаг байжээ. Одооны нөхцөл байдал харин эсрэгээрээ, Багш нь та нарт саймширч, сурах хүсэл байна уу гэж асууж байна. Өөрийнхөө төлөө, амьдралаа улам аз жаргалтай болгохын төлөө Арьяабалын аргыг заавал сураарай!



ХОРСОЛ ЗАНАЛЫГ ХАЙРААР АРИЛГАХУЙ

*Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Амеркийн Калифорни мужийн Сан Диего хот
1991оны 3 дугаар сарын 23 (Эх нь вьетнам хэлээр)*

*※ Хүн бүхэн дайсандаа хайраар хандвал аливаа хорсол
заналыг арилгаж чадах бөгөөд ингэснээр тэд бүр ч түргэн
дэвшиж, сүнс нь хурдан сэрэх болно.*

Ном тайлахаас өмнө та бүхэн маань эхлээд нүдээ аньж, Багштайгаа хамт хэдэн минут залбиран даатгаж, энэ ертөнц дэх хамгаас золгүй хүмүүст, тэр дундаа вьетнамчуудад сэтгэлийн амар амгаланг ерөөе! Та бүхэнд баярлалаа!

Та бүхэн маань номын хуралд морилон саатсанд баярлалаа! Та нар бүгдээрээ амьд сэрүүн бурхан мөн, ирээдүйн бурхан мөн - одоо ч гэсэн бурхан, гэхдээ өөрсдийгөө бурхан гэдгээ хараахан мэдээгүй хүмүүс их байна, тиймээс ирээдүйн бурхан гэж хэлдэг. Хүн бүхэн Шагжамуни Бурхантай адил бөгөөд Багштайгаа ч бас адилхан. Ихэнх хүн ердөө амьдралаа залгуулж, ертөнцийн

мэдлэгийг хуримтуулах гээд цаг завгүй, эгэл ертөнцийн үзэл бодол болон ажил төрөлд хүлэгдэн өөрсдийнхөө агуу гэдгээ мартчихсан байдаг гэж Багш нь урьд өөр газруудад ном тайлахдаа ярьсан. Арьяабалын бясалгалын арга нь арван зүг, гурван цагийн бурхдын гайхалтай нууцлаг хүчийг ашиглаж, хоромхон зуур өөрийн тань дотор угаас мөнхөд оршин байдаг гэрэл гялбаат билиг ухааныг та нарт шинээр таниулдаг юм.

Дайснаа хайрлаж, дотно найз бололцохуй

Энэ удаа Багш нь Америкт олон хоног байжээ, бараг сар гаруй болчихлоо. Энэ хугацаанд би олон газар очиж, ном тайлсан бөгөөд Багшийг нь эрж ирсэн хүмүүс ч их байлаа. Зарим нь найрсгаар харилцах, зарим нь нөхөрсөг сэтгэлээ илэрхийлэхээр иржээ. Үүнд Вьетнамын нэр хүндтэй шашны урсгалынхан, итгэл хүндтэй гэгээнтэн лам нар, судар номд нэвтэрсэн гэрээс гарагч нар Багштай нь уулзаж, бясалгалын тухай туршлагаа солилцсон нь “сэтгэлээрээ холбоотой”, бүгдээрээ угаас дотно найз болохыг гэрчилж байна.

Үүнээс гадна, бас улс төр, нийгэм, шашны бүлгэмийн хүмүүс ирж Багштай нь уулзсан нь намайг тун баярлуулсан. Бясалгалчдын хооронд, ядаж л вьетнамчуудын янз бүрийн бүлгэмийн хооронд нэгэнт эе эвийн найрсаг уур амьсгалын нахиа гөлөглөсөн байна, үүнийгээ үргэлжлүүлэн арчилж тордвол хожим лавтай бүдүүн мод болж ургана. Ингэснээр хамаг төрөлтөнд ач тус хүртээж, бүх дэлхийд үлгэр жишээ болно. Иймийн учир Багш нь тун баярлаж байна, маш олон шавьтай болсноос ч илүү баярлаж байна.

Шавь нар угаас Багштайгаа хувь барилдлагатай, төрөл төрөлдөө нэгэнт бясалгачихсан болохоор Багшийгаа ярмагц даруй ойлгодог. Гэтэл Багштай нь уулзахаар ирсэн тэр хүмүүс уул нь ондоо бясалгалын замыг сонгож, ондоо шашныг шүтсэн байтлаа харин Багшийг нь гадуурхахгүй, эе эвээр найрсаг харилцах болсон нь ховорхон тохиолдох

нэр төрийн хэрэг тул Багш нь энэ хэдэн хоногт тун баяртай байна. Мэдээжээр, тэдний зарим нь орчлонгийн бүх оршихуй нэг цогц болох зүй тогтолцоог хараахан ойлгоогүй, хамаг төрөлтөн цөм бурхан чанартай гэдгийг ойлгоогүй болохоор санал зөрөлдөөн үүсэх нь зайлшгүй. Ямар хүнээс болгоомжлох хэрэгтэй, ямар ямар бүлгэмээс болгоомжлох нь дээр шүү гэж зарим хүн Багшид нь сануулж байсан, тэгэхэд би : “Юунд нь болгоомжлох юм бэ?” гэхэд тэд “Энэ хүмүүс Багшийг ашиглаж муу хэрэг үйлдэнэ шүү!” гэж хэлсэн. Би: “Ашиглаж болмоор зүйл юу байна?” гэсэн. Багшид нь бусад хүн ашиглаж болмоор чадвар байхгүй. Гэхдээ энэ ертөнцөд амжилтад хүрч, нэрд гаръя гэвэл заавал тийм буян заяатай байх хэрэгтэй. Шашин, улс төр, нийгмийн аль ч салбарт ч адилхан, ач буян байхаас гадна бас бүтээгчийн зөвшөөрөл байх хэрэгтэй.

Тэр муу хэрэг үйлдэгсэд бүтээгчийн зөвшөөрөлгүйгээр үйлдсэн гэж та нар үзэж болохгүй! Аливаа бүхнийг бүгд л бүтээгч зохицуулж байгаа билээ. Гэтэл яагаад муу хэрэг үйлдэхийг бүтээгч зөвшөөрдөг вэ? гэвэл энэ төрөлдөө бусдад алуулсан хүн урьд нь муу хэрэг үйлдсэн болохоор үйл үрийн хууль нь түүнд хорлогдсон тэр хүмүүст энэ төрөлдөө өш хонзонгоо авахыг зөвшөөрч, занал хорслын хүслийг нь хангадаг. Жишээлбэл, зарим амьтан энэ төрөлдөө хөнөөгдөж, хор хөнөөл амсагч болдог, үнэндээ тэд урьд төрөлдөө яргачин байсан болохоор одоо амьтан болж, арьсаа хуулуулж, махаа идүүлж, урьд төрлийн үйл түйтгэрээ төлж байгаа билээ.

Хэрвээ тэр амьтдыг уучлан өршөөж, залхаан шийтгэхгүй, харин хайраар нигүүлсвэл, тэдний хувьсал түргэн байх бөгөөд тэд маш баярлаж, дахин зовлон амсахгүй болно. Дайсан этгээдээ хайрлаж, аливаа занал хорслыг арилгавал тэд түргэнээр дэвшиж, сүнс нь бүр ч түргэн сэрэх болно. Тиймээс өс хонзон нэхэх хоёр төрлийн аргаас сонголт хийж болно: нэг төрөл нь ачийг ачаар, өсийг

өсөөр хариулах, нөгөө нэг төрөл нь бүр ч дээд зэргийн, бүр ч үүрдийн арга - дайснаа хайрлаж, дотно найз бололцох явдал юм. Өстөн дайсан алга болж, өс хонзон нэхэх хүн дахин биднийг эрж хайхаа болино. Ямар ч өвчнийг бүгдийг эдгээдэг нэг зүйлийн эм бий. Тэр бол Эзэн Бурханы Хайр мөн. Арьяабалын бясалгалын аргын хүчээр, орчлонгийн цаглашгүй хайраар ял гэмтэй, эсвэл ариун цайлган ялгалгүй бүгдийг авран тусалдаг.

Сэтгэлийн амар амгалангийн өглөг

Гэгээнтэн лам нар, өөр бусад шашны урсгалын бясалгагч нар Багштай нь уулзахаар ирэх буюу тэд Багшийг нь урих үед үргэлж “сайн санаат хүмүүс” гарч ирж, “Багш аа! Битгий очоорой! Тэр хүмүүстэй битгий харилц, Багшийн нэр төрийг барагдуулна, тэд цөм асуудалтай, өөр бүлгэмээс хөөгдсөн хүмүүс шүү” гэж ярьдаг. Тэгэхэд би: “Багш нь бясалгалтан хүн, бусдын хог новшийг харах дургүй, зөвхөн гэрэл гялбаатай, эрхэм дээд, нигүүлсэнгүй бурхан чанарыг нь л хардаг” гэж хариулдаг. (Бүгд алга ташив.)

Ингэх нь сая зүй ёстой бөгөөд цэцэн мэргэн хэрэг, бид бусадтай уулзахдаа гэрийнх нь хогийн савыг л үнэрлэвэл мэдээж өмхий үнэр үнэртэнэ. Хог новшийг нь хараад л байвал гоо сайхны мэдрэмжээ алдаж, өөрийгөө өмхий, бохир, муухай болгоно. Тэгэхийн оронд яагаад зочдын өрөөн дэх бурхны хөрөг, богд гэгээнтнүүдийн хөрөг, загалмай модыг нь харж болохгүй гэж? Бид эрхэм дээд, гоё сайхан, гэрэл гэгээтэй, яруу алдрын бэлгэдэлтэй орныг харах нь зүйтэй. Хог новшгүй гэр гэж байх уу? Ер нь хогийн сав руу өнгийж, өмхий үнэр үнэрлэсэн нь өөрийн чинь буруу, хэрвээ хогийн савыг нь хормойлоод гэртээ авчирвал, уучлаарай, энэ бол үнэхээр өөрийн тань буруу! (Бүгд алга ташив.)

Хүмүүс сайхан сэтгэлээр биднийг хүндэт зочин хэмээн хоймортоо залж, чин сэтгэлээсээ хаалган дээрээ халуунаар угтаж байгаа. Гэхдээ хүмүүс хоорондоо угаас

нэг нэгнийгээ зочин мэт хүндэлж, харилцан шилдэг талаа харвал зүйтэй, ингэвэл хоёр этгээдийн шилдэг тал уусан нэгдэж, нэг нэгэндээ тусалж, хамтаар дэвшиж чадна. Нөгөө этгээдийнхээ шилдэг талд урам хайрлавал тэд тэр талаараа хөгжин дэвших болно. Ер нь бусдын новшийг үнэрлэвэл мэдээж өмхий үнэр үнэртэх болно. Гэрийн эзэн дахин урихаа больж, үнэт эрдэнэсээ харуулах хүсэлгүй болно. Бид хүндэт зочин больё гэвэл эрхбиш гэрийн эзнийг хүндэлбэл сая түүний хүндэтгэлийг олж чадна.

Хүн болгон бүгд л бурхан, Эзэн Бурхан мөн. Хэрвээ өөрийн найзаа дэвшүүлэх гэвэл дутагдлыг нь харах биш, ямагт эрхэм дээд бурхан чанарыг нь хараарай. Энэ бол өрөөл бусдыг энэ ертөнцийн амжилтад хүргэх цорын ганц нууц жор мөн гэдгийг санаж яваарай! Бусдад нөхөрсөг сэтгэлээр тааруухан гэж санагддаг тэр хүмүүс Багшид нь яагаад тийм сайн ханддаг, эрхэм дээд байдаг вэ? гэвэл Багш нь зөвхөн тэдний шилдэг талыг л харж, эрхэм дээд зан чанарыг нь дуудан сэрээдэг, харин хувийн муу зан араншинг нь сэрээдэггүйгээс тэр.

Тэр хүмүүс яагаад бусдад тийм болхидуу хандаж, тэдэнтэй өрсөлдөхийг боддог вэ? гэвэл шүүмжлэл хүмүүсийн өрсөлдөх чанарыг дуудан сэрээдэг. Та нар тодорхой харсан уу? Багш нь улс төрийн хэрэгт оролцдоггүй, ерөнхийлөгч, УИХ-ын гишүүний байр суурийн төлөө хэн нэгэнтэй өрсөлдөх тухай мэддэг ч үгүй. Тиймээс тэд Багшийг нь өрсөлдөөнд оролцож, тэднийг ялахаас айдаггүй. Үүний эсрэгээр тэд ажлаа сайн хийвэл Багш нь чин сэтгэлээсээ, нөхцөл болзолгүйгээр дэмжихийг тэд мэддэг. Тиймээс тэд Багшид нь тун дуртай бөгөөд айдаггүй, энэ бол сэтгэлийн амар амгалангийн өглөг болно. Ойлгож байна уу?

Бид Арьяабал Бурхан шиг хамаг төрөлтөнд амар амгалангийн өглөг үйлдвэл зүйтэй. Юуг амар амгалангийн өглөг гэдэг вэ? гэвэл хэн ч бай, бидний энд ирвэл сэтгэлийг нь засаж, урам хайрлаж, амар амгалан болгоно, харин эмээх

бодол төрүүлэх биш. Зарим хүн Багшийг нь харвал дагжин чичирдэг гэж хэлдэг боловч миний бодлоор надаас айсандаа биш, ихэнх нь өөрсдөө буруу хэрэг хийсэн гэж боддогоос болжээ. Зөв замд хараахан гараагүй, нинжин сэтгэл нь өөрийгөө зэмлэдэг болохоор дагжин чичирдэг, харин Багш нь ширүүн зантайгаас болсон юм биш.

Багшид нь хүч байдаг хэдий ч бусдыг зодож загнах, айлган сүрдүүлэх мэтийн эгэл хүний хүч байхгүй. Багшийн хүч бол нэг зүйлийн оюун санааны хүч мөн, ял гэмтэй, эсвэл ёс суртахуунтай гэж ялгалгүй хайраараа хүн бүхнийг уучлан багтаадаг. Та нар ч гэсэн Багш шигээ байх хэрэгтэй. Хаалгыг чинь тогшсон хүн болгон Эзэн Бурхан, Будда хэмээн хүндлэн дээдэлбэл, тэд Эзэн Бурхан, Будда болно. Үргэлж ийм итгэл бишрэл өвөрлөвөл зөвхөн Багш нь л Бурханы хутгийг олсон төдий биш, хүн бүхэн бүгд л Бурханы дэст хүрэх болно.

Буддын шашинд: “Яргачны хутгаа таягдан хаявал даруй Бурхан болно” гэдэг үг байдаг. Тиймээс та нар Арьяабалын бясалгалын арга хүмүүсийг энэ төрөлдөө туулан гэтэлхэд хүргэж чадна гэдэгт эргэлзэн сэжиглэхгүй байвал зохино. Багш нь зөвхөн энэ төрөлдөө туулан гэтэлнэ гэж ярьсан төдий байхад ихэд шүүжлүүлсэн, хэрвээ “Яргачны хутгаа таягдан хаявал даруй Бурхан болно” гэж яривал ямар их шуугиан дэгдэх бол? Арьяабалын бясалгалын аргаар бясалгавал энэ төрөлдөө туулан гэтэлж чаддаг боловч юу ч хийхгүйгээр гэтэлчихдэг юм бас биш. Харин бас ургамал хоол идэх, сахил сахих, бясалгаж суух, нийтийн бясалгалд оролцох, Багшийн заавар, номын ах нар болон ахмад бясалгагчдын заавар жолоодлогыг дагах гэх мэт зүйл байх хэрэгтэй. Гэхдээ бясалгал хийхэд зэрэг дэс, насны ангиллын ялгаа байдаг биш, харин бясалгалын эдгээр шаардлагыг дамжиж байж л сая энэ төрөлдөө туулан гэтэлж чадна.

※ *Хаалгыг чинь тогшсон бүхнийг Эзэн Бурхан, Будда хэмээн хүндлэн дээдэл.*

Жинхэнэ гэрээс гарагч

Бясалгал хийхэд бас дөт замаар явж болно, яг л энэ дэлхийд байхдаа нарийн бичиг болоход ердөө нэг хоёр жилийн хугацаагаар суралцах хэрэгтэй байдагтай адил. Гэхдээ түргэн сурч дуусгах ангид сурч болно. Аялал жуулчлалын үед машин, галт тэрэг, усан онгоцонд суувал нилээд удаан, нисэх онгоцонд суувал харин нилээд түргэн. Гэтэл онгоцны тасалбар тун үнэтэй, хэрвээ худалдан авах мөнгөтэй бол онгоцонд суувал нилээд түргэн зорьсон газартаа хүрч чадна. Та нар хоёр, гурван мянган жил, эсвэл дөрөв, таван мянган жилээр хүлээж байж л сая туулан гэтлээ гэвэл алгуураар бясалгаж болно. Сард хоёр хоног ургамал хоол идэх, эсвэл нэг жилдээ хагас өдөр ургамал хоол идвэл тоолшгүй олон жилийн дараа лавтай Бурханы хутагт хүрэх болно. Бурхан болохгүй хүн гэж байдаггүй, асуудал нь хичнээн жил хүлээх бол, хэзээ чухам Бурханы хутагт хүрэх бол гэдэгт л байгаа.

Энд ирэхээс өмнө Багш нь үнэндээ юу яривал зүйтэй вэ? гэдгээ мэдэхгүй байсан. Гэтэл та нартай уулзмагц дотоодын эрхэм дээд бурхан чанар чинь илрэн Багшийг нь адисалснаар, та нарын юу сонсохыг хүсэж байгааг мэдчихжээ. Багшийнх нь ярьдаг нь зөвхөн та нарын дотоодын хүсэл мөрөөдлийг чинь тусгаж байгаа хэрэг юм. Би бол зөвхөн радиогийн үүргийг гүйцэтгэж байгаа төдий. Орчлон ертөнц болон хамаг төрөлтний охь шимийг шингээн авсны дараа гадагшаа нэвтрүүлж, хүмүүст сонсож байгаа болохоор ач гавьяа гэмээр зүйл байхгүй. Багш нь радиотой адил. Радио өөрөө сэтгэл уярам хөгжим бүтээж чаддаггүй. Заавал эхлээд дуучин дуулсны дараа радио хорооноос дууны долгион цацдаг. Радио бол зөвхөн дууг нэвтрүүлдэг төхөөрөмж төдий билээ. Тиймээс өнөөдөр та нар Багшийнхаа ном тайлахыг сонсож байгаа нь үнэндээ өөрсдийнхөө дотоодын аялгууг сонсож байгаа хэрэг юм.

Та нарын сонссон, ойлгосон хэмжээ бол билиг ухааны чинь нээгдсэн хэмжээ болно. Хэрвээ ойлгоогүй байвал өөрсдөө өөр явдлыг бодож байсан, эсвэл дэсээр нилээд доор байгаа гэдгээ мэдэж болно. Багшийнх нь ярьсан агуулга зөв эсэх нь гол биш. Харин та нарын хүсэл эрмэлзэл болон санаа бодлын саруул уудмын хэмжээ чинь ямар агуулга сонссон, эсвэл хичнээнийг шингээж чадсан гэдгийг тогтооно. Багшийнхаа ном тайлахыг хэдэн цагаар сонссон байтлаа зөвхөн ганц, хоёрхон өөрийн дуртай үгийг л санадаг хүмүүс их байдаг. Тэгээд Багш маань зөвхөн нийтэд л хандаж ярьсан байна гэж бодон тун жаргалтай санагддаг, (Багш инээв) тийм үү, үгүй юу? (Бүгд инээлдэхийн зэрэгцээ алга ташив.)

Багш та яагаад өөрийгөө Төгс Гэгээрсэн Их Багш гэж нэрлэдэг юм бэ? гэж олон хүн надаас асуухад Багш нь: “Төгс Гэгээрсэн Их Багш (хятдаар 无上□ гэдэг) гэдэг нь намхан биетэй багш гэсэн үг (Багш инээв). Учир нь “无” гэдэг нь биш, “上” гэдэг нь өндөр гэсэн үг. “□” гэдэг нь Багш гэсэн утгатай, тиймээс “无上□” (Төгс Гэгээрсэн Их Багш) гэдэг нь “Өндөр биш Багш” гэсэн үг мөн. Багшийн чинь биеийн өндөр зөвхөн зуун тавин сантиметр болохоор “无上□” гэж нэрлэгдэх нь бас зөв юм байна. Багш нь Вьетнамчуудын дунд намхан биетэй хүнд тооцогдоно, тийм биз дээ? Вьетнамчуудын ихэнх нь Багш шиг нь ийм намхан нуруутай юу? Тиймээс та нар “Намхан нуруутай Багш” буюу “Тийм ч өндөр биш Багш” гэж дуудвал бүгд зөв.

“Багшаас өндөр зүйл өөр байхгүй” гэсэн утга нь ч бас зөв. Яагаад вэ? гэвэл миний сэтгэл нэгэнт Бурханы дэст хүрсэн болохоор хэн надаас дээр байх вэ? (Бүгд инээлдэхийн зэрэгцээ алга ташив.) Бид мөр ёсыг таньж, өөрсдийнхөө бурхан чанараа мэдэх үедээ хамаг төрөлтөн бүгд л бурхан мөн гэдгийг ойлгодог. Энэ нь бардамнамаар хэрэг биш, тиймээс “Төгс Гэгээрсэн Их Багш”, эсвэл “Төгс Гэгээрээгүй Их Багш” гэж дуудах нь бүгд адилхан. Ертөнцийн үг хэлээр дүрслэн илтгэхийн аргагүй болохоор бүр ч сайн нэршил

байдаггүй нь харамсмаар юм шүү! (*Бүгд алга ташив*).

Хүмүүс ердөө ямар нэгэн хэлбэр дүрсэнд баригддаг бөгөөд иймэрхүү тогтсон үзэл бодлоор бусдыг магадлан тогтоодог. Гэхдээ өнгөн талын нөхцөл байдалд баригдснаар үнэн ёсыг хайж олохгүй. Хүмүүс сэтгэлдээ эхлээд нэгэн бурхны хөрөг зургийг урлан зурж, бурхан бол ийм дүр төрхтэй, гэрээс гарагчид тийм байдалтай байж таарна гэж үздэг. Тиймээс зарим их багш хүмүүсийн тогтсон үзэл бодлыг эвдэхийн тулд энгийн хүмүүстэй адилгүй ер бусын зүйл хийдэг. Жишээлбэл, Жи Гон хувраг угаас архи уудаггүй, мах иддэггүй боловч архи ууж, мах иддэг маяг гаргадгийн зорилго нь архи ууж, мах иддэг тэр хүмүүсийн огоорч чаддаггүй, хүлэгдэж байгаа сэтгэлийг шоглохын төлөө байжээ.

Бурханы хутгийг олсон хүмүүс угаас гадна төрхөд баригддаггүй, гэтэл зарим хүн юу ч ойлгодоггүй хэр нь бусдын гаднах төрхийг л хардаг. Үс нь урт, эсвэл богино, хувцасных нь ханцуй элбэг, эсвэл нарийн, яагаад европ хувцас өмсөв, гэрээс гарагчийн хувцас өмсөөгүй байна гэдгийг л анхаардаг. Тэр ч байтугай зарим хүн: энэ хүн багш болж тэнцэхгүй, орхимжоо тайлах хэрэгтэй, тэр хүн сая багш болж орхимж өмсөх ёстой гэж хэлдэг. Хэрвээ орхимж өмсөхөөр л багш болчихдог бол дэндүү хялбар хэрэг болчихно шүү!

Ямар хүмүүсийг гэрээс гарагч гэдэг вэ? гэвэл нэгэнт гурван ертөнцийг даван туулж, ховдог шунал, уур хилэн, мунхаглалаа эрхшээж, хийхгүйгээр хийх түвшинд хүрвэл л сая гэрээс гарагчид тооцогдоно. Бүхий л орчлонг авран туслах нь түүний хувьд яг л гараа угаах шиг энгийн байдаг. Тийм хүн бол жинхэнэ гэрээс гарагч мөн. Жинхэнэ гэрээс гарагч ямар хувцас өмссөн ч гэрээс гарч чаддаг, хаа ч байсан сүм хийд мөн. Будда болон Эзэн Бурхантай ямагт найзалдаг. Тийм хүн бол жинхэнэ гэрээс гарагч мөн. Гэрээс гарагч мөн эсэхийг магадлан тогтооход хувцас засал, үйл

ажиллагаа буюу уламжлалт зан заншил болон Их Багшаа залгамжилсан эсэх зэргээр баримжаалж болохгүй.

Ихэд билиг нээгдсэн хүмүүсийн хүнийг гэтэлгэх арга барил

Шагжамуни Бурхан гэрээс гарч бясалгал хийсний дараа сүм хийдэд суугаагүй, тэрээр өдөр бүр олон газарт очиж бадарладаг байжээ. Бурхан Багш бадарладаг нь ядуудаа биш, харин хамаг төрөлтнийг гэтэлгэхийн төлөө юм. Бурхан Багш бол хаан хүү, угаас ирээдүйн хаан мөн. Хаан суудлаа орхиж, гэрээс гарлаа ч гэсэн хааны угсааныхан түүнийг эд зүйлсээр элбэг хангана, гэтэл Бурхан Багш бадарлах замыг сонгожээ - тухайн үеийн гэрээс гарагчдын уламжлал нь бадарлах байв. Гэрээс гарагч хүн олон газраар бадарчилж, өглөгийн эздийн гэрт хоног төөрүүлэх бөгөөд хажуугаар нь тэдэнд үнэн ёсыг ярьж, ном дэлгэрүүлж, барилдлага үүсгэдэг. Өглөгийн эзэд багахан цагаан будаа өгсний хариуд Бурхан Багш харин цаглашгүй номын өглөг өгч, хүмүүсийг төрөл төрөлд нь амар амгалан, аз жаргалтай болгодог байжээ.

Библи сударт бас: Есүс Христ нэг удаа ам цангахаар нь худгаас ус татаж байсан нэгэн бүсгүйн дэргэд очиж ус гуйжээ. Тэгэхэд өнөө бүсгүй: “Та яагаад надаас ус гуйна вэ? Бид хоёр нэг овогт хүн биш шүү!” гэж хэлжээ (тухайн үед хоёр өөр овогтон хоорондоо харилцдаггүй байжээ). “Би танай усыг уусны хариуд хожим чамд рашаан ус уулгана, ингэснаар төрөл төрөлдөө үүрд ундаасахгүй болно” гэж Есүс Хрис хариулжээ. Энэ бол ихээр билиг нээгдэгсдийн хүнийг гэтэлгэх арга барил юм.

Шагжамуни Бурхан бадарлах аргаар барилдлага үүсгэж, гэтэлгэдэг. Эрт дээр үед зам харилцаа тун хүндрэлтэй. Шагжамуни Бурхан дандаа нэг тогтсон орондоо бясалган суугаад хүмүүс уулзахаар ирэхийг хүлээвэл ном уламжлахад тун бэрх болно. Өнөө цаг бол нэг

хүн мэдвэл зуун хүн, мянган хүнд дамжаад мэдчихнэ. Эрт дээр үеэр ном дэлгэрүүлэх нь одоогийнх шиг ийм хялбар дөхөм биш байсан. Тиймээс Бурхан Багш заавал өөрийгөө золиосолж, зовлон зүдгүүр амсан олон орноор бадарлаж, хамаг төрөлтөнд түүнтэй уулзах аз завшаан олгох хэрэгтэй байжээ.

Хамаг төрөлтөн Шагжамуни Бурханыг харвал өөрсдийн бурхан чанараа харах боломжтой болдог. Яг л хараахан асаагүй галт бамбар шиг, хэрвээ асаж байгаа галд хүрэлцвэл удалгүй хоёулаа адилхан асна, ойлгож байна уу? (Бүгд алга ташив), Бурхан Бодьсадваг хармагц цаглашгүй ач буян хураадаг болохоор Шагжамуни Бурхан зовлон зүдгүүрээс халшралгүй, бадарлаж байжээ.

Бурхан Багш бадарчилсан нь ядуу хоосон, идэж өмсөх нь хангалтгүйдээ биш бөгөөд нийгэмд дараас болох гэсэн юм биш. Түүний төрөл төрөлдөө бясалгасан ач буян хэрэглээд дуусашгүй, материалаг эд хөрөнгийн талаар ч гэсэн хичнээнийг хүснэ, түүнийгээ олдог. Гэхдээ нэгэнт Бурханы хутгийг олсон болохоор ийм зүйлсэд шунах ёсгүй, зөвхөн нөхцөл боломж, хувь барилдлагын дагуу хамаг төрөлтөнд тусалдаг.

Хамаг төрөлтний хувьд хамгийн дээд ач тус гэж бурхныг шүтэн тахиж, буян хураахыг хэлдэг биш. Харин Бурханыг өөрийг нь харах явдал юм. Ялгаварлах сэтгэлгүйгээр бурханд мөргөдөг, диваажингаас болон бусдаас буян эрдэггүй тэр хүмүүс эсрэгээрээ цаглашгүй буян хураадаг. Зарим өглөг үйлдэгч ганц мөхлөг будаа, ганц жигнэмэг өргөхдөө ач хариу хүсдэг. Гэхдээ Бурхан бодьсадва цаглашгүй ач буян өгч чаддагийг тэд ойлгодоггүй, эсрэгээрээ харин хүн болон тэнгэрийн мөнх бус буянд шунадаг. Энэ нь үнэхээр харамсмаар!

Тиймээс Багш нь та нарын бэлгийг авдаггүй, хүмүүсийн өргөл барьцыг авдаггүй юм. Та нар чин сэтгэлээсээ, хувийн хүсэл шуналгүй, нөхцөл болзолгүй

өргөл өргөвөл Багш нь мэдээж дуртайяа хүлээн авна. Багш нь хааяа зарим авшигтны чин сэтгэлийн тахилыг хүлээн авдаг. Гэтэл зарим нь тахилынхаа хариуд Багшаасаа материалаг талын буян хураахын тулд харин хүчээр хүлээн авахуулж, тэдний үйлийн үрд хүчээр оролцуулахыг боддог. Ийм хүмүүс буянд шунахын үр дагавар - баян тансаг амьдралыг эдлэхийн төлөө заавал дахин буцан ирж, үхэж төрөхийн сансрын хүрдэнд эргэлдэх хэрэгтэй болно гэдгээ ойлгодоггүй. Тиймээс горьдлого шингэсэн ийм тахилыг Багш нь авдаггүй, ингэвэл та нар хожим бүр ч илүү зовлонд унахаас зайлсхийж чадах болно.

Энэ ертөнцөд амьдрахдаа, өөрийгөө угаас туулан гэтэлчихсэн гэдгээ ойлгодоггүй, хүлэгдэж баригдахгүй сэтгэлийн амар амгалангаа таньж чадахгүй бол байр сууриар хичнээн өндөр, эд хөрөнгөөр хичнээн баян тансаг байлаа ч төгс төгөлдөр баяр жаргалыг яасан ч олж чадахгүй.

Шагжамуни Бурхан олон орноор бадарчилж барилдлага үүсгэдэг нь хүмүүст хүн болон тэнгэрийн буян олгохын төлөө биш, харин үүнээс ондоо арга зам байгаагүйгээс болжээ. Энэтхэгийн газар нутаг өргөн уудам, машин унаа байгаагүй бөгөөд холбоо харилцаа хүндрэлтэй, Шагжамуни Бурхан ямар аргаар хамаг төрөлтөнд танигдах вэ? гэвэл зөвхөн бадарчлахаар дамжин харанхуй мунхаг хамаг төрөлтөнтэй барилдлага үүсгэж, өөрийгөө бурхан гэдгээ хараахан таниагүй тэр хүмүүстэй буянаа солилцох явдал байжээ.

Бурхан чанараа таньж, орчлон ертөнцийг өмчлөхүй

Будда энэ ертөнцөд ирдэг нь хүмүүсээр шүтэн дээдлүүлэхийн төлөө биш, Будда энэ ертөнцөд ирдэг нь хамаг төрөлтөнд бурхан сэтгэлийг нь ойлгуулахын төлөө билээ гэж Бурхан Багш ярьсан байдаг. Хамаг төрөлтөн

Бурханы сэтгэлийг ойлгоё гэвэл эрхбиш эхлээд бурхан болох хэрэгтэй, өөрсдийгөө бурхан мөн гэдгээ мэдэх хэрэгтэй. Есүс Христ ч гэсэн: “Миний хийж чадсан хэргийг та нар хожим бас хийж чадна” гэж ярьсан байдаг. Энэ нь хамаг төрөлтөн болон Есүс Христ яг адилхан гэдгийг илэрхийлж байна. Шагжамуни Бурхан: “Бурхан сэтгэл дотор бий” гэсэн, Есүс Христ харин: “Диваажин таны дотоодод бий” гэжээ. Тэгвэл энэ хоёр гэгээнтний ярьсан нь адилхан биш гэж үү? Зөвхөн илтгэсэн арга барил нь адилгүй байна. Яг л зарим хүн: ус бол маш сэрүүн тунгалаг, уухаар цангаа тайлдаг гэж хэлэхэд зарим нь: энэ бол ус мөн, умдааслыг дардаг гэж ярьдагтай адил. Үнэндээ адилхан зүйл ярьсан биш гэж үү? Үнэхээр тийм. Эзэн Бурханд итгэх, Буддад итгэх нь үнэндээ ямар ч ялгаагүй. Гэтэл Будда болон Эзэн Бурханыг ойлгохгүй бол тэднийг гүтгэж байгаа хэрэг, харанхуй мунхаг эгэл хүмүүсийн сэтгэлээр магадлан шүүж байгаа хэрэг болно.

Төгс Гэгээрсэн Их Багш энэ ертөнцөд ирдэг нь хүмүүсийн өргөл барьцыг эдлэн жаргаж цэнгэхийн төлөө биш юм. Гэхдээ бясалгагч хүн бясалгах тусам бага иддэг болдог бөгөөд заримдаа идэхгүй ч гэсэн өлсдөггүй. Төгс Гэгээрсэн Их Багшийн хувьд идсэн ч болно, идэхгүй байсан ч хамаагүй. Олон орноор явж ном дэлгэрүүлж байгаа учраас л сүсэгтнүүд хоол хүнсээр өргөл барьц өргөдөг болохоор идэхгүй бол тэдний урам хугардаг. Идсэний дараа заавал үргэлжлүүлэн идэх хэрэгтэй, харин өнөөдөр идэж, маргааш нь идэхгүй байж үл болно. Энэ эгэл ертөнцийн хууль гэж ийм юм хойно энд оршин амьдрахдаа заавал эндхийн хууль дүрмийг дагах хэрэгтэй, эсвэл ерөөс юу ч идэхгүй байх хэрэгтэй. Харин өнөөдөр жаахан хооллосноо маргааш нь дахин юу ч идэхгүй байж болохгүй, ингэх нь бие махбодод тун муу.

Бие махбод хооллох дадалтай болж, өдөр бүр шим тэжээл нөхөх дадал суусан бол тогтсон цагт түүнийгээ

хүлээдэг. Тиймээс Шагжамуни Бурхан өдөрт нэг удаа хооллодог нь энэ дадалд зохицохын төлөө байжээ. Гэхдээ заримдаа тэтгэх хүнгүй үед Бурхан Багш ой шугуйд очин хэдэн сараар ус ууж, адуу мал иддэг өвс идэн амиа аргацааж байсан ч ерөөс гомдоллоогүй.

Бодь мөрийг ологсод материаллаг зүйлсийн жаргалд ташуурдаггүй, зөвхөн ерөөл барилдлагыг дагадаг. Бодь мөрийг олоогүй хүмүүсийн хувьд материаллаг зүйлсийн жаргалыг маш чухалд үздэг. Тэд материаллаг зүйлийн жаргалын төлөө өдөр бүр найман цаг, арван цаг, хорин цагийн турш сэтгэл санаа, хүч чадлаа зориулдаг, энэ нь тун харамсмаар хэрэг билээ. Гэхдээ бас зүгээр дээ. Хүн болгон ингэж ажилладаг болохоор та нарыг ажиллуулахгүй байж үл болно, тиймээс үргэлжлүүлэн ажиллаж болно. Гэвч жаахан цаг зав гаргаж, өөрсдийгөө чухам хэн болохоо таних хэрэгтэй.

Өдөржингөө хоол хийнэ, ажиллана, хүүхдээ асарна, хань ижлээ баярлуулна гэх мэтээр завгүй байдаг болохоор амь насны эх үүсэл болон эцэс төгсгөлийн тухай эргэцүүлэн бодох зав байдаггүй. Өөрийгөө бурхан мөн гэдгээ мэддэггүй. Одоо Багш нь та нарт өөрийн бурхан чанараа яаж танихыг зааж өгөх болно. Бурхан чанар гэж юу вэ? гэвэл энэ нь нэг зүйлийн мөнхийн гэрэл гялбаат, цаглашгүй билиг ухаан юм. Түүнд хэлбэр дүрс байдаггүй бөгөөд ямар нэгэн ид шидийн хүч биш юм. Гэхдээ өөрийн бурхан чанараа танимагц аливаа бүхнийг олж, орчлон ертөнц бүхэлдээ биднийх болохыг мэддэг.

Эртнээс өнөө болтол байгаа бүхий л судар номд цөмд нь Буддаг сайшаан магтсан байдаг. Тэгвэл Будда чухам хаа байгаа вэ? гэвэл бидний сэтгэлд бий. Гэвч бид хайж олоогүй болохоор сая ийм зовуурьтай, өөрсдийгөө эгэл хүн гэж үздэг. Гэтэл Будда нээрэн бидний дотоодод байгаа билээ. Бурхан бол хамгаас эрхэм дээд, хамгаас сэтгэгдэшгүй гэж бид боддог, гэтэл тэр харин хамаг төрөлтний дотоодод

оршдог, хол биш. Одоо та нар өөрсдийгөө бурхан мөн гэдгийг ойлгов уу? (*Ойлгосон гэж нэг хүн хариулав*). Зарим хүн ойлгож байна, авшиг хүртээд нилээд удсан хүмүүс ойлгож байгаа. (*Бүгд алга ташив.*)

Гэхдээ зарим хүн бас л өөрийгөө бурхан мөн гэдгийг мэдээгүй байгаа нь нээрэн харамсмаар хэрэг! Хамаг төрөлтөн бүгд бурхан чанартай гэж хэлдэг хэдий ч тэд өөрсдөө оройн дээд билиг ухаантай гэдгээ мэддэггүй болохоор түүнийгээ ашиглахын аргагүй. Яг л мөнгөний авдарт нь зуу зуун тэрбум доллар хадгалаастай байхад харин мөнгөө гаргах зав ерөөс байхгүй, хэрэглэх тохиол бүр ч үгүй бол мөнгөгүйтэй адилхан.

Үүнтэй адилаар, хамаг төрөлтөн аугаа их бурхан чанартай, хамгийн дээд эрх мэдэлтэй, оройн дээд төгс төгөлдөр билиг ухаантай, дотооддоо эзэн бурхантай байдаг хэдий ч ихэнх хүн үүнийгээ анзаарах завгүй явдаг. Түүнийгээ ашиглах талаар бүр ч ярилтгүй. (*Бүгд алга ташив.*) Тиймээс хэн нэг нь Бурханы хутгийг олсон гэдгийг сонсохоор ихэд гайхан энэ тухай төсөөлөн бодож ч зүрхэлдэггүй бөгөөд зөвхөн Шагжамуни Будда л Бурханы хутагт хүрч чадна гэж үздэг. Шагжамуни чухам ямар хүн болчихов, бусдаас ямар онцгой талтай вэ? гэж та нар бодооч! Бусдыг тэгж ихээр бурханчлан шүтээд харин өөрийнхөө агуу ихээ мартчихаж болохгүй.

Шагжамуни Бурхан хамаг төрөлтнийг гэтэлгэхээр Тушита тэнгэрийн орноос бууж ирсэн гэдэг. Гэхдээ энэ нь бүгд л бусдаас сонссон төдийгөөс биш бид үнэн бодитоор хараагүй тул нотлон гэрчилсний дараа дахин итгэхэд оройтохгүй. Мухраар сүсэглэхээс зайлсхий, дам ярианд амархан итгэх хэрэггүй. Хэн ч бай, хичнээн өндөр алба тушаалтай, хичнээн их эрх сүртэй байлаа ч гэсэн ярьсан зүйл нь гэрч баримттай байж л сая бусдыг итгүүлж чадна. Яг л зарим хүн Багшийнх нь ярьсан “Агшин зуур билиг нээгдэж, энэ төрөлдөө туулан гэтэлнэ” гэдгийг гэрчлүүлэх гэж

Багшийг нь шахамдуулж асуухтай адил. Хэрвээ та ургамал хоолтон болж, авшиг хүртвэл агшин зуур билиг нээгдэхийг Багш нь дорхноо нотолж чадна. *(Бүгд алга ташив)*

Хамаг төрөлтөн Бурханыг гэтэлгэдэг, тэгээд өөрсдөө гэгээнтэн болдог

Шагжамуни Бурхан төрөл төрөлдөө бясалгал хийснээс л сая Бурханы хутагт хүрсэн гэж зарим хүн хэлдэг. Гэтэл түүний төрөл төрөлдөө бясалгал хийсэн гэдгийг яаж гэрчилж чадах вэ? Тухайн үед нь бид байгаагүй болохоор яаж мэдэж чадах вэ? Гэхдээ Бурхан Багш ингэж ярьсан юм чинь бид итгэх ёстой. Бүрэн дүүрэн итгэж чадвал хамгийн сайн, энэ нь бид билиг ухаанаар хангалттай өндөр, сэтгэл ариун бөгөөд эргэлзээ тээнэгэлзээ байхгүй гэдгийг илэрхийлж байгаа хэрэг, ийм бол тун сайн. Гэвч тэр биднээс ямар онцгой талтай болохоороо Бурханы хутагт хүрч чадсан тухай сайтар бодож үз!

Тэр хааны хүү болон төрж, олон хүнээр асруулан хайрлуулж, хүндлүүлж өсжээ. Том болсны дараа ч гэсэн олон сайхан хатнаар асруулж, хорь, гучин жил жарган цэнгэж, иргэдийн зовлон зүдгүүрийг ерөөс мэдээгүй явжээ. Тэгээд нэг өдөр хөдөө хээр зугаалахаар гарахдаа иргэдийн зовлонг харснаас сая хүний амьдрал мөнх бус гэдгийг ойлгон таньж, айх бодол төрж эхэлжээ. Тиймээс хамаг төрөлтөн Бурхан Багшийг гэтэлгэж билиг нээгдүүлсэн байна. Зовлонг төрөлтнүүд байгаагүй бол Бурхан Багш ухааран сэхээрхээргүй байсан. Бурханы хутагт хүрсний нь дараа хамаг төрөлтөн аяндаа түүнээс ач тус хүртэх болно. Тиймээс “Би хамаг төрөлтнийг гэтэлгэнэ” гэж битгий ярь! *(Бүгд алга ташив.)*

Багшийнх нь харах өнцөг болон ойлголт та нарынхтай адилгүй. Учир нь бясалгалын арга адилгүй, Багш нь өөрийн цаг заваа Бурханы өмнөөс ажиллаж, өөрийн бурхан чанараа

хайхад зориулдаг. Гэтэл та нар бол цаг заваа өөрийн бие, гэр бүл, дэлхий ертөнцийн төлөө зориулдаг, тиймээс та нар гэр бүл, материалаг зүйлс шаардлагатай талаар бурхныг ойлгохоосоо ч илүү сайн мэддэг. Гэхдээ Багш нь бурхныг нилээд сайн ойлгодог. Учир нь би цаг заваа бүхнээ Бурханы өмнөөс ажиллахдаа зориулж, нэгэн үзүүрт сэтгэлээр Бурханд хандаж, өөрийн бурхан чанараа хайдаг.

Ер нь бид сургуульд сууж, ямар төрлийн мэргэжил сурсан бол зөвхөн тэр төрлийн мэргэжлийг л ойлгож, мэргэжлийнхээ чиглэлээр ажил хайж, зөвхөн энэ чиглэл тийшээ анхаарлаа хандуулдаг. Та нар эгэл ертөнцийн замаар зорчиж, Багш нь “Мөр ёс”-ны замаар зорчдог, ингэснээр бид өөр өөрийн амжилтад хүрдэг. Тиймээс Багш нь “Бодь мөрийн зэрэг”-т хүрч, та нар “хүний зэрэг”-т хүрдэг нь тийм ч гайхмаар хэрэг биш. (*Бүгд алга ташив.*) Уул нь тийм ч ялгаагүй хоёр хүн ондоо чиглэлээр явсны эцэст ондоо зорилгод хүрдэг. Жишээлбэл, хоёр аварга хүчтэн уул руу авирахаар болзоод нэг нь уулын оройд авиран гарч уулын үзэмжийг бүхэлд нь харсан байхад нөгөө нь харин уулын бэл хүрээд цааш явалгүй амарчээ. Хоёр аварга хүчтэн адилхан хүч тамиртай боловч нэг нь уулын оройд авирч гарсан болохоор байгалийн үзэмжийг сонирхож чадсан байна, гэтэл нөгөө нь биеэ зүдрээлгүй уулын бэлд сууж үлдсэн болохоор хүч тамир байлаа ч хэрэглээгүй байна.

Үүнтэй адилаар, та нар Шагжамуни Бурхантай ялгаагүй, гэхдээ түүнтэй заавал адилтгах гэвэл та нарын ач буян Шагжамуни Бурхныхаас их байж таарна. Шагжамуни Бурхан эхийнхээ хэвлийгээс мэндэлмэгц бусдаар асруулж, аав ээж нь эрхлүүлэн хүйтэнд хөрч, халуунд халах зовлон үзээгүй. Ямар ч ажил хийлгүй, хэдэн арван жилээр жарган цэнгэжээ. Ийм хүн угаас улс гэрийн дарамт, гэтэл ийм хүн бас Бурханы хутгийг олж чадсан байна. Та нар бол бас сүм хийдэд очиж, сүсэглэн мөргөдөг, гэтэл Шагжамуни Бурханд сүм хийдэд очих ямар ч боломж байгаагүй. Сүм хийд хаа

байгааг ч мэддэггүй. Бид сүм хийдэд байнга очиж мөргөдөг бөгөөтөл эцэг, эхээ тэжээхийн тулд шаргуу хөдөлмөрлөж, улсдаа татвар төлж, дүрвэгсдэд тусалдаг. Тиймээс бидний ач буян Шагжамуни Бурханыхаас их байж таарна, тийм биз дээ?

Буддын шашны сургаалыг үндэслэж яривал бидний ач буян Шагжамуни Бурханыхаас үнэхээр их. Бид ажил хийдэг, өглөг үйлддэг, зургаан билиг барамидыг биелүүлдэг. Гэтэл Шагжамуни Будда Бурханы хутгийг олохоосоо өмнө аав, ээжээ түшиж, иргэдийн татварыг хонжиж амьдран юу ч хийдэггүйн дээр их үрэлгэн байжээ. Хатад, татвар эмс нь хэдэн зуу - үнэндээ эрэгтэй хүн ганцхан эхнэртэй байвал таарна, гэтэл урьдын хаад олон хатантай байсан. Тэрээр иргэдийн хүч хөлсийг ихэд үрэн таран хийсэн тул буяны өр тооцоогоо төлөх ач буян гэмээр зүйл үлдээгүй байв. Ингэсэн байтлаа Бурханы хутагт хүрч чадсан юм чинь та нарт бүр ч илүү итгэл найдвар байгаа, тийм биш гэж үү? *(Бүгд алга ташив.)*

Багшийнх нь ярьсан үнэн үг чих хатгадаг хэдий ч үнэн бодитой шүү. Яагаад ингэж ярьдаг вэ? гэвэл Багш нь Бурхан Багшийг гүтгэж байгаа биш, би Бурхан Багшийг маш их хүндэлдэг, бид бол сайн найз. Гэхдээ өглөг үйлдэж, сахил сахиж, сүм хийдэд очиж, гурван эрдэнийг тахьдаг хүмүүст үнэн бодит байдлыг мэдүүлэхийн төлөө мөн л ярих хэрэгтэй. Ердөө та нар сүм хийдэд очиж жаахан мөнгө хандивлавал гэрээс гарагч та нарыг: “Бурхан минь! Өглөгийн эзэн таны ач буян цаглашгүй, билиг ухаанаар асар их, урьд төрөлдөө бясалгал хийсэн байна” гэж сайшаадаг. Гэтэл Шагжамуни Будда Бурханы хутагт хүрэхээсээ өмнө сайн үйл үйлдээгүй, нэгэн өдөр хөдөө хээр зугаалахаар гарахдаа төрөх, өглөх, өвдөх, үхэхийн зовлонг хараад эмээх бодол төрж зарцаасаа: “Хэзээ нэгэн өдөр би бас ийм болж хувирах уу?” гэж асуухад “Тийм ээ! Хүн бүхэн энэ дөрвөн зовлонгоос зайлахын аргагүй, хаан хүү та ч адилхан шүү!”

гэж зарц нь хариулжээ. Ингэснээр тэр сая ухааран сэхээрч, өөрийнхөө төлөө санаа зовж, сансрын хүрд, үйлийн үр зэргээс айсан бөгөөд зовж шаналж байгаа хүмүүсийг өрөвдөж, улмаар мөр ёсыг бясалгаж, туулан гэтлэх замыг хайхаар зориг шулууджээ. Тиймээс Багш нь сая хамаг төрөлтөн Бурхан Багшийг гэтэлгэх ёстой гэж хэлсний учир нь энэ.

Багшийнх нь байдал ч бас л адил. Амьдрал маань ер нь баяр жаргалтай байсан. Бусдынхтай адил тийм их аз жаргалтай биш ч зовлон зүдгүүртэй биш байсан. Миний гэр бүл тун жаргалтай, тэр ч байтугай гэрээс гарснаас долоон жилийн хойно эр нөхөр маань мөн л намайг буцаж ирэхийг хүлээж, найман жилийн дараа л сая нэг дахин гэрлэжээ. Тэр маань хайр сэтгэлээр маш үнэнч хүнд тооцогдоно, тун царайлаг (*бүгд инээлдэв*), сэргэлэн ухаантай, баян айлын хүү, залуухан, Багшаас нь насаар нэг ах, анагаах ухааны хос мэргэжлээр доктор зэрэг хамгаалсан, тал талын нөхцөл байдал нь тун сайн болохоор араас нь олон эмэгтэй гүйдэг байсан.

Тухайн үед би баяр жаргалын дунд сэтгэл хангалуун явсан бөгөөд зовлон зүдгүүр амсах тохиолдол бараг байгаагүй. Сүм хийдэд очсон ч шашны нийгэмлэгийн дарга, дэд даргаар сонгогдож, нийгэм олонд нэр төртэй, бусдад хүндлүүлж явсан. Материаллаг зүйлсийн талаар баян чинээлэг, эр нөхөр маань хайр халамжтай, зол жаргалтай гэр бүлтэй байсан. Багшийг нь бясалгал хийж, билиг нээгдэх зам мөрийг хайлгах хувь барилдлага гэмээр юу ч байгаагүй. Тухайн үед Багш нь хүний амьдрал гэж маш зол жаргалтай гэж үздэг байсан болохоор өдөр бүр тав тухтай, сэтгэл хангалуун жаргадаг байжээ. Хожим нь бусдын зовлонг харахаар сэтгэл шаналж, хүний амьдрал мөнх бус гэдгийг ойлгосноос л сая даруй бясалгал хийхийг хүссэн.

Багшийнх нь хувьд бясалгалын ач буян шаардлагагүй боловч түүнийг бусдад түгээн тархааж болохыг мэдсэн

болохоор ач буян эрж, мөр ёсыг хайсан. Тиймээс хамаг төрөлтөн Багшийг нь гэтэлгэжээ. Хамаг төрөлтний гаслан зовуурь байгаагүй бол Багш нь бясалгал хийх бодол төрөхгүй, Бурханы хутгийг олохыг бүр ч хүсэхгүй байх байсан. Хамаг төрөлтний ач энэрэлд баярлан талархдаг учир өөрийн туршлагаа хуваалцсан. Харин хүн гэтэлгэх дуртай, бусдыг сургах дуртай, эсвэл өөрийгөө бусдаас дээд дэсийн гэж үзсэндээ биш шүү. *(Бүгд алга ташив.)*

Заримдаа бид сайн үйл хийсэн ч сайхан магтаал хүртдэггүй, тэр ч байтугай бусад хүн буруугаар ойлгодог. Зарим хүн Багшийг нь шавь нарыг нь булааж байгаа, шашны байр суурийг нь булааж байгаа гэж үздэг нь үнэндээ огт буруугаар ойлгож байгаа хэрэг юм. Гэхдээ Багш нь тэдэнд уурлаагүй. Зөвхөн өрөвдөж байдаг бөгөөд мөн биширч байна. Өөрсдийн шашин шүтлэгээ тэгж чин сэтгэлээр хамгаалж байгаад биширч байдаг билээ. Тэд өөрсдийн шашнаа дэлхий дээрх хамгийн сайн шашин гэж үздэг болохоор байдгаараа чармайн цаг зав, мөнгө төгрөг ихээр зарцуулж, шашин шүтлэгээ хамгаалдаг нь хүндэтгэн бишрүүштэй.

Тэдний хийх арга барил болон харах үзэл бодлыг Багш нь ойлгож байна. Одоо Багшийг нь буруугаар ойлгож байгаа боловч хэзээ нэг өдөр өөрсөдтэй нь адил гэдгийг ойлгох болно. Багш нь бурхан чанарыг бүхэлд нь хамгаалахын зэрэгцээ хүмүүст өөрсдийнх нь бурхан чанарыг ойлгуулдаг. Гэтэл тэд бол байдгаараа чармайн “Мөр ёс”-ны жижигхэн хэсгийг л хамгаалдаг. Ингэх нь үнэндээ хүч чадлаа дэмий үрж байгаа хэрэг, гэхдээ бас муу санасандаа биш. Багш нь адилхан тийм зүйлийг хийдэг хэдий ч “Мөр ёс”-ыг бүхэлд нь хамгаалдаг, гэтэл бусад хүн зөвхөн жижигхэн хэсгийг нь л харж, өөр хэсгийг нь ойлгодоггүй. Тиймээс л Багшийг нь буруугаар ойлгодог. Багш нь бүх хэсгийг нь хардаг болохоор мэдээж нилээд тод харж чаддаг. *(Бүгд алга ташив.)*

Багшийг нь гүтгэдэг, шүүмжилдэг тэр хүмүүс

Багшийг нь ойлгосны дараа Багш нь тэднийг хайрлан өршөөж, мэхийн ёсолж, чин сэтгэлээсээ баярлан угтана. Учир нь тэд бол мөн л гэгээрсэн Будда, хүндэт Будда нар мөн. Би ерөөс өөрийгөө цорын ганц бурхан гэж үздэггүй. Хүн бүхэн угаас Будда мөн. Хэн хүн өөрийгөө бурхан мөн болохоо мэдвэл би түүний өмнөөс баярладаг, харахан мэдээгүй хүмүүс бол зөвхөн цаг нь болоогүй байгаа л хэрэг. Энд байгаа хүн болгон бүгд л Будда мөн болохыг би маш тод харсан болохоор сэтгэл минь тун баяртай байна. Зөвхөн энэ баяр баяслаа та нартай хуваалцахын аргагүй байгаадаа тун харамсаж, сэтгэл дундуур байна. Гэхдээ энэ нь бас та нарын буруу биш.



САХИЛ САХИХЫН ЧУХАЛ ЧАНАР

*Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар
Америкийн Лос Анжелес хот
1997 оны 7 дугаар сарын 13
(Эх нь вьетнам хэлээр)*

*※ Толгой тархи юу бодно, бие махбод түүнийг нь хийдэг.
Учир нь бидний биеийн эс оюун ухааны бодсон, анхаарсан
аливаа үйл явдлыг бичиж тэмдэглэж авдаг юм.*

Багшийгаа дагаж бясалгах хүсэлгүй хүн ч гэсэн боломжийнхоо хэрээр веган хоол идэж, таван сахилыг сахивал сая дахин хүний төрөл авч чадна. Таван сахилыг сахивал дахин ирж, хүний төрөл авч чадна. Үгүй бол хүнээс доогуур дэсийн төрөлтөн болж төрж мэднэ. Энэ нь бид сургуульд сурахдаа ямар нэгэн стандартад тулгуурлан байж, бага сургуульд сурч, дараа нь өөр нэг стандартын дагуу дунд болон ахлах сургуульд сурдаг. Дараа нь дахин өөр нэг стандартаар их сургуульд сурдагтай адил.

Мэдээжээр, зарим гоц авъяастай хүүхэд ахлах сургуулиасаа шууд их сургуульд сурах, эсвэл бага сургуулиасаа шууд их сургуульд орж сурдаг. Гэхдээ ийм хүүхэд тун цөөн. Бурханы хутагт хүрсэн зарим хүн маш

залуу хэдий ч бясалгал хийж дорхноо Бурханы хутагт хүрч чаддаг. Учир нь тэд бол гоц авьяаслаг хүүхэд юм. *(Багш инээв.)* Хүрэл бурхан. Харин модон бурхан биш. *(Багш ижил дуудлагатай үгийг ашиглан хошигнож байна.)*

Бүр нарийн нандин сахилуудыг сахихуй

Чин Хай хатагтайг дагаж бясалгахад веган хоол иднэ, бас тийм удаан цагаар бясалгаж сууна, ингэх нь дэндүү төвөгтэй юм гээд ингэж чадахгүй гэж бодож байгаа хүмүүс байвал ядаж л таван сахилыг сахиарай. Амь хороохгүй, худал ярихгүй, садар самуун явахгүй (нэг эрэгтэй ганцхан эхнэртэй байх), архи уухгүй, мөрийтэй тоглоом тоглохгүй гэх зэрэг сахилыг биелүүлчихвэл хэзээ нэгэн өдөр дахин хүний төрөл авч болно. Багш нь та нарыг айлган сүрдүүлэх, эсвэл хүчээр сахил сахиулах гэсэн биш. Зөвхөн орчлонгийн хууль дүрмийг л ярьж байгаа хэрэг билээ.

Хэрвээ гэгээнтэн, эсвэл бурхан болохын тулд бясалгахыг хүсэхгүй байлаа ч гэсэн сахил сахиж чадвал дахин хүн болоод буцан ирж, эрүүл саруул, баяр жаргалтай, зовлон багатай амьдарч болно. Таван сахилыг сахиж чадахгүй бол бидний зан үйлийн хэм хэмжээ хүнийхээс доогуур болдог тул төрөл арилжин буцаж ирэхдээ хүнээс доогуур дэсийн төрөлтөн болдог. Жишээлбэл, амьтан, ад, буг чөтгөр гэх мэт болно. Таван сахилыг сахихын хамт бясалгал хийж, нарийн сахилуудыг бүр ч сайн сахивал гэгээнтэн буюу Будда болно. Жишээлбэл, бид бусадтай эр, эмийн харилцаа үүсгээгүй, бусдын эхнэртэй садарлаагүй бол сахил алдаагүй гэж үргэлж боддог. Үнэндээ тийм биш, хэрвээ зориудаар бодсон бол бодсон төдий байлаа ч хэдийн сахилаа алдсан байдаг. Зөвхөн харсан төдий байлаа ч мөн л сахилаа алдсан байдаг. Зориудаар бодоогүй бол бас зүгээр. Гэхдээ сахил алдаагүй гэсэн хэрэг биш, бас л алдсан байдаг,

зөвхөн арай хөнгөн.

Нэгэнт гэрлэж, хүүхэдтэй болчихсон мөртлөө зориудаар гоё сайхан үгээр бусдын дур булаах, бусадтай харц солилцож, ариун бус бодол өвөрлөвөл нэгэнт сахилаа алдсан гэсэн үг. Учир нь сахилаа алдах гэдэгт бие, хэл, сэтгэлээр алдах багтана. Зөвхөн бие махбодоор алдахыг л хэлдэг биш. Бодлоос хэл, биед дамжигддаг бөгөөд бодол үүсэхгүй бол ярих үйл үүсэхгүй, бодол үүсэхгүй бол бие махбод хийх боломжгүй.

Тиймээс сахил зөрчих гурван төрөл байдаг: нарийн төрөл нь оюун бодлоос, нилээд бүдүүн хадуун нь үйл хөдлөлөөс үүсэлтэй. Үүн дээр үг хэлийг нэмбэл, за тэгээд дуусах нь тэр. Иймээс ямагт хичээн болгоомжлох хэрэгтэй. Дахин хүний төрөл авъя гэвэл заавал сахил дүрмийг тодорхой сахих ёстой.

Бодол санаа маань бие махбодын эсэд бичиж тэмдэглэгдэж байдаг

Бусдын бие махбодод гар хүрээгүй, ямар ч хүнийг үнсээгүй бол сахил алдаагүй гэж бүү бод! Бид хүсэл тачаал үүсгэх буюу хаана очсон ч ер нь шунахай харц шидвэл мөн л сахил дүрмийг зөрчиж байгаа хэрэг болно. Учир нь бид өөрийгөө муу дадалд автуулсан болохоор оюун бодол маань нэгэнт зохиогдсон зам дагуу аяндаа ажиллаж, нааш нь буцаан авчрахад тун бэрх болдог. Толгой тархи юу бодно, бие махбод түүнийг нь л хийдэг. Учир нь биеийн эс нь толгой тархины бодсон, анхаарсан аливаа үйл хэргийг бичиж тэмдэглэдэг.

Ген, эс, бие махбодын бүтцэд бичигдсэн тэр бүх мэдээлэл өдөр бүр байнга давтагдаж, улмаар нэмэгдсээр угааж цэвэрлэхэд тун бэрх болдог. Тиймээс та нар хар даа! Архичин хүн архинаас гарахад тун бэрх, улам улам

их уусаар гарахад бүр бэрх болдог. Тамхи татдаг хүн мөн л тийм, өдөр бүр хичнээн хэмжээний тамхины бохь (никотин) шаардлагатай гэж толгой тархинд нь бичээстэй байгаа болохоор гарч чаддаггүй! «Өнөөдрийн тамхи яав?» гэж асуугаад л байдаг. Нууц амрагтай болдог нь мөн л нэг зүйлийн муу дадал, эрхэмсэг бус, завхай зайдан дадал зуршил юм. Муу дадал суусны дараа бие махбод тийм зуршлыг аяндаа тасралтгүй шаардаад байдаг.

Заримдаа ийм тэмдэглэл дэндүү их хуримтлагдвал бие махбодын бүх эрхтэн, бүх эс нь хүсэн шаарддаг. Тэр үед оюун ухаан тун сул дорой болж, дахин эсэргүүцэхийн аргагүй уруудан дордож, улам уруу татагдах бөгөөд хөгжин дэвших аргагүй болдог. Ингэснээр заавал дахин буцан ирж, хүний төрөл авч байж л сая шунал хүслээ хангаж чадна. Ингэсээр байж хэзээ нэгэн өдөр тэнхээ тасарч, амьсгал давхцан тэвчихийн аргагүй болох үед сая ухааран сэхээрч, өөрөө босож зогсдог. Гэхдээ маш урт хугацаа, тэр ч байтугай хэдэн зуун жил үргэлжилж байж л ийм болж чадна.

Өөрийгөө дасгалжуулж, хурдан ухааран сэхээрэхүй

Тиймээс толгой тархи биднээр тийм хэргийг хийлгэх үед бид даруйхан сэргэж, таван нэрээ уншин өөрийгөө зөв зам руу хурдан чиглүүлбэл асуудалгүй болчихно. Хэрвээ толгой тархиныхаа дагуу хийгээд байвал уруудан дордох болно. Бясалгал хийлээ ч гэсэн хүч тамираа талаар үрэх хэрэг.

Биднэг өдөр зөвхөн хоёр цаг гучин минутаар бясалгаж суудаг. Магадгүй 2 цаг хагасаа ч хийж чадахгүй байж магад. Тиймэрхүү бодол бүтэн өдөржин бидний толгойд эргэлддэг болохоор дэс доошлох нь яриангүй. Ийм бодол биднийг хорин нэгэн цаг, хорин хоёр цагаар уруу татахын эсрэг бид зөвхөн хоёр цаг хагас л дээш татдаг бөгөөд толгой дохин нойрмогловол бясалгалын цаг угаасаа хангалтгүй. Хоёр цаг

хагас нь өөрийгөө дасгалжуулж, цэвэр ариун амьдралаар амьдрахын төлөө юм. Хэрвээ өөрийгөө зөв сургахгүй бол нэгмөсөн уруу татагдаж, бусдаасаа хоцрох болно.

Заримдаа гадуур цэвэр биш идээ идэж, харахад веган хоол шиг идээг дураар иддэг. Бид хангалттай ариусаагүй үед цэвэр бус идээг ялган таньж чаддаггүй. Хангалттай ариусчихвал цэвэр бус идээ идвэл дорхноо мэднэ. Ходоод хариу тусгал үүсгэж, огиж бөөлжих, эсвэл тавгүйрхээд цэвэр бус идээ идсэнээ мэддэг. Эсвэл орой бясалгаж суух үед доод дэсийн аймшигтай ахуй ойлголттой болох юмуу Багш ирж (дотоодод) бидэнд: цэвэр бус идээ иджээ гэж хэлэх болно.

Дотоодын багшийгаа харах нь дэсээр өндөр болохыг илэрхийлж байна. Тийм биш бол Багш ирж бидэнд хэлэх үед сонсож чадахгүй. Багш нь хорин дөрвөн цагаар ямагт та нартай хамт байдаг. Харин та нар дүлий, сохор болохоор юу ч сонсдоггүй, зөвхөн толгой тархины бичиж тэмдэглэсэн эмх замбараагүй хэргийг л сонсдог. Дотоодын багшийнхаа дууг сонсож чадвал сахилаа алдахгүй бөгөөд уруудан дордох хүн байхгүй болно. Багш нь хүн бүхэнд хичээж мэрийж, тэмцэж туулах боломж олгодог. Хэрвээ Багш нь өөрөө сонгоно гэвэл энд суух хүмүүс маш цөөхөн дөө.

Дэсээр өндөр бясалгагч байлаа ч гадуур явахаараа бас л нөлөөнд автаж, ойр орчны соронзон талбай бидэнд нөлөөлж, маш олон асуудал үүсдэг. Бясалгал хийх нь яаж тийм хялбар байж болох вэ? Нэгэнт тийм бэрх байхын дээр нэмээд өөрийн биедээ төвөг удвал бүр ч илүү бэрх болно. Тэр үед Эзэн Бурхан, Бурхан бодьсадва ч гэсэн туслахын аргагүй. Гэхдээ сахил алдсанаас болж, өөр хүн биднийг хордуулдаг биш юм. Харин бид өөрийн дэсээ бууруулснаас болж байгаа хэрэг бөгөөд хожим мөн л өөрөө өөрийгөө дээш татах хэрэгтэй болдог. Яг л сурах дургүй сурагч шиг сургуульдаа сахилгагүйтвэл анги улирах буюу сургуулиасаа

гардагтай адил. Дараа нь алдаагаа засаж, сургуульдаа дахин оръё гэвэл багшдаа өөрийн сайжирсан байдлаа үзүүлэх хэрэгтэй болдог.

Та нар өөрийн биеэ сайтар харгалзан веган хоолтон болж, сахил сахих хэрэгтэй. Хичээнгүйлэн бясалгадаг хүмүүс заримдаа болгоомжгүйгээр амьтны найрлагатай идээ идвэл тэр дороо мэднэ. Гэртээ харьсны дараа нүүрэнд нь батга ихэд гарах буюу орой унтахад нь дүрсгүй төрөлтөн ирж, хөлөөс нь чангаах, эсвэл бясалгаж суухад хав харанхуй түвшнийг харах юмуу гэдэс өвдөх, толгой өвдөх, үгүй бол гэнэт Багшдаа ихэд дургүйцэх сэтгэл төрнө. (Багш инээв.)

Нээрээ тэгдэг шүү! Бясалгахаа больсон хүмүүсээс асууж болно. Тэдний зууны ерэн есөн хувь нь цэвэр бус идээ идсэн буюу сахилаа алдсаны улмаас Багшаасаа алгуурхан холджээ. Учир нь энэ бол зүг чиг нь эсрэг тэсрэг хоёр зам юм. Зориудаар Багшаасаа холдоогүй ч гэсэн өөр чиглэл рүү явсан болохоор мэдээж холдох л болно. Нэг нь хойшоо, нөгөө нь урагшаа явсан тул хоёулаа яаж уулзаж чадах билээ? Үнэндээ тэд Багшаасаа салсан биш, харин өөрөөсөө л салдаг юм!

Хоёр өөр чанартай соронзон талбай харилцан таталцах боломжгүй, “ороо нь ороогоороо, жороо нь жороогоороо, дугуй дугуйгаараа нийлэх” гэдэг нь үүнийг л хэлдэг. Зарим хүн өөр замаар явбал хэзээ нэгэн өдөр биднээс холдох нь мэдээж. Тэд Багшаас нь салаагүй, харин өөрийн хүсэл зорилго болон андгай тангаргаа хаясан байна. Өөрийн сонгосон яруу алдар, сайн сайхан зүйлсээ орхиж, хүсэл найдваргүй мухар замаар явж байгаа хэрэг. Мэдээж, хүн бүрт сонгох эрх нь байдаг хойно бусдыг хүчээр хийлгэж болохгүй. Тиймээс авшиг хүртээх үед Багш нь та нарыг насан туршдаа Багшийнхаа замыг мөрдөх хэрэгтэй гэж ердөө албаддаггүй.

Бид албаддаггүй, зөвхөн сануулж хэлдэг. Энэ нь

Багшийнх нь заавал гүйцэтгэх ёстой сануулга: өөрсдийн сонгосон эрхэмсэг сайхан замаараа зорчоорой! Хэрвээ буруу замд орвол холдох л болно. Та нар Багшаасаа салсан хүмүүсийг хар! Нэгт, тэд мах идэх болов, хоёрт сахилаа алдсан болохоор соронзон талбай нь мэдээжээр өөрчлөгдөнө.

Амьтны зан чанар болон соронзон талбай бидэнд нөлөөлдөг

Бид юу иднэ, бие махбод маань түүнд хувирдаг. Жишээлбэл, амьтны мах идвэл тэдний алагдах үед ялгарсан хорт эд нь биднийг бохирдуулж, цаашилбал өвчин халдаадаг. Гэхдээ энэ нь зөвхөн бие махбодын талаарх нөлөө төдий, оюун санааны талын нөлөө нь бүр ч их байдаг. Амьтны сүнслэг мэдрэмж нь хүнийхтэй адилгүй. Ургамал буюу ногоонд амьтан шиг тийм хүчтэй үзэл ухамсар байдаггүй. Амьтад үхлээс айдаг бөгөөд соронзон талбай нь маш хүчтэй, тэд явж чаддаг бөгөөд үржиж чаддаг. Тэд харилцан хайрлалцдаг бөгөөд хайрынхаа төлөө, өөрсдийнхөө амьдрах орчин болон бүх зүйлийн төлөө яаж тэмцэхээ мэддэг.

Өвс ургамал бол харьцангуй хөдөлгөөнгүй амьд организм бөгөөд харилцан тэмцэлддэггүй. Тогтсон нэг газартаа нам жим оршиж, цэцгийн тоосонцороо салхиар дамжуулан нөхөн үрждэг. Гэтэл амьтан бол явж чаддаг, эсрэг хүйстнээ хөөцөлдөж, үржиж чаддаг төрөлхийн чадвартай. Тиймээс атаархах сэтгэл болон өмчирхөх шуналтай байдаг бөгөөд төрөлхөөс ширүүн зантай. Ялангуяа махчин амьтан бол бүр ч илүү хэрцгий байдаг.

Заан болон туулай уурлах үедээ л бусдыг хаздаг, дайрдаг. Бар бол яриангүй дургүйг нь хүргээгүй байсан ч хүн рүү дайрах буюу бусад амьтдыг барьж иддэг. Тиймээс бид ургамал ногоог идвэл үйл түйтгэрээр нилээд хөнгөн бөгөөд амьтдын хэрцгий чанар халдварлахгүй.

Амьтдын соронзон талбай болон бүтэц нь амьтны аймагт харьяалагддаг болохоор л амьтан болж хувирчээ. Тэдний оюуны чадвар нь хүнийхтэй адилгүй. Хайрын сэтгэл болон хариу үйлдэл нь ч хүн төрөлтөнтэй адилгүй болохоор л амьтны дэст багтдаг. Амьтдын биеийн бүтэц, соронзон талбай болон ухамсар нь өвөрмөц онцлогтой. Бид түүний махыг идвэл соронзон талбай нь биднийхтэй холилддог. Хэт их мах иддэг хүмүүсийн амьтны зан чанар нь хэзээ нэгэн өдөр хүний зан чанараас нь давах үед амьтан болж хувирдаг. Энэ бол тун энгийн зүй тогтол, харин мухар сүсэг биш. Хүн төрөлхтөн төрөл бүрийн амьтан болж, дахин төрнө гэдгийг нотлохын тулд Буддын шашны үйл үрийн хуулийг эш татах шаардлага ч алга. Жишээлбэл, нэг саван дахь цэвэр усанд ганц, хоёр дусал бэх дусаавал ус тийм ч ихээр булингардахгүй. Хэрвээ үргэлжлүүлэн дөрөв, тав, зургаа, долоон дусал гэхчилэн дусаавал удалгүй саван дахь ус бэхтэй адилхан болж хувиран цэвэр ус алгуурхан бэх болчихдог. Хэрвээ бэхийг бүр ч ихээр дусаавал, усны чанарыг алдагдуулж, бэх болгон хувиргаад үг бичихэд ашиглаж болно. Үүнтэй адилаар, хүний зан чанар нь амьтныхтай адилгүй. Жишээлбэл, зууны наян хувь нь амьтны зан араншинтай байх юм бол хэсэг хугацааны дараа амьтан болж хувирна.

Бараг зууны далан хувь болбол амьтан болж хувирна. Учир нь амьтны чанарын эзлэхүүн нь хүний чанарын эзлэхүүнээс давсан байдаг. Зууны жаран хувиас далан хувийн хооронд байвал бас ч гэж хүний зан араншингаа хадгалдаг. Гэхдээ амьтны зан араншин нилээд их байна. Тиймээс амьтантай адилаар зан араншинтай хүн их байдгийг та нар харсан биз. Тэдэнд хүний зан араншин байдаггүй. Тэднийг тэр, энэ ноёнтон, хатагтай гэж дууддаг ч үнэндээ амьтны зан араншин нь хүний зан араншингаасаа давсан байдаг. Тэд хүн алах, хулгайлах, мэхлэх үйлдэл

хийж, худал ярих нь яг л дуу дуулах шиг нэг зүйлийн дадал зуршил болчихсон байдаг.

Өөр нэг зүйлийн байдал нь зарим амьтан хэдийгээр амьтны дүртэй боловч ухамсар сайтай бөгөөд билиг ухаантай, хүн төрөлтөн шиг хайрын сэтгэлтэй байдаг. Учир нь тэдний хүн төрөлтний зан араншин нь өөр амьтдынхаас их байдаг. Жишээлбэл, зууны наян хувь нь амьтны зан араншинтай байвал амьтны хандлагатай. Харин хүн төрөлтөнтэй адилгүй, гэтэл амьтдад хэрвээ зууны дөчөөс дөчин таван хувийн хүн төрөлтний зан араншин байвал тал хувь нь хүн, тал хувь нь амьтны шинжтэй болдог. Зарим амьтныг харахад маш сэргэлэн бөгөөд хайрын сэтгэлтэй байдаг нь үүнээс болж байгаа юм.

Зарим хүн яг л амьтан шиг байдаг нь тэд өөрсдийгөө сургасаар тийм байдалтай болгосон байна. Тэд амьтдын зан байдал, үйл ажиллагаанд суралцаж, амьтанлаг зан араншингаа хянаж хязгаарладаггүй болохоор улам ихэсгэдэг. Ингэснээр дэндүү их болоод хэзээ нэгэн өдөр амьтан болж хувирдаг. Харахад хүн шиг боловч үнэндээ хүнтэй адилгүй. Сайн зан араншингүй, хүний мөсөө үгүйсгэсэн хэрэг хийдэг бөгөөд үүнийгээ ичгүүр гэж боддоггүй, ойлгож байна уу? (Бүгд алга ташив.)

Багш нь та нарыг шахаж байж сахил сахиулах гэсэн юм биш, зөвхөн зөвлөдөг билээ. Энэ бол эртнээс өнөөг хүртэлх Төгс Гэгээрсэн Их Багш нарын уламжлан үлдээсэн билиг ухаан болон бясалгалын нууц арга юм. Орчлон ертөнцийн хувьслын хууль дүрэм ийм л байдаг. Дэлхий ертөнцийн хууль дүрмийг ойлгон танивал эв найрамдалтай амьдралыг эдэлж чадна. Хууль зөрчихгүй бол залхаан шийтгэгдэхээс айх шаардлагагүй. Ийм л юм. Яг л бид Америкт амьдрахдаа эндхийн хууль дүрмийг мэдэх хэрэгтэй байдагтай адил. Хэрвээ дураараа машин жолоодвол цагдаад баригдахаар барахгүй заримдаа бүтэн жилээр машин

жолоодох эрхээ хасуулж ч мэднэ. Учир нь зориудаар хууль дүрмийг зөрчсөнөөс үүдсэн байна. Заримдаа ганц, хоёр удаа хэргээс мултрах боломж байгаа хэдий ч хууль дүрмийг байнга зөрчөөд байвал зуршил болж, улмаар хэзээ нэгэн өдөр хуулийн торноос мултрахын аргагүй болдог.

Өөрийгөө хянан захирч, өөрийнхөө эзэн болохуй

Бодлоороо сахил зөрчих болгондоо өөрийгөө даруй хязгаарлан захирах хэрэгтэй. Тэгвэл бодлоороо сахил зөрчсөн ч ядаж л бие махбодоороо сахил алдахгүй. Хэрвээ бие махбодоороо хүртэл сахил зөрчөөд байвал аврахын аргагүй болно. Багш нь та нарт хатуу хандаж байгаа юм биш, амьдрал өөрийнх чинь хойно хүссэн бүхнээ хийж болох бөгөөд өөрөө чөлөөтөй сонгож болно. Гэхдээ бас сонголт болгон бүгд өөр өөрийн үр дагавартай байдаг гэдгийг мэдэж байх хэрэгтэй. Харин надад эрх чөлөө байгаа юм чинь юу ч хийсэн болно шүү дээ! гэж бодож болохгүй. Тийм хялбар биш шүү! Ингэх нь эрх чөлөө биш. Бидэнд хүн алах, хулгайлах эрх чөлөө байдаг боловч бас шоронд орох эрх чөлөө ч байдаг. (Бүгд алга ташив.)

Энэ дэлхийд бусдын үйл ажиллагааг хориглох эрх мэдэлтэй хүн байдаггүй. Учир нь хүн болгон бурхан мөн. Бүгдээрээ Эзэн Бурханы нэг хэсэг нь. Гэхдээ бас дотоодынхоо Эзэн Бурхан, Будда чанараа ойлгон таньж, Будда болон Эзэн Бурханы оноосон амьдралыг мөрдөх хэрэгтэй. Ингэвэл л сая дахин хүний төрлийг олж чадна. Сая өөрийгөө хянан захирах чадвартай болж чадна. Сая өөрийнхөө эзэн, өөрийнхөө багш болж чадна.

Багш болно гэдэг нь өөрөө өөрийнхөө Багш болохыг хэлж байгаа хэрэг бөгөөд бусдын багш болно гэж байгаа биш. Өөрийнхөө Багш болох нь маш хүнд хүчир. Бусдын Багш болох нь тун хялбар. Эртнээс өнөөг хүртэл Төгс

Гэгээрсэн Их Багш нар өөрсдийнхөө багш болсоор иржээ. Өөрийнхөө багш болсны дараа л бусад хүн бидний соронзон талбай болон хүч чадалд аяндаа татагдах болно. Зөвхөн хий хоосон сургаал ёсыг ихэд яривал бидэнд итгэх хүн байхгүй. Учир нь үйлдэл нь үг хэлнээс бүр ч илүү хүчтэй.

Америкийн нэгэн гүн ухаантан Эмерсон: “Та хийж үйлдсэнээ дэндүү чанга дуугаар яривал би сонсож чадахгүй” гэж хэлсэн байдаг. Та нар Багшдаа хайртай байдаг нь өөрсдөө багш шигээ болохыг хүсдэгээс болж байгаа юм. Багшийн маань амьдралын арга хэлбэр л зөв. Хамгаас хүсэн эрмэлздэг амьдрал мөн гэж үздэг. Тиймээс та нарын хайрладаг нь энэ хүний уг чанар нь болохоос харин хувь хүн нь биш. Түүний хийдэг үйл ажиллагаа болон төлөөлж байгаа зан араншинг бахархан хайрладаг. Яг л ямар нэгэн хүнийг хайрладаг шиг, эхэндээ гаднах байдалд нь сэтгэл татагддаг. Гэтэл хэсэг хугацаанд хамт амьдарсны дараа нэг нэгнийхээ хайрын сэтгэл, зан араншин болон амьдралын хэлбэрт нь бүр ч илүү сэтгэл татагдахаас биш, харин царай төрхийг нь анзаарахаа больдог. Түүнийг өдөр бүр харсаар хэдийнээ дасчихсан болохоор гаднах төрх нь хичнээн гоё байлаа ч хараад л байвал бас залхах болно. (Бүгд алга ташив.)

“Сайныг ч бодохгүй, мууг ч бодохгүй” байх түвшин

Муу хэргийг сайн гэж, сайн хэргийг муу гэж ярьж болохгүй, нэгэнт Бурханы хутагт хүрчихсэн, эсвэл гэгээрчихсэн хүмүүсийн хувьд муу нь муугаар, сайн нь сайнаараа ялгардаг. Зүгээр л муу ч бай, сайн ч бай түүнийг хамаардаггүй, ялгаварладаггүй, ойлгож байна уу? Сайн хэргийг сайшаан дэмжиж, сайн хэрэг үйлдэгсдийг магтдаг. Муу хэргийг аяар нь байлгаж, муу хэрэг үйлдэгсдийг ч хамаардаггүй, зориудаар ямар нэгэн үйл хэрэг хийж, тэднийг өөрчилдөггүй, зөвхөн сургаал ёс тайлбарлаж, ёс суртахуун,

сахил дүрмийн талаар тэднийг заан жолооддог. Ингэх нь сая сайныг ч бодохгүй, мууг ч бодохгүй байх явдал юм. Харин “Сайныг ч бодохгүй, мууг ч бодохгүй”-н түвшинд хүрвэл муу хэрэг үйлдэж болно гэсэн хэрэг биш.

Нэгэнт сайн ч биш, муу ч биш болчихсон юм чинь муу хэрэг үйлдэх боломж яаж байж болох вэ? Ихэнх хүн бурхны судрыг буруугаар ойлгож, бясалгагч хүн сайн, муугийн талаар баригдаж хүлэгдэж болохгүй гэж үздэг. Сайн, муугийн талаар баригдахгүй гэх юм бол бурхны шашинд яагаад амь хороож болохгүй, хулгайлж болохгүй, худал ярьж болохгүй, муу үйл үйлдэж болохгүй, архи ууж болохгүй, мах идэж болохгүй гэж тодорхой тогтоосон бэ? Шагжамуни Бурхан яагаад бас шавь нартаа ямар нь сайн зам мөр, ямар нь муу зам мөр гэдгийг тодорхой заан сургаж байсан бэ? Бурхны шашны сүсэгтнүүд арван сайн үйл үйлдэж, католик шашинтнууд арван зарлигийг дагадаг, ийм байхад юунд “сайныг ч бодохгүй, мууг ч бодохгүй” гэж ярьж чаддаг юм бэ?

“Сайныг ч бодохгүй, мууг ч бодохгүй” гэдэг нь эгэл ертөнцийн сайн, муу үйл хэргийн тухай бодол сэтгэлээс хэтийдсэн тэр хүмүүст л хандаж хэлсэн хэрэг. Тэд ертөнцийн үйл хэргийг зөвхөн харах төдийд л сэтгэл татагдан шүүмжлэх, хараан загнах буюу гүтгэн дайрдаггүй. Зөвхөн хайрын сэтгэл, учир зүйгээр ерөөл барилдлагатай, сонсох хүсэлтэй, даган суралцах хүсэлтэй хүмүүст л тайлбарлан ярьдаг, ингэх нь сая “сайныг ч бодохгүй, мууг ч бодохгүй”-д тооцогдоно. Нэгэнт Бурхан Бодьсадвагийн түвшинд хүрсэн хүн л “сайныг ч бодохгүй, мууг ч бодохгүй” байж чаддаг, сэтгэл тайвуу, ертөнцийн аливаа сайн, муу үйл хэргийг харсан ч сэтгэл татагддаггүй.

Сайн, муу нь зөвхөн үйлийн үрийн үр дагавар болохыг нэгэнт мэдчихсэн болохоор алуурчныг сэтгэлийн хөөрлөөр шүүмжилдэггүй бөгөөд бас алагдсан хүнийг

өрөвддөггүй. Зөвхөн л: амь хөнөөж болохгүй, хөнөөгдсөн хүн ч хорсол занал өвөрлөж болохгүй гэж бусдыг ятгадаг. Харин аливаа бүхэн бүгд л үйлийн үрээс үүсэлтэй гэдгийг ойлгож, хожим харилцан хөнөөлцөж болохгүй, эс бөгөөс үйлийн үрийн холбоост гүн орооцолдож, өөрийгөө аврахын аргагүй болно гэж сануулдаг. Тэд аль алинд нь ч сэтгэл татагддаггүй, үүнийг л сая “сайныг ч бодохгүй, мууг ч бодохгүй” гэж хэлнэ.

“Сайныг ч бодохгүй, мууг ч бодохгүй” гэдэг нь сайн, мууг үл ялган дур зоргоороо өдөөн хатгаж, амь хороож, булаан дээрэмдэхийг хэлдэг биш. Бурхны оронд сайн, мууд баригдаж хүлэгддэггүй гэдэг нь үнэн хэдий ч бид энэ түвшинд хараахан хүрээгүй байж, дураараа тайлбарлаж, бусдыг эндүү буруу ойлгуулахгүй байвал зохино. Өөрөө буруугаар ойлгох нь угаас маш муу байтал бас өөрийн буруу ойлголтоо бусдад ярьж, элдвийн арга хэрэглэн үгэндээ оруулах нь бүр ч муу нөлөөтэй. Бусад хүн биднийг аяндаа дагавал бас тийм ч хүнд ноцтой биш. Хэрвээ зориудаар туйлширсан, албадлагын, эсвэл хууран мэхлэх арга ашиглаж, бусдад нөлөөлж, өөрийгөө итгүүлэн дагуулбал, үйл түйтгэр нь бүр ч хүнд байдаг.

“Хуурмаг эрх чөлөө” болон “Жинхэнэ эрх чөлөө”-ний ялгаа

Одоо та нар сахил сахих болон сахихгүйн ялгааг нэгэнт мэдлээ. Бурхны сударт: Бурхан сахил дүрэмд баригддаггүй, сахил дүрмийг журамлах шаардлагагүй гэж өгүүлсэн байдаг, энэ нь зөв боловч өөр ертөнц дэх байдал болно. Жишээлбэл, та нар бясалгаж суугаа үедээ бурхны оронтой холбогдож, өөрөө бурхан болчихсон шиг санагддаг, тэр үед ямар нэг сахилын тухай хаанаас санаж олох билээ? Эсвэл дээд түвшинд хүрэх үед булаан дээрэмдэх, бусдыг

хөнөөх тухай хэрэг гардаггүй газарт, сахил сахих тухай хэрэг хаанаас гарах билээ? Дээд түвшин угаас дэг журамтай, сахил сахих шаардлагагүй.

Гэтэл энэ доор дэсийн ороо бусгаа хүний ертөнцийг дүрэм журам болон сахил санваараар хязгаарлахгүй бол бүр ч илүү самуурч, тэр ч бүү хэл, тамын орон, дайны талбар болж хувирна. Тиймээс энэ ертөнцөд сахил сахих шаардлагагүй гэж ярьж болохгүй. Үзэсгэлэнтэй сайхан энэ дэлхийгээ бид хайрлан хамгаалахгүйн дээр бүр ч ихээр самууруулбал хүн болсны үүрэг хариуцлагаа сайтар биелүүлээгүй хэрэг болно. Энэ ертөнцөд бид гахай, үхэр зэрэг амьтныг бүтээж чаддаггүй байтлаа харин алж хөнөөдөг. Бид өөрсдөө үхрийг бүтээж, хээр талаар тоглуулж чаддаг бол бас яах вэ, тэднийг алах эрхтэй гэж үзэж болно. Гэтэл ингэж чадахгүй байтлаа харин алж нядалбал амь насыг хулгайлж, бүтээгчийн өмчлөх эрхийг хулгайлсанд тооцогдоно, яг л хөршийнхөө жимсийг хулгайлсантай адилхан хэрэг мөн.

Сургаал ёс, сахил дүрмийг тайлбарлахад тун бэрх, өөрийгөө хүчилж сахил сахих буюу сургаал ёсыг бодитой гүйцэлдүүлэх дуртай хүн тун цөөн. Хүн болгон цөм би өөрийн гэсэн эрх чөлөөтэй, юу хийсэн ч миний дур, “Энэ бол эрх чөлөө мөн” гэж үздэг. Гэтэл эрх чөлөө болон жинхэнэ эрх чөлөө хоёр адилгүй. Яг л та нар би эрх чөлөөтэй, хулгайлах, булаан дээрэмдэх эрхтэй гэж ярьдаг, гэхдээ ийм байдал нь бусдын эрхэнд халдсан хэрэг болдогтой адил. Тиймээс та нар ерөөс жинхэнэ эрх чөлөөтэй байж чаддаггүй. Та нарын нинжин сэтгэл чинь ингэх нь буруу, бусдын эрхэнд халдаж байна гэж мэдэрдэг. Иймээс жинхэнэ эрх чөлөө болон хуурмаг эрх чөлөөний хооронд ялгаа бий.

Жинхэнэ эрх чөлөө гэдэг нь өөрийн амьдарч буй орчиндоо хийсэн бүх зүйлдээ хариуцлагатай байж, үүргээ тууштай гүйцэтгэхийг хэлнэ. Эрх чөлөө гэдэг нь юу хүснэ, түүнийгээ хийнэ гэсэн үг биш. Бид жинхэнэ эрх чөлөөтэй

болъё гэвэл хууль дүрмийг хүндэтгэх хэрэгтэй. Заримдаа бид: “Засгийн газар маш олон хууль дүрэм тогтоодог, хэтэрхий ядаргаатай болохоор надад эрх чөлөө алга. Яагаад ингэж ч болохгүй, тэгж ч болохгүй гэж хориглодог юм бэ?” гэж гомдоллодог. Хэрвээ энэ хууль дүрмийг зөрчин эрх чөлөө гээчийг эдэлбэл бид хууль дүрмийг зөрчиж, эцэс сүүлдээ шоронд орж, бүрмөсөн эрх чөлөөгүй болно. Хууль дүрмийг хүндэтгэвэл биднийг хязгаарлах хүн байхгүй, хаа хүрье гэвэл хүрч, аль ч хоолны газарт очиж хооллосон болно, хэчнээн мөнгө олж, яаж хэрэглэх нь бүгд таны дур. Үүнээс та нар хуурмаг эрх чөлөө болон жинхэнэ эрх чөлөөний ялгааг харж чадаж байна уу?

Орчлон ертөнц ч гэсэн өөрийн гэсэн хууль дүрэмтэй. Хэрвээ ертөнцөд ямар ч хууль дүрэм байдаггүй бол яаж хувьсаж өөрчлөгдөх вэ? Хэдийгээр бид хүн болж энэ дэлхийд амьдрахдаа эрх чөлөө эдлэх ёстой гэж үздэг ч хууль дүрмийг дураар зөрчиж болохгүй. Үүнтэй адилаар орчлонгийн хуулийг сөрсөн хэрэг үйлдвэл шийтгэгдэх болно. Яг л нэгэн улсын иргэн хуулийг зөрчвөл эрт орой хэзээ нэг өдөр шийтгүүлдэгтэй адил.

Багш нь энгийн үед сахилын тухай тийм их тайлбарладаггүй, гэтэл одоо илүүхэн тайлбарлах шаардлагатай гэж Багш нь бодож байна. Энэ муж улсад нэг зүйлийн онцгой шаардлага байдаг болохоор сахил санваарын тухай илүүхэн ярилцах хэрэгтэй, та нар гайхах хэрэггүй шүү! Багш нь аль ч улсад ном тайлсан бүгд л тухайн орны шаардлагад тулгуурлаж, сонсогчдын хүсэл сэтгэлд нийцүүлж ярьдаг. Гэхдээ ерөөс эх ноорог бэлтгэдэггүй бөгөөд тайлах сэдвээ урьдчилан тогтоодоггүй. Тэр ч байтугай уг нь ярья гэсэн зүйлээ тухайн газраа хүрсний дараа ярихаа больж, огт өөр зүйл ярьж, Эзэн Бурханы санаа зорилгыг дагаж, Дээд Тэнгэрийн зохицуулалтаар ном тайлдаг. Ийм хэлбэрийн ном тайлалд дуртай хүмүүс олон байдаг бөгөөд

дургүй хүмүүс ч их байдгийг та нар ойлгох болов уу? Та нар өөрсдийн хүсэж байгаа учраа сонсох хүсэлтэй бол дараа асуугаарай! Тэгэх үү? Олон хүний цуглаанд ном тайлах үеэр хүн болгоны хүслийг хангах боломж байхгүй.

Хоёр хуврагийн үлгэр

Багшийнх нь саяхан ярьсан сахил нь бас үнэмлэхүй зүйл биш бөгөөд эрхбиш газар орон болон орчин тойрны байдлыг харж, үйл хэргээ зохистой шийдвэрлэх хэрэгтэй. Эрт урьдын цагт сахилаа маш чанга сахидаг хоёр хувраг байжээ, хувраг хүн эмэгтэй хүнтэй ойр дотно байж болдоггүй, эхнэр хүүхэдтэй байж болохгүй. Нэг удаа хоёр хувраг голын хөвөөнд очих үед нэгэн охин гол гаталж чадахгүй тэнд арга барагдан сууж байжээ. Учир нь голын урсгал тун догшин бөгөөд цаад эрэгт ээж нь гэртээ түүнийг хүлээж буй ажээ. Завь байхгүй, гүүр ч байхгүй болохоор охин хоёр хуврагаас түүнийг гол гатлуулж өгөхийг гуйжээ. Үүнд нэг хувраг нь сахилаа эвдэхээс болгоомжилж, гол гатлуулахаас татгалзав. Нөгөө хувраг нь харин зөвшөөрч, охиныг үүрч, гол гаталган цаад эрэгт хүргээд цааш явжээ. Тэгээд нэгэн газар хүрч, хоёр хувраг жаахан амсхийж унтахаар болов. Охиныг үүрч гол гаталсан хувраг хэвтмэгц унтчихав, гэтэл нөгөө хувраг нь унтаж чадахгүй баахан бодол болж, ийш тийш хөрвөөсөөр унтаж байсан хуврагаа сэрээчхэв. Тэгээд: “Хүндэт ламтан минь ээ! Та өнөөдөр яагаад сахилаа зөрчиж, эмэгтэй хүнийг үүрч гол гатлав аа” гэж асуужээ. Тэгэхэд нөгөө хувраг: “Өө, Бурхан минь! Би голын эрэг дээр түүнийг нэгэнт тавиад орхичихсон байхад та яагаад одоо болтол охиныг үүрсэн хэвээр байна вэ?” гэжээ.

Чухам хэн нь баригдаж хүлэгдэж байгааг та нар мэдэв үү? Сахилд тэгж ихээр хүлэгдэх нь буруу. Тэр хувраг хэдийгээр охиныг үүрсэн боловч үүрээгүйтэй адил байж.

Харахад сахилаа зөрчсөн шиг боловч муу бодол өвөрлөөгүй, зөвхөн бусдад тусалсан төдий бөгөөд тусалж дуусчхаад мартжээ. Гэтэл нөгөө хуврагийг харахад сахилаа сахиж байгаа шиг боловч сэтгэл нь ариун биш, угаас цэвэр ариун хэргийг харин муугаар бодсон байна, ойлгосон биз?

Тэр хувраг зөвхөн бусдын өнгөн талын үйл хэргийг харснаас биш, харин бусдад туслах гэсэн цэвэр цайлган сэтгэлийг ойлгоогүй байна. Бүр хар муухай сэтгэлээрээ бусдыг магадлан шүүмжилж, тэр ч байтугай нойр нь хулжихдаа тулжээ. Нөгөө хувраг үүрсэн охиныг голын эрэгт тавиад цаашаа хэдэн километр явахдаа аль хэдийн мартсан бөгөөд амсхийх үеэрээ тайвуу сайхан нойрсжээ. Гэтэл нөгөөх нь харин бухимдан уурлаж, өнөө охиныг сэтгэлдээ хэдэн километр алс тээж, огтхон ч тавьж явуулаагүй байж. Энэ бол сая сахилаа зөрчиж байгаа хэрэг мөн.

Нөгөө хуврагийг харахад сахилаа зөрчсөн шиг боловч зөрчөөгүй байна. Учир нь тэр олон зүйлийг бодоогүй бөгөөд сахилаа зориудаар зөрчөөгүй, зөвхөн бусдад туслахыг л бодсон байна. Гэтэл өнөө хувраг хэдийгээр сахилаа зөрчөөгүй боловч бодол сэтгэл нь тайвшраагүй, унтах нойргүй, хэдэн километрийн турш өнөө охиныг сэтгэлдээ тээсээр явжээ. Ийм байдал нь бас л сахилаа зөрчиж байгаа хэрэг болно.

Багш нь яагаад тэр хуврагийг сахилаа зөрчлөө гэж ярьсан бэ? Мэдэх хүсэлтэй бол эхлээд юунд сахил сахих хэрэгтэй вэ, сахилаа зөрчих нь яагаад муу байдаг вэ? гэдгийг ойлгох хэрэгтэй. Жишээлбэл, урьд нь ярьсанчлан, хамрыг нь дөрлөн хөтөлж явдаг үхэр шиг, хэрвээ хөтөлж байгаа хүнийг дагаж явахгүй бол хамар нь өвдөх болно.

Сахил сахиж, бясалгал хийдэг хүмүүсийн хувьд ч бас үүнтэй адил. Сахилга батад дассан, сахил дүрмүүдийг нэгэнт сахиж хэвшсэн байдаг бөгөөд энэ ертөнцөд амьдрахдаа ингэж хийвэл сайн, тэгж хийвэл муу гэдгийг

ойлгочихсон байдаг. Тэгээд муу үйл мөн гэдгийг тодорхой мэдсээр байж хийчихвэл нинжин сэтгэлийнхээ зэмлэл буруутгалыг хүртэж, санаа сэтгэл тогтворгүй болдог бөгөөд өвчилсөн ч ихэвчлэн шалтгааныг нь мэддэггүй. Энэ бол сахил сахидаггүйн муу тал болно.

Сахилаа сахиж, өөрийн хийсэн бүхий л үйл хэргээ бүгд зөв бөгөөд нийгмийн болон шашин суртахууны талын магтаал сайшаалыг олно гэдгийг мэдэж байвал, санаа сэтгэл амар амгалан байх болно. Сэтгэл тогтуун байвал, бясалгал ч тогтвортой байж, эргэлзээ төрөхгүй. Бодол сэтгэлд эргэлт буцалт, тээнэгэлзээ байхгүй болж, есөн шидийн юм бодохоо больдог. Ингэснээр нэгэн үзүүрт сэтгэлээр бясалгаж, маш түргэнээр самадид орж дээд түвшинд хүрэх болно. Санаа сэтгэл тээр дараатай байвал доош татагдан унах болно. Энэ бол сахил сахиж хэрэгтэй байдгийн шалтгаан юм.

Нөгөө хувраг сахил сахиж шаардлагагүй. Тэр сахил сахижгүйгээр сахилаа сахидаг, учир нь түүний сэтгэл нэгэнт юунд ч хүлэгдэхгүй болжээ. Нэгэн охиныг үүрч гол гаталгах нь яг л нэг мод, бяцхан хүүхэд, эсвэл өөрийн ачаагаа үүрч байгаатай адилхан санагддаг болсон. Нөгөө хувраг бол албадлагын эрхээр сахил сахиж байгаа төдий, яг л саяхан ярьсан эмэгтэй авшигтантай адил. Авшиг хүртэхээс өмнө ургамал хоол идэх хоёр хоногтоо цагийн зүүг нүд салгалгүй ширтэж, оройн арван хоёр цаг болмогц тэр дорхноо бор хоол руугаа яаран гүйдэг. Ийм хүн бол жинхэнээр ургамал хоол идэж, сахил сахиж байгаад тооцогдохгүй.

Сэтгэлдээ ургамлан хоол идвэл болчихно гэж зарим хүн хэлдэг, яагаад ингэж ярина вэ? Сэтгэлдээ ургамлан хоол идэх гэдэг нь бясалгал хийж, ургамлан хоол идэхийг чин сэтгэлээсээ хүсэхийг хэлдэг. Харин ургамлан хоол иднэ гэж ярихаас цаашгүй, бор хоол идэхийг хүсдэг бол энэ нь буруу юм. Гэвч маш олон хүн ингэж боддог, энэ бол сахил сахиж байгаа хэрэг биш.

Багш нь яагаад өнөөх хувраг тэр охиныг үүрээгүй байтлаа сахилаа зөрчив гэж ярьсан бэ гэвэл тэр өөрийн бие, сэтгэлээ амарлингуй байлгаж чадсангүй. Найзынхаа үйлдлийг зэмлэн буруушааж, найздаа уурласан байна. Ингэх нь тэр өөрийгөө хорлож, бясалгалын талдаа сахилаа зөрчсөнтэй адил билээ. Ойлгож байна уу? Бид сахил сахидаг нь өөрийн сэтгэлээ амарлингуй тайвуу болгодог, гэтэл тэр тэгж чадаагүй болохоор сахилаа зөрчжээ, ийм л төдий. Тиймээс бид сахил сахиж байгаа эсэхийг нь өөр өөр нөхцөл байдлын дагуу тогтоох хэрэгтэй.

Есүс Христийн билиг ухаан

Есүс Христийг амьд сэрүүн байх үед нэг бүсгүй нууц амрагтай болсноос ялд унажээ. Есүс Христ үүнийг яаж шийдвэрлэх бол гэж хүмүүс анхаарч байв. Тухайн үед нууц амрагтай болсны ял шийтгэл нь олон хүн түүн рүү чулуу шидэж алдаг, хамгийн багадаа хүнд шархдуулдаг байв. Есүс Христ өнөө бүсгүйг гэмгүй гэж яривал хүмүүс түүнийг дураар чалчиж байна, хууль дүрэм, ёс суртахууныг хүндэтгэхгүй байна гэж шүүмжлэх болно. Гэмтэй гэж яривал мөн л түүнийг нигүүлсэнгүй биш, эгэл хүн шиг бусдыг залхаан шийтгэдэг гэж ярих болно.

Тэд Есүс Христийг арга барагдуулахаар санаархжээ. Гэтэл Есүс Христ хүүхэд биш хойно арга барагдаж яаж болох вэ? Өнөөх бүсгүй яагаад ялд унасан гэдгийг тэр мэднэ. Тэр бүсгүйн ярьснаас харахад эр нөхөртэй боловч үнэндээ ямар ч хайр сэтгэлгүй гэжээ. Түүний нөхөр нь эрх сүр, эд мөнгөө ашиглан бүсгүйг угийн хайр сэтгэлтэй хүнээс нь, өөрөөр хэлбэл нууц амраг гэгдэх нөгөө эрээс нь салгаж, хүчээр эхнэрээ болгожээ.

Гэрлэсний хойно бас өнөөх эр нөхөр нь бүсгүйд сайнаар хандсангүй, өдөр бүр хүнд ажил хийлгэж, хэдэн

жилээр байнга загнан зодож, тэвчихийн аргагүй болгожээ. Бүсгүй ихэд гуньж зовдог ч чухам хаа очихоо мэддэггүй. Урьдын хайрласан эр нь удаж удаж нэг удаа ирдэг бөгөөд уулзсаны дараа ихэд баярлаж, зөвхөн харилцан тэврэлцдэг төдий л байжээ. Энэ бол хүн бологсдын энгийн хайр сэтгэл. Тиймээс бүсгүй өөрийгөө ял гэмтэй гэж бодоогүй. Есүс Христ түүнийг хэлмэгдсэнийг мэддэг болохоор ял гэмгүй гэжээ. Энэ нь тийм нөхцөл байдалд л ял гэмгүй гэдгийг л илтгэж байгаагаас биш, харин нууц амрагтай болсон бүхэн бүгд л ял гэмгүй гэсэн хэрэг биш.

Гэтэл өөр хүмүүс үүнд яаж итгэж чадах билээ? Тэд ял гэмийн гэрч баримт нэгэнт хангалттай болчихсон гэж ярина, тус орны хууль дүрмийг үндэслэвэл өнөөх бүсгүй олон хүний шидсэн чулуунд зодуулна. Есүс: “За! Та нар хэрвээ түүнийг ял гэмтэй гэж бодвол чулуу шидээрэй! Гэхдээ өөрийгөө хар багаасаа өдийг хүртэл огт гэм зэм хийгээгүй, ямар ч муу хэрэг үйлдээгүй гэж үздэг хүн байвал эхний чулууг шидээрэй!” гэж хэлжээ. Хүмүүс үүнийг сонсоод цөм толгойгоо ганзагалаад дув дуугүй зайлж оджээ.

Багш нь энд, эсвэл өөр ямар нэгэн газарт очдог нь хүмүүсийн үйл ажиллагааг шүүж шалгахын төлөө биш, зөвхөн та нарт хялбар дөхөм бөгөөд шулуун түргэн нэгэн зам бий гэдгийг сануулахын төлөө билээ. Энэ замыг эртнээс эдүгээ болтол Төгс Гэгээрсэн Их Багш нар нэгэнт засан тэгшилж явахад бэлэн болгочихсон байдаг. Хэрвээ даруй түргэнээр диваажинд буцахыг хүсвэл яагаад энэ замаар явахгүй байна вэ?

Мод чулуунд хашигдаж, бут сондуул хөглөрсөн энхэл донхол замаар явах нь тун аюултай бөгөөд цаг завьг ихэд үрнэ, зорьсон газартаа чухам хэзээ хүрч чадахыг мэдэхийн аргагүй. Гэвч ихэнх үед зорьсон газартаа хүрэхээс өмнө амиа алдаж ч мэднэ. Тиймээс Багш нь сая зам зааж өгч, та нарт сануулж байгаа билээ. Багш нь бусдын ял гэмийг шүүж,

эсвэл шүүмжилж дайрч байгаа биш. Бусдын ял гэмийг ямар ч алдаагүй шүүн тогтоож чаддаг туйлын эрхэм дээд хүн байдаг гэж Багш нь үздэггүй. Өөрийгөө ч гэсэн ямар ч ял гэмгүй бөгөөд өөрөөсөө дэсээр доор хүмүүсийг зэмлэн шүүмжилж чаддаг гэж үздэггүй, ерөөс ингэж бодоогүй.

Энэ ертөнцөд хамт амьдрахдаа бид бага зэрэг ч гэсэн нийтийн үйл үрийг хуваалцдаг, нэг хүн алдаа гаргавал бүгдээр хариуцах ёстой. Харин ганцхан тухайн хүний алдаа биш. Тухайлбал, сонин хэвлэл уншиж, нийгэмд гарсан зарим хэргийг уншиж байхад эмэгтэйчүүдийг хүчирхийлж, шүүхээр ял сонссон олон хүн харагддаг. Залхаан шийтгэх нь зөв, гэхдээ зөвхөн ялтан л буруутай биш, улс даяар цөм хариуцах ёстой байж таарна. Учир нь тэр шалиг завхай кино болон бие махбодынхоо нууцгай хэсгээ дэндүү ил болгож, хүмүүсийн сэтгэлийг татаж, ил задгай хувцасладаг эмэгтэйчүүд эрчүүдийн шунал хүслийн уг чанарыг өдөөдөг.

Тиймээс алдаа гаргасан хүмүүс залхаан шийтгүүлэх нь зүйтэй хэр нь өөр хүмүүс ч гэсэн ухааран сэхээрч, үүрэг хариуцлагаа биелүүлж, ойр хавийн амьдарч буй орчин тойрноо хамгаалж, ял гэм хийгсдийг өдрөөс өдөрт багасгах хэрэгтэй. Үр хүүхдээ сурган хүмүүжүүлж, ах дүүсээ удирдан дагуулж, нийгмээ сайжруулах хэрэгтэй. Боломжийнхоо хэрээр чармайвал гэмт хэрэг үйлдэгсэд яриангүй багасах болно. Бид энэ нийгэмд оршин амьдрахдаа нийгэм болон дэлхий ертөнцийн ялзармал байдалд зохих хариуцлага үүрвэл зүйтэй гэж Багш нь үздэг. Багш нь олон орноор тойрон ном тайлж, уламжлан дэлгэрүүлж байгаа нь боломжийнхоо хэрээр гараг дэлхийг авран туслахын төлөө билээ. Харин өөрийгөө эрхэм дээдээр үзэж, ондоо хүсэл зорилготой хүмүүсийг дур зоргоороо шүүж шүүмжлэхийн төлөө биш юм гэдгийг та нар ойлгож байна уу?



ХАА САЙГУЙ ОРШИХ УГ ДҮР

*Төгс Гэгээрсэн Их багш Чин Хайн айлдвар
Америкийн Калифорин мужийн Лос Анжелес хот
1997 оны 7 дугаар сарын 19
(Эх нь вьетнам хэлээр)*

*※Бид аугаа их, аливаа бүхнийг ойлгон мэддэг түвшиндээ
буцахыг хүсвэл Арьяабалын бясалгалын аргаар бясалгаж
байж л сая аливаа бүхнийг дахин таньж чадна.*

Бид энд ярилцан сууж байгаа үед үнэндээ бас өөрийн мэддэг болон мэддэггүй түвшиндээ оршин байдаг. Зөвхөн энд л хүн болж амьдрах төдийгүй, үүнийхээ зэрэгцээ бас тэнгэрийн элч, Эзэн Бурхан, Будда болж, тэр ч байтугай чөтгөр ч болдог. Учир нь орчлон дэлхийд маш олон дэсийн түвшин оршин байдаг. Жишээлбэл: өнөөдөр та шарсан веган хоол бэлтгэж, нэг хүн танд нэг ширхэг савхан мод өгчээ. Түүнд та чинжүү, дүүфүү, веган хиам зэргийг шорлон хэлхэж болно. Тэр үеэр та гар дахь шорлоотой олон төрлийн ногоог маш тод харж чадна. Хүний амьдрал мөн л ийм. Бид орчлонгийн бүх чанар болон түвшинг хамтад нь ойлгож чаддаг. Бид гагцхүү үүнийгээ мэддэггүй төдий л юм!

Хамаг оршихуй нь нэгэн цогц

Бид одоо энэ ертөнцөд хүний төрөл авч, “хүн”-ий амьдралаар амьдрахыг сонгосон болохоор үүнийгээ биелүүлэхийн тулд өөр бусад хаалгыг хаах хэрэгтэй. Хэрвээ өөр хаалгуудыг онгойлгочихвол хүн байхын зэрэгцээ бас тэнгэрийн төрөлтөн, Будда, Эзэн Бурхан болж өнгөрсөн, одоо болон ирээдүйгээ мэдэх болно. Гэхдээ ингэвэл та өөрийн үүрэг хариуцлагаа гүйцэтгэж чадахгүй. Өөрийн сонгосон хүний амьдралаа үргэлжлүүлж чадахгүй болно. Тиймээс гурав, дөрөв болон тавдугаар ертөнц гэж угаас ялгадаггүй. Бид бол аливаа бүхэн мөн. Хоёр, гуравдугаар ертөнц бол бид мөн. Дөрөвдүгээр ертөнц бол бас л бид мөн.

Бид аугаа их, аливаа бүхнийг ойлгон мэддэг түвшинд буцахыг хүсвэл Арьяабалын номын цогцосыг бясалгаж байж л сая аливаа бүхнийг дахин таньж чадах болно. Бясалгалын зэрэг дэс дээшлэх тусам: үнэндээ бид бол аливаа бүхэн мөн, учир нь хамаг оршихуй нэг цогц мөн гэдгийг улам их ойлгох болно. Бясалгал хийхгүй бол өөрийгөө хүн төрөлтөн гэдгээ л ойлгодог. Өдөржин тогтчихсон ажлаа үргэлжлүүлж, гэртээ харьсны дараа эр нөхөр, эхнэр хүүхдээ асран харгалзана, эсвэл хэрүүл маргаан үүсгэнэ. Үүнээс өөрийг мэдэж чадахгүй.

Хүний амьдралын энэ аяллаас аяндаа залхаж, үүнийг буруу сонголт гэсэн бодол төрж, бүр ч илүү зүйлийг мэдэхийг хүсвэл Арьяабалын бясалгалын аргаар бясалгаарай! Ингэвэл бидний амьдрал аяндаа адилгүй болно. *(Бүгд алга ташиув.)* Юу болох нь энэ вэ? Та нар яагаад ингэж нижигнэтэл алга ташиж байна вэ? *(Маш сайн гэж бүгд хариулав.)* Багш нь ийм муугаар ярьж байхад та нар бас л ойлгочих юм даа, үнэхээр сүрхий юм аа! Багшийнх нь ярьж байгаа зүйл бол тун ээдрээтэй, ойлгуулахад бэрх тул үнэндээ та нарт ойлгуулж чадахгүй байх вий гэхээс би тун их санаа зовж

байлаа.

Шарсан ногоог шорлосон савх модоор жишээлэхэд: үүнд шорлоотой олон ногооноос та дүүфүүг л идсэн байвал зөвхөн түүний амтыг л мэдэж чадна. Өлсөж байх үед дүүфүү хамгаас амттай санагддаг тул эхлээд түүнийг иддэг. Тэр үедээ зөвхөн дүүфүүний л амтыг мэддэг. Учир нь зөвхөн дүүфүүг л сонгож, түүнийг амтархсан болохоор санаа бодлоо түүнд хандуулж, тэр зүсэм дүүфүүг иддэг. Хэдийгээр савх модонд ногоо дүүрэн шорлоотой байлаа ч бид тэдгээрийг анзаараагүй болохоор өөр ногоо байгааг мэддэггүй.

Мэдээж, тэр ногоо биднийх боловч анзаараагүй болохоор тэр бүхнийг үлдээчихжээ. Бид хамаг бодол санаа, анхаарлаа тэр жижигхэн хэсэг дүүфүүд хандуулж, амтархан идсэн болохоор зөвхөн дүүфүүний сайхан амтанд мансуурч, өөрийн эрхгүй өөр бусад идээг нь мартжээ. Гэхдээ ямартаа ч гэсэн тийм олон идээ байдгийг цаанаа мэдэж байгаа болохоор өөр зүйлийн амттай идээг хүсэх үедээ аяндаа санаж олох болно.

Бид насан туршдаа зургаа дахь мэдрэхүйтэйгээ байнга холбоотой байдаг. Та нар хүүхэд наснаас өнөөг хүртэлх өнгөрүүлсэн амьдрал, тэр ч байтугай Арьяабалын аргаар бясалгахаас өмнөх амьдралаа дурсан санавал тэр дурсамжуудаа эргэн санадаг. Тийм үү, үгүй юу? Заримдаа ямар нэгэн газар сууж байхдаа өөрөө сайн мэдээгүй ч ямар нэгэн хэрэг, цаашилбал огт хийгээгүй хэргээ гэнэт зөнгөөрөө мэдэрдэг. Гэхдээ цаанаа мэдэж байдаг. Заримдаа харин хийх гэж байгаа ямар нэгэн хэргийнхээ төлөө айх бодол төрж, зургаа дахь мэдрэхүйгээс бидэнд битгий гэж хэлдэг. Заримдаа ажлынхаа явцад: “Аан за! Энэ хэрэг бүтэхгүй юм байна!” гэж бодсоны эцэст нээрээ бүтдэггүй. Үүнийг бид зөн совингоороо аль хэдийн мэдчихсэн байдаг.

Ажлаа хийж дуусгахаас өмнө үр дүнг нь яагаад

урьдчилан мэдчихдэг вэ? Ихэнх хүн үүнийг зургаа дахь мэдрэхүй гэдэг. Зарим хүн бас урд төрлийн сэтгэгдэл гэж хэлдэг. Үнэндээ ийм биш шүү! Далд ухамсар, өнгөрсөн буюу ирээдүйн туршлага гэж ярьдаг нь нэг зүйлийн хэллэг төдий зүйл. Үнэн хэрэгтээ урд төрөл, хойд төрөл гэж байдаггүй. Амь нас бол эхлэл, төгсгөлгүй үргэлжилсэн нэг шугам юм. Зөвхөн бид л түүнийг өнгөрсөн болон ирээдүй гэж хуваадаг хэрэг.

Ингэж хувааж ялгаснаар тус тусдаа бие даасан, өөр өөрийн адилгүй туршлага хуримтлуулах болжээ. Яг л бид гэрээ олон өрөө болгон хуваадагтай адил. Салгаж тусгаарлахаас өмнө задгай талбай байсан. Хэрвээ гэр доторх бүх ханыг нураавал бас л задгай талбай болчихно. Хана босгож салгаснаар бид хувийн зүйлсээ хийхэд амар болдог билээ.

Өнгөрсөн, одоо, ирээдүй гэж байдаггүй

Үүнтэй адилаар, мөнхийн амь нас гэдэгт зөвхөн “хүн” болж амьдрах хугацаан дахь замнал багтаад зогсохгүй, аливаа төрөлтний амьдралын замнал ч багтдаг. Мөнхийн амь нас нь маш олон өөр төрөл зүйлээс бүрддэг бөгөөд “энэ нас”-аа элээхийн зэрэгцээ “өнгөрсөн” болон “ирээдүй”-н амьдралаа ч туулдаг. Учир нь цаг хугацаа болон орон зай нь угаас оршдоггүй.

Бид аль нэгэн цаг хугацаа болон орон зайг сонгодог нь хүн болж амьдрахын төлөө л юм, ингэснээр л сая, одоо хийж байгаа үйл хэргээ үргэлжлүүлж чаддаг. Хэрвээ өнгөрсөн болон ирээдүйн бүх ажлаа хоромхон зуур дуусгачихвал дэндүү утгагүй болчих биш үү? Бид ингэх дургүй. Энэ дэлхийд ирж, хүний төрөл авч болдог бөгөөд хожим өөр нэгэн хугацаанд тэнгэрийн төрөлтөн, будда, эсвэл өөр дэсийн төрөлтний амьдралыг сонгож болно.

Чөтгөр, эсвэл адын амьдралыг сонговол өөр нэг хугацаанд тэдний амьдралыг туулж болно.

Бид хүн, чөтгөр, ад, эсвэл тэнгэрийн төрөлтний амьдралын замналыг тус тусад нь ойлгохын тулд цаг хугацаа болон орон зайн хаалгыг хаадаг. Үнэндээ аливаа төрөлтний амь нас хязгааргүй үргэлжилдэг, аливаа бүхэн өнгөрсөн, одоо, ирээдүй гэж байхгүй энэ хязгааргүй хугацааны хүрээнд л оршдог. Ямар нэгэн онцгой төлөвлөгөөг биелүүлэхийн төлөө, эсвэл өөрийн дуртай үйл хэргээ бодитой ойлгож мэдрэхийн тулд амь насны аль нэг хэсгийг сонгодог. Ингэдэг нь зөвхөн ийм төрлийн амьдралыг туулахын төлөө л байдаг юм. *(Бүгд алга ташив.)*

Ай даа! Ингэх нь тун бэрх, учир нь өөрийгөө гэгээнтэн, будда гэдгийг зэрэг мэдчихвэл хүний амьдралын үүрэг хариуцлагаа биелүүлж чадахгүй болно. *(Бүгд алга ташив.)* Ингэх боломжгүй. Учир нь бид юу хийсэн ч бүхий л хүч чармайлтаа зориулж, бодол санаагаа хандуулж байж л сая бүрэн гүйцэд ойлгож чадна. Өөрийгөө бурхан гэдгээ аль хэдийн мэдчихсэн бол эр нөхөр чинь таныг хаях үед та яаж сэтгэл шаналан уйлж чадах вэ? Уйллаа ч гэсэн ямар ч сэтгэл хөдлөлгүй байна. *(Бүгдээрээ инээлдэж, алга ташив.)*

Хэрэв сэтгэл хөдлөлгүй уйлбал эр нөхөртөө хаягдсан бүсгүй хүний зовлонг ойлгож чадахгүй. Өөрийгөө туршин шалгахын тулд нягт нямбай төлөвлөсөн дүрдээ төгс сайхан тоглож чадахгүй. Ийм дүрд туршин тоглодог нь тиймэрхүү сэтгэлийн эмзэглэл, гуниг зовлонг ойлгохын төлөө билээ. Ингэснээр хүмүүс хаягдсан бүсгүйн сэтгэлийн гунигийг ярилцах үед бид сая энэ тухай ойлгон өрөвдөх сэтгэл төрж, боломжийнхоо хэрээр тэдэнд тусалж асуудлыг нь шийдвэрлэх болно. Өөрөө нэгэнт тийм зовлонг туулж байсан учраас тэр.

Будда хэрвээ хаана ч очихгүй, юу ч хийхгүй, сэтгэл гуниглахгүй, санаа зовдоггүй юм бол бид ийм байдлыг

сонгосон ч болно. Ямар ч асуудалгүй. Гэтэл ихэнх хүн олон зүйлийн зовлонг амтархан туулах байдлыг сонгодог нь зугаа цэнгэлийн төлөө юм. Учир нь орчлонгийн зах хязгааргүй амь насны үргэлжлэлд бид юу ч хийхгүй байдлыг сонговол уйдаж үхэхэд хүрнэ шүү! (Бүгд инээв.) Өнөөдөр бид эр нөхрөө голж хаяна, маргааш нь эр нөхөр маань дахин биднийг голж хаяна, ийм амьдрал гээч нь ёстой зугаа цэнгэлтэй биш үү? (Бүгд инээхийн зэрэгцээ алга ташив.)

Жишээлбэл, нэгэн Бурхан хүний амьдралыг сонгон амьдрах үедээ бурхан гэдгээ мэдсээр л байдаг бол эхнэр нь түүнээс салах үед ямар сэтгэгдэл төрөх бол? Эсвэл эр нөхөр нь салж явах үед ямар сэтгэгдэл төрөх бол? “За ашгүй дээ!, Явбал ч яваг, амрагаар дутдаггүй хорвоо хойно дахиад нэгэнтэй нь ханилаад жаргана. Сэтгэлээр унах хэрэг алга!” гэж бодож ч мэднэ, амь насанд эцэс төгсгөл байдаггүй болохоор тэр ирээдүйгээ харж: “Шинэ амраг маань удахгүй ирнэ, урьдын нөхрөөс бүр ч илүү сайхан байж таарна” гэж ярина. Дараа нь: “За! Явсан ч яахав, надаас хол зайлсан нь илүү дээр” гэж бодоод уйлахаа болино.

※ Бид “энэ нас”-аа элээхийн зэрэгцээ “өнгөрсөн” болон “ирээдүй”-н амьдралаа ч туулдаг.

“Хүн” дүрдээ гоц сайхан тоглохуй

Одоо бид ойлгоход нилээд амархан хэргийн тухай ярья. Таны дуртай аль нэгэн жүжигчин, жишээ нь Элизабет Тейлор, тэрээр Египетийн хатан хаан Клеопатра-гийн дүрд тоглох үед бүх оюун санаа болон анхаарлаа энэ дүрдээ хандуулж байж л сая гоц сайхан тоглож чаджээ. Хэрвээ тоглох үедээ өөрийгөө найман удаа гэрлэж, найман удаа ураг салсан Элизабет Тейлор гэдгээ санаж байвал тоглолтын байдал нь адилгүй болчихно! (Бүгд инээв.) Тэр

дүрдээ сайхан тоглож чадахгүй байж мэднэ. Саяхан салсан эр нөхрөө санаж байвал түүнийхээ төлөө сэтгэлээр унаж гунигийн хар мананд төөрөх болно. Тэгвэл Клеопатра-гийн дүрд яаж тоглож чадах билээ. Тэрээр жүжигтээ тоглох үедээ Клеопатра болж хувирах ёстой.

Энэ жишээнээс бид дорхноо ойлгож болно. Будда болон Эзэн Бурхан бас л ийм. Хүний амьдралыг сонгомгоцгоо “хүн”-ий дүрд төгс төгөлдөр тоглох хэрэгтэй. Өөрийгөө аанай л Будда, Эзэн Бурхан гэдгээ санасаар байвал “хүн төрөлтөн”-ий дүрд хэзээ ч тоглох аргагүй. Эзэн Бурхан, Бурхан бодьсатва агуу их, зөн билиг нь цаглашгүй. Тэд бүсгүйдээ хаягдсан сэтгэлийн гунигт автан нулимс унагадаггүй, ийм байдал хэзээ ч үүсдэггүй, ийм л учиртай шүү! (*Бүгд инээв.*) Тиймээс заримдаа Багш нь та нар ч гэсэн Бурхан бодьсатва, гэгээнтэн мөн гэж ярихад та нар харин ойлгодоггүй. Учир нь нэгэнт өөрийн уг дүрээ мартахыг сонгосноос болж байгаа юм.

Одоо хүний амьдралаас залхаж, сурмаар зүйл алга болсон шиг санагдан өөрийн сонгосон замдаа сонирхолгүй болов. Сонголтоо зөв биш гэдгийг мэдсэн болохоор буцаж бурхан, гэгээнтэн болохыг хүсжээ. Эсвэл хүн болж амьдраад дэндүү удаж байна, дахин ижилхэн амьдралыг элээж, туулан гэтлэж чадахгүй гэдгээ бодмогц ихэд залхаж, сэтгэл хоргодох зүйл алга болдог. Та нар дээд түвшний төрөлтөн болохыг хүсвэл Арьяабалын бясалгалын аргыг сонговол зохино. (*Бүгд алга ташив.*)

ВЕГАН ХООЛНЫ АЧ ТУС

Насан турш веган (ногоон) хоолтон байх буюу ургамал хоол хэрэглэх нь Арьяабалын Бясалгалын (Quan Yin Method) авшиг хүртэх тэргүүн нөхцөл юм. Ургамлын гаралтай зүйлсийг хүнсэнд хэрэглэж болох ч өндөг болон амьтны гаралтай аливаа хоол хүнсийг идэж болохгүй. Үүнд олон шалтгаан байдаг ч хамгийн чухал нь амьтны амь хороож болохгүй гэсэн нэгдүгээр сахил буюу амьтан бүү хөнөө гэдгээс үүдэлтэй.

Амь хороохгүй байх, бусад амьд биест хор хүргэхгүй байх нь тэдгээр амьтанд ач тустай нь яриангүй. Бусдад хор хөнөөл учруулахгүй байх нь бидэнд ач тустай болох нь тэр бүр илт харагддаггүй. Энэ нь “ямар үйл хийнэ, тийм үр байна” гэсэн үйлийн үрийн хуулиар зохицуулагддагаас тэр юм. Мах идэх шунал хүслээ хангахын тулд амьтны амь хөнөөх, эсвэл бусдаар амьтны амь хороолговол та амь насны төлөөсөнд унаж, хэзээ нэгэн цагт заавал төлөх ёстой болно.

Веган хоол идэх нь үнэндээ бидний өөртөө барьж буй бэлэг юм. Ингэснээр бид хураасан асар их үйлийн үрээ нимгэлж, амьдралын чанараа сайжруулан, өөрийгөө улам чөлөөтэй сайхнаар мэдрэх төдийгүй, дотооддоо нэвтэрч диваажингийн нууцлаг, шинэ содон зүйлсийг ч мэдрэх болно. Энэ бүхнийг та веган хоол идсэнээрээ хүртэж буй хэрэг. Зарим хүн сүнслэг үзэл бодлоор махнаас татгалзуулдаг нотолгоонд нь итгэдэг ч веган хоолтон байхыг хөхиүлэн дэмждэг өөр олон зайлшгүй учир шалтгаан бий. Эдгээр нь хүний эрүүл мэнд, хоол хүнсний шим тэжээл, байгаль экологи, ёс суртахуун, амьтдын зовлон, дэлхийн өлсгөлөн зэрэг асуудалтай холбоотой юм.

ЭРҮҮЛ МЭНД БА ХООЛ ХҮНС

Хүн төрөлхтний хувьслын түүхээс үзвэл манай өвөг дээдэс төрөлхийн цагаан хоолтон байжээ. Хүний бие махбодын бүтэц нь мах идэхэд зохицоогүй. Колумбын их сургуулийн доктор Г.С.Хантинген хүний биеийн бүтэц зүйн харьцуулсан судалгааны өгүүллээрээ үүнийг нотолсон байна. Тэрээр махчин амьтны нарийн, бүдүүн гэдэс нь богино байдгийг анзаарчээ. Махчин амьтны бүдүүн гэдэс шулуун бөгөөд гөлгөр байдаг. Харин мах иддэггүй амьтны нарийн, бүдүүн гэдэсний аль аль нь урт байдаг. Махан дахь эслэгийн агууламж бага, уургийн нягтрал ихээс шим тэжээлийг шингээхэд урт хугацаа шаардагддаггүй тул махчин амьтны гэдэс богино байдаг аж.

Төрөлхийн ургамлаар хооллогч бусад амьтны нэгэн адил хүн төрөлтний бүдүүн, нарийн гэдэс нь урт байдаг. Бидний гэдэсний нийт урт барагцаалбал 8.5 метр (28 фут), олон нугалаатай, хана нь хуниастай, гулгамтгай биш, махчин амьтны нарийн гэдэснээс урт тул идсэн мах гэдэсэнд удаж ялзран хорт бодис ялгаруулдаг. Энэ нь шулуун гэдэсний хорт хавдар үүсэхтэй холбоотой төдийгүй элэгний ачааллыг ихэсгэж, элэгний хатуурал, элэгний хорт хавдар үүсэхэд хүргэнэ. Маханд ихээр агуулагддаг урокинез уураг, шээсний хүчил нь бөөрний ачааллыг ихэсгэж, үйл ажиллагааг нь алдагдуулдаг. Хагас килограмм шарсан үхрийн маханд 14 грамм урокинез уураг агуулагддаг. Амьд эсийг шингэн урокинез дотор хийхэд бодисын солилцоо нь алдагддаг байна. Маханд эслэг эд, ширхэглэг бодис бага байдаг бөгөөд эслэг бодис дутагдвал өтгөн амархан хатдаг. Өтгөн хатах нь шамбарам болон бүдүүн гэдэсний хорт хавдрыг үүсгэдэг.

Махан дахь холестерин, ханасан өөх нь зүрх судасны өвчин үүсгэдэг. Зүрх судасны өвчин нь америкчуудын нас баралтын шалтгааныг тэргүүлдэг бөгөөд өнөө үед Тайваньд ч мөн адил болжээ.

Хорт хавдар нь үхэлд хүргэж буй хоёр дахь том шалтгаан юм. Махыг шарж хайрахад метилхолантрен хэмээх химийн

бодис үүсдэг. Энэ нь маш хүчтэй хорт хавдар үүсгэгч болохыг туршилтаар нотолжээ. Нядалгааны газрууд мэргэжлийн байгууллагын хяналтад байдаг тул махны эрүүл ахуй асуудалгүй гэж ихэнх хүн үздэг. Үнэн хэрэгтээ нядалгааны газарт өдөр бүр маш олон үхэр, гахай, тахиа, нугас зэргийг алж худалддаг. Тэр бүхний хорт хавдартай эсэхийг нь нэг бүрчлэн шалгах бололцоогүй. Амьтан нэг бүрийг бүү хэл зүсэм махан дахь хавдрын эсийг нягтлах нь туйлын бэрхшээлтэй. Орчин үеийн махны үйлдвэрүүдэд амьтны толгой нь сэжигтэй бол толгойг нь, хөл нь өвчтэй бол хөлийг нь хаях маягаар өвчтэй хэсгийг салгаж бусдыг нь худалдаж байна. Ногоон хоолтон эмч, нэрт доктор Ж.Х.Келлог: “Бид веган хоол идвэл хоол хүнс маань ямар өвчнөөр үхсэн бол гэж санаа зовохгүй, айдасгүй амар тайван хооллоно!” гэжээ.

Өөр нэгэн санаа зовоож буй зүйл бол бордоо тэжээл, антибиотик болон өсөлт хурдасгах даавар, стеройд зэргийг агуулсан эм бэлдмэлийг амьтны тэжээлд холих буюу биед нь шууд тарьдаг явдал. Ийм мах идвэл эдгээр бодисууд хүний биед шингэдэг болохыг нийтэд мэдээлсэн байна. Махан дахь антибиотик нь хүмүүсийн эмчилгээнд хэрэглэж буй антибиотикийн үйлчилгээг бууруулах магадлалтай.

Зарим хүн веган хоол идэхэд шим тэжээл дутагдана гэж үздэг. Америкийн гэмтэл согогийн эмнэлгийн мэргэжилтэн, доктор Миллер Тайваньд дөч гаруй жил ажилласан бөгөөд эмнэлгийн ажилтан, өвчтөн цөмөөрөө веган хоол иддэг эмнэлэг байгуулсан байна. Тэрээр: “Орчин үеийн шинжлэх ухааны ачаар эм, эмнэлгийн шинжлэх ухаанд их дэвшил гарсан ч эм нь зөвхөн өвчнийг л анагаана. Харин хоол хүнс бол эрүүл мэндийг тэтгэнэ” гэжээ. Мөн тэрээр: “Ургамлаас авч буй шим тэжээл нь махныхыг бодвол бидэнд шууд хүрнэ. Учир нь амьтад ургамлаас шим тэжээлээ авдаг. Ихэнх амьтан нас богинотой, хүнд байдаг ихэнх өвчнийг тээдэг. Иймээс хүн төрөлтний өвчин эмгэгийн ихэнх нь өвчтэй малын мах идсэнээс үүсэлтэй байх магадлал тун өндөр. Хүн яагаад шим тэжээлээ ургамлаас шууд авдаггүй юм бэ?” гэжээ. “Үр тариа, буурцагт ургамал, хүнсний ногооноос хангалттай шим тэжээлээ авч эрүүл саруул байх бүрэн боломжтой” гэж Доктор

Миллер үзсэн байна.

Амьтны уураг төгс, ургамлынх төгс бус учраас амьтны уураг ургамлынхаас илүү гэж олон хүн үздэг. Үнэндээ зарим ургамал төгс уурагтай. Хүнсний бүтээгдэхүүнүүдийг хооронд нь зөв харьцаагаар хольж төгс уураг үүсгэж болно.

Америкийн Хоол Судлалын холбооноос 1988 оны гуравдугаар сард “Шим тэжээлт чанарыг нь зохистой тохируулж чадвал веган хоол нь эрүүл мэндэд ашигтай, хангалттай шим тэжээлтэй” гэж зарлажээ.

Мах иддэг хүмүүс веган хоолтнуудаас хүч чадалтай байдаг гэсэн төөрөгдөл түгээмэл байдаг. Йелийн их сургуулийн профессор Ирвинг Фишер 32 веган хоолтон, 15 махан хоолтон оролцсон туршилт хийхэд веган хоолтнууд нь илүү тэсвэр хатуужилтай байжээ. Туршилтад оролцогсдыг удаан хугацаагаар гарыг нь өргүүлэхэд үр дүн нь тун тодорхой байв. Мах иддэг 15 хүний 2 нь л арван таваас гучин минут өргөсөн бол веган хоолтон 32 хүний 22 нь арван таваас гучин минут, 15 нь хагас цаг, 9 нь нэг цагаас дээш, 4 нь хоёр цагаас дээш, нэг нь гурван цагаас дээш хугацаагаар өргөсөн байна.

Марафон гүйлтийн тамирчид тэмцээний өмнө веган болон цагаан хоол иддэг байна. Цагаан хоолоор эмчлэх мэргэжилтэн, эмч Барбара Море 200-гаад км зайг 27 цаг 30 минутад туулжээ. Тавин зургаан настай энэ эмэгтэй залуучуудын тогтоосон дээд амжилтыг эвдсэн байна. Тэрээр: “Веган хоолтон хүн эрүүл чийрэг, ухаан саруул, цэвэр ариун амьдралтай байдгийг харуулах жишээ байхыг би хүссэн юм” гэжээ.

Веган хоолтон хоол хүнснээсээ хангалттай хэмжээний уураг авч чаддаг уу? Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын зөвлөснөөр бид өдөр тутам авах илчлэгийнхээ 4,5 хувийг нь уургаас авч болно. Буудайн 17%, ногоон цэцэгт байцайны 45%, цагаан будааны 8%ийн илчлэгийн эх үүсвэр нь уураг юм. Иймээс мах хэрэглэхгүй веган хоол идвэл хоол хүнснээсээ хангалттай уургийг амархан авч болно. Хүртэж болох өөр ач тус гэвэл өөх тос хэтрүүлснээс үүсдэг зүрх судасны өвчин, хорт хавдар зэргээс зайлсхийж чадна. Иймээс веган хоол идэх нь хамгийн зөв сонголт гэдэг нь илэрхий байна.

Зүрх судасны өвчин, хөхний болон шулуун гэдэсний хавдар, тархины саа өвчнөөр өвчлөх нь ханасан өөх тос ихээр агуулдаг мал амьтны гаралтай хүнсний хэт их хэрэглээтэй холбоотой нь батлагдаад байна. Тос багатай веган хоол идсэнээр бөөрний чулуу, булчирхайн хавдар, чихрийн шижин, арван хоёр нугалаа гэдэсний шархлаа, цөсний чулуу, ходоодны архаг үрэвсэл, үе мөчний үрэвсэл, буйлны өвчин, батга, нойр булчирхайн хавдар, ходоодны хавдар, цусан дахь чихрийн хэмжээ багасах, өтгөн хатах, дивертикулит, цусны даралт ихсэх, яс сийрэгжих, өндгөвчний хавдар, шамбарам, хэт таргалалт, багтраа зэрэг өвчнөөс урьдчилан сэргийлж, явцыг нь сааруулж тэр ч байтугай эмчилж болно

Тамхийг эс тооцвол хүний эрүүл мэндийг мах шиг хохироож байгаа зүйл байхгүй байна.

ЭКОЛОГИ БА ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН

Мах идэхийн тулд мал амьтан тэжээх нь дараах хор уршигтай. Үүнд: ширэнгэн ойг сүйтгэх, дэлхийн дулаарал, усны бохирдол, усны нөөц хомсдол, цөлжилт, эрчим хүчний гарздал болон дэлхийг хамарсан өлсгөлөн зэрэг болно. Газар, ус, эрчим хүч, хүний нөөцийг мах боловсруулахад ашиглаж байгаа нь дэлхийн нөөц баялгийг үр ашиггүй зарцуулж байгаа хэрэг юм.

1960-аад оноос Төв Америкт үхрийн бэлчээрт зориулан халуун бүсийн ойн 25 орчим хувийг шатааж устгасан байна. Тооцоолсноос үзэхэд шатааж устгасан 5 метр квадрат ой тутмаас 115 грамм бургерын мах үйлдвэрлэжээ. Үүнээс гадна үхэр тэжээхэд ихээр ялгардаг гурван төрлийн хорт хий нь дэлхийн дулаарлыг ихэсгэдэг. Мөн 450 грамм үхрийн мах үйлдвэрлэхэд 9117 литр ус зарцуулдаг нь үнэхээр цочирдмоор. Гэтэл 450 грамм улаан лооль ургуулахад ердөө 107 литр ус, тийм хэмжээний цагаан талх үйлдвэрлэхэд 514 литр ус хэрэглэдэг. АНУ хэрэглээний усныхаа тэн хагасыг тэжээл бордоо тарих, үхэр тэжээх болон бусад мал амьтны хэрэгцээнд зарцуулж байна.

Үхэр бордоход хэрэглэж байгаа нөөц баялгаар үр тариа үйлдвэрлэж, дэлхийн хүн амыг хангавал маш олон хүн идэх хоолтой болох сон. Хэрэв нэг акр газарт овъёос тарьж малд биш хүмүүсийн хүнсэнд хэрэглэвэл махныхаас 8 дахин их уураг, 25 дахин их илчлэг өгнө. Нэг акр газарт тарьсан ногоон цэцэгт байцаа (брокколи) нь ийм хэмжээний газраас гаргаж авсан үхрийн махнаас 10 дахин их уураг, илчлэг, ниацин өгдөг. Иймэрхүү тоо баримт маш их. Мал амьтан тэжээж буй газарт хүнсний таримал таривал дэлхийн нөөц баялаг илүү үр ашигтайгаар зарцуулагдана.

Веган хоол танд энэ гараг дээр “өр төлөөсгүй амгалан амьдрах” боломж олгоно. Зайлшгүй чухал зүйлээ хэрэглээд, амь хороохоо багасгаж, хоолноос минь болж амьтны амь сүйдээгүй гэж бодохоор таны сэтгэл амар байх болно.

ДЭЛХИЙН ӨЛСГӨЛӨН

Дэлхийн бөмбөрцөг дээр нэг тэрбум орчим хүн өлсгөлөн, хоол тэжээлийн дутагдлаас шаналан зовж байна. Жилд 40 сая хүн өлсөж үхэж байгаагийн ихэнх нь хүүхэд юм. Гэтэл үүнийг үл харгалзан дэлхийн үр тарианы гуравны нэгийг хүмүүсийн хоол хүнсэнд бус, мал аж ахуйн хэрэгцээнд зориулж байна. АНУ-д үйлдвэрлэсэн үр тарианыхаа 70%-ийг малын тэжээлд хэрэглэж байна. Хэрвээ бид энэ үр тариагаар хүмүүсийг хоолловол хэн ч өлсөхгүй.

АМЬТНЫ ЗОВЛОН ЗҮДҮҮР

Америкийн Нэгдсэн Улсад өдөр бүр 100 гаруй мянган үхэр нядалдгийг та бүхэн харсан уу?

Өрнөдийн орнуудад ихэнх мал амьтныг “үйлдвэржсэн аж ахуй”-д тэжээж байна. Эдгээр фермүүд бага зардлаар олон мал амьтдыг нядлахаар тооцоолж баригдсан байдаг. Мал амьтныг зайгүй чихэлдсэн тун хэцүү орчинд байлгаж, тэдэнд, тэжээлийн мах бэлтгэдэг машин мэтээр хандаж байна. Бидний ихэнх нь бодит байдлын үнэн төрхийг өөрийн нүдээр хэзээ ч олж хараагүй. “Чи нядалгааны газар нэг л очвол насаараа веган хоолтон болно” гэсэн үг байдаг.

Лев Толстой: “Нядалгааны газар байгаа цагт дайны талбар байсаар байх болно. Цагаан хоол бол хүнлэг энэрэнгүй чанарын өндөр шалгуур юм” гэжээ. Бидний ихэнх нь амьтны амийг санаатайгаар хөнөөдөггүй ч нийгмийн зуршлаа дагаад байнга мах иддэг дадалтай болсон бөгөөд идсэн амьтанд ямар хор хөнөөл учруулснаа үнэндээ ойлгодоггүй.

ГЭГЭЭНТНҮҮД БА ҮЙЛС НЭГТНҮҮД

Хүн төрөлхтний тэмдэглэж үлдээсэн эртний түүхээс үзэхэд ургамал нь хүн төрөлхтний байгалиас заяасан хоол хүнс байжээ. Эрт үеийн Грек болон Еврейн домог үлгэрт хүмүүс анхнаасаа жимс жимсгэнэ иддэг байсныг өгүүлдэг. Эртний Египетийн билиг ухаант хуврагууд хэзээ ч мах иддэггүй байв. Грекийн агуу их философичид жишээ нь, Платон, Диоген, Сократ нар цагаан хоол идэхийг шийдвэртэй дэмждэг байв.

Энэтхэгт Шагжамуни Будда “Ахимса” буюу аливаа амьтанд хор хөнөөл учруулахгүй байхыг чухалчлан тэмдэглэж, амьтдыг айдаст автуулахгүйн тулд мах идэхгүй байхыг шавь нартаа дахин дахин анхааруулж байв. Будда: “Мах идэх нь ердөө л олдмол зуршил төдий. Бид мах идэх хүсэлтэй төрөөгүй. Мах идвэл их нигүүлслийн үр тасарна. Мах идэгчид бие биеэ алж иддэг. Энэ төрөлд би чамайг, дараа төрөлд чи намайг иднэ гэхчлэн хэзээ ч таслах аргагүй. Ийм хүн яаж гурван ертөнцийг гэтлэх вэ?” гэж өгүүлжээ.

Эрт үеийн Дао, Христ, Еврейн шашны олон лам хуврагууд цагаан хоолтон байжээ. Энэ талаар Библид тун тодорхой тэмдэглэсэн байна. Эзэн Бурхан: “Би та нарыг идэг гэж элдэв зүйлийн жимс, төрөл төрлийн үр тариа өгөв. Харин хээрийн амьтад болон бүх шувуудын хоол тэжээл болгож, өвс ногоо, навчит ургамлыг өглөө” гэж (Genesis, 1:29) Ариун Библид өгүүлжээ. Библид мах идэхийг цээрлэсэн өөр нэг жишээ нь гэвэл: “Амьтны мах, цусыг идэх ёсгүй. Цус амьтай” гэсэн үг юм. (Genesis, 9:4) Эзэн Бурхан: Хэн та нарыг энэ эр үхэр, эм ямааг алж, надад тахил өргө гэсэн юм бэ? Намайг мөргөл залбирлаа сонсоосой гэж байгаа бол гэмгүй амьтны цуснаас өөрийгөө цэвэрлэгтүн. Тэгэхгүй бол би та нараас нүүр буруулна. Яагаад гэвэл та нарын гар нэлдээ цустай байна. Надаар өршөөж уучлуулахын тулд гэм нүглээ наманчил.” (Isaiah: 11-16) гэж хэлжээ. Есүсийн шавь нарын нэг Гэгээн Павел Ромчуудад илгээсэн захидалдаа: “Мах идэхгүй, дарс уухгүй байх нь аль аль нь сайн хэрэг” гэсэн байдаг. (Ромчуудад илгээсэн захидал, 14:21).

Саяхан түүхчид Есүсийн амьдрал болон сургаалыг шинээр

тодруулсан олон эртний судар ном олж илрүүлсэн байна. Есүс: “Амьтны мах иддэг хүмүүс өөрсдийнхөө булш нь болдог. Та нарт үнэнээр нь хэлэх юм бол алж хөнөөж байгаа хүн өөрөө алагдах болно. Амьд амьтныг хөнөөж, махыг нь идэж буй хүн бол хүний үхдэл хүүрийн мах идэж байгаа хэрэг юм.” гэжээ.

Энэтхэгийн шашнууд ч бас мах идэхийг цээрлэдэг. Энэ нь “Хүн амьд амьтныг хөнөөхгүйгээр махыг нь идэж чадахгүй. Амьд амьтныг зовоож тарчлааж буй хүнийг Эзэн Бурхан хэзээ ч адислахгүй. Тийм учраас мах идэхийг цээрлэ!” (Энэтхэг шашны сахил). Исламын Ариун судар Коранд: Үхсэн амьтны мах, цусыг идэхийг хориглосон байдаг. Хятадын агуу их Зэн Багш Хань Шань-Зу мах идэхийг эрс эсэргүүцсэн найраглал туурвиж: “Эхнэр хүүхдээ тэжээхээр зах зээлээс мах, загасхан худалдан авах гэж яарах хэрэг юун. Таны амьдралыг тэжээж тэтгэхийн төлөөнөө эдний амь тасрах заавал албатай юу? Ингэхийн утга учир алга. Энэ нь таныг диваажинд хүргэхгүй, харин тамын хог новш болгоно!” хэмээжээ.

Маш олон алдарт зохиолч, урлаачид, эрдэмтэн, гүн ухаантан, гарамгай хүмүүс цагаан хоолтон байжээ. Үүнээс жишээ болгон цөөхнийг дурдвал: Шагжамуни Будда, Есүс Христ, Вергилий, Гораций, Платон, Овидий, Петрарка, Пифагор, Сократ, У.Шекспир, Вольтер, И.Ньютон, Леонардо Да Винчи, Чарльз Дарвин, Бенжамин Франклин, Ральф Уолд Эмерсон, Хенри Дэйвид Торо, Эмиль Золя, Бертран Рассель, Ричард Вагнер, П.Б.Шелли, Х.Ж.Уэллс, Алберт Эйнштейн, Рабиндранат Тагүүр, Лев Толстой, Жорж Бернард Шоу, Махатма Ганди, Алберт Швейцер болон орчин үеийнхнээс цөөхнийг дурдах юм бол Пол Ньюмен, Мадонна, Диана гүнж, Линдсей Вагнер, Пол Маккартни, Кандис Берген нар цагаан хоол идэх ёсыг зориг төгс сайшаан дагаж байв. Алберт Эйнштейн хэлэхдээ: “Миний бодлоор бол цагаан хоолны улмаас хүний зан чанарт гардаг өөрчлөлт, ариусгах нөлөө нь хүн төрөлхтөнд ихээхэн ашигтай юм. Иймээс хүмүүс цагаан хоол идэхийг сонгох нь буян хишигтэй болоод амар амгалан хоёр талтай юм” гэжээ. Энэ бол хүн төрөлхтний түүхэн дэх сод гарамгай, сэцэн мэргэн олон хүний номлосоор ирсэн сургаал билээ.

АВШИГ ХҮРТЭХҮЙ- АРЬЯАБАЛЫН БЯСАЛГАЛЫН АРГА

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай Үнэнийг таньж мэдэхийг чин сэтгэлээсээ эрмэлзэн тэмүүлж буй хүмүүст Арьяабалын бясалгалын аргыг авшгаар дамжуулан уламжилна. “Аялгуу ажиг” гэдэг нь Хятадаар амарлин сууж аялгууны хэлбэлзлийг ажиглах гэсэн утгатай. Энэхүү бясалгалын аргад дотоодын “Гэрэл” болон “Аялгуу”-г ажиг багтана. Эртнээс нааш дэлхийн шашнуудын болон бясалгалын ном сударт дотоодын ийм ахуй ойлголтыг олонтоо дурдсан байдаг. Тухайлбал, Христийн шашны “Библи”-д: “Түмэн бодис аялгуунаас үүссэн. Энэ аялгуу Эзэн Бурхантай хамт байсан. Аялгуу өөрөө Эзэн Бурхан байсан” гэжээ. (Иохан 1-р бүлгийн 1-р хэсэг) Энэхүү аялгуугаар дотоодын аялгууг заажээ. Мөн “Бурханы хэл”, “Шабд”, “Дао”, “Аялгууны урсгал”, “Ум”, “Тэнгэрийн хөгжим” гэж бас нэрлэдэг. Их Багш Чин Хай: “Тэрээр түмэн бодисын дотор хэлбэлзэн, бүхий л орчлон ертөнцийг тэжээн тэтгэдэг. Энэхүү дотоодын хэмнэл нь аливаа шархыг эмнэн, бүхий л хүсэл эрмэлзлэлийг хангаж, эгэл ертөнцийн элдэв дур хүслийг намжаана. Тэрээр бүхнийг чадагч бөгөөд хайраар бялхаж байдаг. Бид энэхүү аялгуунаас үүссэн болохоор түүнтэй холбогдвол сэтгэл ханаж амарлина. Энэхүү аялгууг сонссоноор бид бүхэлдээ хувирч, амь амьдралын тухай үзэл бодол маань үндсээрээ өөрчлөгддөг.” гэжээ.

“Билиг нээгдэх” гэдгээр дотоодын гэрэл- “Эзэн Бурханы гэрэл”-ийг хэлж байна. Гэрлийн хүч нь өчүүхэн багаас авахуулаад тоо томшгүй олон нарны гэрэл мэт хурц тод. Бид Бурханыг дотоодын гэрэл, аялгуугаар л таньж мэддэг.

Арьяабалын аргаар сүнслэг дадал бясалгал хийх, авшиг хүртэх нь ямар нэг нууц ёслол үйлдэж буй, эсвэл шинэ шашинд орж буй хэрэг биш. Авшиг хүртэх үеэр гэрэл болон аялгуу ажиглах онцгойлон анхаарах зүйлсийг зааж өгдөг. Хамгийн анхны ариун ахуй ойлголт чимээ аниргүйд бууж ирнэ.

Арьяабалын бясалгалын аргын хамгийн чухал хэсэг нь авшиг уламжлах юм. Таны билгийн үүдийг нээхэд Их Багш Чин

Хай өөрийн биеэр морилох шаардлагагүй. Гэхдээ Их Багшийн адислалгүй бол бясалгалын арга ач тусаа өгөхгүй. Авшиг хүртэх үед та тэр даруйдаа дотоодын аялгууг сонсож, дотоодын гэрлийг харна. Үүнийг “Агшнаа гэгээрэх” юм уу “Агшин зуур билиг нээгдэх” гэдэг.

Их Багш Чин Хай шашин шүтлэг, соёл уламжлалын ялгааг үл харгалзан авшиг хүртээдэг. Та шүтэж буй шашин, сүсэг бишрэлээ өөрчлөх шаардлагагүй. Таныг ямар нэгэн байгууллагад элсэхийг, эсвэл таны амьдралын одоогийн хэв маягт тохирохгүй аливаа үйл ажиллагаанд оролцохыг шаардахгүй.

Авшиг хүртэх нь ямар ч үнэ төлбөргүй.

Насаараа веган хоолтон байх нь авшиг хүртэх зайлшгүй нөхцөл болно.

Арьяабалын бясалгалын аргаар өдөр бүр бясалгах, таван сахил сахих нь авшиг хүртсэний дараах цорын ганц шаардлага юм.

Сахил нь өөртөө болон өрөөлд хор хүргэхгүй байхад туслах хэм хэмжээ бөгөөд үүнийг сахиж бясалгавал авшгаар нээгдсэн билиг ухаанаа улам тэлсээр эцэст нь хамгийн дээд ухамсрыг олж Будда болно. Хэрэв өдөр бүр бясалгахгүй бол билиг нээгдсэнээ мартаж, ердийн ухамсрын түвшинд эргэж очдог.

Өөрөө бясалгал хийж төгс гэгээрэлд хүрэхийг бидэнд зааж сургах нь Их Багш Чин Хайн зорилго билээ. Иймээс Түүний зааж буй бясалгалын аргаар хэн ч бясалгаж болдог. Нэмэлт тусламжид түшиглэхгүйгээр өөрөө бясалган дадуулж болно. Тэрээр сүсэгтэн, бишрэн шүтэгч, шавь эрдэггүй, гишүүнчлэлтэй байгууллага байгуулж хугацаат татвар хураадаггүй. Их Багш Чин Хай сөгдөж мөргөхийг зөвшөөрөхгүй, мөнгө төгрөг, бэлэг сэлт хүлээж авахгүй учир өргөл барьц хэрэггүй. Тэр зөвхөн таны өдөр тутмын амьдрал болоод бясалгал дадалдаа өөрийгөө дэвшүүлэн богд гэгээнтэн болохыг хүсэх тэрхүү чин сэтгэлийг чинь л хүлээж авна.

ТАВАН САХИЛ

Аливаа амьтанд хор хөнөөл учруулахыг цээрлэнэ;*

Үнэн бус зүйл ярихыг цээрлэнэ;

Өөрийн бус юмыг авахыг цээрлэнэ;

Бэлгийн зүй бус харилцааг цээрлэнэ;

Согтууруулах, мансууруулах бодис, хорт зүйл хэрэглэхийг цээрлэнэ;**

* Энэ сахил нь веган хоолны дэглэмийг хатуу мөрдөхийг шаардана. Мах, сүү, сүүн бүтээгдэхүүн, загас, шувууны мах, өндөг (өндөгтэй болон сүүтэй боов, чихэр, бялуу, жигнэмэг, зайрмаг гэх мэт) амьтны гаралтай аливаа хүнсийг хэрэглэж болохгүй.

** Энэ сахилд бүх төрлийн хорт бодис, тухайлбал: архи уух, тамхи, хар тамхи татах, мөрийтэй тоглоом тоглох, садар самуун, хүчирхийлэлтэй кино, зураг үзэх, ном, сэтгүүл унших, компьютер тоглоом тоглох зэрэг аливаа хортой зүйлээс зайлсхийх багтана.

ТӨГС ГЭГЭЭРСЭН ИХ БАГШ ЧИН ХАЙН НОМ ХЭВЛЭЛИЙН ЖАГСААЛТ

Агшин зуур Гэгээрэхийн Түлхүүр

Англи (1-5), Ау Лак (1-15), Герман (1-2), Индонез (1-5), Испани (1-3), Монгол (1-7), Польш (1-2), Солонгос (1-11), Португал (1-2), Тай (1-6), Төвөд (1), Унгар (1), Фин(1), Франц (1-2), Хятад (1-10), Швед (1), Япон (1-4)

Агшин зуур Гэгээрэхийн Түлхүүр - Асуулт Хариулт

Англи (1-2), Ау Лак (1-4), Болгар (1), Герман (1), Индонез (1-3), Монгол (1-2), Орос (1), Польш (1), Португал (1), Солонгос (1-4), Унгар (1), Франц (1), Хятад (1-3), Чех (1), Япон (1)

Агшин зуур Гэгээрэхийн Түлхүүр - Багш шавийн хоорондын захиа

Англи (1), Ау Лак (1-2), Испани (1), Хятад (1-3)

Агшин зуур Гэгээрэхийн Түлхүүр - Багштайгаа өнгөрүүлсэн гайхамшигт мөчүүд

Ау Лак (1-2), Хятад (1-2)

1992 онд Сан Ди Мун-д болсон 7 хоногийн даяан бясалгал / тусгай хэвлэл

Англи (1), Ау Лак (1)

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн 1993 онд Дэлхий даяар ном дэлгэрүүлсэн аялал

Англи (1-6), Хятад (1-6)

Их Багшийн ярьсан үлгэр түүх

Англи (1), Ау Лак (1), Испани (1), Монгол (1), Солонгос (1), Тай (1), Хятад (1), Япон (1)

Эзэн Бурхантай шууд холбогдох - Энх тайванд хүрэх зам

Англи, Ау Лак, Хятад

**Эзэн Бурхан ба хүн төрөлхтний үлгэр - Библийн
үлгэрүүдийг ухаарахуй**

Англи, Ау Лак, Хятад

Амьдралаа солонгоруулья

Англи, Ау Лак, Монгол, Хятад

**Эрүүл мэндээ ухаарахуй Жам ёсны зөв амьдралын хэв
маягт эргэн орохуй**

Англи, Ау Лак, Монгол, Хятад

Оюун санааны дадал бясалгалын нууц хялбар аргууд

Англи, Ау Лак, Монгол, Хятад

**Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдсан билиг
ухааны зурагт үлгэрүүд- Бурхан бүхнийг зохицуулдаг**

Англи, Ау Лак, Монгол, Солонгос, Хятад, Франц, Япон

**Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Гэгээрүүлэгч
хошигнол - Таны гэрлэн бүрхүүл дэндүү давчуу байна!**

Англи/Хятад (ном + CD)

Онч мэргэн үгс (1)

*Англи (1), Хятад (1), Испани/Португал, Франц/Герман,
Англи/Солонгос, Англи/Япон*

Онч мэргэн үгс (2)

Англи (1), Хятад (1)

Тэнгэрлэг зоог - Олон улсын цагаан хоолны гал тогоо

Англи/Хятад, Ау Лак, Япон

Тэнгэрлэг зоог – Гэрийн хоолны амтат сонголт

Англи/Хятад

Диваажингийн урлаг

Англи, Ау Лак, Хятад, Монгол

Жинхэнэ хайр

Англи, Хятад, DVD, MP4

Ая эгшгээр амгалан дэлхийг бүтээхүй (тусгай хэвлэл)

Англи/Ау Лак/ Хятад

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн урлагийн бүтээлийн цоморлог

Англи/Ау Лак/Хятад

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн урлагийн бүтээлийн цоморлог - Уран зургийн цувралууд

Англи (1), Хятад (1)

Тэнгэрийн хувцас

Англи/Хятад

Шувууд миний амьдралд

Англи, Ау Лак, Араб, Герман, Индонез, Монгол, Солонгос, Орос, Франц, Хятад

Эрхэм ариун амьтад

Англи, Ау Лак, Герман, Монгол, Солонгос, Франц, Хятад

Аниргүй нулимс

Англи, Ау Лак, Хятад, Герман, Франц, Испани, Португал, Солонгос, Монгол, Филиппин

Вуузуу шүлгүүд

Англи, Ау Лак, Хятад

Мартагдсан дурсамж

Англи, Ау Лак, Хятад

Хайрга ба Алт

Англи, Ау Лак, Хятад

Эрвээхэйн мөрөөдөл

Англи, Ау Лак, Хятад

Өмнөх амьдралын зам мөр

Англи, Ау Лак, Хятад

Хуучин цаг

Англи, Ау Лак, Хятад

Эрин зууны хайр

Англи, Ау Лак, Хятад, Монгол

Аниргүйхэн нулимсыг хайрлахуй

Англи, Хятад, CD, DVD, MP4

Амьдрал болоод ухамсрын тухай бодрол:

Доктор Жанезын бичсэн ном

Хятад хэл дээр

Хямралаас энх тайванд: Шийдэл нь Органик веган хүнс

<http://crisis2peace.org> хаягаар олон хэл дээр үнэ төлбөргүй унших болон татаж авна уу.

Дээрх номууд үргэлжлэн хэвлэгдсээр байна.

Бусад айлдварууд болон дууны DVD, MP3, MP4, CD-ны цувралууд Араб, Армен, Ау Лак, Болгар, Камбож, Кантон, Хятад, Хорват, Чех, Дани, Голланд, Болгар, Англи, Фин, Франц, Герман, Грек, Еврей, Унгар, Индонез, Итали, Япон, Солонгос, Малай, Монгол, Непал, Норвег, Перс, Филлипин, Польш, Португал, Румын, Орос, Шри Ланк, Словени, Испани, Швед, Тай, Турк, Зулу хэл дээр хэвлэгджээ.

БИДЭНТЭЙ ХЭРХЭН ХОЛБОГДОХ ВЭ?

Шуудангийн хайрцаг 9, Шихү, Миаоли, Формоса,
БНХАУ (36899)

Шуудангийн хайрцаг 730247, Сан Хосе,
Калифорни 95173-0247, АНУ

Суприм Мастер Телевиз

И-мэйл: Peace@SupremeMasterTV.com

Утас: 1-626-444-4385

Факс: 1-626-444-4386

Ном орчуулгын групп:

И-мэйл: divine@godsdirectcontact.org

(Та Их Багшийн номыг олон хэл дээр орчуулах ажилд оролцож болно.)

Мэдээний групп:

И-мэйл: lovenews@godsdirectcontact.org
S.M. Celestial Co., Ltd:

И-мэйл: smclothes123@gmail.com;
Vegan999@@hotmail.com

Утас: 886-3-4601391

Факс: 886-3-4602857

Веб сайт: <http://www.smcelestial.com>

<http://www.sm-celestial.com>

Асуулт хариултын баг:

И-мэйл: lovewish@godsdirectcontact.org

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Олон Улсын Нийгэмлэгийн
Хэвлэлийн ХХК

И-мэйл: smchbooks@godsdirectcontact.org

Утас: 886-2-23759688 Факс: 886-2-23757689

<http://www.smchbooks.com>

Онлайн дэлгүүр

Celestial Shop: <http://www.theCelestialShop.com> (Англи)

Eden: <http://www.EdenRules.com/> (Англи, Хятад)

Цэвэр веган бүтээгдэхүүний онлайн дэлгүүр

<http://www.lovingfood.com.tw>

**“Loving Hut” Олон Улсын Веган Хоолны Сүлжээ
ресторан**

И-мэйл: service@lovinghut.com

Утас: 886-3-4683345

Факс: 886-3-4681581

Веб сайт: <http://www.lovinghut.com/tw/>

Гуань Инь веб сайтууд:

Бурхантай шууд холбогдох- Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Олон Улсын Нийгэмлэгийн интернэт хаяг:

<http://www.godsdirectcontact.org.tw/eng/links/links.htm>

Энэхүү хаягаар дэлхийн олон хэл дээрх Гуань Инь вэб хаягуудыг олж авахаас гадна 24 цагийн интернэт телевиз болох Суприм Мастер Телевиз болон Урлагийн Ертөнцөөр Аялахуй нэвтрүүлгийг үзэх боломжтой.

Мөн олон орны хэл дээр “Агшин зуур гэгээрэхийн түлхүүр” үлгэр дэвтрийг татаж авч болно. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн мэдээ сэтгүүлийг цахим хэлбэрээр татаж авах болон унших боломжтой.

Суприм Мастер Телевиз

Суприм Мастер Телевиз нь бүтээлч хөтөлбөрүүдийг нэвтрүүлдэг суваг бөгөөд танд сүнслэг дэвшлийг авчирч, амьдралд тань цоо шинэ өнгө төрхийг бэлэглэх болно.

Суприм Мастер Телевизийг 24 цагийн турш онлайнгаар үзэх хаяг: <http://suprememastertv.com/mn1/>

Агшин зуур Гэгээрэхийн Түлхүүр (үлгэр дэвтэр)-г олон хэл дээр үнэ төлбөргүй татаж авах хаяг (80 орны хэл дээр)

<http://sb.godsdirectcontact.net>

<http://www.direkter-kontakt-mit-gott.org/booklet/>

<http://www.Godsdirectcontact.com/sb/index.html>

Агшин зуур Гэгээрэхийн Түлхүүр 9
(Ау Лак хэл дээрх айлдвар)
Зохиогч: Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай

Хэвлэсэн газар: Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай
Олон Улсын Нийгэмлэгийн Хэвлэлийн Компани

Хаяг: Тайпэй хот, Жүнзэн дүүргийн Жүншиао баруун замын 1-р хэсэг, 8-р давхарын 16, 72 тоот

Утас: 886-2-23759688

Факс: 886-2-23757689

И-мэйл : smchbooks@Godsdirectcontact.org <http://www.smch-books.com>

Шуудангийн дугаар: 19259438

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай © 1987~2015

Зохиогчийн эрх: Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай

Энэхүү номын агуулгыг хэвлэлийн компаниас зөвшөөрөл авсны дараа хуулбарлаж болно

Анхны хэвлэл: 2004 оны 10-р сар

Хоёр дахь хэвлэл: 2005 оны 5-р сар

Дөрөв дэх хэвлэл: 2011 оны 5-р сар

Тав дахь хэвлэл: 2014 оны 7-р сар

Хялбаржуулсан хятад хэлний хэвтээ бичгийн хувилбар:

2015 оны 11-р сар

Монгол хэл дээр нэг дэх хэвлэл:

Энэхүү хувилбарыг монгол хэлнээ орчуулсан 2023 оны 8 сар

Цахим хувилбар:<http://www.gegeerel.mn/> 2024 оны 1-р сар

Агшин зуур Гэгээрэхийн Түлхүүр / Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай

Дахин хэвлэл-

Гайпей хот: Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай Олон Улсын Нийгэмлэг, 1998 он “Тайвань тооллоор 86 он”

1 –р боть; 13x19 см

ISBN 957-28245-5-4 (Боть 9: Хатуу хавтастай)

1. Сүнслэг дадал бясалгал

2. Оюун санааны амьдрал

192.1

93018084



Та нар газрын зураг дээр Ау Лакын хэлбэр дүрсийг харсан уу? Үнэний бэлгэдэл болсон арга билгийн зураг дүрсийг та нар харсан уу? Тэр нь нэг тойргийг дундуур нь S хэлбэртэй шугамаар хоёр хэсэг хуваасны нэг тал нь цагаан өнгөтэй, нөгөө тал нь хар өнгөтэй байдгийг та нар харж байсан уу? Нэг улсын газрын зураг дээрх хэлбэр дүрс яг ийм байдаг нь үнэхээр гайхалтай. Тэр нь үнэний хүслэнт ахуйн бэлгэдэл юм. Зөвхөн газар нутгийн хэлбэр дүрсийг нь хараад Ау Лак бол ариун дагшин орон болохыг ойлгож болно. Тэндхийн хүн ард төрөлхийн сэргэлэн авхаалжтай болохоор л сая өч төчнөөн зовлон зүдгүүр, хүчир бэрхийг туулан байж, эрч хүчээ дасгалжуулан дэвжүүлжээ. Үүний улмаас яг л тэнгэрийн орны луугийн хүүхдүүд шиг улам бүр баатар зоригтой, тэсвэр тэвчээртэй, цөхрөшгүй болдог.

*Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар,
Филиппин улсын Батан хот, 1991 оны 4-р сарын 5*

Багшийн чинь бодож буйгаар бол хамгийн сайн арга нь бясалгал хийх явдал юм. Бясалгал хийсний дараа бид бясалгалын ач буянаараа ахан дүүс хийгээд хамаатан садны хоорондох зөрчил гэмцлийг эелүүлж найрамдуулж чадна. Ау Лакчуудын хүн болгон бүгд бясалгал хийвэл нэг хүн маш олон хүнийг гэтэлгэж чадах бөгөөд тэгсээр тэгсээр хэзээ нэгэн өдөр улс орон бүхэлдээ аяндаа туулан гэтэлж чадах юм;

Улс орон маань ийм олон дайн дажныг үзэж туулснаас бид өс хонзон, дайн дажнаар асуудлыг шийдвэрлэж чаддаггүй гэдгийг ойлгож болно.

Хайр бялхсан уудам сэтгэл болон бясалгал хийснээр л сая аливаа бүхнийг ялан давж, сайн сайхан үр дүнд хүрч чадна.

*Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн
айлдвар, Америкийн Калифорни мужийн
Санта Анна хот, 1989 оны 10-р сарын 21*

